



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2022 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2022 ОНЫ 10 ДУГААР САРЫН 27-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
НЭГДСЭН ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2022 оны 10 дугаар сарын 27-ны өдөр, Пүрэв гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2-10
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	10-19
<hr/>	
<i>1. Улсын Их Хурлын дэд даргыг чөлөөлөх тухай асуудал</i>	13-15
<i>2. “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2023 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Монголбанкнаас 2022.09.27-ны өдөр ирүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	
<i>3. Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөл /Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/</i>	15-56
<i>4. Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг нарын 4 гишүүн 2022.10.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	58-81
<i>5. ““Эрдэнэт үйлдвэр” Төрийн өмчит үйлдвэрийн газрын технологид тохирохгүй хүдрийн овоолгыг ашиглах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг 2022.04.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	81-107
<i>6. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьяаа 2022.06.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	107-116

**Монгол Улсын Их Хурлын 2022 оны намрын ээлжит чуулганы
10 дугаар сарын 27-ны өдөр /Пүрэв гараг/-ийн нэгдсэн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дэд дарга С.Одонтуяа ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 76 гишүүнээс 40 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 07 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Ж.Батсуурь, Э.Батиугар, Х.Булгантуяа, Ц.Даваасүрэн, Г.Занданшатар, Ж.Мөнхбат, Б.Пүрэвдорж, Ц.Сандаг-Очир, Б.Энхбаяр;

Чөлөөтэй: Л.Оюун-Эрдэнэ;

Эмнэлгийн чөлөөтэй: Х.Ганхуяг, Д.Сарангэрэл;

Тасалсан: А.Адъяасүрэн, Ж.Сүхбаатар;

Хоцорсон: С.Батболд-2 цаг 35 минут, Б.Баярсайхан-55 минут, Д.Ганбат-25 минут, М.Оюунчимэг-40 минут, Г.Тэмүүлэн-50 минут, Н.Учрал-55 минут, Д.Цогтбаатар-29 минут, Ж.Эрдэнэбат-2 цаг 41 минут.

Улсын Их Хурлын дэд дарга С.Одонтуяа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалмаа, С.Ганбаатар нараас ирүүлсэн албан бичгийг танилцуулж, Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалмаа, С.Ганбаатар нар үг хэлэв.

Нэг. Улсын Их Хурлын дэд даргыг чөлөөлөх тухай асуудал

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Улсын Их Хурлын дэд дарга С.Одонтуяа Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Т.Аюурсайханаас Засгийн газрын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын ажилд томилогдсонтой холбогдуулан Улсын Их Хурлын дэд даргаас чөлөөлөгдөх хүсэлтээ 2022 оны 10 дугаар сарын 26-ны өдөр Улсын Их Хуралд ирүүлснийг уншиж танилцуулав.

Улсын Их Хурлын дэд даргыг чөлөөлөх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

С.Одонтуяа: Төмөрбаатарын Аюурсайханыг Монгол Улсын Их Хурлын дэд даргын албан тушаалаас чөлөөлөхийг дэмжье гэсэн саналаар санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 38
Татгалзсан: 13
Бүгд: 51
74.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын дэд дарга С.Одонтуяа “Улсын Их Хурлын дэд даргыг чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолыг уншиж танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс тогтоолын эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./10:34/

Уг асуудлыг 10 цаг 35 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2023 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Монголбанкнаас 2022.09.27-ны өдөр ирүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан, Монголбанкны Ерөнхий эдийн засагч Д.Ган-Очир, мөн банкны Мөнгөний бодлогын газрын дарга Б.Баярдаваа, Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газрын захирал А.Энхжин, Банкны бүтцийн өөрчлөлт, бодлогын газрын захирал Н.Ариунбат, Судалгаа, статистикийн газрын захирал Д.Даваасүх, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын Төлбөрийн тэнцлийн хэлтсийн дарга Б.Мөнх-Эрдэнэ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын дэд дарга С.Батбаатар, Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Т.Доржханд танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат, О.Цогтгэрэл, Б.Батгөмөр, С.Амарсайхан, Ц.Туваан, Н.Энхболд, С.Ганбаатар, Ц.Мөнх-Оргил, М.Оюунчимэг, Ш.Адъяаа нарын тавьсан асуултад Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан, Эдийн засгийн байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг, ажлын хэсгийн гишүүн, Улсын Их Хурлын гишүүн Т.Доржханд нар хариулж, тайлбар хийв.

“Төрөөс мөнгөний бодлогын талаар 2023 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн санал:

С.Одонтуяа: 1.Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг, Х.Ганхуяг, Т.Доржханд, Ч.Ундрам, О.Цогтгэрэл /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар заалтад доор дурдсан агуулгатай дэд заалт нэмэх:

“9/Монгол Улсын Засгийн газраас дэвшүүлсэн “Халамжаас хөдөлмөрт” зорилтын хүрээнд ажлын байрыг хадгалах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, эрэлтэд нийцсэн ур чадвартай ажиллах хүчний нийлүүлэлтийг нэмэгдүүлж, мөнгөний болон төсвийн бодлогоор дэмжих;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил, Б.Баттөмөр, С.Чинзориг нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 20
Бүгд: 42
52.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Цэрэнпунцагийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан учир санал хураалтын дүнг дэмжсэнээр тооцож, 54.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, төслийн 2 дугаар заалтад доор дурдсан агуулгатай дэд заалт нэмэх:

“10/валютын захын үр ашиг, хүртээмжийг нэмэгдүүлэх, харилцагчдыг таньж мэдэх хууль, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, түүнчлэн санхүүгийн үүсмэл хэрэгслийн зах зээлийг хөгжүүлэх, хэрэглээг нэмэгдүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээг авах;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 18
Бүгд: 42
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар заалтад доор дурдсан агуулгатай дэд заалт нэмэх:

“11/урт хугацааны тогтвортой санхүүжилтийн үйл ажиллагаа эрхлэх гадаадын хөрөнгө оруулалттай төрөлжсөн банкны эрх зүйн орчныг бүрдүүлэх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 19
Бүгд: 43

55.8 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Улсын Их Хурлын гишүүн Т.Доржхандын гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар заалтын 8 дахь дэд заалтын “2023 онд” гэснийг “2023 оны 2 дугаар улиралд” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Т.Доржханд, Ц.Туваан нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 24

Татгалзсан: 19

Бүгд: 43

55.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

“Төрөөс мөнгөний бодлогын талаар 2023 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 12 цаг 39 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөл /Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Д.Цолмон, Санхүүгийн зохицуулах хорооны Банк бус санхүүгийн байгууллагын газрын дарга Б.Итгэлсүрэн, Монголбанкны Хууль, эрх зүйн газрын Банк, санхүүгийн эрх зүйн хэлтсийн захирал Ө.Мөнх-Ундарга нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат, референт П.Хулан нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

С.Одонтуяа: Байнгын хорооноос гаргасан Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн анхны

хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын санал гаргасныг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 19
Бүгд: 40
52.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Үдээс өмнөх хуралдаан 2 цаг 41 минут үргэлжилж, 12 цаг 48 минутад завсарлав.

Үдээс хойших хуралдаан 14 цаг 09 минутад эхлэв.

Дөрөв.Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг нарын 4 гишүүн 2022.10.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Төрийн албаны зөвлөлийн дарга Б.Баатарзориг, мөн зөвлөлийн Сургалт, судалгааны мэдээллийн нэгдсэн сангийн газрын дарга Ж.Эрдэнэбат, Төрийн албаны зөвлөлийн гишүүн Д.Баатарсайхан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаар илтгэлийг хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаар Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ё.Баатарбилэг, Ш.Адъяаа, Б.Бат-Эрдэнэ, Н.Наранбаатар, Ц.Туваан нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг, Төрийн албаны зөвлөлийн гишүүн Д.Баатарсайхан нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн С.Амарсайхан, С.Ганбаатар, Ц.Туваан нар үг хэлэв.

С.Одонтуяа: Байнгын хорооны саналаар Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 30

Татгалзсан: 17

Бүгд: 47

63.8 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 15 цаг 25 минутад хэлэлцэж дуусав.

Тав. ““Эрдэнэт үйлдвэр” Төрийн өмчит үйлдвэрийн газрын технологид тохирохгүй хүдрийн овоолгыг ашиглах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг 2022.04.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл, мөн газрын Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга Ц.Баяр-Эрдэнэ, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Уул уурхайн бодлогын газрын дарга Б.Элбэгзаяа, “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын ерөнхий геологич Д.Алтанхуяг, мөн газрын Улаанбаатар хотын төлөөлөгчийн газрын Албаны дарга Г.Тамир, Эдийн засагч М.Баясгалан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Гандулам, референт Б.Ууганцэцэг нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаар илтгэлийг хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг, тогтоолын төслийг хэлэлцэх эсэх талаар Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьшаа, О.Цогтгэрэл, Н.Ганибал, Ц.Туваан, Б.Баттөмөр нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг, Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны дарга Т.Энхтүвшин, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням үг хэлэв.

С.Одонтуяа: Байнгын хорооны саналаар ““Эрдэнэт үйлдвэр” Төрийн өмчит үйлдвэрийн газрын технологид тохирохгүй хүдрийн овоолгыг ашиглах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх шаардлагагүй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 18

Татгалзсан: 22

Бүгд: 40
45.0 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдсэнгүй.

““Эрдэнэт үйлдвэр” Төрийн өмчит үйлдвэрийн газрын технологид тохирохгүй хүдрийн овоолгыг ашиглах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 16 цаг 53 минутад хэлэлцэж дуусав.

Зургаа.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаа 2022.06.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат, референт П.Хулан нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаар илтгэлийг хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаа, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаар Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалан нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар, Б.Бат-Эрдэнэ нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаа хариулж, тайлбар хийв.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг дараагийн хуралдаанаар үргэлжлүүлэн хэлэлцэхээр тогтов.

Улсын Их Хурлын дэд дарга С.Одонтуяа Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгээс Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэд хандан 2022 оны 6 дугаар сарын 03-ны өдрийн 27 тоот албан бичгээр “Монгол Улсын экспортын уул уурхайн бүтээгдэхүүний хяналтыг сайжруулах” талаар тавьсан асуулгын хариуг хэлэлцэхийг хойшлуулах тухай албан бичиг ирүүлснийг танилцуулж, хуралдааны тов, дарааллаас хойшлуулж байгаа тухай мэдэгдэв.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 6 асуудал хэлэлцэв.

Бусад. Улсын Их Хурлын гишүүн П.Анужин, Э.Батшугар, Х.Нямбаатар, Б.Жаргалмаа, Н.Учрал нарын урилгаар Сонгинохайрхан дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид, Засаг даргын Тамгын газрын ажилтнууд, Улсын Их Хурлын гишүүн Г.Мөнхцэцэгийн урилгаар Говьсүмбэр аймгийн 5 дугаар сургуулийн ахлах ангийн багш, сурагчид, Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакир, Х.Баделхан, Б.Бейсен нарын урилгаар Баян-Өлгий аймгийн иргэдийн төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар, Ц.Мөнх-Оргил, Ц.Мөнхцэцэг нарын урилгаар Сүхбаатар дүүргийн 2, 12 дугаар хорооны иргэдийн төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Н.Энхболд, Ц.Туваан нарын урилгаар Төв аймгийн Мөнгөнморьт сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид, Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнийн урилгаар Булган аймгийн Дашинчилэн сумын эмнэлгийн эмч, ажилтнууд, “Рояаль” олон улсын их сургуулийн төрийн удирдлагын хөтөлбөрийн багш, оюутнууд, Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатарын урилгаар “Маргаашийг бүтээнэ” үндэсний чуулганд орон нутгаас оролцогчид, Улсын Их Хурлын гишүүн Б.Баярсайхан, Ц.Цэрэнпунцаг нарын урилгаар Завхан аймгийн Их-Уул сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид, Улсын Их Хурлын гишүүн Ж.Эрдэнэбат, Ч.Ундрам, Д.Өнөрболор нарын урилгаар “Маргаашийг бүтээнэ” үндэсний чуулганд Сэлэнгэ аймгаас оролцогчид, мөн аймгийн Шаамар сумын мод үржүүлгийн “Шаамар питомник” компанийн ажилчид, Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Ерөнхий боловсролын 23 дугаар сургуулийн 11^Б ангийн багш, сурагчид, Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрамын урилгаар “Орчлон” сургуулийн 9^Б ангийн багш, сурагчид, Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалангийн урилгаар Баянзүрх дүүргийн Сууц өмчлөгчдийн холбооны удирдлагууд Төрийн ордон, Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаатай танилцав.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч М.Номиндулам, С.Энхзаяа нар хариуцан ажиллав.

Хуралдаан 5 цаг 57 минут үргэлжилж, 76 гишүүнээс 62 гишүүн хүрэлцэн ирж, 81.6 хувийн ирцтэйгээр 17 цаг 25 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2022 оны 10 дугаарсарын 27-ны өдөр,
Пүрэв гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
10 цаг 00 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

С.Одонтуяа: Улсын Их Хурлын гишүүдийн амгаланг айлтгая.

Өнөөдрийн хурлын ирц 57.9 хувьтай байна. Улсын Их Хурлын 2022 оны Намрын ээлжит чуулганы 10 дугаар сарын 27-ны өдрийн 27-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Өнөөдөр 6 асуудал хэлэлцэнэ.

1. Улсын Их Хурлын дэд даргыг чөлөөлөх тухай асуудал.

2. Төрөөс мөнгөний бодлогын талаар 2023 онд баримтлах Үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Монголбанкнаас 2022 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр ирүүлсэн. Өнөөдөр анхны хэлэлцүүлэг. Нийт зарчмын зөрүүтэй санал 4 байна.

3. Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөл, Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан анхны хэлэлцүүлэг

4. Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг нарын 4 гишүүн 2022 оны 10 дугаар сарын 12-ны өдөр өргөн мэдүүлсэн, өнөөдөр хэлэлцэх эсэхийг шийдвэрлэнэ.

5. “”Эрдэнэт үйлдвэр” Төрийн өмчит үйлдвэрийн газрын технологид тохирохгүй хүдрийн овоолгыг ашиглах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл Улсын Их Хурлын гишүүн Норовын Алтанхуяг 2022 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх,

6. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөл, Улсын Их Хурлын гишүүн Ширнэнбандийн Адъяаагийн 2022 оны 6 дугаар сарын 03-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх гэсэн ийм 6 асуудлыг хэлэлцэнэ ээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13.4-т гишүүн энэ хуулийн 9.5-д заасан нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхээр тогтсон асуудлыг хойшлуулах, дараалал өөрчлөх асуудал нэмэх горимын санал гаргах бол Улсын Их Хурлын даргад нэгдсэн хуралдааны өмнөх өдрийн 17 цагаас өмнө үндэслэл бүхий саналаа бичгээр ирүүлнэ гэж заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн

Бадарчийн Жаргалмаа, Сайнхүүгийн Ганбаатар нараас тус тус албан бичгүүд ирүүлсэн байна. Албан бичгүүдийг танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Жаргалмаа Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудалтай холбогдуулан үг хэлэх хүсэлтэй байгаа тул зохих журмын дагуу зөвшөөрөл олгоно уу гэсэн байна.

Жаргалмаа гишүүнд үг хэлэх зөвшөөрөл олгоё.

Б.Жаргалмаа: Эрхэм гишүүдийнхээ өглөөний амгаланг айлтгая.

Миний бие Улсын Их Хурал дахь эмэгтэйчүүдийн бүлгээс үүрэг өгсний дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрх ашгийг хамгаалах асуудлаар анхаарч, тэдэнд дэмжлэг үзүүлэхийг зорьж ажиллаж байгаа. Хамтран ажиллаж байгаа тодорхой шийдлүүд гарган ажиллаж байгаа Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга болон Боловсрол, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд нартаа бас талархаж байгаагаа үүгээр уламжилж байна.

Жил бүрийн 10 дугаар сарын 27-ны өдөр тохиодог. Хөдөлмөр засалчдын өдөр энэ өдөр тохиож байгаа. Энэ өдрийг тохиолдуулан хөдөлмөр засалчдын холбоод, Ээлтэй ертөнц Төрийн бус байгууллагаас санаачлан хөдөлмөр засалч, мэргэжлийн талаарх товч танилцуулга бүхий ил захидлуудыг та бүхний ширээн дээр байрлуулсан байгаа. Та бүхэн ширээн дээр тань байрлуулсан энэ жижигхэн танилцуулгаас бас Хөдөлмөр засалчдын холбооны үйл ажиллагаа,

хөдөлмөр засал чухам юунд хэрэгтэй юм бэ гэдэг талаарх мэдээллийг авах байх гэж найдаж байна. Мөн стресс тайлагч тоглоомууд тавьсан байгаа. Бид байнга суугаа ажил хийдэг, хүн болгонд хөдөлгөөн, хөдөлмөр зайлшгүй шаардлагатай байдаг учраас та бүхэнд бас энэ тоглоомыг зориуд тавьсан байгаа шүү.

Энэ өдрийг тохиолдуулан миний бие өөрийн ахлан ажиллаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх ашгийг хамгаалах, нийгэм дэх тэгш оролцоог нь хангахад дэмжлэг үзүүлэх зорилгоор лобби бүлэг байгуулан ажиллаж байгаа. Лобби бүлэгт оролцож байгаа, хамтрахаар болсон эрхэм гишүүддээ бас талархлаа илэрхийлье.

Та бүхнийг холбоодын үйл ажиллагаанд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрх ашгийг хамгаалах чиглэлээр тусалж, хамтран ажиллана гэдэгт бас итгэлтэй байна. Нэгэнт үг авах эрх авсан учраас би 10 дугаар сарын энэ 27-ны өдрүүдэд миний сонгогдсон Сонгинохайрхан дүүргийн маань түүхт 30 жилийн ой тохиож байгаа. Энэ өдрийг тохиолдуулан нийт Сонгинохайрханчууд даа бас халуун баярыг дахин хүргэе гэж бодож байна.

Мөн жил бүрийн 10 дугаар сарын 29-ний өдрийг нийслэлийн өдөр болгон тэмдэглэдэг байгаа. Их хүрээ, Хүрээ, Номын хүрээ, Нийслэл хүрээ хэмээн нэрийдэж байсан. Нийслэл Улаанбаатар хотын маань түүхт 383 жилийн ой өдрүүдэд тохиолдож байна. Энэ өдрийг тохиолдуулан нийт нийслэлчүүддээ их ойн баярын мэндийг хүргэе гэж бодож байна. Баярлалаа та бүхэндээ.

С.Одонтуяа: Одоо Сайнхүүгийн Ганбаатар гишүүнээс ирсэн хүсэлтийн дагуу үг хэлэх зөвшөөрөл олгож байна.

С.Ганбаатар: Үг хэлэх зөвшөөрөл өгсөнд баярлалаа.

Монгол Ардын намын нөхдүүд Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд аймшигтай гар дүрж байна. Та нар маш том нүгэл хийж байна даа. Арслан, хонь 2 хэлэлцээрт орвол хонь удахгүй мах болдог гээд нэг англи үг байдаг юм. Тэрэн шиг өнөөдөр Монголын төр Оросын төртэй шууд бензиний үнээ ярьдаг болж байгаа. Урьд нь бол хувийн хэвшлийн компаниуд хоорондоо ярилцаж ойлголцдог, тэндээ зодоон бол тэндээ болно. Үл ойлголцол бол тэндээ болно. Одоо бол шууд гаднын төр Монголын зах зээл рүү бензиний энэ шатах тослох материалын зах зээл рүү шууд орж ирж байгаа, орох үүд хаалгаа нээлээ. Та хэд чинь 62 билүү 63 суудалтай Монголын ард түмэн та нарт яагаад итгэсэн бэ гэвэл бизнес эрхлэгчдийг дэмжээрэй. Ажлын байр бий болгоорой, орлого нэмээрэй гэсэн. Та нар эсрэгээр нь ГОК-той адилхан нэг хуучин нийтийг буцаагаад байгуулж байгаа. Бас л улс төрчид, дарга нар тавьдаг компаниа бий болгож байгаа юм. Би нэг ганц нэг компанийн тухай яриагүй шүү. Та нар онгоцны бензин дээр нээж өгч байгаа 7.2 дугаар заалтаар шууд 92 дизелийг бас нээж өгч байгаа гэсэн үг шүү.

Дараа дараагийн ээлжид энэ үндэсний шатах тослох материалын компаниуд энэ МАН-даа итгэсэн хэвээрээ л байгаа юм байх даа. Тэрийг бариад явлаа, би чимээгүй байлаа. Намайг бариад явахад хэн ч дуугарсангүй гэдэг шиг үндэсний бизнес эрхлэгчдийн эрх ашгийг ноцтой

зөрчиж байна. Энэ асуудлыг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөр хэлэлцсэн үү? Би өнөөдөр энэ хууль тогтоох хууль тогтоомжийн төсөл боловсруулах ажлын зохион байгуулалт гэдэг хуулийг харлаа. Интернэт дээр та нар 3 шатлалаар энэ хуулийн зохион байгуулалтын тухай бичсэн байх ёстой юу ч алга. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөр ярьсангүй. НИК-ийг яагаад бид либералчилсан бэ гэвэл, гадаадын төртэй шууд Монголын төр бензиний хэрүүл хийхээсээ залхаад л хувийн компаниудад либералчилж өгсөн. Энийгээ буцааж авчихна. Та нар үнэ буурна гэж ярьж байна. Үгүй ээ, энэ үнэ буурах асуудлаа үндэсний компаниудтайгаа ярихгүй яасан юм. Хэлэлцээр хийсэн юм уу? Таг энэ дээр судалгаан дээр юу ч алга.

Хоёрдугаарт, Станы орнууд Узбекистан, Киргизстан, Тажикстан өнөөдөр МАН-ын дарга нартай адилхан сэтгэсэн. Шууд Оросын төртэй харьцвал бензин буух юм байна гэсэн. Та нар судалгаа хийгээч. Энэ хуулийн урьдчилан боловсруулах шатандаа судлах ёстой заалт нь дотор яг бидэнтэй адилхан орнууд яасан бэ гэдэг. Болгар энэ дээр сүйрхээ алдсан. Өөрөө алдаагаа зассан 7 жилийн дараа. Узбекистан, Киргизстан, Тажикстан би энэ 3-ыг судалсан. Манайхаас үнэтэй байгаа. Тэд нарт өөрийнх нь Засгийн газар нь үндэсний шатах тослох материал оруулж ирдэг компаниудтайгаа хэлэлцээр хийхгүй. Шууд Оросын төртэй хэлэлцээр хийдэг. Оросын төрийг би муулаагүй ээ. Аль нэг гадаадын төр орж ирвэл бидэнтэй бензиний үнэ ярьдаг нэг ийм улс төрийн хэрэгсэлтэй болж авч байгаа л гэсэн үг. Энэ өнөөдөр нэг хэдэн компаниудыг шахах тухай асуудал ч биш. 3.4 сая хүмүүсийн шатах тослох

материалыг авдаг эрхийг нь худалдаж авдаг эрхийг нь шууд гаднын төрд өгч байна гэсэн үг. Өгөх хүн гэдийдэг авах хүн бөхийдөг. Би бол цөөнхийн цөөнх та нарыг шүүмжлэхийн төлөө шүүмжилдэггүй.

Та нарыг засаж залруулахын төлөө байдаг. Та нар энэ алдаагаа засаад өгөөч. Би жадлан эсэргүүцээгүй шүү дээ. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөрөө хэлэлцээдэхээ ч.

Хүрэлсүх Ерөнхийлөгч мэдэн будилаад намайг мэдээгүй байхад энийг оруулаад батлуулчхаарай гэж л лав бодохгүй байгаа байх. Та нар ар хударгаар нь хийж байх шиг байна. Булиа 3 тэр том улс төрч нь хоорондоо ярилцаад энэ болох юм байна гэж бодож байгаа бол дүгнэлтээ Их Хуралд оруулж ирээч. Энэ сүүлд нь хариуцлага. Үнэ буулгана гэж байна. Тонн тутамд нь нэг сая гаран төгрөгөөр бууна гэж байна. Үгүй ээ, энэ үндэсний компаниудтайгаа яг энэ талаараа ярьсан юм уу? Бензин эрхлэгч компаниуд яагаад дуугай байдаг юм бол? Бүгдээрээ барьцаалагдсан юм уу? Тэгэхлээр миний хэлэх гээд байгаа зүйл гэвэл Рио Тинтотой Монголын Засгийн газар хувь эзэмшиж, нэг хөнжилд орсноороо бид хорин хэд билээ дээ тэрбум долларын өрөнд орж балрахаа алдсан.

Харин яг энэ дээр бол Оюун-Эрдэнийн Засгийн газар Нямбаатар сайдаар ахлуулсан ажлын хэсэг бол махаа зулгааж байж жоохон наашлуулах гэж оролдсон. Олон гишүүд орсон. Ард иргэд бүгдээрээ дэмжсэн. 20 жилийн хөдөлмөр энэ бол. Яг тэрэнтэй адилхан бензиний асуудлаар та нар Монгол Ардын намын ухаантай царайтай гишүүд та

нар аймшигтай нүгэл хийх гэж байна. Энийгээ эргэж хараад.../минут дуусав/

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөрөө нэг.

С.Одонтуяа: Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл хэлэлцэх эсэх нь дэмжигдээд Эдийн засгийн байнгын хороогоор анхны хэлэлцүүлэг нь хийгдсэн Улсын Их Хурлын даргын дэргэдэх зөвлөлийн 2022 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн хуралдаанаар шийдвэрлэсний дагуу өнөөдрийн нэгдсэн хуралдааны хэлэлцэх асуудлын дарааллаас хасагдсан байгаа Ганбаатар гишүүн ээ.

Энэ 7 хоногт төрсөн өдөр нь тохиож байгаа гишүүндээ мэндчилгээ дэвшүүлье.

10 дугаар сарын 25-нд Улсын Их Хурлын гишүүн Хаянгаагийн Болорчулуун төржээ. Намхайн Хаянгаа, Загдын Чимэд нарын айлын том хүү болон мэндэлсэн Болорчулуунд төрсөн өдрийн мэнд хүргэж, Монгол төрийн эрхэм түшиэ, ард түмний элч болсон танд болон таны гэр бүлд Улсын Их Хурлын нийт гишүүдийнхээ нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Одоо хэлэлцэх асуудлын нэгд,

Улсын Их Хурлын дэд даргыг чөлөөлөх тухай асуудал байгаа.

[Улсын Их Хурлын дэд даргыг чөлөөлөх тухай асуудлыг хэлэлцэнэ.](#)

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 15.2-т энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасны дагуу гишүүний бүрэн эрхийг нь түдгэлзүүлсэн, 10 дугаар зүйлд заасны дагуу гишүүний бүрэн эрх

нь дуусгавар болсноос гадна өөрийнх нь хүсэлтээр, эсвэл нэр дэвшүүлсэн нам, эвслийн бүлгийн хүсэлтээр Улсын Их Хурлын дэд даргыг үүрэгт ажлаас нь чөлөөлж, огцуулна гэж заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Төмөрбаатарын Аюурсайхан, Засгийн газрын гишүүн-Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын сайдын ажилд томилогдсонтой холбогдуулан чөлөөлөгдөх хүсэлтээ 2022 оны 10 дугаар сарын 26-ны өдөр Улсын Их Хуралд ирүүлсэн.

Ингээд хүсэлтийн дагуу санал хураалт явуулна. Гишүүний өргөдөл, хүсэлт нь энэ байна. Гишүүд санал хураалтдаа бэлдье.

Төмөрбаатарын Аюурсайханыг Монгол Улсын Их Хурлын дэд даргын албан тушаалаас чөлөөлөхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Нийт 74.5 хувиар дэмжигдлээ.

Тогтоолын төслийг уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын тогтоол 2022 оны 10 дугаар сарын 27-ны өдөр Монгол Улсын Их Хурлын дэд даргыг чөлөөлөх тухай.

Монгол Улсын Үндсэн хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь.

Нэг. Монгол Улсын Их Хурлын гишүүн Төмөрбаатарын Аюурсайханыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдаар томилогдсонтой холбогдуулан өөрийнх нь хүсэлтийг

үндэслэн Монгол Улсын Их Хурлын дэд даргын албан тушаалаас чөлөөлсүгэй.

Хоёр. Энэ тогтоолыг 2022 оны 10 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Тогтоол батлагдлаа.

Ингээд Аюурсайхан дэд даргадаа, цаашидынх нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдынх нь ажилд ажлын амжилт хүсэн ерөөе.

Одоо тэд 2 дахь асуудал байгаа. Сая тогтоол уншиж танилцууллаа.

Тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүд байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

10.23 цаг

Одоо 2 дахь асуудалдаа оръё. Ажлын хэсгийг орж ирж байх хооронд мэндчилгээ дэвшүүлье.

Зочдыг танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Нямбаатар, Жаргалмаа, Учрал, Анужин, Батшугар нарын урилгаар Сонгинохайрхан дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид, Засаг даргын Тамгын газрын ажилтнууд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Өнөөдөр Сонгинохайрхан дүүрэг үүсгэн байгуулагдсаны 30 жилийн ой тохиож байгаа юм байна. Тэгээд манай Сонгинохайрхан дүүргээс 5 гишүүн сонгогдон ажиллаж байгаа. Бүгдээрээ өнөөдөр Улсын Их Хурал, Засгийн газрын хариуцлагатай албыг хашиж байна. Нямбаатар гишүүн маань Хууль зүй, дотоод хэргийн сайдаар ажиллаж байна. Учрал

гишүүн Цахим хөгжил, харилцаа холбооны сайдаар, Анужин Нийгмийн бодлогын байнгын хорооны даргаар, Батиугар Инновац, цахим бодлогын байнгын хорооны даргаар, Жаргалмаа маань бас маш олон ажлын хэсэг ахалж лобби бүлгийг ахлаад ажиллаж байна. Ингээд нийт 5 Улсын Их Хурлын гишүүндээ амжилт хүсье.

Мөн Сонгинохайрхан дүүргийн иргэдийн эрүүл, аюулгүй, ажилтай орлоготой амьдрахын төлөө итгэл зүтгэл, сэтгэлээ зориулан ажиллаж байгаа Сонгинохайрханчууд даа бас нийт Улсын Их Хурлын гишүүдийнхээ өмнөөс халуун баяр хүргэе.

Одоо хэлэлцэх асуудалдаа орё.

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2023 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлэг орно.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Тогмидын Доржханд танилцуулна. Индэрт урьж байна.

Т.Доржханд: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монголбанкнаас Төв банкны тухай хууль 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэгт заасны дагуу 2022 оны 9 дүгээр сарын 27-ны өдөр Улсын Их Хуралд ирүүлсэн төрийн мөнгөний бодлогын талаар 2023 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх асуудлыг 2022 оны 10 дугаар сарын 6-ны өдрийн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, төслийг анхны

хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн.

Байнгын хорооноос тус тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэх Байнгын хорооны санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн С.Чинзоригор ахлуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, Х.Булгантуяа, Т.Доржханд, Ч.Ундрэм, О.Цогтгэрэл нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан бөгөөд Байнгын хорооны 2022 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаанаар тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг хийлээ.

Тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед ажлын хэсгийн зүгээс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, гадаад валютын захын үр ашиг, хүртээмжийг нэмэгдүүлэх, санхүүгийн үүсмэл хэрэгслийн зах зээлийг нэмэгдүүлэх, гадаадын хөрөнгө оруулалтын банкны эрх зүйн орчныг бүрдүүлэх, орон сууцны ипотекийн зээлийн хөтөлбөрийг 2023 оны 2 дугаар улиралд багтаан Монголбанкнаас Засгийн газар шилжүүлэх зэрэг зарчмын зөрүүтэй саналууд гарсныг нэг бүрчлэн хэлэлцэн санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүд олонх дэмжсэн болно.

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2023 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг Байнгын хорооны санал, дүгнэлтийн хамт та бүхэнд хүргүүлсэн.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2023 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсан баярлалаа.

С.Одонтуяа: Баярлалаа. Ажлын хэсгийг танилцуулъя.

Бядрангийн Лхагвасүрэн
Монголбанкны ерөнхийлөгч,
Дэмбэрэлдашийн Баярсайхан
Санхүүгийн Зохицуулах хорооны дарга,
Түндэвийн Жамбаажамц Санхүүгийн
Зохицуулах хорооны Ажлын албаны
дарга, Доожавын Ган-Очир
Монголбанкны ерөнхий эдийн засагч,
Баярсайханы Баярдаваа
Монголбанкны Мөнгөний бодлогын
газрын захирал, Атарбаатарын
Энхжин Монголбанкны Нөөцийн
удирдлага Санхүүгийн зах зээлийн
газрын захирал, Найманжингийн
Ариунбат Монголбанкны Банкны
бүтэц өөрчлөлтийн бодлогын газрын
захирал, Энхболдын Анар
Монголбанкны Төлбөр тооцооны
газрын захирал, Дамдинжавын
Даваасүх Монголбанкны Судалгаа,
статистикийн газрын захирал,
Батсүхийн Сүх-Очир Сангийн яамны
Санхүүгийн бодлогын газрын дарга,
Батхишигийн Мөнх-Эрдэнэ Эдийн
засаг, хөгжлийн яамны Макро эдийн
засгийн бодлогын газрын төлбөрийн
тэнцлийн хэлтсийн дарга.

Байнгын хорооны санал,
дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух
Улсын Их Хурлын гишүүд байна уу?
Ц.Идэрбат гишүүнээр тасаллаа.

Ц.Мөнх-Оргил гишүүнээр тасаллаа.
Идэрбат гишүүн асууя.

Ц.Идэрбат: Та бүхэнд өглөөний
мэнд хүргэе.

Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах бодлогын анхны хэлэлцүүлэг явж байна. Хэлэлцэх эсэх асуудлыг яригдаж байх үед Монголбанкны Ерөнхийлөгчөөс 5 асуулт асуугаад 2-ыг нь хариултыг авч чадаагүй. Та бид 2-ын хугацаа хаана, хаанаа хүрээгүй. Түүний нэг нь бол ард иргэдийн дунд яригдаад байдаг зээлийн хураамж, үйлчилгээний хураамж гэж ингэж яригдаад байдаг. Нэг хувийн тэгээд энэ хуулийн байгууллага дээр ч бас шат шатан дээр зөрүүтэй шийдвэрүүд гараад ингээд яваад байгаа. Энэ ер нь цаашидаа байх ёстой юу байх ёсгүй юу? Монголбанк энэ дээр ер нь ямар байр суурьтай байдаг юм? Тэтгэврийн зээлээс хүртэл нэг хувийг аваад байдаг ямар зардлын ямар шалтгаанаар авч байгаа юм бэ гэхээр зээлийг гаргахад гаргасан зардал гэдэг ийм ангилалд бас ороод байдаг юм байна лээ. Тэгэхээр энэ дээр та нэг тодорхой хариулт өгөөч.

Хоёрдугаарт, энэ Монголбанк дээр байдаг зээлийн мэдээллийн сан гэж маш том сан байгаа. Энэ сангийн яг үүрэг ач холбогдол ер нь яг юу юм бэ? Иргэдээс маш олон гомдлууд ирдэг. Үүрэн холбооны сүлжээ нь үүрийн холбооныхоо утасны төлбөрийг төлөөгүй байхад хар жагсаалтад оруулчихсан. Хар жагсаалт гэж ярьдаг болчихсон байна лээ. Тийшээ орсон байна. Үүнээс болоод дараагийн бизнесийн үйл ажиллагаа явуулахад тээг болоод байна. Тэгэхээр энэ дээр яг энэ зээлийн мэдээллийн сангийн үүрэг нь юу юм, ач холбогдол нь юу юм? Тэгээд иргэдэд яг ийм зах зээл савлагаатай байгаа ийм үед бас

бизнесээ цааш нь өргөжүүлэх, тэлэх ийм зүйл дээр бол маш их тээг саад болоод байна гэдэг ийм зүйлийг ярьж байгаа юм. Тэгэхээр энэ 2 дээр би хариулт авъя гэж бодож байна.

С.Одонтуяа: Хэн хариулах вэ? Лхагвасүрэн Ерөнхийлөгч хариулъя. 83 дугаар микрофон.

Б.Лхагвасүрэн: Идэрбат гишүүний асуултад хариулъя.

Үйлчилгээний хураамж энэ шимтгэлтэй холбоотой асуудал байгаа. Нөгөө банкны урт нэртэй хууль гэдэг банк, эрх бүхий этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцооны зээлийн үйл ажиллагааны тухай хуулиараа банк бол ийм үйлчилгээний шимтгэл, хураамж авч болохоор хуулийн зохицуулалт байгаа. Энэнд нь харин ямар хэмжээтэй ийм шимтгэл хураамж байх вэ гэдэг дээр нэлээн бас янз янзын л зүйлүүд байдаг. Тэгэхээр Монголбанкны зүгээс бол нэгэнт ингээд хуулиараа банк авах эрхтэй ийм хуулийн зохицуулалттай учраас харин энэ шимтгэл хураамж нь хэр тооцоо судалгаатай үндэслэлтэй вэ гэдэг дээр нь хяналт тавьж явдаг. Монголбанкны зүгээс 1 хувиас хэтрэхгүй байхаар зохицуулаад журмаар бол журам гаргаад зохицуулсан байгаа. 1 хувиас дээд хэмжээ нь бол 1 хувь байна гээд тэгэхлээр ипотекийн зээл таны хөндөж байгаа тэр асуудал дээр ипотекийн зээл дээр бол 1 хувийн хураамж аваад явж байгаа. Ипотекийн зээл дээр өөр 1 хувийн хураамж байдаг нь тэр нотариатаар батлуулахад бас 1 хувийн хураамж аваад явж байгаа. Ийм 2 нэлээн тийм том дүнтэй хураамж байгаа юм. Тэгээд Монголбанкны зүгээс бол дахиж хяналт шалгалтаа явуулаад 1 хувь гэдэг нь өөрөө хэр тооцоо судалгаатай, үндэслэлтэй вэ гэдэг

дээр нь бас тооцоо судалгаа хийгээд явж байгаа.

Тэгэхээр бол энэ доошоо буурах боломжтой болов уу гэж харж байгаа.

Тэгэхдээ хуулийнхаа талаас бол энд авах эрх нь бол хуулиараа банканд олгогдчихсон байгаа. Яах вэ, надад бол ийм тоо жишээнүүд байна л даа. АНУ-д 0.65, Канадад 1 хувь, Австрали 0.3, Филиппинд 0.5, Вьетнамд 0.95 мөн манайх бол дундаж нь бол Монголынх бол 0.75 байгаа. Одоо тэгээд л Мьянмар гэдэг юм уу 1.1, Индонезын 1 хувь гээд ер нь олон улсад бол энэ өөр өөр байдаг л ийм жишиг зүйл байгаа юм. Тэгэхээр харин хэр их өндөр хэмжээтэй байна, бага хэмжээтэй байна уу, авч байгаа тооцоо судалгаа, үндэслэл нь хэр байна вэ гэдэг дээр л сайн үзэж харах, шалгах ийм шаардлага байгаа даа.

Зээлийн мэдээллийн сантай холбоотой бол Зээлийн мэдээллийн сангийн тухай хууль бол 2011 онд энэ батлагдсан ийм хууль байдаг. Энэ хуулийн дагуу бол зээлийн мэдээллийн санг бол хувийн сектор ажиллуулж болно. Хувийн сектор одоохондоо өнөөдөр манайхаас зөвшөөрөл авсан ийм 2 хувийн компани яг одоо энэ нарийвчилсан тооцоо судалгаа, программ хангамж нь хийгдээд бүрэн үйл ажиллагаа хийгдээгүй байгаа. Энэ хүртэл нь бол Монголбанк зээлийн мэдээллийн сангийн үйл ажиллагааг аваад явж байгаа. Зээлийн мэдээллийн сангийн гол зорилго нь бол санхүүгийн сахилга батыг л хангахад чиглэсэн ийм мэдээлэл байдаг. Нэг банкнаас зээл авчхаад төлөхгүй нөгөө банканд дээрээ бас өөр банкнаас зээл аваад явдаг энэ үйл ажиллагааг л таслан зогсоох. Нэг банканд дээрээ төлөхгүй мөртөө нөгөө банкинд дээрээ сайн үнэлгээтэй байх

ийм зүйлүүд гардаг учраас энийг бол адилхан байлгах үүднээсээ энэ мэдээллийг ингэж цуглуулаад явдаг ийм л хууль, эрх зүйн тогтолцоо байгаа юм.

Тэгэхээр бол зээлийн мэдээллийн сангийн тухай нэгэнт ийм хууль байгаа. Энэ хуулийн дагуу бол зөвхөн банкны зээлээс гадна бусад бас өр төлбөртэй холбоотой мэдээллийг авч болохоор зохицуулчихсан байгаа учраас бол таны нөгөө дурдаж байгаа тэр гар утасны компаниуд юм уу, ус цахилгааны төлбөр тооцоо хийдэг компаниудаас энэ мэдээллүүдийг бол зээлийн мэдээллийн сан дээр бол нийлүүлээд явдаг.

Тэгэхээр энэ өнцгөөсөө энэ үйл ажиллагаа, энэ арга хэмжээнийхээ үүднээс бол энэ мэдээлэл дотор бол зөвхөн банкны зээлээс гадна бусад олон мэдээллүүд ороод явж байдаг.

С.Одонтуяа: Цагаанхүүгийн Идэрбат гишүүн тодруулъя.

Ц.Идэрбат: Зээлийн хураамж гэж яригдаад байгаа зүйл таны сая нэр дурдсан улсуудад ер нь зээлийн хүүгийн асуудал энэ ямархуу байдаг юм бол? Миний ойлгосноор бол хүү багатай улсуудад 1 хувийн хураамж 1 хүртэлх хувь, одоо Америкт 0.75 гээд байна. Ийм зүйлүүд байгаад байна гэж байгаа. Манай хадгаламжийн хүү, зээлийн хүү 2-ын харьцаа бол нэлээн өндөртөө ороод явдаг улсын тоонд байдаг гэж ингэж ойлгодог.

Тэгэхээр энэ зээлийн хураамжийн асуудал хүүний өндөр багаас бас шалтгаалж байна уу, үгүй юу гэдэг дээр би нэг тодруулга авъя гэж бодож байна.

Зээлийн мэдээллийн санг бол санхүүгийн сахилга батыг сайжруулахын тулд хийж байгаа олон арилжааны банкууд дундаас олон зээл авах бололцоог бас сахилга батгүй эрсдэлээс бас давхар хамгаалж байгаа ийм үүрэгтэй юм байна гэж ингэж ойлголоо. Гэхдээ бага хэмжээний цалингийн зээл өөр тийм зээлийн шалтгаанаас болоод зээлийн мэдээллийн санд.

С.Одонтуяа: Хэн хариулах вэ? Тодруулгад Лхагвасүрэн Ерөнхийлөгч. 83 дугаар микрофон.

Б.Лхагвасүрэн: Идэрбат гишүүний асуултад тодруулаад хариулъя.

Тэгэхлээр ерөнхийдөө хүү бол Монгол Улсад өндөр байдаг гэдэг ойлголт бол бас яригдаад байдаг. Яг бас нарийн тооцоод үзэхлээр бол бас тийм өндөр зөрүүтэй байгаа зүйл бол ажиглагдахгүй байгаа. Жишээлбэл, өнөөдөр Монгол Улсад ипотекийн зээл 6 хувьтай байхад, АНУ-д 6.99 хувь буюу манай ипотекийн зээлийн хүүнээс ч өндөр ингээд болчихсон байх жишээтэй. Тэгэхлээр гэх мэтчилэнгээр хүү бол бас яг тийм өндөр нам уу, үгүй юу гэдэг нь одоо харьцангуй ойлголт болоод байгаа юм.

2 дахь асуултын хувьд бол Зээлийн мэдээллийн сангийн тухай хууль дээр бол тэр хувь хүний зээлийн мэдээлэлтэй холбоотой мэдээллийг 6 жил хадгалагдахаар хуульчилсан байгаа. Тэгэхдээ Монголбанкны зүгээс бол ялангуяа таны хөндөж байгаа тэр гар утасны жижиг төлбөр, цахилгаан, дулааны усны төлбөртэй холбоотой зүйлийг бол төлөгдсөн тохиолдолд нь зээлийн мэдээллийн сангаас яг тодорхой хугацаанд хасаад явж

байгаа. Ялангуяа энэ 2022 онд.../минут дуусав/

С.Одонтуяа: Дараагийн гишүүн асуухаас өмнө мэндчилгээ дэвшүүлье.

Улсын Их Хурлын гишүүн Гомпилдоогийн Мөнхцэцэгийн урилгаар Говьсүмбэр аймгийн 5 дугаар сургуулийн ахлах ангийн багш, сурагчдын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Эх орны ирээдүйг бүтээх сурагч дүү нартаа цаашдынх нь сурлагад өндөр амжилт хүсье. Багш сурган хүмүүжүүлэгчдэд мөн ажлын амжилт хүсэн ерөөе.

Одоо Одонгийн Цогтгэрэл гишүүн асууна.

О.Цогтгэрэл: Та бүхэнд өглөөний мэнд хүргэе.

Жил бүрийн уламжлал ёсоор мөнгөний бодлого орж ирээд батлагдах шат руугаа бараг гулсаад гэх юм уу, батлагдах шат руугаа л явж байна л даа. Тэгээд л яригддаг үндсэн сэдвүүд байдаг. Валютын нөөц багаслаа, валютын хани алдагдлаа төгрөгийн хани уналаа, инфляц зорилтот түвшинээс давлаа, тэр мөрийн хөтөлбөрт тусгагдсан сарын 1 хувийн хүү одоо бүх зүйл байхгүй боллоо гэж баахан шүүмжлэл яваад яг ингээд гулсаад л батлагддаг зам руугаа л бас ингээд л явж байна. Энэний цаана тэгээд тодорхой шалтгаан нь тодорхой л байгаа. Төсөв томроод байгаа. Ийм учраас Монголбанканд бодлогын орон зай, бодлогын хүүгээ нэмэхээс өөр орон зай үндсэндээ байхгүй болчихсон. Тэрийгээ бас яг ил тод ч хэлдэггүй, бодлогын хүү нэмнэ гэдэг нь цаана нь бизнесүүдэд мөнгө

очихгүй гэдэг л ганцхан сигналтай нэг ийм л бодлого яваад л батлагдах л тал руугаа л явж байна. Эндээс нэг зүй нь бол, төр нь төсөв нь багасаад мөнгөний бодлогын орон зай гараад эндээс бизнесүүд нь энэ улс орноо босгодог энэ тогтолцоо л энэ улс оронд чинь ил тод хэлээд энэ бодлого руугаа явахаас өөр сонголт, зам уг нь бол байхгүй шүү дээ. Тэгэхээр эндээс зүгээр нэг асуулт л асуух гээд байна л даа.

Энэ төр томорч байгаагийн цаана төсөв томорч байгаа. Төсвийн гадуур зарцуулалтууд их байгаа. Хөгжлийн банк, төрийн өмчит аж ахуйн нэгжүүд гээд баахан зүйл л байдаг. Тэд нар л томроод байгаа. Тэгэхээр энэ төрийн өмчит аж ахуйн нэгжүүд дээр байгаа тоо баримтууд, банктэй холбоотой ганц 2 тоо асуух гэсэн юм.

Яг нөгөө алдартай Хөгжлийн банк дээр төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн 2 их наяд шахуу ч билүү зээлийн мэдээлэл гараад ирсэн. Энэний эргэн төлөлт яг юу болж байгаа вэ? Сая тэр төлөвлөлтийн мэдээнүүд гараад байгаа нь хувийн аж ахуйн нэгжүүдийн төлөвлөлтүүд яваад байх шиг байсан. Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн Хөгжлийн банкны зээлийн эргэн төлөлтийн.

2 дугаар гол асуух гэж байгаа зүйл нь энэ төрийн өмчит аж ахуйн нэгжүүд алдагдалтай мөртөө ашиггүй, үр өгөөжгүй мөртөө ингэж амь тогтоож амьдраад байдаг энэ системийн цаана хаанаас ямар санхүүжилт аваад, ямар шийдвэрүүдээр санхүүжилт аваад яваад байдаг бол. Энэний цаана энийг хэрхэн яаж зүй зохистой зам руу нь оруулах боломж байж болох вэ. Хэдэн их наядаар нь зээл авч авдаг ямар

шийдвэрээр тогтоол шийдвэрээр мэдэхгүй, авдаг, авсан шийдвэрээ авсан зээл нь эргээж төлөгддөггүй, энэний цаана чинь л дахиад Монголбанкны бодлогын орон зай хумигдаж байгааг нь явсаар явсаар учиг чинь бас энд л очиж байгаа шүү дээ.

Тэгэхээр нэгдүгээрт нь энэ дээр мэдээлэл өгөөч.

Хоёрдугаарт нь энэ нүх сүвүүдийг ер яаж хаах ёстой юм. Цаашид энэ дээр яаж ёстой юм. Би бас нэг санал гаргаад ажлын хэсэг дээр уначих шиг болсон. Ер нь энэ төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийг үр ашигтай ажиллахад нь Монголбанк ямар хөшүүрэг ашиглаж болох юм, зөв зүйтэй санхүүжилтийн механизмаар тэжээгдэхэд нь энэ дээр бодлогын ямар өөрчлөлт байж болох юм, тэгээд саяын мэдээллүүд дээр хариулт өгөөч.

С.Одонтуяа: *Лхагвасүрэн Ерөнхийлөгч 83 дугаар микрофон дээр хариулъя.*

Б.Лхагвасүрэн: *Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя.*

Тийм ерөнхийдөө Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүн бол ер нь ойролцоогоор 50-55 их наядын ийм хэмжээнд явж байгаа. Ирэх жилийн дотоодын нийт бүтээгдэхүүнийхээ төсөөллийг бид хэд 54-56 их наяд гэдгээр төсөөлөн хийсэн. Ирэх жилийн төсөв бол 20 их наядар яригдаж байгаа. Тэгэхлээр бол ерөнхийдөө бараг GDP-ийн 40 хувь руу 40-өөс ч илүү хувь руу очиж байгаа. Тэгэхлээр бол улсын секторын хэмжээ бол улам л нэмэгдээд байгаа л даа. Тэгээд яг банкны сектороос улсын секторт гаргаж байгаа зээлийн хэмжээ бол ерөнхийдөө нийт

зээлийнхээ 17 орчим хувь байдаг. Тэгэхээр бол ер нь яах вэ, банкны сектороос бол улсын секторт олгодог зээл нь бол ерөнхийдөө бага байгаа. Хөгжлийн банкнаас бол Хөгжлийн банкны ихэнх дийлэнх зээл нь төрийн өмчит аж ахуйн нэгжүүдэд олгосон ийм зээлүүд л явж байгаа. Тэгэхлээр Хөгжлийн банк өнөөдөр нэгэнт энэ муу зээлтэй холбоотойгоор нэлээн үйл ажиллагаа нь доголдохсон байгаа.

Ялангуяа тэр зээл төлүүлэх үйл ажиллагаан дээрээ өнөөдөр хамгийн гол нь анхаараад явж байгаа учраас бол ойрын хугацаанд буюу Хөгжлийн банкнаас бол ингээж дахиж энэ улсын сектор руу гаргах зээл бол нэг хэсэгтээ гарахгүй байх гэсэн ийм төсөөллийг бол бид хэд хийгээд явж байгаа.

Манай банкны сектороос бас улсын сектор олгодог зээл дээр бол бас нэлээн болгоомжтой хандаад эхэлсэн. Ялангуяа энэ үзүүлэлт өөрөө миний саяын дурдсан 17 хувь гэдэг бол өөрөө бас буурч явж байгаа үзүүлэлт байгаа.

С.Одонтуяа: *Одонгийн Цогтгэрэл гишүүн тодруулъя.*

О.Цогтгэрэл: *Хамгийн гол нь цаашид яг тэр бусад төрийн өмчит аж ахуйн нэгжүүдэд очиж байгаа энэ зээлийг зүй зохистой болгох талд нь Монголбанкнаас ямар бодлогын хөшүүрэг ашиглаж болох вэ. Энэ мөнгөний бодлогод магадгүй юу гэж сууж өгөх ёстой вэ гэдэг л асуулт л даа.*

Хоёрдугаарт нь дахиад тодруулга тэр 17 хувь гэж байгаа дотор яг энэ арилжааны банкнуудаас энэ төрийн өмчит аж ахуйн нэгжүүд нь хэр зэрэг их зээл авдаг юм, энэ дээр ямар дүнгүүд байгаад энэ дээр найдваргүй, найдвартай, сайн муу зээл

гэдэг үзүүлэлтүүд нь хэр зэрэг байдаг юм бол.

С.Одонтуяа: Лхагвасүрэн
Ерөнхийлөгч хариульъя.

Б.Лхагвасүрэн: Цогтгэрэл
гишүүний асуултад тодруульъя.

Ерөнхийдөө төв банкнаас бол энэ банкны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт гэдгээрээ арилжааны банкнуудтай хяналт тавиад явдаг. Арилжааны банкнуудад тавьж байгаа хяналтаас Хөгжлийн банканд тавьж байгаа хяналт маань арай өөр. Яагаад гэвэл Хөгжлийн банкны тухай хууль гээд тусдаа хуультай. Тэр хуулийн хүрээнд бол ер нь Монголбанкны оролцоо юм уу, хяналтын талаар ерөөсөө 2-хон заалт л байдаг.

Нэгдүгээрт бол төрийн, тухайн банкиг хариуцаж байгаа төрийн байгууллагынхан өгсөн захиалга гэдэг юм уу зааврын дагуу хяналт шалгалтыг явуулна. Тэгээд хяналт шалгалтынхаа тайланг тухайн төрийн байгууллагад өгч байна л гэсэн л ийм л зохицуулалт байдаг. Тэгэхлээр бол Хөгжлийн банкны дотоод үйл ажиллагаа хэнд ямар хэмжээтэй, ямар хувийн хүүтэй, ямар салбарт юм уу, хувийн салбар, улсын салбарт ингэж олгох талаар бол Төв банкнаас бол оролцоод байх ийм зохицуулалт угаасаа байхгүй. Тэр хүрээндээ ч гэсэн энэ 2021 оны төгсгөлөөр.../минут дуусав/

С.Одонтуяа: Баагаагийн
Баттөмөр гишүүн асуулт асууя.

Б.Баттөмөр: Мөнгөний
бодлого 2 дахь шат, 2 дахь
хэлэлцүүлгийг нь явж байна. Мөнгөний
бодлогын төсөөллийн хувьд бол

тодорхой бус байдал өндөр бөгөөд сөрөг хандлага 2023 онд нэлээн давамгайлна гэсэн ийм бодолтой байгаа. Тогтворгүй байдал үүсэж, эрсдэл нэмэгдэж байгаа үед 2023 оны мөнгөний бодлогод бол тодорхой тохируулгууд хийгдэж явагдана гэдэгтэй бол санал нэг байна. Ингээд хэдэн асуулт байна.

Нэгдүгээрт нь энэ банкны IPO явж байгаа. Төрийн банкны IPO яваад дуусаж байгаа гэсэн ийм мэдээлэл байгаа. Энэ дээр ямар мэдээлэл байна. Нууц биш бол их тодорхой тийм мэдээлэл өгөөч гэсэн ийм нэг дэх асуулт байна.

Хоёр дахь асуулт, 2023 онд Монголбанк хэдэн тонн алт худалдаж авахаар төлөвлөж байгаа бэ гэсэн ийм 2 дахь асуулт байна.

3 дахь асуулт бол юу вэ гэхээр гадаад өрийн дарамт бол мэдээж инфляцыг өдөөх чухал зүйл гурван ч одоо өрийн бичиг, бондын төлбөр төлнө. Инфляцыг нэг оронтой тоонд багтаана гэж байгаа. Энэ дээр ямар эрсдэл байна гэсэн асуулт байна.

Олон улсын валютын сан Монголд ажилласан. Та бүгд бас Америкт Валютын сангийн хуралд суугаад ирсэн. Валютын сан Монголын 2023 оны эдийн засгийн төлөв байдлыг юу гэж дүгнэж байна, ямар зөвлөгөө өгч байна. Та нар эндээс яаж ажиллая гэж бодож байна гэсэн энэ асуултад хариулаач.

Стекуляц гэж ойлголт байдаг. Ойлголт гэждээ байдаг. 1980-д оны үед үүссэн. Ийм онолын ойлголт л доо. Үйлдвэрлэлийн хэмжээ буураад, бараа бүтээгдэхүүний үнэ өсөхийг стекуляц гэж хэлнэ гэж байгаа юм. Манайд үйлдвэрлэл унасан, бараа

бүтээгдэхүүний үнэ өссөн, эдийн засгийн өсөлт 1.9 хувь байгаа. Өгөөжтэй бус хөдөө аж ахуйн өсөлт, малын хорогдол гээд. Инфляц 14 хувь гээд өгчихсөн 14 орчим байгаа. Төлбөрийн тэнцэл 1 тэрбум долларын хасах алдагдалтай урсгал данс хоёр 2.4 тэрбум долларын алдагдалтай. Он гарснаас хойш ам.долларын эсрэг Монгол төгрөг маань 17.8 хувиар суларсан. Монгол Улсын Засгийн газрын өр 28.7 их наяд төгрөг. Тэгээд өрхийн орлого өсөөгүй ер нь стекуляц Монголд яг бодитой болчихсон юм биш үү. Монголбанкны Ерөнхийлөгчийн хувьд та энийг юу гэж дүгнэж байна. Энэ эдийн засгийн байдлыг.

Дараагийн асуулт бол юу гэхээр зэрэг энэ манай арилжааны банкнууд АНУ-д төвтэй энэ корреспондент банкнуудтай харилцаатай ажилладаг. Миний ойлгож байгаагаар бол 50 орчим банктэй холбоотой байсан. Энэ гаднын банкууд Монголын банктэй байгуулсан корреспондент харилцаагаа тасалж байгаад цуцалж байгаа, гэрээгээ цуцалж байгаа гэсэн ийм мэдээллүүд байгаа. Яг өнөөдрийн байдлаар хэд цуцлах вэ, өнөөдөр хэчнээн корреспондент банктэй харилцаатай байна гэсэн ийм асуулт байгаа.

Төгсгөлийн асуулт бол энэ эдийн засгийн шинжлэх ухаанд валютын ханшийг тогтоохдоо тэнцвэрийг хадгалах гэдэг ойлголт байдаг. Монгол төгрөг он гарснаас хойш америк долларын эсрэг 18.7 хувиар унаж байгаа. Сүүлийн 7 хоногт 12 нэгжээр унаад байна. Та нар яаж тооцож байна? Энэ тэнцвэрийг хангах гэдэг хадгалах гэдгээрээ Монгол төгрөгийн өгөөжийг нэмэгдүүлэх чиглэлээр юу хийж байна?

С.Одонтуяа: Хэн хариулах вэ? Лхагвасүрэн Ерөнхийлөгч.

Б.Лхагвасүрэн: Баттөмөр гишүүний асуултад хариулъя.

Тэгээд 2021 оны 1 дүгээр сард батлагдсан Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан хуулиар системийн нөлөө бүхий 5 том банк бол Хөрөнгийн биржээр дамжиж олон нийтэд нээлттэй хувьцаагаа арилжаалах үүрэг хүлээсэн байгаа. Энэ хүрээнд бол эхний банк буюу Төрийн банк бол сая олон нийтэд нээлттэй хувьцаагаа арилжаа хийлээ. Ямар ч байсан ерөнхийдөө амжилттай болж дууссан. Анх 5 хувиа олон нийтэд арилжаалж байгаа. Тэгээд 20 хүртэлх 3 үе шаттайгаар явах ийм төсөл саналаа бол өгсөн. Энэний дагуу эхнийхээ 5 хувийг ил борлуулсан. Ингээд хувьцааг бол саналын хэмжээнээсээ 300 хувиар 3 дахин өндөр ийм санал ирж, хувьцааны арилжаа бол амжилттай явагдсан. Үнэ бол эхлээд нэлээн өсөөд, одоо ингээд ерөнхийдөө тогтворжчихсон байгаа.

Тэгэхээр одоо дараа нь энэ ондоо багтаагаад дараагийн 2 банк буюу Голомт, Хаан банк бол бас нээлттэй хувьцаа арилжаагаа хийхээр бэлтгэл ажлаа хангаад явж байгаа. Үлдсэн 2 банкиг нь бол 2023 оны эхээр хийхээр болов уу гэсэн ийм төсөөлөлтэйгөөр явж байна.

2023 онд Монголбанкны хувьд бол 20-22 тонн алт авахаар төсөөллөө хийж явж байгаа. Ерөнхийдөө яагаад ийм төсөөлөл ерөнхийдөө ийм тогтвортой байна вэ гэхлээр л одоо энэ ашигт малтмалын хайгуулын лиценз олборлох лицензтэй холбоотойгоор ерөнхийдөө энэ алтны олборлолтын хэмжээ огцом нэмэгдэх ч

юм уу, огцом буурахаар янз янзын мэдээлэл байхгүй байгаа учраас бол бидний хувьд ер нь ойролцоо энэ хэмжээний алтыг л худалдаж авах байх гэсэн төсөөллөө хийгээд явж байгаа. Ирэх 2023 онд бол нэлээн том өрийн төлбөр хийх томоохон хуваарь байгаа. Ялангуяа таны дурдаж байгаа Евро бондын 500 сая доллар бол 5 сард, Гэрээг бондын 500 сая доллар бол 11 сард, Хөгжлийн банкны Самурай бонд бол 12 сард төлөгдөхөөр нийлбэр дүнгээрээ 1.3 тэрбум долларын ийм өр байгаа. Энэ бол нэлээн томоохон өр. Ялангуяа ер нь бол 2023, 2024 он бол өр төлөх хамгийн хүнд жилүүд нь л байгаад байгаа.

Тэгэхлээр Монгол Улсын хувьд бол энэ хэмжээний мөнгийг өөрөө бэлдсэн байх ёстой. Энэ утгаараа бол ийм мөнгийг яаж хэрхэн бэлдэх вэ, зүгээр олон улсын зах зээл дээрээс энийг босгох боломж нь байна уу гэхээр өнөөдрийн энэ ковид энэ олон улсын хурцадмал дайны нөхцөл байдалтай холбоотойгоор ерөнхийдөө олон улсын зах зээл дээр бол хүү маш өндөр түвшинд тогтоогдож байгаа. Тэр утгаараа энийг олон улсын захаас авах юм бол, хүү бол 2 оронтой тооноос доошгүй байхаар ийм өндөр зардалтай ийм зүйл байгаа. Тэгэхээр одоо энийгээ яаж шийдэх вэ гэдэг дээр бол нэлээн нарийн сууж ажиллах ийм зайлшгүй шаардлага байгаад байгаа юм. Таны дурдаж байгаа тэр төлбөрийн тэнцэл бол одоо бас их төвөгтэй байгаа.

Монгол Улсын төлбөрийн тэнцэл сая 3 дугаар улирлын энэ 2022 оны 3 дугаар улирлын байдлаар 1.5 тэрбум долларын алдагдалтай байгаа. Энийг бас л одоо 2023 онд ямар байх вэ гэдэг төсөөллийг хийхэд бол энэнээс бас нэг их тийм дээрдэхээргүй ийм төсөөлөл яваад байгаа. Тэгэхлээр энэ

утгаараа өр төлөх энэ хуваарь байна. Төлбөрийн тэнцэл дээрээ нааштай үр дүн гарахаар ийм сэргэлт байхгүй байгаа учраас ирэх онд ерөнхийдөө нэлээн төвөгтэй байна гэдэг талаасаа Монголбанк нэлээн эерэг, өөдрөг биш байдлаар бол төсөөллүүдээ хийгээд явж байгаа. Стикуляцын хувьд бол стикуляц бол инфляц өндөр, бүтээмж байхгүй буюу дотоодын нийт бүтээгдэхүүн уналттай байх ийм үзэгдэл байгаа. Тэгэхээр бидний хувьд яг өнөөдөртөө Монгол Улсад хэдийгээр инфляц өндөр байгаа ч гэсэн Дотоодын нийт бүтээгдэхүүн өсөлттэй явж байгаа. 1.9 гээд энэ хагас жилээр гарсан үзүүлэлт маань одоо 3.3 хувь болоод өсөөд явж байгаа. Оны төгсгөл рүү энэ хэвээрээ байх юм бол 3-4 хувийн өсөлттэй гарахаар ийм төсөөлөл байгаа учраас яг одоохондоо стикуляци байна гэж үзэхэд бол бас өөр. Өөр нэг зүйл нь гэвэл үйлчилгээний салбар хэрэглээ.../минут дуусав/

С.Одонтуяа: Лхагвасүрэн Ерөнхийлөгчийн микрофоныг нэмж өгье.

Б.Лхагвасүрэн: Баттөмөр гишүүний асуултад гүйцээгээд хариулъя.

Та үйлчилгээний салбар хэрэглээ, хөдөлмөрийн зах зээл дээр нэлээн эерэг тал руугаа өсөлт байгаа учраас бол яг одоохондоо стикуляци үүсэх талаасаа бол харьцангуй гайгүй. Тэгэхдээ мэдээж энэ гадаад нөхцөл байдал, ирэх жил байдал яаж өөрчлөгдөхөөс хамаараад мэдээж стикуляци үүсэх магадлал нь бас байж л байгаа.

Тийм Корреспондент банкттай холбоотой асуудлын хувьд бол ерөнхийдөө 2019 оны 10 сард Монгол Улс олон улсын мөнгө угаах

террозимтэй тэмцэх байгууллагын саарал жагсаалтад орж байсан. Хэдийгээр 6 сарын дотор бол энэ саарал жагсаалтнаасаа гарч чадаж байсан ч гэсэн, яг анх тэр саарал жагсаалтад ороход бол маш олон улсын ялангуяа тэр АНУ өндөр хөгжсөн орнуудын банкнууд бол Монголын банкнуудаас бол энэ корреспондент харилцаагаа бол тухайн үед салгаж байсан. Одоо бол өнөөдөр Монгол улсад манай арилжааны банкууд, бас Америкийн банкнуудтай корреспондент харилцаагаа эргээд сэргээсэн зүйл одоохондоо байхгүй. Тэгэхдээ нэг банкны хувьд бол Худалдаа хөгжлийн банк, Нью-Йорк, Миланы банктай бол корреспондент банкны харилцаагаа сэргээх ажиллагаа бол эцсийн шатандаа ороод ер нь удахгүй сэргээгдэхээр болж байгаа. Тэгэхлээр анхны одоо анх удаагаа энэ 2019 оны саарал жагсаалтаас хойш анх удаагаа ингээж харилцаа сэргээж байгаа тийм зүйл. Тэгээд мэдээж Европын Герман ч гэдэг юм уу, бусад улсын банктай бол ганц нэг банкнууд бол ингээд харилцаа байгаа.

Германы Коммерц банктай, Италийн Юни Кредит банктай ч гэдэг юм уу харилцаанууд бол байгаа. Тэгэхдээ энийгээ бол илүү цаашаа сэргээх тал руу нь Төв банкны зүгээс ч гэсэн бас нэлээн оролцоод Америкийн Сангийн яам руу захиа өгөөд Америкийн банкнуудтай ч гэсэн уулзалт хийгээд энэ харилцаагаа сэргээх тал руу нь дэмжээд захидал өгөөд явж байгаа.

Ханштай холбоотой зүйлийн хувьд бол яах вэ өнөөдөр Монгол Улсын валютын нөөц 2.6 тэрбум доллар буюу импортын 3-4 сарын хэрэгцээг хангах хэмжээнд байгаа. Энэ бол хангалттай тийм сайн хэмжээ биш. Тэгэхээр энийг

нэмэгдүүлэхийн төлөө одоо бүх л бодлого зүйлээ чиглүүлээд явж байгаа. Тэр утгаараа нөөцөө гамнах, нөөцөө бууруулахгүй байх талаасаа Төв банкны бодлого бол ийшээгээ илүү анхаарч байгаа энэ тал руугаа. Тэр утгаараа бол ханишин дээрээ нэлээн чөлөөтэй орхиод явж байна. Яах вэ, мэдээж онолынх нь талаас нь бодох юм бол Монгол Улсын инфляц доллар гэдгээр нь АНУ-ын инфляц энэ 2-ын зөрүүгээрээ тэнцвэртэй ханиш ч гэдэг юм уу тэр ханишийн тооцоолол гарах ёстой.

Тэгэхдээ бидний хувьд бол Америкийн ханиш бол 8.5 хувь, манай ханиш 13.5 хувь гэж бодох юм бол 4 хувийн л зөрөөтэй байхаар байтал одоо долларын эсрэг бол төгрөг маань өөрөө өнгөрсөн оны мөн үеэс жил тутам 18 хувь сулраад явж байгаа нь бол өөрөө яг энэ онолынх нь талаас нь бодох юм бол харин ч чангарах хандлагатай юм шиг. Гэхдээ мэдээж одоо өнөөдөр АНУ-ын долларын өгөөж нь өөрөө бараг 4 хувь руу хүрч байгаа учраас бүх улсын валютын эсрэг Америкийн доллар маш их чангаралттай явж байгаа. Тооцоог ингээд гэх юм бол Монгол төгрөг бол 18 хувь суларсан байхад бол манай төгрөгөөс илүүгээр Европын Евро, Английн фаунд, Японы иень ч юм уу эд нар бол маш их илүү сулралттай явж байгаа нь өөрөө тэнцвэрт ханишийг хадгалахад төгрөг бол бас л илүү сулрах ёстой юм шиг л ийм байдалтай байгаа. Мэдээж Монголбанк бодлогын хүүг 12 болгож байгаа нь өөрөө төгрөгийн өгөөжийг нэмэгдүүлэх л бас ийм давхар зорилготой.

Нэгдүгээрт мөнгөний бодлогыг хатууруулж байгаа мөртөө нөгөө талдаа хадгаламжийн хүүг бас энэ хэмжээгээр өсгөх орон зайг гаргаж өгч байна гэдэг маань төгрөгийн

өгөөжийг энэ талаас нь нэмэгдүүлэх л ийм бодлого явж байгаа гэж ойлгож болно.

С.Одонтуяа: Баттөмөр гишүүн тодруулъя.

Б.Баттөмөр: Төрийн банкны энэ IPO гарах мэдээллийг нууц биш бол нэг иймэрхүү хэмжээнд үр дүнтэй явлаа гэдгээ ард иргэд мэдээлмээр байгаа юм. Одоо надад байж байгаа энэ ард иргэд байгаа мэдээллээр бол юу гэхлээр том хадгаламж эзэмшигч нар нь авчихсан, жижиг хувьцаа эзэмшигч байхгүй гэсэн ийм мэдээлэл байгаа юм. Энийгээ нэгдүгээрт анхаараарай.

Хоёрдугаарт, Монгол Улсын энэ төсөв дээр бол 17 тонн алт авна гэж орж ирсэн. Та нар 22 тонн гэж байгаа юм байна. Би та нартай санал нэг байна. Одоо маш их хэмжээний боломж байгаа шүү дээ. Энийгээ үзээрэй. Корреспондент банкны хувьд бол Монголбанк бодлогын хувьд бол энийг дэмжиж, тэр авч хаясан, гэрээ цуцалсан юмнуудыг дэмжиж хийж өгмөөр байна. Энэ бас нэг дэвшил шүү дээ тийм ээ. Тэр нүүрсэн дээр бол яах вэ өчигдөр Засгийн газраас бас нэлээн томоохон арга хэмжээ авчихлаа. Энэ Оюутолгой төсөл дээр та бүгд Оюутолгой төслийн тэр борлуулалтын мөнгийг Монголоор дамждаг Монголын эдийн засагт яг өнөөдөр чухал шаардлагатай байгаа энэ үед бол энэ ашиглах чиглэлд бас.../минут дуусав/.

С.Одонтуяа: Зочид танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Телуханы Аубакир, Хавдесламын Баделхан нарын урилгаар Баян-Өлгий аймаг болон Улаанбаатар хотын иргэдийн төлөөлөл Улсын Их Хурлын

үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Алс баруун хязгаар нутгийн Казах түмний төлөөлөл болсон та бүхэнд ажлын амжилт хүсэн ерөө.

Манай 3 гишүүн манай Бейсен гишүүн маань бас мэндчилгээ дэвшүүлж байна. Та бүгдийн ажилд ажлын амжилт хүсье. Олон алдартнууд бас энэ төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд харагдаж байна. Та бүхэнд сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

80 дугаар микрофон.

Д.Ган-Очир: Баттөмөр гишүүний асуултад тодруулга өгье.

Системийн нөлөө бүхий банкууд Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орсонтой холбоотойгоор олон нийтийн болох үйл явц бол амжилттай хэрэгжээд явж байна. Төрийн банкны хувьд IPO анхдагч зах зээл дээр амжилттай гаргасан. Бас тодорхой хэдэн тоо хэлчихье гэж бодож байна. Нийт олон нийтээс 22 тэрбум төгрөг татан төвлөрүүлэхээр байсан. Гэсэн хэдий ч захиалга бол 67.3 буюу 41.9 тэрбум төгрөгөөр давсан. Дээрээс нь эндээ бас том хөрөнгө оруулагчид буюу стратегийн хөрөнгө оруулагчид бол 165, жижиг хувьцаа эзэмшигчид бол 7141 нийлээд 7306 хувьцаа эзэмшигчтэй компани болсон. Олон нийтийн компани болсон гэдгийг хэлье. Ханиш бол харьцангуй одоо.../минут дуусав/

С.Одонтуяа: Сайнбуянгийн Амарсайхан гишүүн асууна.

С.Амарсайхан: Монголбанкны Ерөнхийлөгч бол үндэсний мөнгөн тэмдэгт дээр гарын үсэг зурдаг, дэлхийн цөөхөн улсуудын

Монголбанкны Ерөнхийлөгчийн эрхийг эдэлдэг. Гарын үсэг зурдаг үндэсний мөнгөн тэмдэгтийнхээ чанарыг, үнэлэмжийг яагаад хадгалж чадахгүй байна вэ гэдэг асуудал хамгийн түрүүн тавигдах ёстой. Монгол ам.долларын эсрэг Монгол төгрөгийн ханил жил, өдрөөр цаг, минутаар суларч байгаа. Хамгийн сүүлд энэ оны өнөөдрийн байдлаар 18 хувь суларсан. Сүүлийн хэдэн жилүүдэд суларсаар бүр хэдэн зуун хувиар суларсан.

Дээрээс нь энэ төлбөрийн тэнцлийн урсгал ба хөрөнгийн дансны алдагдал энэ жилийн хугацаанд бас 100 гаруй хувиар өмнөх оны мөн үетэй харьцуулах юм бол гарсан байгаа юм. Тэгээд яах вэ, мэдээж одоо мөнгөний бодлого гээд орж ирж байна. Энэ мөнгөний бодлого энэ жилийн орж ирж байгаа мөнгөний бодлогыг бий болсон өмнөх жилүүдийн мөнгөний бодлоготой харьцуулах юм бол харьцангуй нарийн тооцоо судалгаатай, нэлээн чамбай хийсэн, бэлтгэсэн ийм бодлого орж ирж байна гэж үзэж байгаа юм. Гэхдээ цаашаа яах вэ гэдэг том асуулт бий.

Инфляц, төгрөгийн ханишийн сулралын үндсэн шалтгаан бол төсөв худалдаа мөн төлбөрийн тэнцлийн олон жил үргэлжилсэн алдагдал өнөөдөр Монгол Улсын эдийн засгийн чадавч, төлбөрийн тэнцлийн алдагдалд асар их сөргөөр нөлөөлж байгаа. Дээрээс нь Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагаа, мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд ихээхэн хүндрэл учруулж байгаа хамгийн том хүндрэл бол энэ олон жил үргэлжилсэн энэ төлбөрийн тэнцлийн алдагдал, дээрээс нь бүс нутгийн дайн тулаан, хил гааль, тэгээд бараа бүтээгдэхүүний тээвэрлэлт гээд түүнээс үүдсэн инфляцын өсөлтүүд, ханишийн өсөлтүүд явж байгаа.

Тэгэхдээ бид зөвхөн энэ инфляц, төгрөгийн ханишийн үнэ цэнийг экспортод гардаг нүүрс, зэсийн хэмжээгээр үнэлээд байж болмооргүй байгаа юм. Эзэнгүй явж ирсэн энэ төлбөрийн тэнцлийн алдагдлыг хэн, хэзээ хариуцаж, хэзээ эзэнтэй болох вэ гэдэг нэгдүгээр асуудал байна.

Хоёрдугаарт нь Монголын төгрөгийн ханил, инфляцын асуудал ярихаар Америкийн ханил яриад байдаг, хүү яриад байдгаа болимоор байна. 200 жил капитализмаар явчихсан өнөөдөр дундаж цалин сарын 5000 доллар ийм улсын иргэдийн амьдрал, мөнгөний ханил, хүүгийн хувийг жилийн 300 долларын цалинтай Монголынхоо ард түмний ажил амьдралтай жишиж, ингэж тэнгэрээс агаараас юм ярьдгаа болимоор байна. Хэдий болтол ингэж явах юм бэ. Энэ асуудлаа жоохон амьдралд газар дээр хөрсөн дээр бууж, харж дүгнэж шийдвэрлэвэл яасан юм.

Тийм учраас 2 дахь асуудал бол тэр ипотекийн зээлийн асуудал байгаа. Энэ оны 6 сарын байдлаар нийтдээ 110 орчим мянган иргэнд ипотекийн зээл олгосон. Нийт санхүүжсэн 6 их наяд хүүг буулгах, урьдчилгаа төлбөрийг багасгах, дээрээс нь хүртээмжийг нэмэгдүүлэх асуудал яригдаж байгаа. Засгийн газраар удахгүй оруулж хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ. 8 хувийн хүүтэй иргэдийн зээлийг 6 хувь руу оруулах бүрэн боломжтой гэдэг тооцоолол гарсан. Мөн.../минут дуусав/

С.Одонтуяа: Хэн хариулах вэ? Лхагвасүрэн Ерөнхийлөгч. 83 дугаар микрофон.

Б.Лхагвасүрэн: Амарсайхан гишүүний асуултад хариулъя.

Ерөнхийдөө энэ саяын олон улсын хурцадмал нөхцөл байдалтай холбогдуулаад ялангуяа АНУ-ын эдийн засгийн энэ өөрийнх нь дотоод асуудлаас болоод АНУ-ын доллар бол зөвхөн Монголын гэлтгүйгээр бүх дэлхийн бүх валютын эсрэг бол маш их чангарч байгаа. Ялангуяа АНУ-ын бодлогын хүү бол урьд өмнө нь байгаагүйгээр огцом өсөж явж байгаад дандаа 0.75 буюу урьд нь ийм том алхмаар ерөнхийдөө дундаж алхам нь 0.25-аар алхдаг байсан бол дундаж алхаасаа ингээд 3 дахин ихээр сүүлийн 3 удаа огцом алхсан. Энэ нь өөрөө бусад валютуудын эсрэг бол бүх л валютуудыг сулруулахад ингээж нөлөө үзүүлээд явж байгаа юм.

Тэгээд Монгол Улсын төгрөгийн хувьд бол долларын эсрэг ингээд 18 хувь сулраад явж байна. Тэгэхдээ бидний хувьд бол энэнээс илүү сулрах дарамт нь бол ерөнхийдөө бас гайгүй болов уу гэж хараад байгаа. Учир нь юу вэ гэхлээр ерөнхийдөө бусад улсуудын Төв банкнууд ч гэсэн энэ мөнгөний хатууруулж байгаа бодлого дээрээ бас өөрсдөө нэлээн болгоомжтой хандах ёстой гэдгээрээ ярьж байгаа. Ялангуяа АНУ-ын хувьд бол хэрвээ бодлогын хүүгээ хатууруулаад яваад байх юм бол АНУ бол удахгүй нэлээн тийм хямралын шинжтэй болохоор зүйлүүд хараад харагдаж байгаа.

Тэгээд бодлогын хүүгээ цааш нь чангаруулах алхам дээрээ ч гэсэн нэлээн бодолцохоор яригдаж байгаа. Яг манай төгрөгөөс илүүгээр суларсан. Жишээлбэл, 9 сарын байдлаар Японы иень манайхаас илүү 9.9 хувь, Солонгосын вон манайхаас илүү 3 хувиар, Монгол төгрөг маань өөрөө иений эсрэг 9.9 хувь, воны эсрэг 3 хувь, Британийн фаундын эсрэг 2.5 хувь, еврогийн эсрэг 0.6 хувь гээд

чангарчихсан явж байгаа. Энэ нь өөрөө юу хэлж байна гэхээр чангарна гэдэг маань манайхаас илүү эдгээр улсын валют бол сулраад явж байна. Тэгэхээр ерөнхийдөө ханшийг ингээд сулруулах гэдэг нь бол нэгдүгээрт бас энэ тохиргоо гэж Төв банкны зүгээс хардаг. Яагаад гэвэл гаднаас ирж байгаа шокийг эдийн засаг руу орж ирж байгаа шокийг тодорхой хэмжээнд зөөлрүүлэх ийм тохиргооны арга хэмжээ нь энэ ханшаар дамжиж гарч ирдэг. Тэгэхээр энэ утгаараа бол ерөнхийдөө бидний хувьд бол тодорхой хэмжээнд тохиргоо хийгээд явж байгаа гэдэг утгаараа харж байгаа.

Энэ нь өөрөө макро эдийн засгийнхаа тогтвортой, тэнцвэртэй байдалд бол илүү зөв нөлөөтэй болж байгаа. Монголбанк бол энэ төлбөрийн тэнцлийн балансыг жил болгон сар болгон гаргаад явдаг байгаа. Ер нь бол төлбөрийн тэнцлийн балансыг Монголбанкнаас өөр газар хийхгүй байгаа. Эдийн засгийн хөгжлийн яаман дээр бол төлбөрийн тэнцлийн холбоотой ийм нэгж байгуулагдсан. Тэгэхлээр ялангуяа тэр урсгал тэнцэл, худалдааны тэнцэл дээр байгаа алдагдлыг хэрхэн бууруулах вэ гэдэг тал руу нь энэ бодлогын арга хэмжээг бол энэ нэгжээс гаргаад явах байх. Бидний өнөөдрийн манай гаргаж байгаа тэмцлээр бол хэдийгээр худалдааны тэнцэл дээр ашигтай гэж харагдаж байгаа боловч яг үндсэн гэрээгээрээ бол худалдааны тэнцэл 2.5 тэрбум долларын ашигтай гэж гараад энэ нь өөрөө урсгал тэнцэл дээрээ байгаа алдагдалтайгаа алдагдлыг бууруулж байгаа мэт харагдаж байгаа боловч яг жинхэнэ худалдааны тэнцэл маань өнөөдөр 9 сарын байдлаар 117 сая долларын ашигтай ийм тэмцэл байгаа.

Тэгэхээр энэ нь өөрөө юу хэлж байна вэ гэхлээр худалдааны тэнцэл дээрээ бол хэрвээ гадаад худалдаа, ялангуяа экспортынхоо хэсэг дээр манай экспортын 94 хувь нь бол уул уурхайн бүтээгдэхүүн байгаа юм. Тэгэхээр одоо чулуун нүүрс, зэс мөнгөжсөөгүй алт, төмрийн хүдэр гээд цөөхөн нэр төрлийн ийм бараанууд байгаа. Тэгэхлээр эдгээр дээрээ экспортын орлогоо сайн нэмэгдүүлж чадвал худалдааны тэнцэл, төлбөрийн тэнцлийн тэр ашигтай гарахаар ийм тооцоо судалгаа байдаг. Тэгэхлээр энэ тал руугаа л анхаарах ёстой. Урсгал тэнцэл дээрээ мэдээж томоохон алдагдал.../минут дуусав/

С.Одонтуяа: Амарсайхан гишүүн тодруулъя. Амарсайхан гишүүнд тодруулга 1 минут.

С.Амарсайхан: Ер нь бол бид нар бүгдээрээ мэдэж байгаа. Аж ахуйн нэгжүүд орлогогүй болсон, эхнээсээ дамнуурч байгаа. Айл өрх орлогогүй болсон, ядуурал туйлдаа хүрч байгаа. Тэгэхдээ бүх зүйлийг төсвийн орлого, зарлага тэр хоёрыгоо зөвхөн экспортоор харж, нүүрсний зэсийн орлогоор харж, мөнгөний ханшаа тодорхойлдог, мөнгөний бодлогоо тодорхойлдог, ирээдүйгээ хардаг, ийм байж болохгүй ээ гэж нэгдүгээрт хэлж байгаа юм.

Хоёрдугаарт, илүү дорвитой ажиллагааг богино хугацаанд авч хэрэгжүүлмээр байна. Зах зээл рүүгээ чиглэсэн аж ахуйн нэгж дэмжих татварын бодлого, хөрөнгө оруулалтыг татах эрх зүйн орчин, төсвийн алдагдлыг бууруулах, төсвийн бодлого, мөнгөний ханшаа хадгалах мөнгөний бодлого, хөрөнгө оруулалт, аж ахуйн нэгжийн ажлын байрыг нэмэгдүүлэх, зах зээлийг тэлэх хөрөнгө оруулалтын хууль гэсэн ийм багц

асуудлуудаа бид амьдралд ойрхон.../минут дуусав/

С.Одонтуяа: Одоо Цэвэгдоржийн Туваан гишүүн асууна.

Ц.Туваан: Мөнгөний бодлогоо анхны хэлэлцүүлгээ хийж байна. Тэгээд миний хувьд бол энэ төв банкны үйл ажиллагааны зорилгыг бол инфляцыг тогтвортой барих, дээрээс нь энэ Монгол төгрөгийн тогтвортой байдал гэж ингэж боддог л доо. Тэгээд яг мөнгөний бодлого хэлэлцэж байгаа энэ үед Монгол банкныхнаас яг Монголбанкны үндсэн зорилгыг **1, 2, 3** гээд манай ард иргэдэд нэг ойлгомжтойгоор та Ерөнхийлөгч нэг дурдаад хэлээдхээч. Энэ инфляц маань бол мэдээж өндөр болчихсон, бодит инфляц бол бүр 20 гараад явчихсан. Тэр бол тодорхой байгаа. Сүүлийн 6 жилийн дотор валютын хани нэг дахин буюу 100, 200 хувь явчихсан долларын хани. Тэгээд аюул нь юундаа өгөх байна вэ гэхлээр манай улсын эм, бараа бүтээгдэхүүн, хүнсний импортын хамаарал 70 хувьтай байгаа. Бид бүхэн өөрсдөө нөгөө нэг үйлдвэрүүдээ дэмжсэн, бодлого явуулдаггүйн хар гай өнөөдөр энэ дээр ингэж ирж байгаа. Төлбөрийн тэнцэл алдагдалтай байгаа нь энэтэй холбоотой.

Тэгэхээр доллар чангарч долларын хани өсөөд ирэхээр бизнесменүүдэд маш хүнд болж байгаа юм. Тэр нь юу вэ гэхээр гадагшаа нөгөө арилжаа наймаагаа хийх гээд доллар шилжүүлбэ гэхээр банк дээр хязгаар тавиад хаячихсан. Өдрийн л 1000 доллар. 1000 гаран долларын. Саяхнаас мянга гаран болж байгаа байх шиг байна.

Дээрээс нь энэ валютын зээлтэй аж ахуйн нэгжүүд 2 дээр бол үнэхээрийн хүнд тусаж байгаа. Тэгэхээр энэ дээр энэ бодлого дотор чинь одоо ямар зүйл байгаа вэ?

Дээрээс нь энэ сүүлийн жилүүдэд нэлээн валютын албан нөөц овоо байна гээд л яриад байсан. Тэгээд энийгээ маш хурдан хугацаанд нэг дахин бараг бууруулсан шүү дээ. Одоо яг л оновчгүй интервенц хийсэн гэж ингэж харж байгаа. Энэ валютыг чинь олох гэж Монгол Улс бас л жилжингээ махаа идэж, хамаг нутаг усаа ухааж гаргаж олдог шүү дээ. Тэгэхээр энэ дээр энэ интервенцийн бодлого энэ валютын албан нөөц багассантай холбоотой, энэ жилийн мөнгөний бодлого дээр чинь яг ямар одоо бодлого суусан юм бэ гэдэг асуулт.

Банкнуд дээр энэ хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл гээд нэг юм байдаг. 1.2 их наяд даваад явчихсан. Чанаргүй зээл нь 2.5 их наяд даваад явчихсан. Тэгэхээр энэ чинь эргээд энэ банкны салбарын хямрал руугаа явж байгаа юм биш үү? Энийг ер нь Монголбанк, энэ банкнуудын бодлогыг барьж байдаг. Монголбанк энэ дээр яг ямар бодлоготой байгаад байгаа юм бэ? Манай дээр энэ инфляц гээд ярихаар мэдээж энэ инфляцын хамгийн 1, 2, 3 номерын бүтээгдэхүүн гээд бид нар бол мах, гурил, бензин гээд үнэ тогтворжуулах хууль хүртэл батлаад өгсөн шүү дээ. Энэ ер нь ямар шаттай хэрэгжиж байдаг юм бол. Тэгээд энэ хүнсний бүтээгдэхүүнээ бид нар доллароор авдаг. Долларыг нь шилжүүлж өгөхгүй болохоор нийлүүлэлт хомсодно. Нийлүүлэлт багасаад ирэхээр нийлүүлэлтийн гачигдалтай холбоотой энэ эрэлт ихсээд үнэ өсөөд байгаа шүү дээ. Тэгэхээр энэ дээр бас ямар бодлого байгаа юм.

Хамгийн сүүлд энэ Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар хүнсний хангамж, аюулгүй байдал гээд Улсын Их Хурал хөтөлбөр батлаад төлөвлөгөөг нь батлаад ирсэн. Улсын төсөв дээр энэ жил 228 тэрбум төгрөг гээд тавьчихсан. Энэ дээр үнэ бараг 70 хувь нь 138 тэрбум төгрөгийн зээлийн хүүгийн марж төлөх гээд төсөв дээр тусгачихсан. Энэ зээлийн мөнгө нь хаана байна. Энэ яг мөнгө нь хаанаас зээл авагдаад төсвөөр энэ хүүгийнх нь зөрүүг төлнө гэж харж байгаа вэ?. Монголбанк энэ дээр нэг хариулт өгөөч. Энд яагаад Монголбанк оролцохгүй байгаа юм бэ. Ерөөсөө энийг хөтөлбөр батлагдахаас нь эхлээд л нэхээд байсан, оролцож байгаа оролцоо энэ тэр ерөөсөө харагдахгүй байна. Энэ дээр нэг тайлбар өгөөдхөөч. Ийм асуултуудад хариулт авъя.

С.Одонтуяа: Хариултын өмнө зочид танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Дамдины Цогтбаатар, Цэндийн Мөнх-Оргил, Цэрэнжамцын Мөнхцэцэг нарын урилгаар Сүхбаатар дүүргийн 2, 12 дугаар хорооны иргэдийн төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд нийт Улсын Их Хурлынхаа гишүүдийн өмнөөс ажилд нь амжилт, амьдралд нь хамгийн сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Хэн хариулах вэ. Монголбанкны Ерөнхийлөгч Лхагвасүрэн. 83 дугаар микрофон.

Б.Лхагвасүрэн: Туваан гишүүний асуултад хариулъя.

Төв банкны тухай хууль дээр угаасаа “Монголбанкны үндсэн зорилго бол Монгол Улсын үндэсний мөнгөн төгрөгийн тогтвортой байдал, тэгээд санхүүгийн тогтвортой байдлыг хангах замаар эдийн засагт дэмжлэг үзүүлнэ.” гээд шууд Монголбанкны Төв банкны үйл ажиллагааны үндсэн зорилгыг бол тодорхойлсон байгаа юм. Тэгэхдээ энэ заалт маань өөрөө ерөнхийдөө онолын гэдэг юм уу, онолынхоо энэ юмнаас бол жсоохон зөрүүтэй зүйл байгаа юм. Онолын хувьд бол бүх улсын төв банкнууд бол инфляцыг онилно гэдэг. Ингээд онилно гэдэг маань яг тодорхой зүйлийг л онилж байгаа юм. Тэрнээс биш ерөнхий зүйлийг бол онилно гэсэн ийм ойлголт байдаггүй л дээ. Тэр утгаараа уул нь үнийн тогтвортой байдал гэдэг талаасаа ингээд яг явах юм бол яг л бусад улсуудын тэр зүйлтэй л зөв болохоор байгаа юм. Тэгээд тэр утгаараа ер нь бол Монголбанк ч гэсэн нэгэнт л үйл ажиллагаа, зорилго нь энэ тал руугаа л бусад улсын төв банкттай адилхан л явах учраас бидний хувьд бол инфляцыг онилно гэдгээрээ инфляцын зорилтыг б /+-2/ гэдгээрээ л ингээд л онилоод явж байгаа. Өмнө нь бол ерөнхийдөө нэг оронтоо тоо ч гэдэг юм уу, тэр хавьд ч гэдэг юм уу, ингээд ерөнхий онилдог байсан бол одоо бол нэлээн тодорхой, б +-2 гээд. Яагаад ингээд б+-2 гээд явж байгаа юм гэхлээр энэ хэмжээнд барих юм бол макро эдийн засгийнхан ерөнхийдөө тогтвортой байдлыг хангах боломжтой юм байна.

Ялангуяа Монгол шиг жижиг улсын хувьд бол одоо инфляц бол тодорхой хэмжээнд бол бас өндөр байх ийм орон зайтай учраас ийм хэмжээнд нь ингээд бариад явахад бол одоо эдийн засаг өөрөө тодорхой хэмжээний өсөлттэй, тогтвортой

байхаар байх юм байна гэдгээрээ ингээд явж байгаа юм.

Тэгээд 2 дахь асуултын хувьд бол валютын нөөцтэй холбоотойгоор Монголбанк бол тэр интервенц гэдгийг бол яг ханшийг тогтворжуулах маягаар интервенц хийдэггүй. Ерөнхийдөө арилжааны банкууд өөрийн харилцагчийн төлбөр тооцоог хийх үүднээсээ харилцагчийнхаа захиалгаар хэчнээн хэмжээний валютын хэрэгцээ байна гэдгээрээ Монгол банканд бол хүсэлтээ тавиад, 7 хоногтоо 2 удаа ийм дуудлага худалдааг зохион байгуулаад явдаг. Тэгэхээр Монгол банкнаас хэчнээн хэмжээний долларыг нийлүүлж байна гэдгээрээ гадагшаа явж байгаа бүх төлбөр тооцоо хийгдээд явж байгаа. Одоо таны дурдаж байгаа тэр зарим бараа бүтээгдэхүүн буюу 3 бараа бүтээгдэхүүн байгаа. Тэрний нэг нь бол түлш, нефтийн бүтээгдэхүүн байгаа.

Тэгээд нефтийн бүтээгдэхүүн импортлодог компаниудын зүгээс бол ийм хэмжээний нефтийн төлбөр тооцоог хийж, ийм хэмжээний нөөцийг барих шаардлага байна гэдгээрээ захиалгаа банкаараа дамжуулж өгөөд л явж байгаа. Мэдээж Монгол Улсын валютын нөөц тодорхой, ийм хэмжээтэй, хязгаартай учраас бол тодорхой хэмжээ хязгаарт нь барих үүднээсээ Монголбанкны зүгээс яг хүссэн хэмжээгээр нь бол өнөөдөр нийлүүлж чадахгүй байна. Өнгөрсөн оны 5 сард Монгол Улсын валютын нөөц 5 тэрбум доллар руу буюу бараг түүхэн дээд хэмжээндээ хүрч байсан. Тэгээд БНХАУ-ын тэг ковид гэдэг хатуу нөхцөлд тавигдаж, хил гааль хаагдсаны улмаас бол нөөц маань бол тэрнээс хойш ингээд буураад явж байгаа. Тэгэхдээ ингээд нүүрс, бусад

бүтээгдэхүүнүүд маань уул уурхайн бүтээгдэхүүнүүд хэвийн хэмжээнд гараад эхлэх юм бол эргээд хэвийн байдалдаа орох боломжтой гэж бол бидний зүгээс үзэж байгаа. Нийт зээлийн 10.9 хувь нь бол чанаргүй гэсэн ангилал байгаа. Тэгэхдээ өмнө нь бүр энэ чанаргүй зээлийн хэмжээ бүр 14, 15 хувьд ч хүрч байсан үе байдаг. Тэгээд өнөөдрийн энэ хэмжээ бол ерөнхийдөө тийм муу хэмжээ биш гэж харагдаж байгаа.

Олон Улсын Валютын сангийн 4.4 дүгээр заалтын дагуу ч сая баг ирж ажиллаад явсан. Бид нар бас Төв банкны зүгээс ч гэсэн активын чанарын үнэлгээг сая хийж гүйцэтгэсэн байгаа. Тэгээд активын чанарын үнэлгээ хийж гүйцэтгэсний дараа ингээд 10.9 хувьтай байна гэдэг маань өөрөө бол ерөнхийдөө чанаргүй зээлийн хэмжээ бол тийм их муудчихсан, бүр түүхтэй банкны салбарыг... /минут дуусав/

С.Одонтуяа: Нэмээд Лхагвасүрэн ерөнхийлөгчийн микрофоныг нээе. 83.

Б.Лхагвасүрэн: Нэгэнт ингээд активын чанарын үнэлгээ системийн 5 том банканд хийгдсэний дараа ийм үнэлгээ гарч байна гэдэг маань өөрөө бол тодорхой хэмжээнд харин ч сайжирч байна гэж харагдахаар байгаа юм. Тэгэхээр бидний хувьд бол банк санхүүгийн салбар маань өөрөө эдийн засгийг дэмжих хэмжээний өөрийн харьцааны үзүүлэлт сайтай байгаа гэж хэлж болохоор байгаа.

Хууль гарсан 3 бүтээгдэхүүн байгаа мах, гурил, шатахуун гээд ийм АИ 92 гээд. Ерөнхийдөө хууль анх гарахдаа бол Төв банкиг эндээс санхүүжилт хийж мөнгөний нийлүүлэлт хийхгүй шүү гэсэн ийм

хэлбэрээр гарсан. Ялангуяа мах, гурилан бүтээгдэхүүнд. Харин АИ 92 бензиний хувьд бол repo санхүүжилтээр санхүүжилт болно гэдгээрээ. Тэгэхээр бол АИ 92 бензиний хувьд санхүүжилт хэвийн явагдаад, Монгол Улсад энэ нөөц 30 хоногоос бүр 45 хоногийн ийм хангалттай хэмжээний нөөцийг бол бариад явж байгаа. Мах, гурилын хувьд бол ерөнхийдөө Хөдөө аж ахуйн зээлийг бол өнгөрсөн 2021 онд нөгөө Засгийн газрын 10 их наядын хөтөлбөрийн хүрээнд ч гэсэн ингээд тодорхой хэмжээнд олгоод явж байгаа. Одоо ч гэсэн энэ хэмжээгээр бол гараад явж байгаа. Зүгээр энэ эх үүсвэр хаанаас гарах вэ гэхлээр энэ арилжааны банкны эх үүсвэрээр гарна. Тэгээд улсын төсөв дээр бол хүүний хөнгөлөлт маягийн ийм татаасыг суулгаад явж байгаа.

Ялангуяа одоо Засгийн газраас бол гарч байгаа. Ялангуяа махан дээр юм уу, гурилын үйлдвэрт гарч байгаа зээл бол 7-10.65 хувийн ийм хүүний татаастайгаар ингээд гараад явж байгаа. Энэ жилийн махны нөөц бэлтгэл дээр бол банкнууд зээлээ олгоод эхэлчихсэн. Бидний сүүлд авсан мэдээллээр бол 40-50 тэрбум төгрөг бол олгогдоод явж байгаа. Тэгээд оны төгсгөл хүртэл бол энэ цаашаа нэмэгдээд 100 тэрбум руу хүрэх байх гэсэн бидний төсөөлөл байна. Энэ жилийн улаан буудайн үр тариа хураалтын эхний зээлийг бол ингээд банкнуудад олгохоор ярьж байгаа. Тэгээд гурил үйлдвэрлэгчид, банкууд Хүнс, хөдөө аж ахуйн яам Монголбанк бид хэд хамтарсан ажлын хэсгээрээ суугаад ямар хэмжээний хүүтэй, ямар хэмжээний хүүний татаастайгаар гарах вэ гэдгээрээ ярьж байгаа. Тэгээд ерөнхийдөө суурь хүүг нь бол 6 хувь, зээлдэгч маань 6 хувийн хүү, тэгээд саяын таны дурдаж байгаа, тэр улсын

төсөвт суучихсан байгаа хүүний татаас нь 10.65 байхаар ийм хэмжээгээр 100 тэрбум орчим төгрөгийн зээлийг гаргахаар банкууд маань өөрийн харилцадаг аж ахуйн нэгжүүдтэйгээ хамтраад явж байгаа.

С.Одонтуяа: Ерөнхийлөгчийн санаачилга тодруул гэсэн.

Б.Лхагвасүрэн: Ерөнхийдөө энэ геополитикийн хурцадмал нөхцөл байдал нь өөрөө улс болгон өөрийн бие даасан эдийн засгийн хувьд ч гэсэн бусдаасаа хараат бус хүнсний байдлын хувьд ч гэсэн өөрөө өөрийгөө хангаж байх нь зайлшгүй чухал юм байна гэдгийг нэлээн олон улсын нөхцөл байдал харуулж байгаа учраас аль болохоор хүнсний аюулгүй байдал талаасаа хүнсээрээ өөрийгөө бүрэн дүүрэн хангахад чиглэсэн бодлого явуулах ёстой гэдэг ийм улс болгон л ийм бодлогыг барьж байгаа. Монгол Улсын хувьд ч гэсэн энэ ийм зөв зохистой байхаар энэ бодлогыг явуулж байгаа нь бол маш зөв гэдгээрээ Төв банкны зүгээс ч гэсэн дэмжээд явж байгаа. Ялангуяа тэр хаврын газар тариалалтын үеэр бол бид нэлээн ийм дэмжиж ажилласан. Тэгээд яваандаа, ялангуяа энэ гурил, мах, бусад бүтээгдэхүүний хувьд бол өөрийгөө хангадаг. Тэгээд тариалалтаас нь авхуулаад хураалт хүртэл, тэгээд эцсийн бүтээгдэхүүн гурил болтол гартал нь энэ санхүүгийн схем гаргахаар бид нар Хүнс, хөдөө аж ахуйн яамтай ерөнхийдөө схемүүдийг янз бүрийн хэлбэрээр гаргаж байгаа.

Банкны зээл хэлбэрээр явж болно. Векселийг бусад ийм өрийн бичгүүдийг гаргах маягаар төлбөр тооцоог нь хийдэг байхаар энэ бүх схемүүдийг бас хамт зурж байгаа юм. Европын энэ Сэргээн босголт хөгжлийн банк.

С.Одонтуяа: Туваан гишүүн тодруулъя.

Ц.Туваан: Лхагвасүрэн ерөнхийлөгч өө, тэгээд удирдлагын багийнхан танай энэ Төв банкны хараа чинь муу байна шүү. Бууны чинь овоо хараа хөдөлчихжээ. Энэ онилоод байгаа инфляцаа онохгүй байна. Нэг дээр онож болдог инфляц шүү, тэр 6, 8 хувь руугаа онох энэ ажлаа сайн хийгээрэй. Наад инфляц чинь иргэдийн карма тор хоёрыг бол маш их хүнд оноод байгаа шүү. Энэ дээр та бүхэн бол толгойгоо өдөр шөнөгүй ажиллуулж, яах ёстой ажиллах ёстой. 100 мянган төгрөгт авдаг юм гэж ер нь бараг байхгүй болоод байна шүү. Энийг хатуу хэлчихье. Тэр юун дээр 228 тэрбум гээд би тодорхой зүйл асууж байгаа. Энэний чинь цаад талд таны 10.65-аар бодох юм бол 1.3 тэрбум төгрөгийн эх үүсвэр шаардаж байгаа юм. Энэ эх үүсвэрийг чинь мөнгөний бодлого барьж байгаа хүний хувьд хаанаас гаргаж авах юм бэ? Энэ юм чинь тэгвэл эх үүсвэргүй бол агаар дээр хоосон бодлого болоод өнгөрөх юм уу? Энэ дээр нэг тодорхой хариулт.

С.Одонтуяа: Монголбанкны Ерөнхийлөгч Лхагвасүрэн хариулъя.

Б.Лхагвасүрэн: Туваан гишүүний асуултад хариулъя.

Тэгээд яах вэ, инфляцыг онилно гэдэг маань бид нар яг энэ рүүгээ л хурдхан хүрэхийн төлөө л ингээд л онилоод л явж байгаа л даа. АНУ-ын инфляцын зорилтод түвшин 2 хувь, өнөөдөр инфляцын 8.5 хувь. Тэгээд АНУ-ын хувьд бол одоо энийг 2024 ондоо 2 хувь руугаа аваачна гээд л энэ бодлогоо чангаруулаад явж байгаа. Тэрэнтэй адилхан бидний хувьд ч гэсэн аль болохоор 2023 онд нь багтаагаад

оруулчих ийм л зорилготой л явж байгаа. Таны дурдаж байгаа тэр 228 тэрбумын 100 тэрбум нь бол гурил, 130 тэрбум нь маханд зориулалттай байгаа. Тэгэхлээр бол энэ арилжааны банкнаас. Ер нь бол анхны тооцоо нь бол өөрөө тийм байгаа юм. Гурилын үйлдвэрүүдэд 100 тэрбум төгрөг, махны нөөц бэлдэхэд 130 тэрбум төгрөг л гарахаар. Энэ мөнгө бол нэгэнт Монгол банкнаас гарахгүй гэдэг хуультай учраас арилжааны банк гаргахаар, тэгээд арилжааны банк нь ямар нөхцөлд гаргах вэ гэхлээр 6 хувийн хүүн дээр саяын хүү.../минут дуусав/

С.Одонтуяа: Нямаагийн Энхболд гишүүн асуулт асууна.

Н.Энхболд: Би саяынхыг гүйцээгээд Туваанаа асуугаадахъя.

Тэр банкууд гээд яриад байх юм хамгийн сүүлд. Банкуудтай үгүй ээ, банкнууд биш гурилын үйлдвэрүүдтэй гээд. Тариаланчид ногоочид нь яг юу очихоор, яагаад байгаа юм? Тэрийг хариулангаа Тувааны асуултад гүйцээгээд хариулчихна биз.

Энэ инфляц 6-8 гээд ярьж байна. Сая нэг зөвлөгөөн болсон. Энэ санхүүжилт эдийн засагчид, бас мэргэжлийн хүмүүс, эд нар бол Монголбанкны тооцоонд итгэхгүй байна гэсэн юмнууд яриад байсан байна лээ байна лээ. Ер нь бараг 20 хүрнэ энэ тэр гээд. Тэгэхээр энэ дээр яг яагаад тэд нарын бодол тийм байгаа юм бол? Тэрийг нь бас судалж үзсэн үү? Тэгээд мөнгө хэвлэж гаргах уу? Та нар ер нь дараа жилийнхээ энэ төлөвлөгөөнд мөнгө хэвлэж эргэлт оруулах тухай юм ямар нэгэн байдлаар бодсон уу, бодоогүй юу? Инфляцаа доош нь хэмжээнд байлгая гэвэл энэ тухай бодоогүй л байж таарах болов

уу гэж бодоод байх юм. Бас далдуур хийчихсэн байдаг энэ дээр нэг тодорхой хариулт өгмөөр байна.

Танилцуулга, материал дотор ийм зүйл байна. Хөрвөх чадвар сайтай активыг нийт өр төлбөрт нь харьцуулсан нөгөө түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт гээд байдаг шүү дээ. Тэр нь 35.5 байна гэж байна. Дээр нь банкнуудын орлого 22 хувиар нэмэгдсэн гэсэн ийм 2 тоо байна.

Тэгэхээр тэр эхний 35.5 гэдэг чинь одоо хэр зэрэг найдвартай байгааг харуулж байна уу? Яаж байна. Тэрэн дээр нэг олон нийтэд ойлгогдохоор хариул.

Хоёрдугаарт нийт банкны системийн орлого 22 хувь байж байдаг. Гэтэл иргэдийн орлого, өрхийн орлого, худалдан авах чадвар, бодит орлого бүгд доошоо буурчихсан, эдийн засгийн өсөлт дөнгөж 1.5, 1.6-хан хувьтай гарах гэж байгаа ийм нөхцөл байдал байна. Энэ ер нь хэр зэрэг зохистой үзэгдлүүд бэ? Банкнууд нь хорин хэдэн хувийн ашигтай байгаад байдаг, улсынх нь эдийн засаг, хүмүүсийнх нь орлого, зарим нь бүр унасан, зарим нь дөнгөж нэг юм амьтай төдий байгаад байдаг. Хэр түгээмэл үзэгдэл вэ? Бусад оронд ямар байдаг юм? Энэнтэй уялдуулаад өр төлбөрийн асуудал хойтон жил, тэрний хойтон жил маш өндөр хэмжээнд яригдана. Өрөө төлөх гэж улс орнууд янз бүрийн арга хэмжээ хэрэглэж байсан. Банкнуудаа энэ тал дээр уриалдаг, оролцуулдаг хувийн банкнууд, арилжааны банкнуудыг ийм боломж байна уу? Тэр их өндөр орлоготой байдаг юм бол хэтдээ гадаад өрийн дарамт бага болсон үед та нарын энэ мөнгийг чинь буцааж өгнө гэдэг маягаар ч юм уу, гэрээ хэлцэл ярилцлага хийгээд та нар улсын

гадаад өрийг дарахад бас тодорхой хэмжээгээр ашиг орлогоосоо зарцуулж оруулах ийм бололцоо байна уу? Тийм практик байдаг уу ер нь. Тийм боломж банкуудтай ярьж байгаа юм байна уу? Хүн бүр байгууллага бүр л энэ дээр тал талаасаа анхаарч байж энэний ард гарна уу гэхээс зүгээр л ганцхан засаг юм уу, зөвхөн банк руу чихээд байх хэцүү шүү дээ.

Би ингэхдээ ер нь банк бол итгэлийн байгууллага, их орлого олж байгааг нь муулах талаас нь биш үнэхээр эдийн засаг ийм байдалтай үед ингэж, ингэж орлого олоод байгаа юм бол 22 хувь хувийн орлого өснө гэдэг чинь бол бас нэлээд хэмжээний тоо гэж бодоод байна. Энэ яагаад хувь нэмрээ жишээ нь оруулж болдоггүй юм бэ? Боломж практик байдаг уу, ярьсан уу? Нэг ийм асуулт байна. Тэгээд дараа нь тодруулъя.

С.Одонтуяа: Хариултын өмнө мэндчилгээ дэвшүүлъя.

Улсын Их Хурлын гишүүн Жигжидийн Батжаргал, Нямаагийн Энхболд, Цэвэгдоржийн Туваан нарын урилгаар Төв аймгийн Мөнгөнморьт сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Иргэдээ ажилтай, орлоготой, эрүүл аюулгүй орчинд ажиллаж амьдрах хариуцлагатай энэ үүрэгт ажилд нь амжилт хүсье. Нийт Улсын Их Хурлын гишүүдийнхээ өмнөөс амжилт хүсье.

Хэн хариулах вэ? 83.
Монголбанкны Ерөнхийлөгч
Лхагвасүрэн.

Б.Лхагвасүрэн: Энхболд гишүүний асуултад хариулъя.

Тэгээд ерөнхийдөө 2022 оны би зүгээр тоонуудыг бас дурдаж байна. 2022 оны 8 дугаар сарын байдлаар Хөдөө аж ахуйн малчдыг дэмжих зээл, ноолуур бэлтгэл, газар тариалан, махны нөөц бүрдүүлэх, улаан буудай, тосны ургамал худалдан авах, гурил тэжээл, ургамлын тос, төмс, хүнсний ногоо тариалах арьс шир бэлтгэл, ноос бэлтгэл гээд нийтдээ бол 22 мянган зээлдэгчид 751 тэрбум төгрөгийн зээл олгочоод байгаа юм. Тэгэхлээр бол яг таны тэр хэлж байгаа тэр хаврын газар тариалангийн үеэр бол яг одоо хувиараа ногоо тарьдаг, тэр иргэдэд зориулж Төрийн банкн дээрээс бол тусгайлан ийм зээлүүдийг гаргасан. Яагаад энэ зээл гаргасан бэ гэхлээр яг л хүнсний өөрийн бие даасан байдлаа хангах, ялангуяа тэр хүнсний ногоог нэлээн тарьж ургуулахад нь дэмжлэг үзүүлэх зорилгоор л ингээд зээл олгосон. Энэ жилийн хувьд бол яг зорилтот бүлгээрээ. Тэгэхээр бидний хувьд бол нөгөө тарихад нь эх үүсвэрийг нь гаргаад борлуулах асуудал дээр нь бол тэгээд л банк ч юм уу, Төв банкнаас бол орох оролцоо ч гэж байхгүй л дээ.

Ерөнхийдөө 2 дахь асуултын хувьд бол мөнгөний нийлүүлэлт бол өмнөх онтой харьцуулахад бол 1.7 хувиар буурчхаад байгаа юм. Тэгэхлээр бол бидний хувьд мөнгө хэвлэх юм уу, мөнгө нийлүүлж нэмэгдүүлэх гэдэг ийм бодлого бол байхгүй. Яагаад гэвэл инфляц ийм өндөр байгаа, хани өөрөө сулрах ийм дарамттай байгаа энэ үед бол илүү мөнгөний нийлүүлэлтээр тэрийг нь урамшуулж өөгшүүлэхгүй гэдгээсээ ингээд л ийм байгаа юм. Тэгэхээр таны асууж байгаа тэр нарийн төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт гээд 35 хувь. Энэ бол жишээлбэл, нийт арилжааны банк дээр Төв банкны үнэт цаасан дээр 3.9

их наяд төгрөг байж байна. Тэгэхлээр бол нийт хэчнээн хэмжээний эх үүсвэрийг татсан бэ. Тэрнээсээ хэдэн хувийг нь яг өнөөдөр гаргахад бэлэн хэмжээнд хадгалж байна гэдэг нь л энэ төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт л дээ, 35 хувь. Тэгэхээр бол энэ зүгээр дэлхийн дундаж ч юм уу, олон улсын жишиг бол 25 хувь байдаг. Тэгэхлээр банк одоо төлбөр түргэн гүйцэтгэх чадварын хувьд бол ямар ч асуудалгүй байгаа гэж хэлж болно.

Тэгээд мэдээж энэ нөхөх бодлогын хүү өсөж байгаа, дэлхий даяараа хүү өсөж байгаа учраас бол олон улсад энэ банкны ашиг орлого бол нэмэгдэж байгаа л даа. Дэлхийн олон улсад. Тэр утгаараа олон улсад бол томоохон банкнуудын тэр хувьцааны үнэ хани байнга өсөөд явж байгаа. Тэгэхлээр орлого бол нэлээн өндөр байгаа юм. Яагаад гэвэл хүү өсөөд байгаа учраас. Бодит орлоготой холбоотой яах юм бол инфляц өнөөдөр ингээд 13-14 хувийн хооронд байна. Бодит цалингийн орлого өнөөдөр цалин яг энэ хэмжээнд өсөж байна уу гэдэг тооцоогоор нь бид нар тооцоогоо хийгээд явдаг. Тэгэхээр цалингийн хувьд бол энэ хэмжээнд өсөөгүй байгаа учраас арай гүйцэхгүй гэдгээрээ хасах. Зүгээр өрхийн бодит орлого талаасаа бол бусад нөгөө халамжийн бодлого, бусад орлогуудаараа бодох юм бол ерөнхийдөө тийм бууралттай биш байгаа. Тэгээд энэ өрхийн бодит орлого өөрөө бууралттай биш байгаа учраас хэрэглээ талдаа бас өндөр байгаа.

Ер нь өрхийн хэрэглээ бол нэлээн өсөлттэй гараад байгаа. Ялангуяа цахилгаан бараа.

Мэдээж хэрвээ төр, төр өөрөө энэ өр төлбөрийг нь тооцох дээрээ банкнаас мөнгө зээлэх асуудал бол

нээлттэй л дээ. Чөлөөтэй. Тэгэхээр ялангуяа өнөөдөр байгаа нөхцөл байдал юу байна гэхээр Монгол Улсын тодорхой хэмжээний бондууд, Хөгжлийн банкны бонд, манай Монгол Улсын Засгийн газрын өөрийнх нь бондуудын хүүний зөрүү нэлээн нэмэгдчихсэн бүр 20 гаран хувьтай болчихоод байгаа юм. Тэгэхлээр энэ дээр бол ялангуяа манай арилжааны банкууд нэлээн орж тэр улсын өрийг олон улсын заххаас бас худалдаж авах ийм зүйл ажиглагдаад байгаа юм. Тэгэхлээр энэ нь өөрөө юу хэлж байна вэ гэхлээр бидний хувьд бол гаднын хөрөнгө оруулалт.../минут дуусав/

С.Одонтуяа: Нямаагийн Энхболд гишүүн тодруулъя.

Н.Энхболд: Хэрэв нууц биш бол арилжааны банкнуудын 2022 оны ашигийн өсөлтийн хэмжээ, тоо нэрээр нь авч болох уу? Тэрийг өгөөдхөөрэй. Тэр Туваан гишүүний. Би ч бас давхар сонирхож байгаа юм тэр асуултын хариуг.

С.Одонтуяа: Эхэлж хариулж байгаа хүмүүс нэрээ албан тушаалтайгаа хэлээд хариулаарай. 84. Хариулах гэж байна уу?

А.Энхжин: Монголбанкны Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газрын захирал Энхжин.

Туваан гишүүний асуултад хариулъя.

Тэгэхээр ирэх жилийн улсын төсөвт суусан татаасыг ерөнхийдөө ашиглаад банкны эх үүсвэрээр Хөдөө аж ахуйн салбарт зээл олгоно гэсэн төлөвлөгөөтэй байгаа. Тэгэхээр 228 тэрбум төгрөгийн татаас ойролцоогоор таны хэлдгээр 1.3 их наяд төгрөгийн зээлийн эх үүсвэр

гарна. Энийг дийлэнхийг нь ерөнхийдөө банкны эх үүсвэрээр, ирэх жилийн эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалаад шаардлагатай үед Монголбанкны репо санхүүжилтээр бас дэмжээд явна л гэсэн төлөвлөгөөтэй.

С.Одонтуяа: Сайнхүүгийн Ганбаатар гишүүн асуулт асууна.

С.Ганбаатар: Бид хүнд байдалд орчихсон. Тэгээд бүр анх ер нь энэ Монголбанк ямар зорилготой, яаж байгуулагдсан юм бэ гэдэг талаар би товчхон ярья. Монголбанкны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1-д нь “Монголбанкны үндсэн зорилт нь үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгийн тогтвортой байдлыг хангахад оршино” одоо бол тогтворгүй болчихсон. 3500 гарчихсан гээд би ойлгож байгаа. Энэ бол аймшигтай тогтворгүй. 21.4-т “Монголбанк валют худалдан авахдаа төгрөгийн тогтвортой байдлыг хангана” гэж байгаа юм. Үгүй ээ, тогтвортой доод түвшин гэж урьд нь өмнөх хуульд байсан санагдаад байх юм. Тэгээд бүр одоо бол бүр яг тогтооно гэсэн 22.2-т “эдийн засгийн тэнцвэрийг хангана” гэж байгаа юм. Огт тэнцвэргүй болсон. Тэгээд Үндсэн хуульд бол ер нь “төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг бүх хувийн хэвшил, хүн амын эдийн засгийг зохицуулна” гэж заасан. Төр зохицуулалт хийгээд чадахаа больчихлоо.

МАН эрх баригчид эдийн засгийн зохицуулалтаа бүр огт хийж чадахаа болилоо. Үндсэн хуулийн 19 дүгээр зүйл дээр “төрөөс хүний эрх, эдийн засгийн баталгааг бүрдүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэж байгаа юм шүү. Хүлээнэ гээгүй, одоо хариуцлагаа үүрэх цаг болсон. Энэ дээр би Монгол банкиг буруутгамааргүй

байна. Монголбанкны заалтууд дээр хэд хэдэн заалт дээр ерөөсөө байнга хэлж байгаа нэг их олон 7 давтагдсан. Ерөөсөө одоо бид дийлэхээ болилоо. Бидний хяналтаас гарлаа. Монголын мөнгөний бодлогын үндсэн хэрэгсэл болох бодлогын хүүгээр нийлүүлэлтийн хязгаарлалтыг бууруулж, зардлын өсөлтөөр өдөөгдсөн инфляцыг удирдах боломжгүй болчихлоо. Дандаа ингэж хэлж байгаа. Одоо энийг бүр 7 удаа давчихсан байгаа.

Дараа нь бол эдийн засгийн бусад оролцогчдын үүрэг чухал юм. Тэр үүргээ биелүүлэхгүйгээс болж бид ингээд ийм хүнд байдалд орчихлоо гэдгийг аягүй олон удаа давчихсан. Тэгээд энэ бусад оролцогчид гэж ийм бөөрөнхий үгээр хэлэхгүйгээр энэ ирэх жил дахиад л яг ингээд яриад сууж байна. Бусад оролцогчдоос болж бид ийм тэнэг байдалд орчихлоо. Бусад оролцогчдоо одоо тодорхой болгоё. Энэ дээр 6 зүйл заасан байгаа юм. Эзэн нь тодорхой хоёрхон заалт байгаа юм. Иргэд олон нийтийн санхүүгийн суурь мэдлэг, сахилга бат муу байгаагаас болж ийм боллоо 6 дугаар заалт нь.

Дараагийн заалт нь хөдөлмөрийн бүтээмж, ажиллах хүчний ур чадвар муу байгаа учраас ийм боллоо. Ард иргэд хөдөлмөрийн бүтээмжгүй учраас бид ийм байдалд орлоо гэж ийм 2 эзэнтэй юм ярьж байгаа юм. Бусад нь гадаад худалдаа болон гадаад шууд хөрөнгө оруулалтын бодлого алдагдсан. Хэн юм, энэ чинь. Гадаад Харилцааны яамыг яриад байгаа юм уу. Оюун-Эрдэнийг ярьж байгаа юм уу. Эзэн биетэй байя. Одоо энэ чинь Улсын Их Хурлын тогтоол батлах гэж энд бид сууж байгаа шүү дээ.

Дараа нь олон тулгууртай болгон төрөлжүүлэх хэрэгтэй байна.

Энийгээ хийж чадахгүй байна. Оюун-Эрдэнэ юм уу, Хүрэлсүх юм уу, Занданшатар юм уу, яг эзэнтэй бай л даа. Энэ дээр хэн юм. Тэгээд би та нарт тодорхой хэлэх гээд байгаа зүйл гэвэл 8 тогтоолын заалт байгаа. 2 нь л шинэлэг зүйл байна. Бусад 6 нь та нарын хийдэг, өдөр тутам хийдэг ажлаа биччихсэн байна энэ дээр. Хоёр заалт нь 4 дүгээр заалт, уул уурхайн экспортыг нэмэгдүүлэх нэг заалт байна. Орон сууцны ипотекийн нэг заалт байна. Засгийн газарт өгнө гэсэн. Шинэ юм ерөөсөө 2-хон орж ирсэн. Тэгэхээр энэ дээр миний хэлэх гээд байгаа зүйл гэвэл 2 асуулт.

Нэгдүгээрт энэ ард иргэд энэнээс чинь болж хохирчихлоо. Худалдан авах, ялангуяа бага, дунд орлоготой иргэд, цалин тэтгэвэр нь энэ Засгийн газрын болон Монголбанкны хамтын үйл ажиллагаанаас болоод хохирчихлоо. Та нар хариуцлагаа үүрнэ гэж Үндсэн хуулийн 17 дээр заачихсан байгаа. Яаж үүрэх вэ? Би коли кола гээд л алдартай яриад байдаг. Байнга ярьдаг. Амьжиргааны өртөгтэй уялдуулж, ард иргэдийн цалин хөлс, тэтгэвэр дээр нэмэгдүүлэлт өгөх үүрэгтэй энэ хариуцлагаа үүрэх ёстой. Яаж өгөх вэ?

2 дугаар зүйл доллароор ч биш дээ. Ер нь зээл авсан компаниуд, ялангуяа доллароор валютаар авсан компани.../минут дуусав/

С.Одонтуяа: Хэн хариулах вэ? Монголбанкны ерөнхийлөгч Лхагвасүрэн. 83 дугаар микрофон.

Б.Лхагвасүрэн: Ганбаатар гишүүний асуултад хариулъя.

Тэгээд энэ төрийн мөнгөний бодлогын 2023 онд баримтлах үндсэн

чиглэлээр 2 ийм хэсэг төсөл өргөн барьсан байгаа. Нэг нь бол мэдээж 2023 онд төрийн мөнгөний бодлогын үндсэн чиглэлийн хүрээнд Монголбанк дангаараа юу хийх вэ гэдэг энэ манай үндсэн чиглэл байгаа. Хавсралтаар батлагдаж байгаа. Өөр нэг зүйл нь гэвэл бид төрийн бусад байгууллагатай буюу Засгийн газар, Санхүүгийн зохицуулах хороо төрийн байгууллагатай хамтарч хийх ажил. Энэ нь Монголбанк дангаараа бол энд өөрөө оролцох хуулийнхаа хувьд ч гэсэн эрхгүй. Энэ ажлыг мэдээж эдийн засгийнхаа тогтвортой байдал, цаашидын зөв хандлага, тогтворжилтыг бий болгох үүднээс энэ ажлыг нэн тэргүүнд хийх зайлшгүй шаардлага байна гэдэг үүднээсээ ийм Ганбаатар гишүүний дурдаж байгаа 8 заалтыг бол ингэж оруулж өгсөн.

Ялангуяа тэр эхний 3 заалт бол гадаад төлбөрийн чадварыг сайжруулах, гадаад худалдаа, тээвэр ложистикт үүсэж байгаа гээд. Тэгэхээр ээвэр ложистикт үүсэж байгаа асуудал бол Монголбанк бол өөрөө очоод шийдэх асуудал биш учраас ямар хэмжээний тээвэр ложистикийн саатал юм уу, ямар хэмжээний зардал, ямар хэмжээний гацаа байгаа учраас энэ нь өөрөө түүхий эдийн үнэ, бараа бүтээгдэхүүний үнэд энэ нийлүүлэлтийн буюу тэр зардлаараа дамжиж орж ирж нөлөөлөөд байна гэдгийг нь багасгах үүднээс энийг яаж хамт хэрэгжүүлбэл зөв вэ тэгвэл инфляцыг яаж нам дор түвшинд хэр хэмжээнд нь аваачиж чадах юм бэ?

Хоёрдугаарт, мэдээж гадаад худалдаагаа нэмэгдүүлэх буюу манай тоо хэмжээ нь бол их ойлгомжтой л доо. Мэдээж зэсийг бол манай 2 л үйлдвэрлэгч хийж байгаа. Оюутолгой, Эрдэнэт гээд. Энэ 2 үйлдвэрийн хүчин

чадал бол бас мэдээж хэмжээ хязгаартай. Энэ хэмжээнийхээ орлогыг олоод ирж байх юм бол энэ нь өөрөө импортынхоо хэр хэмжээний худалдан авалтыг хангаж чадах юм бэ гэдэг талаас нь бодоод худалдааны тэнцэл төлбөрийн тэнцэл талаасаа яаж сайжрах вэ, яаж нэмэгдүүлж болох вэ, гарц бололцоо юу байна гэдгийг бас энэ дээр заачхаж байгаа юм.

Өөр нэг зүйл нь гэвэл мэдээж тэр хамгийн гол нь тэр төсөв мөнгө, санхүүгийн бодлогын уялдааг хэрэгжүүлэх гээд мөнгөний бодлого нь хатуу байхад төсөв тодорхой хэмжээнд, тэр хэмжээнд нийцтэй маягаар бас хатуу байвал бидний хүрэх үр дүн ойрхон байх юм байна. Цаг хугацааны хувьд наашилах юм байна. Үр дүн маань өөрөө илүү их өндөр үр дүн нь нэмэгдэж гарах юм байна гэдэг талаасаа л эдгээр заалтуудыг мэдээж оруулж өгсөн. Тэгэхээр энэ утгаараа ийм л зүйл байгаа юм.

Тэгээд мэдээж энэ инфляцыг нам доор түвшинд бушуухан аваачих нь макро эдийн засгийн тогтвортой байдлыг бий болгоно. Макро эдийн засгийн тогтвортой байдал бий болсноор хувийн сектор маань өөрөө орчны хувьд бол бизнесийн үйл ажиллагаа тэлж томрох, тэр орчин нь сайжирна гэдэг өнцгөөсөө л эдгээр заалтуудыг л ингэж оруулж өгч байгаа л даа. Тэгээд мэдээж энэ Улсын Их Хурлын тогтоолоор батлагдах учраас ингээд Засгийн газарт, Монгол банканд, Санхүүгийн зохицуулах хороонд гээд даалгавар маягаар орж ирээд явж байгаа.

С.Одонтуяа: Ганбаатар гишүүн тодруулъя.

С.Ганбаатар: Яах вэ нөгөө төр хариуцна гэж байгаа шүү дээ энэ чинь. Монголын ард түмэн 76 биднийг сонгочихоод л хариуцлага тооцно. Монголбанкны Ерөнхийлөгч Лхагвасүрэнг Монголын ард түмэн сонгоогүй, Оюун-Эрдэнийг Монголын ард түмэн Ерөнхий сайдаар сонгоогүй. 76 сонгосон. 76 бол ард түмнээсээ сонгогдсон. Тэр утгаараа бид хариуцлагаа үүрэх үүднээс та нарт надад хэлээд байна шүү дээ. 6 зүйлийн 2 нь надад тодорхой байна. Иргэд буруутай юм байна гэж ойлголоо та нар. Тэгээд 4 дээр нь аль яам юм? Аль газрын аль агентлагийн, аль Ерөнхий сайдын яг хэн юм гэдэг дээр энэ чинь эзэн биетэй баймаар байна шүү дээ. Хариуцлагатай баймаар байна. Энэ гарч байгаа юм чинь дараа жил ярихад эзэн биетэй хэн хариуцах гээд байгаа юм. Ямар ч байсан Монголбанк биш шүү гэдгээ хэлчихлээ. Тэгээд хэн хугацаатай эзэнтэй үүрэг өгье л гэж би яриад байна шүү дээ.

Хоёрдугаарт, миний асуулт дээр ард иргэдийн орлого, төрийн буруутай үйл ажиллагаанаас болоод хохирчихлоо. Тэтгэврийнх нь 40 хувь нь алга болчихлоо. Хэн хариуцлага үүрэх юм бэ? Яаж үүрэх юм бэ?

С.Одонтуяа: Хэн хариулах вэ? Гишүүдийн асуултад тодорхой хариулна шүү. Монголбанкны Ерөнхийлөгч Лхагвасүрэн.

Б.Лхагвасүрэн: Ганбаатар гишүүний асуултад тодруулъя.

Тэгэхлээр өнөөдрийн энэ цаг үе, өнөөдрийн энэ цаг үетэйгээ нийцэж гарч байгаа энэ тоо, статистик, үзүүлэлтүүд бол яг л одоо цаг үеийнхээ л илрэл болоод байгаа юм л даа. Үнэхээр тэр ковидгүй байсан, эс үгүй бол энэ олон улсын хурцадмал нөхцөл

байдал үүсээд, шатахуун, эрчим хүчний үнэ ингээж их дэлхийн зах зээл дээр, дэлхий даяар үүсээж байгаа бүх улсад энэ инфляц бий болчихсон байгаа энэ цаг үед бол Монгол Улс дангаараа өөрөөр байна гэдэг зүйл байхгүй л болчихоод байгаа юм л даа. Одоо АНУ-ын инфляц 8.5 хувь, одоо Европын холбооны инфляц бүр 10 хувь, ялангуяа Европын холбоон дотор хамгийн том эдийн засагтай, хамгийн хүчирхэг гэж хэлдэг эдийн засагтай Герман улсын инфляц өнөөдөр 10.1 хувь гээд явж байгаа. Инфляц бол зөвхөн нэг улсад хамаатай биш, бүх улсад хамаатай болчихсон.

Ялангуяа Монгол улс шиг өөрөө үйлдвэрлэдэггүй энэ газар манай хэрэглээний сагсны.../минут дуусав/

С.Одонтуяа: Хэн хариуцлага үрэх вэ? Хэн юм бэ? Хэн хариуцлага хүлээх вэ?

Энд тодорхой хариулах уу? Одоохон Ганбаатар гишүүний асуултыг дуусгаадахъя. Ажлын хэсгээс хариулж болно. Бас гишүүдээс нэрээ албан тушаалаа хэлээд 81 дүгээр микрофон.

А.Энхжин: Ганбаатар гишүүний асуултад тодруулъя.

Төрийн мөнгөний бодлогын үндсэн чиглэл өргөн баригдахдаа Монголбанк дангаар хэрэгжүүлэх, Засгийн газар, Санхүүгийн Зохицуулах хороотой хамтарч хэрэгжүүлэх гэсэн 2 тусдаа бүлгээр өргөн баригдсан байгаа. Та эхний нөгөө 7, 8 Засгийн газартай, Санхүүгийн зохицуулах хороотой хамтарч хэрэгжүүлэх 8 зорилтын хувьд бол тодруулга хүсээж байна. Эхний тэр нөгөө санхүүгийн боловсролыг дээшлүүлэх гэдэг нь санхүүгийн боловсрол муу байгаагаас болоод асуудал хүндэрчихлээ гэсэн

агуулгатай биш. Цаашид энэ иргэд, аж ахуй нэгжүүдийн санхүүгийн боловсролыг сайжруулах шаардлага байна. Банк санхүүгийн системийн үйлчилгээ өөр түвшинд очиж байна. Эдийн засгийн бүтэц өөрчлөгдөж байна. Дижитал болж байна. Энэ бүх зүйлээр нь сайжруулах ёстой юм байна гэж энийг тасралтгүй хийж байх ёстой юм байна гэдэг агуулгаар орж ирсэн. Нөгөөдөх нь болохоор Засгийн газар эдийн засагт үүсээд байгаа гол хүндрэл бол энэ 8 заалт дээр бол тусгагдсан.

Нэгдүгээрт нь тээвэр логистикийн асуудал байна. Валютын орох урсгалын асуудал байна. Төлбөрийн тэнцлийг сайжруулах асуудал байна. Төсөв мөнгөний уялдааг.../минут дуусав/

С.Одонтуяа: Одоо Цэндийн Мөнх-Оргил гишүүн асуултаа асууна.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа. Энэ нэлээн олон асуудал давхацчихлаа. Би тэгээд зүгээр 2 юм л асуух гэсэн юм. Санал хэлэх гэсэн юм.

Энэ зээлийн 1 хувь авч байна гээд түрүүн манай Идэрбат гишүүн маш тодорхой асуулаа шүү дээ. Тэгээд Лхагвасүрэн Ерөнхийлөгч болохоор хуулийн тийм бололцоотой юм. Тэгээд банкнууд авах ёстой юм. Бусад орнууд авч байгаа юм гээд хариулчхаж байгаа юм. Тэгэхлээр энэ байна шүү дээ нэг ийм санагдаад байгаа байхгүй юу. Энэ бол үйлчилгээний хураамж гэж би ойлгож байгаа юм. Ашиг нь бол хүүгээрээ явчихна. Ашигтай төсвийг тодруулаад сонгоод. Зээлийн хүү дээрээсээ банк нь ашгаа авах ёстой. Энэ бол үйлчилгээний хураамж байхгүй юу. Үйлчилгээний хураамж юм бол энэ олгож байгаа зээлийнхээ дүнгээс шалтгаалаад байх нь их

зохимжгүй байгаа юм. Ялангуяа манайх шиг өнөөдөр ийм эмзэг эдийн засагтай. Ихэнх зээлдэгчид нь жижиг, дунд бизнесүүд, үнийн дүн нь их жсоохон. Тэгэхээр энийг тэр чинь үйлчилгээний хураамж л юм бол тэр 100 төгрөгийн зээл өгнө үү, 100 сая төгрөгийн зээл өгнө үү. Ер нь бол үндсэндээ адилхан л ажил хийгдэж байгаа шүү дээ. Тэгэхээр энийг нэг судлаач Лхагвасүрэн Ерөнхийлөгчөө. Өгч байгаа зээлийнхээ хувиас биш нэг тийм босго тогтоогоод тэдээс дээш бол тэдэн төгрөг, тэдээс дээш бол тэдэн төгрөг гээд нэг ойлгомжтой болгоод өгчихсөн бол. Тэгэх юм бол жижиг бизнесүүд ч гэсэн зээл авахад амар, банкнууд ч гэсэн зээл олгохдоо ер нь томыг нь л өгье. Яагаад гэвэл нэг хувь нь ашиг нь шууд ороод ирж байгаа учраас нөгөө банкнууд чинь тэрийг л сонирхоод байна шүү дээ.

Жижгүүдэд өгч 5, 10 төгрөг авч байхын оронд нэг мөсөн хэдэн зуун тэрбумаар нь өгөөд тэрбум төгрөг авчихвал амар байна гээд. Өөр орнуудад тийм байдаг байх л даа. Тэгэхдээ тэр чинь бол арай л өөр эдийн засагтай, өөр банкттай улсууд байгаа юм.

Хоёр дахь юм нь манай Их Хурлын удирдлага, Их Хурлын гишүүд бид нар өөрсдөө шүүмжлэлтэй хандах юмнууд байна. Энэ гаднын банк оруулж ирэхгүйгээр Монгол Улсад капитал буюу мөнгөний үнэ өртөг бууна гэж байхгүй. Нөгөө хэдэн төгрөг чинь л эргэлдээд байгаа учраас энэ чинь улам л хүү нь нэмэгдээд байна.

Дээр нь инфляц, дээр нь энэ ковид, дээр нь энэ дайн дажин, эрчим хүчний үнэ энэ чинь Ганбаатар гишүүн асуугаад байна л даа, хэн хариуцах юм гээд. Тэгээд ковидыг хэн хариуцах юм? Украйны дайныг хэн хариуцах юм?

Импортоос шалтгаалж байгаа 60 хувийн инфляцыг хэн хариуцах юм? Инфляц 60 хувь нь импортлогч байна гээд байна шүү дээ. Тэгэхээр энэ юман дотор бол нэг л хариулт байгаа байхгүй юу. Бид нар иргэдэд зээл олгох бололцоог нь нэмж өгье. Хүүг нь багасгая, хугацааг нь уртасгая, энийг хэн хийж чадах вэ? Гаднын банк санхүүгийн байгууллагууд л хийж чадна. Энэ хууль нь орж ирчхээд манай Их Хурал дээр бараг 3 дахь жилийнхээ нүүрийг үзэж байна. Энэ бид нар Их Хурлын гишүүд бид нар ичиж амьдармаар байна. Энийгээ хурдан баталмаар байна. Энийг батлахгүйгээр бид нар энд мөнгөний бодлого яриад төсвөө сайн муугаар яриад нэг их үр дүнд хүрэхгүй шүү дээ.

3 дахь нь бид нар гишүүдээ одоо төсөв батлах гэж байна. Энэ Лхагвасүрэн Ерөнхийлөгчийн анх танилцуулахаас хойш хэлээд байгаа нэг юмыг л их бодмоор байгаа юм шүү. Мөнгөний бодлогын үйлчлэх хязгаар хүрээ ер нь үндсэндээ барагдаж эхэлж байна шүү гээд л эртээдээс хойш л хэлээд байгаа шүү дээ. Нийт GDP-ийн гийн 30-35 хувь нь улсын төсөв болчихоод байхад мөнгөний бодлогын үр дүнтэй нөлөөтэй үйлчлэх орон зай бол улам л хумигдана шүү дээ. Тэгэхээр энийгээ бодож бид нар хэдүүлээ энэ төсвөө ч гэсэн бодмоор байна. Хуулиудаа ч гэсэн хурдан баталж, энэ банк санхүүгийн салбарыг эрүүлжүүлэх бололцоогоо сайжруулмаар байна. Өөрсдөө бид нар юмаа хийхгүй ингэж удааж энэ улс орныг.../минут дуусав/

С.Одонтуяа: Хариулахаас өмнө мэндчилгээ дэвшүүлье.

Роял Олон Улсын Их сургуулийн Төрийн удирдлагын хөтөлбөрийн багш, оюутнууд Улсын

Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Эх орныхоо ирээдүйг бүтээх оюутан, залуучууд та бүхний хүсэл мөрөөдлийнх нь мөргөл дардан байхын ерөөлийг нийт Улсын Их Хурлын гишүүдийнхээ өмнөөс хүсэн ерөөж байна.

Асуултад хэн хариулах вэ? Лхагвасүрэн Ерөнхийлөгч. Дэгийн дагуу бас ажлын хэсгийн гишүүд, Байнгын хорооны дарга хариулах боломжтой шүү. Лхагвасүрэн Ерөнхийлөгч хариулья.

Б.Лхагвасүрэн: Мөнх-Оргил гишүүний асуултад хариулья.

Тийм, ерөнхийдөө яг таны саналтай бол санал нэг байгаа юм. Бидний хувьд бол Төв банкны зүгээс, ялангуяа тэр үйлчилгээний шимтгэл авч байгаа энэ байдал нь өөрөө хэр тооцоо судалгаатай юм бэ? Зүгээр л автоматаар ингээд Монголбанк дээд хязгаарыг нь нэг хувь гээд тогтоогоод өгчихсөн нь шууд тулгаад л. Ингээд нэг хувь аваад байна уу? Эс үгүй бол энэ нь өөрөө дүнгээсээ ялгаатай байх боломжтой юу, том зээл байна уу, жижиг зээл байна уу? Тэр л банкны гаргаж байгаа тооцоо судалгаанд гаргаж байгаа тэр зардал тооцоо нь өөрөө хэр яг судалгаатай үндэслэлтэй байна гэдэг дээр ингээд шалгалт хийгээд явж байгаа. Тэгэхлээр бол энэ дээрээ тодорхой, удахгүй нэг шийдэл гаргаж ирж танилцуулна. Тэгээд тэрэн дээрээ бол яг таны энэ ярьж байгаа саналыг бол ер нь яг л тэр тал руу нь л бид нар хийгээд явж байгаа.

Хоёр дахь асуудлын хувьд бол яах вэ? Яг гаднын, ялангуяа тэр манай Банкны тухай хуулиар зохицуулагдаж байгаа хэсэг дээр бол хэрвээ гаднын арилжааны банк, салбар нээх юм уу, эс

үгүй бол бие даасан банк Монголд байгуулах нь бол ерөнхийдөө нээлттэй Банкны тухай хуулиараа. Зүгээр тэр тухайн банк нь гаднаас орж ирж байгаа банк нь өөрөө төрийн өмчтэй аж ахуйн нэгж байх юм бол энэ нь өөрөө тодорхой хэмжээний нөгөө Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тэр нөхцөл шаардлагынх нь дагуу тусдаа зохицуулалтаар зохицуулагдахаар байгаа юм.

Тэгэхээр Их Хурал дээр байгаа тэр Хөрөнгө оруулалтын банкны тухай хууль нь бол арилжааны биш, зөвхөн хөрөнгө оруулалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулах банкны хуулийг зохицуулахаар ийм заалт байгаа учраас хэрвээ өнөөдөр аль ч улсын арилжааны банк, хувийн өмчтэй банк хэрвээ Монголд салбараа нээгээд ороод ирэх юм бол зохицуулалтын хувьд бол нээлттэй байгаа. Монголбанкны зүгээс ч гэсэн энэ дээр нь бол нээлттэй ажиллахаар байгаа. Яг өнөөдрийг хүртэл бол аль нэг ч арилжааны гаднын банкнаас бол зөвшөөрөл авахаар хүсэлт ирүүлсэн зүйл байхгүй. Монгол Улсад бол өнөөдөр гадаадын 3 банкны төлөөлөгчийн газар байна. Японы нэг банк MUFG, БНХАУ-ын 2 банк, нөгөө Хятадын банк болон ICBC гээд үйлдвэр худалдааны банк гээд ийм л банкнууд байгаа юм.

С.Одонтуяа: Эдийн засгийн байнгын хорооны дарга Цэрэнпунцаг нэмж хариулья.

Ц.Цэрэнпунцаг: Мөнх-Оргил гишүүний асуусан асуулт дээрээс нэмээд хариулчихъя.

Лхагвасүрэн Ерөнхийлөгч сая нэлээд тодорхой ярьсан. Одоо Байнгын хороон дээр Эдийн засгийн байнгын хороон дээр бол Хөрөнгө оруулалтын банкны хууль явж байгаа.

Ерөнхийдөө энэ хууль 11 сард орно гэдэг энэ хуваарьт орчихсон явж байгаа юм, ингээд гарах байх. Нэлээн ажлын хэсэг сайн ажилласан. Ер нь бас шалтгаан бол энэ жижиг жижиг улс төрийн шалтгаанаас болоод энэ хуулиуд явж байгаад төслүүд явж байгаад зогсоод л тэгээд л энэ олон дахин хувирч явсаар байгаад л ингээд жаахан хугацаа алдсан асуудал байгаа юм, нэгт.

Хоёрт бид нар өнөөдөр энэ мөнгөний бодлогоо ярьж байна. Мөнгөний бодлогынхоо явуулж байгаа бодлогыг бас гишүүд маань бид нар сайн ойлгож ярих ёстой юм байгаа юм. Энэ Монголбанкныхан бол мэдээж жилийн 2, 3 улирлын дараа 4 улирлын дараах ямар байх вэ гэдгээ үргэлж эд нарын бодлого дээр тавьж байгаа тоо чиглэж байгаа. Одоо зорилт бол дандаа хол зайд байдаг учраас бол тэр хооронд чинь олон нөхцөл байдал гаднаас нөхцөл байдал үүсдэг. Тэр тоо нь янз бүрийн зөрдөг шалтгаанууд байгаа байх. Тэгэхдээ манай Монголбанкныхан бол манай мэргэжлийн залуус бас гайгүй сайхан ажил энэ тал дээрээ мэргэжлийнхээ тал дээр бас дажгүй сайхан ажиллаж байгаа гэж үзэж байгаа юм.

Ер нь хамгийн гол асуудал бол бид нар өнөөдөр энд одоо төсвөө удахгүй батлах гэж байна, тийм ээ. Тэгээд энэ төсвөө батлах гэж байна. Энэ төсөв маань одоо хамгийн гол нь томроод байдаг. Эдийн засагтаа бол одоо бид нар төрийн өмчтэй компаниудаар бол бараг эдийн засгийнхаа 60 хувь нь одоо төрийн удирдлагад орчихоод байна шүү дээ. Тэгэхлээр энэ төсвийн бодлого яаж гарах бол, одоо энэ мөнгөний бодлогын үр нөлөө яаж гарахад вэ гэдэгт шууд нөлөөлөх учраас бид нар бол төсвөө аль болохоор алдагдал багатай, болж

өгвөл алдагдалгүй баталмаар байгаа юм. Тэрэн дээр одоо тэгээд энэ гишүүд маань дараагийн 7 хоногоос төсвөө яриад эхлэхээр ярих байх гэж санаж байна.

Бүгдээрээ энэ дээр бас нэг дуу хоолойтой ярьж, энэ төсвийн алдагдалгүй болгож явах хэрэгтэй. Ингээд энэ төлбөрийнхөө тэнцлийн алдагдлыг багасгах чиглэл рүү бид нар ажлаа хандуулж байж Монголбанкны явуулж байгаа мөнгөний бодлогын үр дүн нааштай, тэр зорьсон зорилтдоо хүрэх байх гэж бодож байгаа юм.

Тийм учраас бол одоо Эдийн засгийн байнгын хорооны зүгээс бол мөнгөний бодлогын үр дүнтэй, энэ ард түмэн одоо энэ ялангуяа одоо бид нар энэ өнөөдрийн цалингаараа амьдралаа болгож байгаа хүмүүст хамгийн хүнд тусаж байгаа энэ гол нэрийн бараа бүтээгдэхүүний үнэ өсөж байна, инфляц өссөнөөс болж амьдралынх нь олох орлогынх нь тийм ээ, ихэнх хувь нь одоо энэ өдөр тутмын хэрэглээнд явдаг энэ хүмүүс дээр хүнд ачаа олж ирж байгаа энэ инфляцыг одоо тэр өөрсдийнхөө тэр зорилтот түвшинд авч ирэх энэ мөнгөний бодлогын гол зорилт хэрэгжих тэр бололцоог нь бол бид нар одоо энэ төсөв дээрээ хатуу чангахан байж байж хангах ёстой гэж ингэж бодож байгаа.

Энэ бол одоо Эдийн засгийн байнгын хорооны бас бодлого шүү. Тэгээд гишүүд маань энэ тал дээр бас төсөв хэлэлцэх үед бас дуу хоолой нь нэгтэй ингэж ярьж байж өнөөдрийн энэ өдрийн бас санаа зовоод байгаа гишүүд бүрийн амнаас гараад байгаа тэр инфляцын асуудал шийдэгдэнэ гэж бодож байгаа.

С.Одонтуяа: Доржханд гишүүн ажлын хэсгийн гишүүн нэмж хариулъя.

Т.Доржханд: Баярлалаа. Мөнх-Оргил гишүүний хамгийн сүүлийн хөнддөг асуудал их чухал юм. Юу нь чухал юм бэ гээд тэгэхлээр одоо энэ төсөв чинь 40 хувь шүү. Нийт эдийн засгийн тэлээд ороод ирчихсэн.

Ийм орон зайн дээр бол мөнгөний бодлого явуулах ямар ч боломж байхгүй ээ. Тэгээд энийг төв банкныхан бол дотроо яриад байгаа. Гадагшаа гаргаж чадахгүй байгаа шүү, нэг.

Хоёрдугаарт, нөгөө Их Хурлын гишүүд маань нэг анхаарах юм нь бол 2023 оны хамгийн хүндрэлтэй зүйл бол төлбөрийн баланс шүү, төлбөрийн баланс.

Хэрвээ бид нар бондуудаа төлж чадахгүй бол деполт зарлана шүү, чадахгүй бол. Энэ тодорхой шүү. Өнөөдөр нийт нөөц чинь 2.5 тэрбум доллар л байгаа. Гэтэл ирэх жилийн төлөх хүн чинь 1.3 тэрбум, нэмээд Хятадын төв банкны своп ллайн чинь 2.5 тэрбум доллар шүү. Тэгэхээр маш хэцүү байгаа. Энийг мөнгөний бодлогын үр дүнг амжилттай явуулах ганц л нөхцөл байгаа юм. Тэр нь бол төсвөө хумих л ийм байгаа. Өнөөдөр 20.5 их наядын төсвөөр чинь бол энэ мөнгөний бодлогоо инфляцаа нэг оронтой тоонд барих ямар ч боломж байхгүй ээ.

Долларыг 3500 дээрээ ч барих ямар ч боломж байхгүй шүү, бодит байдал нь энэ шүү. Тэгээд цаашаага энэ улс деполт зарлахгүйгээр эдийн засгийнхаа асуудлыг шийдээд явъя л гэх юм бол Их Хурлын гишүүд маань төсөв дээрээ л хатуу байр суурьтай

байгаарай. Үгүй бол усаараа дампуурна шүү. Улсаараа дампуурна шүү. Энийг бол ганц бие хэлээд байгаа юм биш үү, олон улсын бүх байгууллагууд хэлээд байгаа. Одоо дэлхий даяар юу болж байна вэ гэхлээр дэлхий даяараа Төв банкнууд нь Засгийн газартайгаа тэмцэж байгаа үе шүү, дэлхий даяараа.

Яагаад гэхээр Засгийн газрууд нь болохоор эдийн засгийнхаа өсөлтийг дээшлүүлэе ээ. Ажлын байрыг бий болгоё оо. Гоё гоё хөтөлбөрүүд санаачилъя гэдэг. Төв банкнууд нь тийм боломж байхгүй. Яагаад гэвэл дэлхий дээр чинь ковидоос болоод ийм их мөнгө байгаа болохоор энийг чинь бид нар татаж авахгүй бол болохгүй гээд бүгд бодлогыг үүсгэж байгаа байхгүй юу. Одоо энэ төв банк чинь бодлогын хүүгээ 12 болгочхож байгаа юм.

Дээшээ өсөх юм бол зээл гарахгүй шүү дээ. Зээл гарахгүй бол эдийн засгийн өсөлт байхгүй шүү дээ. Эдийн засгийн өсөлт байхгүй тохиолдолд энэ чинь бол тэгээд ганц Монгол биш, дэлхий даяараа ийм байгаа тохиолдолд бол дэлхийн эдийн засаг чинь агшина, Монгол чинь агшина. Ингээд буцаад харайчихна шүү дээ. Тэгээд ийм тохиолдолд институциуд нь буюу Төв банкнууд нь улс төрчдийнхөө эсрэг мэргэжлийн байр суурьтай байгаа шүү. Европын төв банкнууд, Америкийн төв банкнууд, Японы төв банкнууд бүгд ийм байгаа.

Тэгэхлээр өнөөдөр Монголын төв банк бас ийм байх ёстой. Энэ дээр харин Улсын Их Хурлын гишүүд дэмжиж, төсөв батлахдаа элдэв тэр төсвийн гадуурх шинж чанартай гоё нэртэй хөтөлбөрүүдийг зогсоох.

Ковидын үе чинь энэ жил дуусаж байгаа шүү дээ, зогсоох хэрэгтэй.

Хоёрдугаарт Төв банкнаас санхүүжүүлдэг элдэв төсвийн шинж чанартай асуудлуудыг зогсоох хэрэгтэй, хоёр.

Гуравт нь энэ төрийн өмчийн компаниар явуулаад байгаа төсвийн шинж чанартай ажлуудыг бүгдийг нь зогсоох хэрэгтэй. Энэ чинь бүгдээрээ импортыг дэмжиж байгаа, эргээд төлбөрийн баланс дээр дарамт болж байгаа шүү. Нэг удаа бид нар дарамтад ороод деполт зарлачих юм бол түүнээс гарах гэж 10 жил шүү.

Латин Америкийн орнуудын жишээнүүд байна. Хамгийн сүүлийн Грекийн жишээ байна. Одоо энэ үүсээд байгаа нөхцөл байдал чинь бол энэ Шри Ланкад явж байгаа, яг энэний араас Монголд явж байгаа шүү. Олон улсын хөрөнгө оруулагч нар бүгдээрээ Монголоос гарчихсан шүү. Ганц Монголд биш, энэ бүс нутгаас бүгдээрээ гарчихсан байгаа ийм эмзэг байдалд байгаа гэдгээ бол ойлгоод төсвийн хэлэлцүүлгийн үеэр бол энэ мөнгөний бодлогоо дэмжих байдлаар та бүгд одоо кнопдож өгөөрэй гэж хүсэж байгаа шүү.

Ирэх жилийн онцлог бол төсөв биш үү? Нэгдүгээрт, мөнгөний бодлого, хоёрдугаарт төсөв дэмжих байдлаар явах учиртай юм. Энэ бол Эдийн засгийн байнгын хороон дээр бол ярьчихаад ажлын хэсгийн түвшинд бас ойлголцоод орж ирсэн асуудал байгаа шүү баярлалаа.

С.Одонтуяа: Одоо 2 гишүүний асуулт хариултын дараа санал хураалт байгаа. Гишүүд санал хураалтдаа идэвхтэй оролцох хэрэгтэй байна.

Одоо Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн асуулт асууна.

М.Оюунчимэг: Баярлалаа. Бид нар маш чухал асуудал шүү дээ. Энэ 2023 онд төрөөс мөнгөний талаар баримтлах бодлого гэж байгаа. Тэгээд бид сүүлийн 10 жил харахад энэ инфляцыг 6 +- 2 гээд 6 хувьд барина гэж ярьсан. Бодит амьдрал дээр энэ хэрэгжээгүй. Тэгээд хэрэгжээгүй шалтгаан нь өөрөө мэдээж дан ганц Монголбанкнаас шалтгаалаагүй. Төсөв мөнгөний нөгөө уялдаа, тэр тавьсан зорилго бүгд бодит амьдрал дээр хэрэгжиж чадаагүй нь бодит үндэслэлтэй. Тэгээд одоо яг хэлээд байна л даа. Мөнгөний хатуу бодлого барих нь энэ 2023 оны Төрөөс мөнгөний талаар баримтлах бодлогын гол зорилго гээд ороод ирчихсэн. Тэгээд сая Лхагвасүрэн Ерөнхийлөгч хэлж байна л даа. Мөнгөний бодлого хатуу байвал төсвийн бодлого хатуу байх ёстой гээд. Ирэх онд бид нар ДНБ одоо хараад үзэхэд улсын төсвийнх 55-56 их наядаар ярьж байхад ирэх жилийнхийг бид нар тооцооллоороо 54 их наяд гээд орж ирж байна. Энэ чинь өөрөө төсвийн тэлэлт тэр хэмжээгээр л их байна гэсэн үг шүү дээ.

Тэгэхээр бид нар энд яриад байгаа төрөөс баримтлах мөнгөний бодлого нь нөгөө 6 хувь инфляцыг онилох тэр бодлогууд маань амьдралд хэрэгжинэ гэдэг бол үнэхээр худлаа л болчихоод байгаа юм. Тэгээд хэлж байна л даа. Энэ 54 их наядыг жишээ нь аваад үзэхэд эдийн засаг энгийн байх үед тэр улсын сектор руу банкнаас орж байгаа нийт зээлийн хувь хэмжээ 17 хувь байсан шүү дээ тэ. Одоо энэ хувь хэмжээ нь ирэх жилд ямар байхаар тооцоолж байгаа юм бол. ОУВС-ийн сая намрын энэ хуралдаан дээр тэр манайхыг

хариуцсан захирал нь Монгол Улсад энэ долларын ханин ингээж огцом өсөх, валютын нөөцийн хомсдолд ороход нөлөөлсөн нэг хүчин зүйл нь Монголд хэрэгжих хэрэгжсэн биш шүү хэрэгжих. БНХАУ-ын барилгын компаниуд руу Эрдэнэс Тавантолгой компани их хэмжээний мөнгө шилжүүлдэг гэсэн мэдээлэл хийсэн.

Тэгэхээр энийг Монголбанк мэдэж байгаа юу? Ер нь ямар банкнуудаар дамжаад БНХАУ-ын барилгын ямар компаниуд руу, хаана хэрэгжих төслүүд рүү ингээж их мөнгөний урсгал, зээл, Эрдэнэс Тавантолгойгоос гарсан юм бол. Би энэ дээр нэгдүгээрт маш тодорхой мэдээлэл авахыг хүсэж байна. Энэ өөрөө бас их чухал асуудал болоод байна л даа.

Хоёр дахь зүйл нь Үндэсний статистикийн газрын дарга Батдаваа хэлсэн л дээ.

Яг одоо бол ядуурлын түвшин 28 хувьтай байгаа. Яг ядуурлын шугамд ирчихсэн иргэдийн хувь хэмжээ өнөөдөр бас 14 хувь буюу ирэх онд энэ ядуурал 42 хувьд хүрэх магадлал маш өндөр байна. Ер нь л 42 хувьтай гарах нь ээ гэж хэлсэн энэ бол бодит үнэн. Би энэ сүүлийн өдрүүдэд нөгөө төсөв ард иргэдээр хэлэлцэж байгаа үед иргэдтэйгээ маш олон уулзалтууд хийж байна. Гурилын үнэ 30 хувь нэмэгдсэн чинь одоо гурилын идэх юм авах битгий хэл талхаа авчихад хэцүү болж байна. Авч байгаа цалин, тэтгэвэр сарын 14 хоногт л үрээд дуусчхаад сүүлийн 14, 15 хоногт өлөн зэлмэн амьдарч байна гэж иргэд бүгд босоод ярьж байна. Аж ахуйн нэгжүүд одоо жишээ нь 8 нэрийн барааны дэлгүүрээ ажиллуулдаг хүмүүс борлуулалтын орлого нь ихэнх

нь бас гурилан бүтээгдэхүүн байсан ч одоо эрс буурчихсан.

Бараа бүтээгдэхүүн борлогдохоо байчихсан. Дэлгүүрээ хааж БНСУ руу ч юм уу, хаашаа ч юм явмаар байна. Та энд одоо гишүүд та нар анхаараач гээд ярьж байгаа байхгүй юу.

Энэ юу гэж байна гэхээр нөгөө төсөв, мөнгөний бодлогын уялдаа нь юун дээрээ ирж наалдах ёстой вэ гэхээр хамгийн гол нь энэ иргэдийн амьжиргааг яаж одоо үнийн өсөлтийн дарамтаас хамгаалах вэ, яаж иргэдийн орлогыг хамгаалах вэ, яаж аль болохоор аж ахуйн нэгж энэ бизнесээ дэмжээд иргэдээ орлоготой ажилтай байлгах уу гэдэг дээр л төсөв мөнгөний бодлогын уялдаа нь, зорилго нь энэ дээр ирж наалдах учиртай.

Гэтэл энэ 2 өнөөдөр наалдахгүй байна. Иргэдийн бид амьдралын энэ баталгааг нь хамгаалж чадахгүй дарамт асар их болчихсон байна. Орлого хаагдаж байна. Тэгэхээр Монголбанкны бас нэг мөнгөний бодлогын зорилго бол ажлын байрыг дэмжих. Ажлын байр, ажлын байр, ажлын байр гээд ярьдаг шүү дээ. Тэгээд энэ 2 дээр одоо ирэх оны нийт төрөөс баримтлах мөнгөний бодлого дээр одоо нэг бүр зах зээлийн бус аргаар ч хамаагүй зарчмаар ийм л юм хийхгүй бол болохгүй байгаа гэдгийг та бүхэн минь нэг зоригтой хэлээдхээч. Бид энийг төсөвтэй уямаар байна. Энэ 2 дээр эхлээд тодорхой хариулт авчихъя гэж бодож байна.

С.Одонтуяа: Оюунчимэг гишүүний асуултад хэн хариулах вэ? Монголбанкны Ерөнхийлөгч Лхагвасүрэн.

Б.Лхагвасүрэн: Оюунчимэг гишүүний асуултад хариулъя.

Тэгэхээр ерөнхийдөө одоо яг өнөөдрийн байдлаар, одоо энэ 3 дугаар улирлын эцсийн байдлаар зээлийн өсөлт бол 13 хувьтай байна.

Нэгдүгээр улирлын эцэст бол 25 хувьтай байсан. Тэгэхээр бол ингээд нэгдүгээр улирлаас 3 дугаар улирал, энэ хооронд бол зээлийн олголт бол ерөнхийдөө ингээд буураад явж байгаа. Энэ хандлага удаан үргэлжлэх юм бол бүр 2020 онд болж байсан бас нэг үйл явц давтагдаж магадгүй гэсэн ийм болгоомжлол байгаа юм. Тэр үед бол зээлийн тасалдал буюу зээлийн өсөлтгүй болж байсан бүр. Зээлийн өрийн үлдэгдлийн хэмжээ 5 хувь хүртэл буурч байсан, ийм байгаа. Тухайн тэр 2020 онд бол Монгол Улсын эдийн засаг хүртэл өөрөө ингээд агшиж байсан. Тэгэхээр энэ утгаараа бол зээлийн тасалдал бий болгохгүй, зээлийн өсөлтийг бол тодорхой хэмжээнд барих нь бол одоо бас мөнгөний бодлого Төв банкны бас үндсэн үйл ажиллагааны бас нэг хэсэг болчихоод байгаа юм. Энэ утгаараа бол бид хэд Төв банкны зүгээс бол нэлээн энэ дээр анхааралтай хандуулж байгаа.

Ялангуяа таны одоо дурдаж байгаа энэ ажлын байрыг хадгалах, ажлын байрыг нэмэгдүүлэх тал руу бол санхүүгийн энэ бүтээгдэхүүн үйлчилгээний хүртээмжийг зайлиггүй байлгах, энэ талаас нь бол нэлээн бодлого явуулж байгаа. Бидний хувьд ч гэсэн сая ОУВС-ийн жилийн уулзалтад очиж ирэхдээ Европын сэргээн босгол хөгжлийн банк болон Олон улсын санхүүгийн корпорацынхантай уулзсан. Энэ уулзалт дээрээ, ялангуяа Монгол Улсад тэр жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх, өрхийн

үйлдвэрлэлийг бий болгох талаар бол хөнгөлөлттэй хүүтэй зээл гаргахад эдгээр байгууллагуудын эх үүсвэрийг одоо ашиглаж болох талаар ярилцсан байгаа. Ялангуяа ямар тоо хэмжээний хувьд ч гэсэн ярьсан. Ерөнхийдөө бол нэг 100 тэрбум төгрөгийн хэмжээнд ярихад бол одоо нэг 30 сая доллар ч гэдэг юм уу, 30-50 сая долларын хэмжээний эх үүсвэр бол тухайн байгууллагуудын хувьд бол их боломжийн, тийм их дүнтэй тоо биш ээ гэдэг талаасаа яригдаж байгаа учраас л ийм хэмжээний ийм тодорхой хэмжээний зорилт бүлгэд олгодог тодорхой нөхцөлтэй, хөнгөлөлттэй ийм зээлийг гаргахаар бол яриад явж байгаа.

Тэгэхээр энэ талаар бол нэлээн боломж гарах байх гэж бодож байгаа юм. Өөр нэг таны хөндөж байгаа тэр Хятадын барилгын компаниудаар дамжиж байгаа, дамжиж байгаа энэ эх үүсвэрийн талаар бол мөн ОУВС ч гэсэн өөрийнхөө энэ дүрмийн 4 дүгээр заалтын дагуу хийсэн. Ажлын хэсгийнхээ дүгнэлт дотор бол дурдчихсан байгаа. Ялангуяа Эрдэнэс Тавантолгойн борлуулалтын орлогыг урьдчилж авах, оптик гэрээ байгуулах замаар экспортын борлуулалтын орлогын ихээхэн хэсгийг БНХАУ-ын барилгын компаниудаар Монгол Улсад хөрөнгө оруулалтын томоохон төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхэд зарцуулж байна гээд угаасаа энэ дүгнэлт дээр хүртэл байж байгаа. Бидний зүгээс ч гэсэн, Монголбанкны зүгээс ч гэсэн гадагшаа хийгдэж байгаа бүх төлбөр тооцоонууд дээр бас тодорхой мониторинг хийж байгаа. Энэ дээр ялангуяа тэр эрчим хүч буюу одоо Монголд бол тэр Төв аймгийн нутагт бас нэг эрчим хүчний эх үүсвэр хийхээр цахилгаан станцын төсөл хэрэгжиж байгаа. Бөөрөлжүүт гээд байгаа. Тэрэнд бол одоо тэр цахилгаан

станцыг барих аж ахуйн нэгж нь бол Хятадын бас нэг барилгын компани байгаа юм.

Тэгэхээр бол томоохон хэмжээний бас төлбөрүүд энэ компаниуд руу бас ингээд гараад явж байгаа юм.

С.Одонтуяа: Оюунчимэг гишүүн тодруулъя.

М.Оюунчимэг: Тэгэхээр Эрдэнэс Тавантолгойгоос гарч байгаа энэ хэмжээний зээл яг манай улсын аль арилжааны банкаар дамжиж гарч байгаа юм. Тэр нь өөрөө яг хуулийн дагуу юм уу? Энэ өөрөө сая яг долларын ханин ингээж төгрөгийн эсрэг огцом өсөхөд бол нөлөөлсөн нь байна шүү дээ. Яг тодорхой бодит нөлөөлнө, нэг.

Тэгэхээр энэ хяналт, ер нь энэ арилжааны банкнуудын мөнгөн гуйвуулга, гадаад дотоод дээр хяналт маш сул байна гэж сая тэр ОУВС-ийн дүгнэлтэд гарсан байсан.

Тэгэхээр энэ дээр ганц энэ компани байна уу, өөр компани байна уу? Тэрэн дээр нэгдүгээрт хариулт өгнө үү?

Хоёрт нь бид 2018 онд 2023 оноос эхлээд зээлийн хүүг нэг оронтой тоонд аваачна гээд тэгээд Монголбанк оруулж ирээд Эдийн засгийн байнгын хороогоор оруулаад Их Хурал энэ хөтөлбөрийг баталсан. Мэдээж ковидын нөхцөл байдал энэнээс болоод нэг оронтой тоонд орно гэдэг худлаа болчихоод байгаа. Одоо 14, 21 хувьтайгаа л байж байна шүү дээ. Ер нь энэ 3, 4 бусад улс орных чинь 3-4, 6-7 байж. Өндөр хөгжсчихсэн. Энд инфляц онилох тухай асуудал хэрэгжээд байдаг манайд хэрэгжихгүй

байгаад байгаа юм. Тэгэхээр л харин миний яриад байгаа тэр мөнгөний.

С.Одонтуяа: Яг тодорхой хариулчих, саяын асуултад нь Лхагвасүрэн ерөнхийлөгч.

Б.Лхагвасүрэн: Оюунчимэг гишүүн асууж тодруулаад хариулъя.

Тийм тэгэхээр энэ асуудал нөгөө Хятадын тэр барилгын компаниудтай холбоотой асуудал нь бол Монголд орж ирсэн мөнгө нь буцаж гарч байгаа биш, нүүрс гараад нүүрсний орлого нь тэндээсээ мөнгө болж оролгүйгээр бараа материал болоод тэгээд бүтээн байгуулалтын төслөө хийхээр тэндээ үлдээд явж байгаа. Тэгэхээр одоо бидний яг хэчнээн хэмжээний мөнгө үлдэж байгааг бол нарийн тооцоолохоор Засгийн газар ингээд ажлын хэсэг байгуулаад явж байгаа. Яах вэ, зүгээр манай төлбөрийн балансыг тооцдог манай аргачлалаар бол тэр зөрүү нь бол хамгийн багадаа хоёр тэрбум. Дээшээ 2.5 тэрбум долларын хэмжээ нь ийм хэмжээнд л яригдаж байгаа зүйл байгаа юм.

Зээлийн хүүтэй холбоотойгоор ерөнхийдөө дэлхий даяараа одоо бүх бодлогын хүү өсөж байгаа учраас бүгдэд нь бол зээлийн хүү өсөөд явж байгаа. Яах вэ бидний сүүлд хийсэн судалгаагаар бол одоо дэлхийн ихэнх улсуудад нь ипотекийн зээл бол одоо бүр бүгдээрэнд нь зургаагаас илүү гараад явчихсан. Одоо манайд бол харин ч ипотекийн зээл маань бага хүүтэй, ийм хэмжээнд тооцогдохоор болчихсон явж байгаа. Бүх л улсад бол одоо.

С.Одонтуяа: Ширнэнбанди Адьяаа гишүүн асуулт асууна.

Дараа нь санал хураалттай шүү, гишүүд ээ.

Ш.Адьяа: Төрөөс баримтлах мөнгөний бодлогыг өнөөдөр Улсын Их Хурал хэлэлцэж байгаа. Эдийн засгийн одоо хүнд нөхцөл үүссэн энэ цаг үед төрөөс баримтлах мөнгөний бодлогыг Улсын Их Хурал бол хариуцлагатай хэлэлцэх ёстой гэдэг ийм байр суурьтай байгаа юм аа.

Ингээд Монголбанкнаас хоёр, гурван зүйлийг асууя. Энэ гаднын хөрөнгө оруулалттай уул уурхайн компаниуд, Монголын банк санхүүгийн байгууллагаар дамжуулахгүйгээр төлбөрийн тооцоо хийдэг энэ асуудал ер нь газар авсан. Би энийг удаа дараа ярьж байгаа. Энэ одоо ямар шалтгаан байна аа?

Энэ дээр одоо Монголын мөн төрийн мөнгөний бодлогыг баримталж байгаа Монголбанкны зүгээс энд одоо ямар дүгнэлт, ямар байр суурь баримтлах вэ гэсэн нэг ийм асуулт байна. Энэ гаднын уул уурхайн компаниуд, газрын тосны компаниуд Монголын баялгийг аваад, тэгээд оронд нь ирж төлбөр тооцоо хийдэггүй, зөвхөн урсгал зардлаа оруулж ирдэг энэ явдал үргэлжилсээр байгаад өнөөдөр бид нар ийм валютын нөөцийн, мөнгөний энэ хомсдолын ийм асуудал үүссэн. Энэ цаашид хэр үргэлжлэх вэ. Энд одоо хууль тогтоох байгууллага, Засгийн газар ер нь ямар одоо арга хэмжээ авбал зөв бэ гэсэн ийм байр суурьтай байна.

Дээр нь энэ дотоодын банкнууд өнөөдөр ард иргэддээ, аж ахуйн нэгжүүддээ зээл өгөхөө болиод удаж байгаа, удаж байгаа.

Дээр нь одоо энэ элдэв хураамж нэрээр ямар л одоо ард иргэдээ, аж

ахуйн нэгжээсээ албан татвар гувчуур авах вэ гэдэг ийм бодлогыг энэ арилжааны банкнууд явуулдаг гэж би боддог юм. Ер нь өнөөдөр энэ арилжааны банкнууд бол улс төрчтэй холбоотой, төр нь хамгаалдаг, Монголбанк ч энд оролцдог гэсэн ийм хардлага надад байна. Яагаад гэвэл өнөөдөр энэ гаднын банк санхүүгийн байгууллагыг оруулж ирэх хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх тухай хуулийн төслийг өргөн бариад 2-3 парламент дамжиж хэлэлцээд шийдэж чадахгүй байна.

Дээр нь одоо хүмүүсийн ярьж байгаагаас энэ гаднын банк санхүүгийн байгууллагад зориулсан нэг төрийн бодлого, Монголбанкны бодлого. Дотнын банк санхүүгийн бизнесийн байгууллагад зөрүүлсэн нэг бодлого байгаа мэтээр ийм ойлголтыг өгч байна аа. Ийм байдлаар бид явахгүй шүү дээ. Зах зээлийн зарчим, гаднын хөрөнгө оруулалтын зарчим энд чинь ингэж гадна дотнынхонд зөрүүлсэн ийм 2 салаатай эдийн засгийн бодлогыг явуулах юм бол нөгөө манай Монгол Улсын улс төрийн тогтвор байдал гэдэг нэрийдлээр аливаа асуудалд гацаа үүсдэг энэ асуудал чинь үргэлжилнэ. Энэ дээрээ Монголбанк бол бас ийм тодорхой дүгнэлт хийгээрэй. Ер нь бол үндэсний аюулгүй байдлын асуудал гэдэг энэ нэг ерөнхий нэрийн дор одоо энэ улс төрчдийн бүлэглэлтэй холбоотой энэ дотоодын хэдхэн одоо банк санхүүгийн байгууллага ч ингээд Монголын ард түмнийг, Монголын хөгжлийг, ард иргэдийнхээ ингээд амьдрах нөхцөлийг бууруулсаар байхад Монголбанк хууль тогтоох байгууллага ингээд л нүдэн балай чихэн дүлий байх юм уу гэдэг дээр бас дүгнэлт хийе.

Энэ талаар хариулт авъя.

С.Одонтуяа: *Хариултын өмнө зочид танилцуулъя.*

Улсын Их Хурлын гишүүн Дамдины Цогтбаатарын урилгаар маргаашийг бүтээнэ Үндэсний чуулганд орон нутгаас оролцогчдын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүгдийн энэ сайхан маргаашийг бүтээх гэгээн үйлсэд нь амжилт хүсье.

Маргаашийг бүтээх чуулганд дандаа эмэгтэйчүүд оролцсон байна шүү дээ Цогтбаатар гишүүн ээ. Эмэгтэйчүүдийн чуулган юм уу. Эрчүүд бүтээхэд нэг их идэвхтэй оролцохгүй байгаа юм байна.

Адьяаа гишүүний асуултад хариулъя. 83 дугаар микрофон Лхагвасүрэн Ерөнхийлөгч.

Б.Лхагвасүрэн: *Гишүүний асуултад хариулъя.*

Тэгэхээр энэ 1994 онд батлагдсан Валютын зохицуулалтын тухай хууль байгаа тэгээд энэ энэ хууль ерөнхийдөө бас шинэчлэгдэж найруулагдахаар бас төсөл нь өргөн бариад ингээд бас Их Хурал дээр байж байгаа. Энэ 1994 онд батлагдсан хуулийн 12. 2 дугаар заалт дээр Монгол Улсад байнга оршин суугч валютын орлогоо 60 хоногийн дотор банканд хадгалах, худалдах тухай заалтыг ийм заалт байдаг, үүрэгтэй гэсэн. Тэгэхээр бол одоо Монгол Улсаас одоо уул уурхайн бүтээгдэхүүн экспортолдог байна уу, бас өөр бүтээгдэхүүн экспортолж байна уу, энэнээс үл хамаараад ерөнхийдөө олсон орлогоо 60 хоногийн дотор Монгол Улсад авчирч, нэг бол банканд хадгалах, нэг бол банканд нь худалдах ийм хуулийн заалт байгаа. Тэгэхээр энэ хуулийн

заалт бол одоо өнөөдрийг хүртэл бол ер нь сайн мөрдөгдөж, биелэгдэхгүй байгаа учраас одоо ингээд зарим экспортын орлого маань өөрөө бараа материал болж, өөр одоо бартер хэлбэрээр орж ирэх ч юм уу, эс үгүй бол бүр тэндээ, гаднаа үлдэх ч юм уу, ийм хэлбэрээр л яваад байгаа л даа.

Тэгэхээр энэ хуулийг хэрвээ яг мөрдүүлж, энэ хуулийнх нь заалтаар ажиллуулах юм бол одоо Монголоос гарсан бүх бараа бүтээгдэхүүний экспортын орлого Монгол Улсдаа бол 60 хоногийн дотор орж байх ёстой гэсэн ийм үүрэг байгаа. Тэгэхээр энэ хуулийн заалтыг л бүрдүүлэх нь нэгдүгээрт маш чухал байгаа. Одоо таны хэлж байгаа санааг бол яг л энэ хуулийн заалт мөрдөж эхлэх юм бол хэвэндээ орох боломжтой гэж Төв банкны зүгээс бол харж байгаа. Монголбанкны хувьд бол мэдээж банкыг бол дотоодын банк, гадаадын банк гэж ялгаварлах ийм боломж байхгүй.

Хуулиараа ч угаасаа ингэж ялгаварлахаар ийм зохицуулалт байхгүй байгаа. Өнөөдөр Монгол Улсад бол 12 банк үйл ажиллагаа явуулж байна. Манай банкны салбар маань өөрөө санхүүгийн зах зээлийг ерөнхийд нь бол тодорхойлоод явж байна. 80х20 гэж харьцаа байх юм бол одоо нийт эдийн засаг маань өөрөө 80 хувийнхаа санхүүжилтийг энэ банкнаас аваад явж байгаа. Тэгэхээр Монгол Улсын хувийн сектор бол одоо ингээд л банкны салбарын санхүүжилтээр л ингээд хөгжиж явж байгаа гэж хэлж болохоор. Тэгэхлээр энэ утгаараа аль болохоор тэр мэдээж хувийнхаа салбарыг бодит эдийн засгийг дэмжих үүднээс банкны энэ салбараас үзүүлж байгаа бүтээгдэхүүн, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхийн төлөө л

Төв банкны бодлого явж байгаа. Мэдээж бүтээгдэхүүн үйлчилгээ нь хүртээмжтэй байхын тулд тухайн банкных нь одоо зохистой харьцаагаа хэр сайн хангаж байгаа, хэр одоо чадавхтай байгаа гэдгээсээ л бүх зүйл хамаарна.

Тэгэхээр тэр утгаараа Монголбанкны зүгээс бол одоо өнөөдөр хяналт шалгалт хийж байгаа тэр активын чанарын үнэлгээг хийгээд явж байгаа энэ олон нийтийн зах зээл дээр зах хөрөнгийн бирж дээр ХК хэлбэрт оруулж байгаа энэ бүх бодлого маань өөрөө энэ банкиг л чадавхжуулж, банкаар дамжаад эдийн засгийг одоо санхүүжүүлэх л энэ зорилготой л нийцтэй, ийм бодлого л явж байгаа л гэж Төв банкны зүгээс үзэж байгаа.

С.Одонтуяа: Гишүүд асуулт асууж хариулт авч дууслаа.

Одоо Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураана.

Нийт зарчмын зөрүүтэй 4 санал байна. Зарчмын зөрүүтэй санал дээр дэмжсэн, дэмжээгүйгээр гишүүд үг хэлж болно, асуулт асуух бол дэг байхгүй.

Ингээд санал хураалтад орёё.

Эдийн засгийн байнгын хороо дэмжсэн саналууд. Тогтоолын төслийн 2 дугаар заалтад доор дурдсан агуулгатай дэд заалт нэмэх:

“9/Монгол Улсын Засгийн газраас дэвшүүлсэн “Халамжаас хөдөлмөрт” зорилтын хүрээнд ажлын байрыг хадгалах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, эрэлтэд нийцсэн ур чадвартай ажиллах хүчний

нийлүүлэлтийг нэмэгдүүлж, мөнгөний болон төсвийн бодлогоор дэмжих;” санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Содномын Чинзориг, Хасарын Гангантуяа, Тогмидын Доржханд, Чинбатын Ундрам Одонгийн Цогтгэрэл. Цаашид ажлын хэсэг гэх.

Санал хурааа.

Үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү, Байгаа байгаа, дэмжсэн, дэмжээгүй байдаг юм. Баттөмөр гишүүнээр тасаллаа. Мөнх-Оргил гишүүн үг хэлнэ.

Ц.Мөнх-Оргил: Би энэ зарчмын зөрүүтэй саналыг дэмжиж байгаа юм.

Гэхдээ энэ дээр нэг ийм, сүүлийн үед нэг юм ажиглагдаад байхад халамжаас хөдөлмөр гээд л байн байн л яриад байх юм. Тэгээд энэний чинь цаана нэг ийм утга санаа агуулагдаад байна шүү дээ, ерөөсөө халамж байх ёсгүй юм шиг нэг тийм санаа байх ёстой шүү дээ. Хэрэгтэй хүндээ зөв хүндээ энэ халамж очиж байх ёстой. Одоо бүр сүүлдээ ингээд ярьсаар байгаад бараг хүүхдийн мөнгө ч олгохгүй тухай ярих гээд байх шиг. Жишээ нь яг хүндээ очиж байгаа хүүхдийн мөнгө чинь бол жишээ нь зөв хөтөлбөр. Дэлхийн банк энийг чинь 2 удаа үзээд явсаар байгаад энэ хүүхдийн мөнгөний хөтөлбөр чинь бол нэгдүгээрт халамжийн хөтөлбөр байна.

Хоёрдугаарт хүндээ очиж байгаа зөв хөтөлбөр байна. Одоо хамгийн гол нь та нар зорилтот бүлгээ, зөв тодорхойлооч ээ л гэдэг шаардлага тавиад байгаа шүү дээ. Тэгээд энэ нэг юмыг заавал ингээд нөгөө тулгах гээд байгаа, эцэст нь бүр ингээд л 2 тийш нь савлуулаад л, эсвэл ерөөсөө дандаа л халамж байгаа юм

шиг, эсвэл ерөөсөө халамж байх ёсгүй юм шиг ийм юм яриад байх юм. Тэгээд энэ халамжаас хөдөлмөрт гэдэг юмаа нэг хавтгайруулахгүйхэн шиг тодорхой агуулгатай болгоод зорилтот бүлгээ тодорхойлоод хамгийн эхэнд одоо хэдүүлээ энэ 2023 оны төсөв дээрээ тэр Засгийн газрын өргөн барьсан 91 хувь гээд байгаагаа зөв тодорхойлодохъя. Тэгээд энэ хөтөлбөрүүдээ зөв хэрэгжүүлээд явчихъя. Тэгээд хөдөлмөр эрхлэлтээ дэмжээд явъя. Өөрөөр хэлбэл аль алийг нь уялдуулах хэрэгтэй байна шүү дээ Тийм ээ, нэгийг нь нөгөөдхөөр нь цохилдуулаад баймааргүй л байна гэж хэлэх гэсэн юм.

Баярлалаа. Тийм юм маань нэг аюулд учрах вий дээ. Хандлага нь тийм болчхоод байна шүү.

С.Одонтуяа: Баагаагийн Баттөмөр гишүүн санал хэлнэ.

Б.Баттөмөр: Энэ заалтыг бол би дэмжиж байна. Халамжаас хөдөлмөрт шилжих, Монголд бол халамж үнэхээр хавтгайрсан. Нэг хүнд халамж авч байгаа хүнийг ингээд тооцоод үзэхээр 3.9 халамжийг авч байна гэсэн ийм тооцоо байдаг. Энэ саналыг дэмжиж байна. Ер нь бол бас нэг үг хэлэх, санал хэлэх боломжууд их бага олдох юм аа.

Тийм учраас энэ мөнгөний бодлоготой холбогдуулаад хэдэн санал би хэлэх гэж байгаа юм.

Нэгдүгээрт нь энэ Монгол Улсад арилжааны 14 банк ажиллаж байгаа. Энэнээс 4, 5 банкнууд одоо ингээд IPO хийнэ. Эхнийх нь энэ Төрийн банкны IPO хийгдчихсэн. Хийгдээд явж байгаа их үр дүнтэй болсон юм байна. 3000 гаруй хувьцаа эзэмшигчтэй болж байгаа юм байна. Энэ бол сайн байна.

7000 гаруй, 7000 гаруй хувьцаа эзэмшигчтэй болж байгаа юм. Тэгэхээр ерөөсөө гол одоо энэ IPO хийх гол зорилго маань бол одоо юу гэхээр маш их олон хувьцаа эзэмшигчтэй болох тусмаа илүү одоо ач холбогдолтой. Энэ дараа дараагийн одоо энэ IPO хийж байгаа банкнууд дээрээ бол урд гаргасан нь энэ янзаараа алдаа гэдэг юм уу эрсдэлүүдийг маш сайн тооцож ийм ажиллах шаардлагатай гэж ингэж үзэж байгаа.

Энэ дараагийн нэг ярих гээд байгаа юм нь төлбөрийн тэнцэл, урсгал данс алдагдалтай мөртөө энэ одоо гадаад худалдааны тэнцэл бол 2.2 тэрбум долларын ашигтай байгаа. Энэ мөнгө хаачиж байна гэхээр ер нь Монголд орж ирэхгүй. Тэгээд энийг бид ер нь яах ёстой юм бэ? Гол асуудал чинь энд байна шүү дээ. Монгол улсад яагаад энэ валют хомсдоод байна? Монгол төгрөг одоо энэ өнгөрсөн 30 жилийн хугацаанд америк долларын эсрэг 900 дахин уначхав гэхээр зэрэг л энэ гол асуудал энд яваад байна шүү дээ, нэгдүгээрт.

Хоёрдугаарт, одоо энэ он гарснаас хойш америк долларын эсрэг Монгол төгрөг 18.7 хувиар унасан. Сүүлийн 7 хоног гэхэд л 12 нэгжээр уначхаад байгаа байхгүй юу? Тэгэхээр энэ тооцоолол янз бүрийн юмнуудаа их сайн хийх ёстой. Яах вэ шинжлэх ухааны тэр онолын юмыг би сая хэлсэн. Тэгэхдээ практик дээр бол янз янзын тооцооллууд байдаг байх. Энийг их сайн үзэж хийх ёстой. Гол нь одоо юу гэж байна гэхээр америк долларын одоо эсрэг монгол төгрөг унаад байгаа. Гэтэл тэр вон гэдэг ч юм уу, юанийн эсрэг яах вэ 4 хувиар унасан байгаа юм. Вон юм уу Тэр одоо нөгөө евро гээд үзэхээр зэрэг уналт байхгүй. Тэгэхээр энд ийм зохиомол, ийм

хомсдолын юмнууд бас байгаад байна уу? Өөрөөр хэлбэл хадгаламжийн Монгол төгрөгийн хадгаламж америк доллар руу шилжээд байгаа ийм зүйлүүд байгаа юм. Энийг л одоо их сайн удирдаж ажиллах л ийм шаардлага л байгаад байна л даа. Тэр энэ уламжлалт мөнгөний бодлого явахаа больсон гэдэгтэй сая тэр Мөнх-Оргил гишүүний хэлж байгаатай би санал нэг байгаа. Ямар нэгэн одоо болохгүй байгаа ажлыг нөгөө болно гээд л үр дүн хүлээгээд суугаад байхыг нөгөө автобусны буудал дээр онгоц хүлээнэ гээд нэг үг байдаг шүү дээ.

Бидний одоо 30 жилийн өнөөдрийн одоо бодит байдал ийм л байна шүү дээ. Тийм учраас энэ одоо уламжлалт бодлого явахгүй байна. Шинэ одоо энэ мөнгөний ямар бодлогуудыг хэрэгжүүлэх вэ, ямар арга хэмжээнүүдийг авах вэ? Энийг одоо гаргаж ирмээр байна. Энэ гаднын банк гаднын хөрөнгө оруулалттай банк оруулж ирэх, энэ манай ажлын хэсгийн гишүүд оруулж ирсэн саналтай санал нэг байна аа. Энэ дээр одоо бид нар ажиллах шаардлагатай гэж байгаа юм. Монгол Улсын Үндсэн хуульд бол төр эдийн засгаа зохицуулна гээд заачихсан байгаа. Худалдааг зохицуулсан эрх зүйн орчин байхгүй. Дур дураараа газрын баялгаа хямд үнээр зөвхөн нэг компани, нэг эзний эрх ашигт нийцүүлж худалдаж байна шүү дээ.

Ингээд худалдааны хуульгүйгээс энэ гадаад худалдаа, тэр оптек гэрээ гээд одоо ингээд мөнгөний бодлогод сөргөөр нөлөөлөөд байна шүү дээ. Ийм ийм зүйлүүдээ сайн ярьж, энэ эрх зүйн орчинг бол энэ сайн бүрдүүлж өгөх ийм шаардлагатай байгаа байхгүй юу. 2023 оны төсвийн одоо баримт бичигт эдийн засгийг төрөлжүүлнэ гэж оруулж ирсэн, яг одоо өнөөдөр

эдийн засгийг төрөлжүүлэхэд мөнгөний бодлогоор ямар бодлогоор яаж дэмжих вэ гэхээр зэрэг бас л одоо энэ номыг уншихаар нэг л тийм юм харагдаж өгөхгүй л байгаад байгаа байхгүй юу. Энэ аливаа улсын мөнгөн тэмдэгт бол одоо үүсэж байгаа сөрөг шокийн тодорхой хэсгийг жижиж хэсгийг ч гэсэн өөртөө шингээх ийм чадвар байх ёстой. Монгол төгрөгт одоо энэ бол байхгүй болчихсон. Энэ чиглэлээр одоо бид нар ингээд цаашидаа богино хугацаанд, дунд хугацаанд, урт хугацаанд одоо ажиллах шаардлагатай. Энэ мөнгөний бодлого, төсвийн бодлогын уялдаа одоо их муу байна л даа. Тухайлбал одоо Лхагвасүрэн Ерөнхийлөгч 2023 онд 24 тонн алт авна гээд зарлачихсан шүү дээ.

Таны одоо ярилцлагад байж байгаа. Гэтэл бол төсөв дээр бол 17 тонн алт авна гэж орж ирсэн. 238.7 тэрбум төгрөгийг төсөвт оруулна гэсэн. Тэгээд энэ 24 тонн болох юм бол эндээс төсөвт орох нь бол одоо дахиад тавин хэдэн ингээд одоо зуу гаруй тэрбум төгрөгөөр нэмэгдэх тийм тооцоо байгаад байгаа байхгүй юу. Зуу гаруй тэрбум төгрөг байгаа. Тэд валютын нөөц одоо нэм.../минут дуусав/

С.Одонтуяа: Одоо Содномын Чинзориг гишүүн үг хэлнэ. Ажлын хэсгийн гишүүн.

С.Чинзориг: Яах вэ, ажлын хэсэг дээр ярьж байгаад энэ халамжаас хөдөлмөрт шилжих хүрээнд ажлын байрыг хадгалах, ажлын байрыг нэмэгдүүлэх энэ хүрээнд энэ мөнгө төсвийн одоо бодлогыг чиглүүлье гэсэн ийм санал бол оруулсан юм. Манай одоо Монголбанкны тухай хуулиар бол зүгээр төгрөгийн ханшийг л одоо

тогтвортой байлгах нь одоо Монголбанкны үндсэн үүрэг гээд бол орчихсон байдаг.

Бусад орнуудын, ялангуяа энэ Америк, эд нарын Монголбанкны банкных нь тухай хуульд бол энэ ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажилгүйдлийн түвшинг одоо бас тогтвортой түвшинд хадгалах ийм одоо зохицуулалтууд бол байдаг юм байна лээ. Манай Монголбанкны тухай хуульд бол ийм зохицуулалтууд байдаггүй.

Тийм учраас бид нар энэ эдийн засаг хүндэрч байгаа, төсөв санхүү хүндэрч байгаа энэ үед бол энэ ажлын байр хадгалах, ажлын байр нэмэгдүүлэх ийм одоо чиглэлээр энэ төсөв мөнгөнийхөө бодлогыг хүртээмжтэй болго гэсэн ийм бас заалт бол шинээр бас энэ ажлын хэсэг дээр хийж байгаад оруулж байгаа гэж байгаа.

Хоёр дахь асуудал Мөнх-Оргил гишүүнтэй би бол санал нэг байгаа юм. Ерөнхийдөө бол энэ Засгийн газраас сүүлийн 2 жил энэ халамжаас хөдөлмөрт гэж ярьчихаад тэгээд халамжаасаа хөдөлмөрт шилжсэн ч юм байхгүй, хөдөлмөр эрхлэлтээ нь дэмжсэн ч юм байхгүй, халамжийн хүрээг нь одоо хумьсан ч юм байхгүй л ингээд яваад байгаа юм л даа. Тийм учраас бол энэ халамжаас хөдөлмөрт гэдэг зорилтын хүрээнд ерөөсөө халамж байхгүй болно оо гэсэн ойлголт бол байж бол болохгүй. Монгол төр гэж байгаа цагт бол зайлшгүй бие даан одоо амьдрах чадваргүй, бие даан орлого олох үйлдвэрлэл үйлчилгээ эрхэлж орлого олох чадваргүй хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настан гээд төр зайлшгүй халамжлах ёстой улсуудаа бол төр халамжилна. Харин одоо бид

ойлголт оо нэгтгээд энэ хууль, эрх зүйн орчныг нь боловсронгуй болгож өгмөөр байгаа юм. Ерөөсөө өрх гэрийн орлогыг дэмжиж байгаа хүний нийгмийн хамгааллыг дэмжиж байгаа орлогыг нь дэмжиж байгаа бодлого болгоныг бид бас сүүлийн үед бол халамж гэж ингээд хавтгайруулж яриад байгаа юм. Тийм учраас бол яг одоо аль нь халамжийн бодлого юм. Аль нь тэр өрхийн гэр бүлийн орлогыг дэмжсэн, иргэнийхээ орлогыг дэмжсэн, хүн амынхаа өсөлтийг төрөлтийг дэмжсэн хүн амын одоо бодлого юм бэ гэдгээ ч гэсэн бас ялгаж заагламаар байгаа юм.

Тэгэхгүй бол ерөөсөө өрхийн орлогыг дэмжиж байгаа хүний амьжиргааны түвшнийг дэмжиж байгаа үйлчилгээ, арга хэмжээ болгоныг халамж гэж ингээж хавтгайруулж яриад халамж хэтэрлээ гэж яриад байгаа бас энэ нэг ойлголтын зөрүү бол байгаа юм.

Тийм учраас бол энэ Засгийн газрын яг одоо хүнд чиглэсэн бодлого, аль нь халамжийн бодлого юм. Аль нь одоо энэ хүн амынхаа өсөлтийг дэмжсэн, төрөлтийг дэмжсэн, иргэдийнхээ амьжиргааны түвшнийг дэмжсэн хүн амын одоо бодлого юм бэ гэдгээ ялгаж зааглаад 2 тусдаа хууль, эрх зүйн орчныг нь одоо бас бүрдүүлж өгмөөр байгаа юм. Тэгэхгүй бол ингээд ерөөсөө хүнд чиглэж байгаа өрхийн орлогыг дэмжиж байгаа бүхий л одоо арга хэмжээ, төсөл хөтөлбөрийг халамж гэж ингээж хавтгайруулаад бас нийтэд нь халамж хавтгайрлаа гээд ингээд туйлирал одоо бас хэт яваад байгааг би бас нэг их зөв гэж бол харахгүй байгаа юм аа.

Тийм учраас энэ хүн амынхаа одоо өсөлтийг дэмжсэн бодлого халамжийн одоо бодлогыг хууль эрх

зүйн орчныг нь одоо тусад нь хууль эрхзүйн орчноо зохицуулдаг болгох чиглэлээр Засгийн газар цаашидаа нэлээн бас санаачилгатай ажиллах байх гэж бол бодож байна.

С.Одонтуяа: Гишүүд санал хэлж дууслаа.

Одоо санал хураалт. Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэдгээр санал хураана. Санал хураахаас өмнө зочдоо танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Балжиннямын Баярсайхан, Цэдэндамбын Цэрэнпунцаг нарын урилгаар Завхан аймгийн Их-Уул сумын ЗДТГ-ын албан хаагчдын төлөөлөл, Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Завхан сайхан нутгаар минь овоглосон Их-Уул сумынхандаа төрийн албанд нь хариуцлагатай ажилд нь өндөр амжилт хүсэн ерөөе.

Санал хураалт.

Гишүүд санал хураалтдаа бэлдээрэй. Байнгын хорооны саналыг дэмжье гэдгээр санал хураая. Түрүүн уншигчсан шүү дээ.

22 гишүүн дэмжиж 52.4 хувиар зарчмын зөрүүтэй санал дэмжигдлээ.

Хоёр дахь санал, тогтоолын төслийн 2 дугаар заалтад доор дурдсан агуулгатай дэд заалт нэмэх.

10.Валютын захын үр ашиг, хүртээмжийг нэмэгдүүлэх, харилцагчдыг таньж мэдэх хууль, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох.

Түүнчлэн санхүүгийн үүсмэл хэрэгслийн зах зээлийг хөгжүүлэх, хэрэглээг нэмэгдүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээг авах. Санал гаргасан ажлын хэсэг.

Үг хэлэх гишүүд алга байна. Санал хураалт.

Нийт 57.1 хувиар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй санал 3.

Тогтоолын төслийн 2 дугаар заалтад доор дурдсан агуулгатай дэд заалт нэмэх:

“11/урт хугацааны тогтвортой санхүүжилтийн үйл ажиллагаа эрхлэх гадаадын хөрөнгө оруулалттай төрөлжсөн банкны эрх зүйн орчныг бүрдүүлэх.” Санал гаргасан ажлын хэсэг. Үг хэлэх гишүүд алга байна.

Санал хураалт.

54.8 хувиар зарчмын зөрүүтэй санал дэмжигдлээ.

4.Тогтоолын төслийн 2 дугаар заалтын 8 дахь дэд заалтын “2023 онд” гэснийг “2023 оны 2 дугаар улиралд” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Т.Доржханд.

Санал хэлэх гишүүдийн нэрсийг авъя Туваан гишүүнээр тасаллаа.

Доржханд гишүүн санал гаргасан гишүүн. Дэгээр 4 минут шүү, түрүүнд 5-аар хийгээд байсан 4 минутаар.

С.Одонтуяа: Би зүгээр товчхон хэлье. Энэ ипотекийн зээлийн энэ хөтөлбөрийг Засгийн газар руу шилжүүлэх асуудал яригдаад, тэгээд

энэ жил нөгөө ковидын хууль дуусгавар болж байгаатай холбоотойгоор уулаасаа шилжиж байгаа юм. Тэгээд Сангийн сайд, Засгийн газрынхантай ярилцаад энэ ирэх жилийн 2 дугаар улирал гэхэд бүрэн боломжтой гэж ойлголцож тохирсон дагуу орж ирж байгаа зүйл шүү гэдгийг л хэлж байгаа юм.

Баярлалаа. Туваан гишүүн саналаа хэлнэ. Би түрүүн хэлсэн тэр хүнсний хангамж, аюулгүй байдал дээр Улсын Их Хурал хуулийн дагуу Түр хороо байгуулагдаад ажиллаж байгаа. Түр хороо өчигдөр хуралдсан. Тэр түр хорооны ирэх 7 хоногийн хуралдаан дээр энэ Монголбанк оролцоорой. Сая бас би буруу ойлгоогүй бол ажлын хэсгээс энэ 138 тэрбум төгрөгийн зээлийн хүүгийн маржен дээр цаад талд нь өгөх зээлийн мөнгө нь арилжааны банкуудад байгаа гэж ойлгосон. банкнууд чинь бол шал өөр юм ярьж байгаа.

Хоёрдугаарт тэр өнгөрсөн хугацаанд бол бид нар 10.65 дээр чинь 3-ыг нь иргэн одоо аж ахуйн нэгжүүд төлөөд 7.65-ын марж төлж байсан. Одоо банкнууд чинь бол бид нар 6 хувиас дээш 6 хувийн хүүгээс доош зээл өгч чадахгүй гээд сууж байгаа. Энэ бол арга ч үгүй байх. Та хэдийн явуулж байгаа энэ мөнгөний бодлогын хүүгийн өсгөсөнтэй холбогдуулаад зээл хумих, чанаргүй зээлийнхээ хувийг нэмэхтэй бууруулахтай холбогдож энэ бодлого явж байгаа байх. Тэгэхээр ингээд юу хэлэх гээд байна вэ гэхээр бид нар төсөв батлах гэж байгаа. Засгийн газар оруулаад ирчихсэн. Маш чухал хөтөлбөр. Хүнстэйгээ хоолтойгоо байх гэсэн хөтөлбөр чинь хийсвэр агаар болоод өнгөрөх ийм асуудал яваад байна шүү.

Түрүүн бас Нямаагийн Энхболд

гишүүн бас асуултдаа хэлсэн. Тэгэхээр энэ дээр Улсын Их Хурал анхааралтай ажиглаж байгаа. Юу вэ гэхээр энэ мөнгөний бодлогод энэ төгрөгийн тогтвортой байдал, бас энэ үндэсний үйлдвэрлэл дэмжих гээд танай нөгөө сайхан сайхан бодлогууд дотор чинь түрүүн хэлсэн 1, 2, 3 дугаар зүйлийн ач холбогдолтой зүйл дотор чинь бол энэ асуудал байгаа шүү. Тэгэхээр урьд нь Монголбанк энэ асуудалд анхаараад оролцоод ирж болчихоод одоо бид нарт хамаагүй юм гээд ингээд хаяж болохгүй. Ялангуяа энэ хүндрэлтэй үед хүнстэй холбоотой асуудалтай үед энийг харж байгаа маш олон компаниуд маш олон ногоочид, эрчимжсэн аж ахуйн фермерүүд хүлээгээд сууж байгаа шүү. Хүнсний салбарынхан. Бусад мөнгүүд бол хүнд байгаа. Гаднын зээл тусламжаас 190 тэрбум төгрөг гэж байгаа. Тэрийг бол би лав үнэмшихгүй байгаа.

Зээлийн батлан даалтын сангийн 55 тэрбум төгрөг бэлэн байгаа гээд ярьж байгаа. Тэр нь бас үнэмшихгүй байгаа. Тэгэхээр энэ болгон зангидах нь мөнгөний бодлого барьж байгаа та бүхний бас нэг үүрэг оролцоо байгаа шүү. Тэгээд энийг бас нэхэж ирэх 7 хоногийн түр хорооны хуралдаан дээр оролцуулж хамтдаа энэ ажлыг ярина шүү гэдгийг бас энэ даширамд хэлье ээ.

Баярлалаа.

Тогтоолын төслийн 2 дугаар заалтын 8 дахь дэд заалтыг 2023 онд гэснийг 2023 оны 2 дугаар улиралд гэж өөрчлөх.

Эдийн засгийн байнгын хорооны саналыг дэмжье гэдгээр санал хураая,

55.8 хувиар санал дэмжигдлээ. Нийт зарчмын зөрүүтэй саналын

томъёоллуудаар санал хурааж дууслаа.

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2023 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүллээ.

Одоо зарчмын зөрүүтэй санал байхгүй, энийгээ хийчхээд цайндаа оръё.

12.39 цаг

Дараагийн асуудал, Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөл. Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан анхны хэлэлцүүлгийг хийе.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Дамдины Цогтбаатар танилцуулна.

Таныг индэрт урьж байна.

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын 2022 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг хийж, эцэслэн батлуулах, бэлтгэл хангуулахаар Хууль зүйн байнгын хороонд шилжүүлсэн. Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар дэмжигдсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг төсөлд нэмж тусган төслийг эцэслэн батлах

хувилбарыг бэлтгээд байна. Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн төсөлд мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээд нь мөнгөн зээлийн үйл ажиллагааны журмын талаарх сургалтад хамрагдах үүрэгтэй гэж тусгасан бөгөөд барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагаатай холбоотой харилцааг анхдагч хууль гарган зохицуулж байгаатай холбогдуулан нэгэнт бүртгүүлэн үйл ажиллагаа явуулж байгаа барьцаалан зээлдүүлэх газрын удирдлага, менежерийг 1 жилийн дотор сургалтад үнэ төлбөргүй хамруулах шаардлагатай гэж ажлын хэсэг үзсэн бөгөөд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.5 дахь хэсэгт заасныг үндэслэн мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг боловсруулсан байна. Хууль зүйн 2022 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн хуралдаанаараа Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан бөгөөд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсэгт заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцсэн болно.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Байнгын хорооны гишүүдээс зарчмын зөрүүтэй санал гараагүй тул Улсын Их Хурлын гишүүн Цогтбаатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.22 дахь хэсэгт заасныг баримтлан хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах, үе шаттай нэгтгэн явуулах горимын санал гаргасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 63.6 хувь нь

дэмжсэн болно оо.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье ээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

С.Одонтуяа: Баярлалаа. Ажлын хэсгийг танилцуулъя.

Пүрэвжавын Сайнзориг Хууль зүй, дотоод хэргийн яамны ТНБД, Дорждэрэмийн Цолмон Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга, Бэгзийн Итгэлсүрэн Санхүүгийн зохицуулах хорооны Банк бус санхүүгийн байгууллагын газрын дарга, Өлзийбатын Мөнх-Ундарга, Монголбанкны Хууль, эрх зүйн газрын Банк, санхүүгийн эрх зүйн хэлтсийн захирал.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгнө үү?

Асуулт асуух гишүүд алга байна.

Байнгын хороо мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах, үе шаттай нэгтгэн явуулах горимын санал гаргасныг дэмжье гэсэн томъёоллоор санал хураая.

Гишүүд санал хураалтдаа бэлдье.

Анхны хэлэлцүүлгийг эцсийн хэлэлцүүлэгтэй нэгтгэн явуулж байгаа юм байна.

Мэндчилгээ дэвшуулье. Улсын Их Хурлын гишүүн Цэвэгдоржийн Туваан, Жигжидийн Батжаргал, Нямаагийн Энхболд нарын урилгаар Төв аймгийн Баянчандмань сумын ахмадуудын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхэнд нийт Улсын Их Хурлын гишүүдийнхээ өмнөөс улс орныхоо хөгжил дэвшил, хойч ирээдүйнхээ төлөө сэтгэл зүтгэлээ гарган ажилласан ахмадууд та бүхэндээ нийт гишүүдийнхээ өмнөөс талархсанаа илэрхийлж, урт удаан наслахыг хүсэн ерөөе.

Гишүүд санал хураалтдаа ирье. Санал хураалт Одоо энэ санал хураачихаад л завсарлана гишүүд санал хураалт явагдах гэж байгаа танхимд хүрэлцэн ирнэ үү.

Их Хурлын даргаа гадаадад томилолттой явж байгаа үед гишүүд сахилга баттай байна шүү, санал хураалтдаа бас идэвхтэй оролцоно шүү.

Ёс зүйн байнгын хорооны дарга бас энэ Баттөмөр гишүүн байна. Гишүүдээ санал хураалтад нь хамруулах хэрэгтэй. Өнөөдөр нөгөө танилцахууд их байгаа учраас гишүүд бас зураг авалт, туг руу их ороод байх шиг байна.

Бүртгэлийн санал хураалт хийгээгүй. Бүртгэлийн санал хураалт хийчихье. Гишүүд санал хураалтдаа бэлдээд. Баттөмөр гишүүнээ сууж байх уу, одоо нэг бүртгэлийн санал

хураалт хийчихье. Бүртгэлийн санал хураалт.

Одоо манай Завханы 2 гишүүн ороод ирвэл болох юм байна. Эцсийн хэлэлцүүлэгтэй хамт хийж байгаа болохоор бас хариуцлагатай байхгүй бол болохгүй.

Санал хураалт 52.5 хувиар санал дэмжигдлээ байнгын хорооноос гаргасан горимын саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Хууль зүйн байнгын хороонд шилжүүлээ.

Үдээс өмнөх чуулганы хуралдаан завсарлаж байна. Үдээс хойших хуралдаандаа идэвхтэй оролцоно шүү.

ЗАВСАРЛАГА

Ингээд 10 дугаар сарын 27-ны өдрийн үдээс хойших чуулганы үйл ажиллагаа эхэлж байна.

Хэлэлцэх асуудлуудаа үргэлжлүүлэе.

Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл Улсын Их Хурлын гишүүн Содномын Чинзориг нарын 4 гишүүн 2022 оны 10 дугаар сарын 12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэхийг нь хэлэлцэнэ ээ.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Содномын Чинзориг танилцуулна. Таныг индэрт урьж байна.

С.Чинзориг: Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд, Д.Тогтохсүрэн, Г.Ганболд, Ж.Батжаргал Н.Наранбаатар, Т.Энхтүвшин, Д.Батлут, Ц.Идэрбат, С.Чинзориг нарын боловсруулсан Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг танилцуулж байна.

Хөдөө орон нутагт төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх анхан шатны нэгжид ажиллаж буй төрийн захиргааны албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, тэдний тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлж зайлшгүй шаардлага байгаа. Аймгийн төвөөс бусад сумдад ажиллаж байгаа эрүүл мэндийн эмч, ажилтнууд, боловсролын салбарын эмч, багш, ажилтнууд, онцгой, цагдаагийн байгууллагын ажилтнуудад 5 жил тутамд нэг удаа мөнгөн урамшуулал олгодог хууль, эрх зүйн орчин үйлчилж байна аа.

Гэтэл аймгийн төвөөс бусад сумдад ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчид тасралтгүй тогтвор суурьшилтай ажилласны урамшуулал олгох хууль, эрх зүйн орчны зохицуулалтгүйгээр өдийг хүрч ирсэн Н Нөгөө талаасаа суманд ажиллаж буй төрийн захиргааны албан хаагчдын цалин, суманд ажиллаж буй төрийн үйлчилгээний албан хаагчдын цалингийн сүлжээнээс нэлээн одоо доогуур бол байна.

Тухайлбал, суманд ажиллаж байгаа боловсролын байгууллагын багш нарын цалин 800-аас сая төгрөгт хүрсэн. Суманд ажиллаж байгаа эрүүл мэндийн байгууллагын эмчийн цалин 850000 төгрөгт бол хүрсэн байна. Гэтэл сумын ЗДТГ-т газарт ажилладаг төрийн захиргааны албан

хаагчдын цалингийн доод хэмжээ 615000 төгрөг бол байна. Үүнээс шалтгаалж сумын ЗДТГ-т мэргэжилтнээр орж ажиллах залуучуудын сонирхол туйлын бага болсон төдийгүй албан хаагчид тогтвор суурьшилтай ажиллахгүй байх нөхцөл үүсэж, боловсон хүчний хомсдолд орох эрсдэл бодитой асуудлууд бий болоод байна аа.

Хууль боловсруулах явцын хүрээнд Монгол Улсын Төрийн албаны зөвлөлөөс авсан судалгаагаар сумдын ЗДТГ-т 1338 орон тоо сул байгаагаас 805 мэргэжилтэн, өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн. 319 мэргэжилтэн өөр ажилд шилжсэн гэсэн ийм статистик судалгаа бол байна. Төрийн албаны зөвлөлөөс авсан мэдээллээр сумдын ЗДТГ-аас 1089 сул орон тоог нөхөх захиалга ирүүлснээс 499-д нь нөөцөд бүртгэгдсэн иргэн байхгүй, 413 сул орон тоонд иргэн бүртгүүлээгүйн улмаас сул орон тоо нөхөгдөж чадаагүй гэсэн ийм судалгаа байна аа.

Иймд аймгийн төвөөс бусад сумдын ЗДТГ-т тасралтгүй ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчдад 5 жил тутамд нэг удаа 6 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал олгож байх хуулийн зохицуулалтыг Төрийн албаны тухай хуульд нэмж тусгах хуулийн төслийг боловсруулан та бүхэнд танилцуулж байна аа.

Хуулийн төсөл батлагдсанаар сумдад ажиллаж, төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх үүрэгтэй төрийн захиргааны албан хаагчид тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл, хөшүүрэг болохоос гадна тэдэнд амьдралын нөхцөл чанараа дээшлүүлэхэд санхүүгийн хувьд тодорхой дэмжлэг болно гэж үзэж

байна. Сумдын ЗДТГ 5 ба түүнээс дээш жил ажилласан төрийн захиргааны 1435 албан хаагч одоо ажиллаж байна гэсэн ийм судалгаа бол байна.

Хэрвээ бидний боловсруулж танилцуулж байгаа хуулийн төсөл Их Хурлаар дэмжигдэж батлагдвал 2023 онд 5 тэрбум төгрөг, цаашидаа жил бүр жил тутам нэг тэрбум төгрөг, сумдын ЗДТГ-т ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчдад 6 сард нэг удаа 5 жил тутамд нэг удаа 6 сарынх нь цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулалд зарцуулагдана гэсэн ийм төсвийн тооцоолол хийсэн болно оо.

Орон нутагт анхан шатны нэгдэж ажиллаж, төрийн бодлогыг хэрэгжүүлэх үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай, чанартай хүргэх үүрэгтэй төрийн захиргааны албан хаагчдын нийгмийн баталгааг хангахад чиглэсэн энэхүү хуулийн төслийг хэлэлцэх эсэхийг нь хэлэлцэж хэлэлцэхийг нь дэмжиж өгөхийг та бүхнээс хүсэж байна аа.

Анхаарал тавьсанд баярлалаа.

С.Одонтуяа: Баярлалаа.

Төслийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Цэрэнжамцын Мөнхцэцэг танилцуулна.

Индэрт урьж байна.

Ц.Мөнхцэцэг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Чинзориг нарын 5 гишүүн 2022 оны 10 дугаар сарын 12-ны өдөр Улсын

Их Хуралд өргөн мэдүүлсэн Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орох тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэхийн асуудлыг Төрийн байгуулалтын байнгын хороо 2022 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч, аймгийн төвөөс бусад суманд ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчид тасралтгүй, тогтвор суурьшилтай ажилласны урамшуулал олгох хууль эрх зүйн орчин, зохицуулалт байхгүйн улмаас сумын төрийн захиргааны байгууллагууд хүний нөөцийн дутагдалд орох, албан хаагчид тогтвор суурьшилтай ажиллахгүй байх нөхцөл үүсэж, суманд ажиллах албан хаагчдын тоо жил бүр буурч байна. Иймд аймгийн төвөөс бусад сумын ЗДТГ-т тасралтгүй ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчид 5 жил тутамд нэг удаа 6 сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал олгох зохицуулалтыг тусгаж, Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан байна. Хуулийн төсөл иргэдийн оролцоог хангах, санал авах зорилгоор Улсын Их Хурлын *D.parliament* хэмээн цахим системд байршуулсан болно Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Мөнх-Оргил төрийн албан хаагчид сар бүрийн цалин дээр тогтмол олгох нэмэгдэл нь нэг удаагийн шинжтэй, мөнгөн урамшуулал, тэтгэмжээс илүү үр дүнтэй гэж үзсэн, Засгийн газрын байр суурийг хэрхэн хүлээн авч авч байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Оюунчимэг эрхэлж байгаа албан тушаалын байдлаар нь тусгайлан хуульчлах нь хэр оновчтой талаар, Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй

хамт дүрэн мэдүүлсэн Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй уялдах эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Баатарбилэг Төрийн албаны зөвлөлөөс гаргуулсан судалгаанаас гадна ямар шалтгаанаар, аймгийн төвөөс бусад суманд ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчдын тогтвор суурьшилтай ажиллахгүй байгаа талаар дэлгэрэнгүй судалгаа бий эсэх, цалин урамшууллаас гадна албан хаагчдын ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, нийгмийн баталгаа хангах арга хэмжээний талаар судалж үзсэн эсэх талаар тус тус асуулт асууж, хариулт авсан болно.

Мөн Улсын Их Хурлын гишүүн Ганболд сумын төрийн захиргааны албан хаагчид албан тушаалын тодорхойлолтод зааснаас гадна өөр албан тушаалын ажлыг давхар гүйцэтгэдэг бөгөөд үүнээс үүдэн тогтвор суурьшилтай ажиллахгүй байх, суманд ажиллах албан хаагчдын тоо жил бүр буурч, хүний нөөцийн дутагдалд орсон нь хуулийн төслийг боловсруулах бодит шаардлага болсон тул хуулийн төслийг хэлэлцэхийг дэмжиж байгаа талаар Улсын Их Хурлын гишүүн Энхболд сумд хуулиар олгосон эрх хэмжээнийхээ хүрээнд зарим төрлийн татварыг нэмэгдүүлж, түүнээс бүрдэх орлого, шаардлагатай мэргэжилтэн, албан хаагчаа сургах, хүний нөөцийн дутмаг байгаа асуудлаа цогцоор нь бие даан шийдвэрлэх боломжтой талаар, Улсын Их Хурлын гишүүн Амарсайхан хуулийн төсөлд тусгасан асуудлыг төрийн албаны цалин хөлсний тогтолцооны шинэчлэлийг хийх үеэр нэг мөр авч үзэх, тэгш хандах. Алслагдсан дүүргүүдийн албан хаагчдын асуудлыг орхигдуулахгүй байх нь зүйтэй талаар Улсын Их Хурлын гишүүн Баатарбилэг орон

нутгийн нэмэгдэл тэтгэмж, урамшууллыг ангилж ойлголтуудыг тодорхой болгох, хуулийн хэрэгжих хугацааг ойртуулах боломжийг судлах талаар, Улсын Их Хурлын гишүүн Бямбацогт төвлөрлийг сааруулах бодлогын хүрээнд иргэн, хөдөө, орон нутгийн ажиллаж амьдрах нөхцөл, нийгмийн баталгааг хангах, Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамтатган хэлэлцэх нь зүйтэй талаар тус тус саналаа илэрхийлсэн болно.

Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн дийлэнх олонх буюу 90.9 хувь нь үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

С.Одонтуяа: Баярлалаа. Тэгэхээр өнөөдөр бас түүхт өдөр юм байна. Одоогоос 61 жилийн өмнө 1961 оны 10 дугаар сарын 27-ны өдөр Монгол Улс Нэгдсэн Үндэсний байгууллагын 101 дэх гишүүн орноор элссэн ийм өдөр байна. Туурга тусгаар улс гэдгээ дэлхийн түвшинд тунхаглан зарласан, НҮБ-ын бүрэн эрхт гишүүн болсон ийм сайхан өдөр байна. Мэндчилгээ дэвшүүлье.

Улсын Их Хурлын гишүүн Жаргалтулгын Эрдэнэбат, Чинбатын Ундрам, Дамдинсүрэнгийн Өнөрболор нарын урилгаар “Маргаашийг бүтээнэ” Үндэсний чуулганд Сэлэнгэ аймгаас оролцогчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхэнд баяр хүргэе ээ. Өвөрхангайх бас байгаа юм уу, тэ. Өвөрхангайнх бас байгаа юм байна. Бүгдээрээ царайлаг байна аа.

Тэгээд хамгийн гол нь өнөөдөр энэ маргаашийг бүтээнэ гэдэг Үндэсний чуулганд оролцож байгаа төлөөлөгчид гэсэн чинь дандаа эмэгтэй байна аа.

Тэгэхээр ер нь Монгол Улс энэ маргаашийг бүтээхэд эрэгтэйчүүдийн оролцоог бас ер нь шаардлагагүй гэж үздэг юм шиг байна. Ер нь шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоо өндөр байгаа орон бол өнөөдөр хөгжлөөрөө дэлхийд тэргүүлж байгаа шүү.

Тийм учраас бүсгүйчүүддээ чуулганых нь ажилд амжилт хүсье ээ.

Одоо ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Ажлын хэсгийн гишүүд орж ирсэн үү? Балдан овогтой Баатарзориг Төрийн албаны зөвлөлийн дарга, Должингийн Баатарсайхан, Төрийн албаны зөвлөлийн гишүүн, Жамбаагийн Эрдэнэбат Төрийн албаны зөвлөлийн Сургалт судалгаа мэдээллийн нэгдсэн сангийн газрын дарга. Ажлын хэсгийнхэнд манай төлөөлөгч бүсгүйчүүд бас амжилт хүсэж алга ташиж байна шүү.

Одоо хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүдийг бүртгэе.

Наранбаатар гишүүнээр тасаллаа. Баатарбилэг гишүүн асуулт асууя.

Ё.Баатарбилэг: Тэгэхээр хуулийн төслийг Байнгын хороогоор хэлэлцэх үеэр бас асууж тодруулж, санал хэлсэн дэмжиж байгаа. Тэгээд одоо яах вэ, Төрийн албаны зөвлөлийн удирдлагууд байгаа учраас хууль санаачлагч хариулах юм уу, Төрийн албаны зөвлөл.

Нэгдүгээрт яг суманд байгаа сумын Тамгын газар ажиллаж байгаа, төрийн албан хаагчидтай холбоотой нийгмийн баталгаатай холбоотой асуудал орж ирж байгаа. Үнэхээр суманд одоо жишээ нь улсын хэмжээнд 1300 гаруй орон тоо дутуу байна гэж байна. Тэгэхээр одоо сумын Тамгын газрын ТЗ-гээр цалинжиж байгаа төрийн жинхэнэ албан хаагч сая танилцуулгад дурдсанаар 600 гаруй мянган төгрөгийн цалингийн сүлжээгээр цалинжиж байгаа, тэрнээс татвараа төлөөд гар дээрээ нэг 500 гаруй мянган төгрөг л авч байгаа юм байна.

Тэгэхээр яг одоо наад 1300 гаруй орон тооны чинь одоо яг хэдэн хувь нь гэдэг юм уу, дийлэнх нь юм уу, тэр дутуу байгаа орон тоо нь одоо яг энэ цалингийн хамгийн доод шатлалаар цалинжиж байгаа төрийн албан хаагчид байгаад байна гэж ойлгож болох уу?

Яагаад гэвэл энэ чинь цалин маш бага бага байгаа учраас суманд Тамгын газарт, одоо сургууль соёл төгсөөд очсон залуучуудаас өгсүүлээд

ингээд очиж ажиллахгүй байна, суурьшихгүй байна, мэргэжлийн боловсон хүчин дутагдаад байна гэдэг ийм юм яригдаад байгаа учраас энэ цалин хөлсний асуудал яригдаад дээр нь одоо энэ хууль бол яах вэ, 5 жилийн нэмэгдэл л ярьж л байгаа юм л даа. Үнэхээр тийм байгаа бол одоо цалингийн сүлжээнд нь шинэчлэл оруулж, ингэхгүй бол одоо тэтгэвэр 500000 болчихсон шүү дээ.

Тэтгэврийн доод хэмжээ 500000 болчихоод байхад тэр сумын Тамгын газрын 10 гаруйхан мэргэжилтнүүд одоо ган, зуд, гал, ус одоо сумын хамаг хүнд хэцүү ажил болдог, олон нийтийн хамарсан ажил болдог, энэ болгонд хамгийн түрүүнд дайчлагддаг хүмүүс. Тэгээд төрийн үйлчилгээний албан хаагчид бас дайчлагддаг. Харьцангуй төрийн үйлчилгээний албан хаагчид, багш, боловсролын салбарынхан, эрүүл мэндийн салбарынхны цалин хөлс нь бас харьцангуй наад төрийн захиргааныхнаас арай дээрдчихээд байгаа юм. Өөр ч нэмэгдүүлэх шаардлага байгаа юм л даа. Тэгэхээр үнэхээр ийм бага цалингаар, одоо тэр суманд тогтвор суурьшилтай ажиллуулах. Сургууль соёл төгсөж очиж байгаа залуучуудыг хөдөө орон нутаг руу ажилла гээд орон нутагтаа очиж ажиллаач гээд ингэхэд бол хүндрэлтэй л дээ.

Тэгэхээр энэ дээр яг судалгаа нь ямархуу байгаа юм. 1000 гаруй 300 гаруй орон тоо нь яг энэ ТЗ-ын одоо хамгийн доод шатлалаар буюу 500 гаруйхан мянган төгрөг гар дээр аваад ингээд ажиллаж байгаа ийм юм байгаад байна уу гэдэг дээр нэг ийм асуулт байна. Тэгээд ер нь бол энэ цалингийн шатлал, урамшуулалтай холбоотой юмыг цогцоор нь яваандаа бол энэ удаа бол энийгээ 5 жилийн

нэмэгдлээ шийдчихээд яваандаа цогцоор нь энэ цалингийн асуудлыг шийдэхгүй бол тэтгэврийн доод хэмжээтэй адилхан цалин аваад суманд төрийн захиргааны албан хаагч тангараг өргөсөн төрийн захиргааны албан хаагч ингээд ажиллаж байна гэдэг бол бас л хүндрэлтэй л дээ.

Бид нар одоо энэ төвлөрлийг бууруулах, төвлөрлийг сааруулах, хөдөө орон нутаг руу энэ сургууль соёл төгссөн залуучуудыг хөдөө орон нутаг руу ажиллуулах, орон нутагтаа ажиллах бол нөөц идэвх сонирхлыг нь бий болгоё гээд ингээд Засгийн газраас ийм бодлого бариад яваад байдаг.

Тэгж байтал яг бодит байдал дээр цалин нь үнэхээр ийм байгаа нөхцөлд бол хүнд шүү дээ залуучууд. Тэгэхээр энэ тал дээр та бүхэн ямархуу судалгаа юмнууд байна гэдгийг тодруулж байна.

С.Одонтуяа: Хэн хариулах вэ? 93. Төрийн албаны зөвлөлийн гишүүн Баатарсайхан хариулна.

Д.Баатарсайхан: Баатарбилэг гишүүний асуултад хариулъя аа.

Ерөнхийдөө сая хууль санаачлагч Чинзориг гишүүний хэлсэн тоо баримтууд Төрийн албаны зөвлөлийн тоотой ижил байгаа. 1338 сул орон тоо байгаа юм аа.

Эндээс мэргэжилтнүүд өөрийн хүсэлтээр ажлаасаа чөлөөлөгдөөд өөр ажилд шилжээд ингээд сул орон тоо гардаг, нийтэд зарлахаар шалгалт өгөх гээд ирж байгаа иргэдийн тоо бас эрс цөөн. Саяын Баатарбилэг гишүүний хэлснээр цалингийн хэмжээ бол үнэхээр бага, тэтгэврийн доод хэмжээтэй ижилхэн.

Дээрээс нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 420000 байгаа. Энэнээс нэг жоохон ахиухан ийм цалинтай байгаа тохиолдолд ирэхгүй байгаад байгаа юм. Тэгээд ер нь бол энэ 5 жил тутамд нэмэгдэл олгоё гэдэг энэ санал тавивал Төрийн албаны зөвлөл ижил байр суурьтай байгаа.

С.Одонтуяа: Хууль санаачлагч Чинзориг гишүүн нэмье.

С.Чинзориг: Суманд ажиллаж байгаа төрийн албан хаагчдыг бас энэ тогтвор суурьшилтай ажиллуулах гэсэн энэ 5 жилд нэг удаа мөнгөн тэтгэмж өгөх асуудал нэг хөшүүрэг болох юм. Гэхдээ ингэснээр бол бүх юмыг бол сайхан болчихно гэж би бол бодохгүй байгаа юм. Хэд хэдэн одоо шалтгаан байгаа юм. Цалин хөлс бага байна.

Дээр нь орон байрны нөхцөл боломж муу. Ер нь энэ ипотекийн зээл гэхэд Улаанбаатар хот, аймгийн төвд л ипотекийн зээлд хамрагдах болохоос биш суманд ажиллаж байгаа төрийн албан хаагч хун суманд нь ипотекийн зээлд хамрагдсан, орон сууц баригддаггүй ипотекийн зээлд орох боломж байхгүй эсвэл одоо суманд ажиллаж байгаа төрийн албан хаагч Улаанбаатар хот болоод аймгийн төвд одоо баригдаж байгаа орон сууц аваад ипотекийн зээлд хамрагдвал тэр байрыг нь дагаад бас одоо шилжих хөдөлгөөн явагддаг. Энэ орон байрны нөхцөл, хүрэлцээг нь сайжруулах асуудал их чухал байгаа юм.

Хоёр дахь асуудал нь яах вэ, өмнө нь одоо бид бас ярьж байсан. Сумын ЗДТГ-т ажилд орох гэж байгаа төрийн албан хаагчид тавьдаг энэ төрийн албан хаагчийн сонгон шалгаруулалтад ороход нь тавьдаг

нөхцөл болзол ч бас жаахан хатуудаад байгаа асуудлууд, шинэ сургууль төгссөн залуу сумын Тамгын газарт мэргэжилтнээр ороход зайлиггүй одоо төрийн албанд 3 жил ажилласан байх гэдэг нөхцөл шалгуур бас жаахан өндөр байна гэж байгаад энийг бас өөрчилсөн.

Хоёр дахь асуудал нь сумын Тамгын газарт ажилд орох гэж байгаа залуучуудын мэргэжлийг бас энд Боловсролын яамнаас гаргадаг боловсролын ерөнхий индексээр тооцохоор хэт нарийвчилж тооцоод бас жаахан хатуудаад чангадаад байна гэж үзээд энэ Хөдөлмөрийн яамнаас одоо зарладаг мэргэжлийн индексээр тэр ажлын байрных нь тодорхойлолтод тавигдах мэргэжлийнх нь шалгуур нөхцөлийг одоо бас жаахан зөөллөх ийм одоо чиглэлийн арга хэмжээнүүд авах зайлиггүй шаардлагууд бол байгаа.

Тийм учраас бол олон бас суманд ажиллаж байгаа төрийн албан хаагчдыг тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллахад нөлөөлж байгаа олон хүчин зүйлүүд байгаагийн нэг нь бол энэ 5 жил тутам нэг удаа 6 сарынх нь цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмж олгоё гэж, нөгөө талдаа бас төр орон нутагт ажиллаж байгаа төрийн албан хаагчдаа тэгш ижил, одоо хандах нөхцөл боломжийг нь бүрдүүлье.

Боловсролынхон эрүүл мэндийнхэн, онцгойхон цагдаагийнхан 5 жил тутам, одоо бас нэг удаа бас энэ мөнгөн урамшуулал авдаг. Сумын Тамгын газарт ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагч энэ одоо урамшууллыг авч чадахгүй байгаа учраас бол ийм одоо хуульд өөрчлөлт оруулж байгаа.

Баатараяа гишүүний яриа асуугаад байгаа тэр 615000 төгрөг гэдэг бол Засгийн газраас төрийн албан хаагчдын цалингийн сүлжээг Засгийн газар тогтоосон цалингийн сүлжээ. Яг одоо хамгийн доод цалин. Яг одоо 1338 хүний хэд нь одоо тэр 615-аар цалинждаг хүн байна уу гэдгийг нарийвчилсан судалгаа бол бид зүгээр авч чадаагүй.

Хэрвээ шаардлагатай бол Төрийн албаны зөвлөлөөс тодруулж Баатарбилэг гишүүнд бас яг тодорхой 615000 төгрөгийн цалин авдаг, доод одоо цалингаа цалинждаг хүн тэр 1330-ын дотор хэд байнд байгаа юм бэ гэдгийг бас нарийвчилсан тоо бас гаргаж өгөх ийм боломжтой болох болов уу гэж л бодож байна.

С.Одонтуяа: Баатарбилиг гишүүн тодруулъя.

Ё.Баатарбилэг: Тэгээд энэ хууль бол ингэж байгаа, 2023 оны 1 сарын 1-нээс эхэлж мөрдөе гээд. Тэгээд 5 жил тутам гэхээр энэ нөгөө 2023 оны 1 сарын 1-нээс 5 жилээ тооцож явах гээд байна уу? Яагаад гэхээр энэ нөгөө төсөвтэй холбоотой болохоор энэ төсөвт суусан юм юу билээ л гэж бодоод байна л даа. 2023 оноос тооцоод 5 жил гээд 2028 оноос олгох юм яриад байна уу, эсвэл одоогоор 5 жил ажиллачихсан хүмүүс нь 5-аас дээш жил ажиллачихсан хүмүүс гээд 2023 оноосоо тоог нь гаргаад жил болгон ингээд олгоод явах юм уу гэдэг дээр энэн дээр хууль санаачлагч яаж тооцсон юм бол.

С.Одонтуяа: Чинзориг гишүүн хариулт өгье.

С.Чинзориг: Одоо сумдын ЗДТГ-т ажиллаж байгаа төрийн албан хаагчдыг судалгаа аваад

үзэхлээр 5 ба түүнээс дээш жил ажилласан 1534 хүн байна гэсэн ийм статистик судалгаа Төрийн албаны зөвлөлөөс бол авсан юм. Тэгээд энэ хуулийг хэлэлцэх эсэхийг нь дэмжээд гишүүд анхны хэлэлцүүлэгт шилжүүлчихвэл 2023 оны төсвийг одоо хэлэлцэх асуудал ид одоо Их Хурал дээр яригдаж байна. 2023 оны Төсвийн тухай хуулийг дагалдан одоо өргөн барьсан, мөн Төрийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах, орон нутгийн нэмэгдэл бий болгохтой холбоотой хуулийн зохицуулалтууд бас явж байгаа. Тэгэхээр энэ одоо төсөв болоод дагалдан өргөн барьсан хуулиудтай энэ одоо хуулийг бас хамтатган хэлэлцээд явах нь зүйтэй юм гэж бодож байгаа. Яах вэ, тэр 5 тэрбум төгрөг хэрэгтэй гэж байгаа 2023 оноос хэрэгжүүлэхээр. Тэгээд энийг нь төсвийн хэлэлцүүлгийн явц явцад бас шийдэх тийм боломж нь юу байна уу гэж.

Хэрвээ хууль батлагдах юм бол 1 сарын 1-нээс одоо тэр 5 жил ажиллачихсан байгаа 1534 хүн нь урамшуулал авна.

С.Одонтуяа: Одоо Ширнэнбандийн Адышаа гэсэн асуулт асууя.

С.Чинзориг: Энэ хуулийн төслийг бол дэмжиж байгаа. Ер нь төрийн анхан шатны нэгжид ажиллаж байгаа төрийн албан хаагчдын цалин хөлс, нийгмийн хамгааллын асуудлыг өнөөдөр Монголын төр авч үзэж, хэлэлцэж, шийдвэрлэж байж энэ төрийн дархлааны асуудлыг бид авч үзэх ёстой. Өнөөдөр энэ Улсын Их Хурлын гишүүдээс өргөн барьсан төрийн анхан шатны нэгжид ажиллаж байгаа төрийн албан хаагчид 6 сар, 5 жил тутамд 6 сарын нэг удаагийн

мөнгөн тусламж олгох энэ асуудал зүгээр л нэг удаагийн шинж чанартай. Зөвхөн энэ өнөөдөр асар их бэрхшээл, бухимдал үүссэн энийг нүүр гарыг нь угаагаад өнгөрч байгаа л төдий энэ асуудал. Гэсэн хэдий ч энийг ингэж санаачилж оруулж ирсэн гишүүдэд бас талархаж байна аа.

Тэгээд 2, 3 зүйлийг асууя. Энэ хөдөө орон нутагт ЗДТГ-т өнөөдөр ажлын байр бий болсон тэнд ажиллах хүмүүс олдохгүй байгаа нь энэ бодит өнөөдөр нүүрлэсэн ийм бэрхшээл. Энд 2 хүчин зүйл байгаа гэж үзэж байгаа.

Нэг дэх хүчин зүйл нь цалин хөлс, нийгмийн хамгааллын асуудал.

Хоёр дахь нь тэнд ажиллаж байгаа хүмүүсийн энэ ажлын байрны тодорхойлолт, тэнд тавигдах ажлын байрны шаардлага гэдэг өнөөдөр нэг загварын энэ хуулийн ч юм уу, одоо Төрийн албаны зөвлөлийн шийдвэр ч юм уу, ийм загвар гаргачхаад тэр одоо загвартаа баригдаад тэнд одоо шинээр сургууль төгсөж очсон, хөдөө орон нутагт ажиллах сонирхолтой энэ төрийн албанд зүтгэх бодолтой хүмүүст энэ хаалт болж байгаа.

Энэ асуудлаа хуулиар нэн тэргүүнд шийдэх ёстой. Ингэж байж бид өнөөдөр төрийн албыг бэхжүүлэх, төрийн албанд ажиллах бэлтгэл хүчийг хангах төрийн бодлого явагдах ёстой гэсэн ийм байр суурьтай байгаа. Нөгөө талаасаа би энэ Төрийн албаны зөвлөлийн дарга нараас бас ганц 2 зүйлийг ажлын хэсэгт асууя гэж бодож байгаа. 2017 онд батлагдсан Төрийн албаны зөвлөлийн Төрийн албаны тухай хууль ер нь хэрэгжилт нь өнөөдөр ямар шатандаа байна аа, энэ талаар та нар ер нь юу гэж бодож байна. Энэ хууль хэрэгжиж байна уу, хэрэгжихгүй байна уу, хэрэгжихгүй

байхад ямар бэрхшээл тавигдаж байна. Ямар одоо асуудал гарч ирж байна гэдэг дээр бас нэг төрийн эрх барих дээд байгууллагад нэг үгийг нь сонсмоор байна. Яагаад гэхээр өнөөдөр мерит зарчим гэдэг нэг юм өнөөдөр үйлчлэх ёстой. Энэ үйлчилдэггүй. Ковид гэдэг нэрийн дор олон 10 төрийн албан хаагчдыг үүрэг гүйцэтгэгчээр тавьсан энэ үйл явдал үргэлжилсээр байгаа. Нөгөө талаасаа төрийн албаны сул орон тоон дээр тэр ажил мэргэжлээрээ шалгараад оноогоо аваад гараад ирсэн ийм төрийн албан хаагчдыг томилдоггүй. Сонирхлын зөрчилтэй. Тэгээд бүр томилох шаардлага хангангуут зарим хүмүүсийн 10, 20 жилийн өмнө тийм зөрчилтэй байна гэдэг мэдээлэл цуглуулж аваад цагдаа, хууль хүчний байгууллагаар шалгуулдаг.

Энэ дээр одоо Төрийн албаны зөвлөл ямар одоо байр суурьтай байна аа? Энэ дотор бол тэр яамдад байдаг агентлагуудад байдаг Төрийн албаны салбар зөвлөл гэдэг тэр байгууллага чинь өнөөдөр ажлаа хийж чадаж байгаа юу, чадахгүй байгаа юу? Хэрвээ ийм одоо ёс бус зүйл гаргасан Төрийн нарийн бичгийн дарга, салбар зөвлөлийн дарга нарт хариуцлага хүлээлгэчих тийм асуудал гарах гарч байсан уу? Ийм асуудал гарсан, гаргасан тийм хүмүүстэй Төрийн албаны зөвлөл Монгол Улсын хуулийн хүрээнд арга.../минут дуусав/

С.Одонтуяа: Хэн хариулах вэ?
93. Баатарзориг дарга хариулъя.

Б.Баатарзориг: Баатарбилэг Улсын Их Хурлын гишүүн, Чинзориг гишүүн, Адъяаа гишүүн асуусан. Бас тодорхой хариулсан. Төрийн албаны шинэтгэл олон үе шаттайгаар өргөн хүрээнд явагдаж байна. Энэний нэг нь бол саяын хэлэлцэж байгаа асуудлаа 5

жил тутамд сумдад ажиллаж байгаа Тамгын газрын захиргааны албан хаагчдад 6 сарын нэмэгдэлтэй холбоотой, энэтэй холбоотойгоор зөвхөн нэмэгдэл олгоод зогсохгүй бас зарим одоо зүйлүүдийг хуульд нэмэлт, өөрчлөлт орохгүйгээр журам, дүрмүүдэд нэмэлт өөрчлөлт оруулах замаар хөдөөгийн хөгжлийн сэргэлтийг сайжруулахтай холбоотой зүйл хийгдэнэ ээ. Төрийн албаны зөвлөлөөс нэгдэн сумын захиргааны байгууллагад ажиллах сум, тосгон, багт ажиллах төрийн албан хаагчид тавигдах мэргэжлийн шаардлагыг одоо байхгүй болгох, анх орж байгаа ажилтнуудад тийм чиглэл барьж байгаа.

Хоёрдугаарт нь туслах түшмэлийн болон дэс түшмэлийн албан тушаалд ажиллахад ажилласан жилийн босгыг одоо хөнгөвчилж байгаа. Ийм олон зүйлүүд зэрэг явагдаж байгаа.

Адъяаа гишүүн сая түрүүнд ярьсан. Бас одоо Төрийн албаны тухай хууль үе шаттайгаар хэрэгжиж байна. Хэрэгжихдээ олон сорилтууд тулгарлаа.

Нэгд нь ковидтой холбоотой, зарим давагдашгүй хүчин зүйлтэй холбоотой, цаг хугацаатай холбоотойгоор Төрийн албаны хуулийг эрчимтэй хэрэгжүүлэхэд бас хүндрэл гарсан. Үүнтэй холбоотойгоор Ковидын хуулийн 3.2 заалтыг барьж 2708 төрийн албан хаагч томилогдсон байсан. Энд бид нар хяналт шалгалт, зөвлөн туслах ажлуудыг хийгээд 1310 төрийн албан хаагчдын нөхөгдөөгүй байсан тусгай шалгалтыг нээлттэйгээр зарлаад тэнцсэн ч, бий тэнцээгүй нь ч бий нөхөх ажлуудыг хийсэн. Мөн зарим хууль бус томилгоотой холбоотойгоор Төрийн

албаны зөвлөл 500 гаруй төрийн албан хаагчдын хууль бус томилгоог хүчингүй болгосон. Ийм учраас хууль хэрэгжилтийн үе хууль засаглах үйл ажиллагаа явагдаж байгаа. Та өмнө бас нэг чиглэлийг өгсөн. Сонгон шалгаруулалтаар нэгд орсон хүнийг тодорхой яамны босоо бүтэцтэй, аймаг дээр байгаа хүнийг томилохгүй байгаа талаар 14 хоногийн өмнө бид нар шалгалт хийгээд тухайн хүнийг томилох үйл ажиллагаа явагдсан байгаа. Энэ тодорхой жишээтэй тодорхой албан тушаалтантай учраас бид нар энэ дээр одоо зохих арга хэмжээ аваад явна. Ийм үзэгдэл бол гарсан. Төрийн албаны зөвлөл, Төрийн байгуулалтын байнгын хороо, Ёс зүйн хороотой хамтраад энэ хууль сахиулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх үйл ажиллагааг үе шаттай хэрэгжүүлж байгаа болно.

Баярлалаа.

С.Одонтуяа: Баярлалаа.

Дараагийн асуулт асуухын өмнө мэндчилгээ дэвшүүлье.

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн ерөнхий боловсролын 23 дугаар сургуулийн 11-ийн В ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Нийт Улсын Их Хурлын гишүүдийнхээ өмнөөс эх орны ирээдүйг бүтээх сурагч дүү нартаа хүсэл мөрөөдлийнх нь зам улам дардан байх болтугай гэж ерөөе.

Одоо дараагийн асуулт асуух гишүүн. Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн асуултаа асууя.

Б.Бат-Эрдэнэ: Их баярлалаа.

Улсын Их Хурлын нэр бүхий гишүүдийн өргөн барьсан энэ хуулийн төслийг бол дэмжиж байна аа. Надад 2 зүйлийн асуулт байна.

Нэг нь бол Засгийн газраас баримталж байгаа ерөнхий чиг шугам бол нэг удаагийн мөнгөн тусламж, урамшуулал гэхээсээ илүү цалинг нь нэмэгдүүлэх ийм боломжийг бий болгох. Цаашилах юм бол өнөөдөр баримталж байгаа цалингийн зэрэглэл 100 гаруй шатлал, зэрэглэлтэй байгаа. Энийг бусад улс орнуудын жишгээр Сингапурын тухайлах юм бол Сингапур улсын жишгээр 60 орчим дээр авч ирэх ийм шинэчлэл хийхээр яригдаж байгаа.

Тэгэхээр зэрэг энэ Засгийн газрын баримталж байгаа бодлого, чиглэлтэй хир уялдаж байгаа вэ гэсэн нэг ийм асуулт байна.

Ер нь та бүхнийхээ санаачилж байгаа энэ хуулийн төслийг бол дэмжиж байгаа. Бодит байдал дээр бол одоо цалин нийгмийн баталгаа нь хангалтгүй байгаагаас тухайн орон тоон дээр ажиллах хүмүүс асар их дутагдалтай байна. Цалин амьдралд нь хүрэлцэхээргүй ийм нөхцөл байдалтай байна. Манай биеийн тамирын салбарт гэхэд бол их амаргүй нөхцөл байдалтай юм байна лээ. Төрийн захиргааны төв байгууллага биеийн тамирын энэ салбарын бодлогыг хэрэгжүүлж байгаа, улс орон даяар хэрэгжүүлж байгаа Биеийн тамир, спортын улсын хороо тохируулагч агентлаг гэхэд одоо 72 хүний орон тоо, бүтэцтэй ажиллахаар өнөөдөр 50 орчим хүнтэй л байна. Зарим хэлтэс нэг мэргэжилтэнтэй ажиллаж байх жишээтэй. Ажиллах хүмүүс хүний нөөцийн асуудал асар их дутагдалтай. Энэний цаад талд бол цалин, нийгмийн

хамгаалал, баталгаатай холбоотой асуудал байгаа юм.

Ер нь биеийн тамирын салбар гээд ингээд аваад үзэх юм бол энэ аймаг, нийслэл, дүүрэг, улсын биеийн тамирын хороонд ч гэсэн ажиллаж байгаа энэ биеийн тамирын салбарын ажиллагсад бол одоо ЕБС-руу биеийн тамирын багшаар шилжиж ажиллах сонирхолтой. Тэнд бол арай жаахан цалингийн нэмэгдэлтэй гэж үзээд тийшээ шилжээд байдаг юм байна. Гэтэл бол ерөнхий боловсролын сургуулиудад ажиллаж байгаа багш нараасаа биеийн тамирын багш нар бол хамгийн доогуур цалин хангамжтай байдаг ийм зүйлүүд байх юм.

Энэ асуудлуудыг яаж одоо арилгах вэ. Хуулийн төсөл санаачлагч манай Чинзориг гишүүн бол Хөдөлмөр нийгмийн хамгааллын салбарын чиглэлд, одоо сайд, орлогч сайд, гол ажлыг л одоо насаараа хийсэн. Энэ талаар бол мэргэжилтэй, одоо мэргэшсэн ийм хүн л дээ. Тэгэхээр зэрэг та бид бас санал онолоо солилцож байсан. Энэ төрийн байгууллагуудын салбарын ажиллагсдын цалин, нийгмийн хамгааллын энэ баталгаа ялгамжгүй байх нэгдсэн нэг тогтолцоо, бодлоготой байх энэ тал дээр одоо ямархуу чиглэлийг авч хэрэгжүүлэх вэ?

Цаашидаа энийг Засгийн газрын дэвшүүлж байгаа бодлоготой нь уялдуулаад нэг цогцоор нь авч үзэхгүй бол ингээд ойцон цойцон нэг салбарын хууль орж ирэхдээ тухайн салбарын нийгмийн хамгааллын асуудал, цалин тэгээд орон тоо, эсвэл нэг тусад нь агентлаг байгууллага байгуулах ийм асуудлууд орж ирэхээр зэрэг бол энэ чинь учир дутагдалтай байна гэж үзээд байна л даа. Тэгээд энэ талаар

ямархуу санал онолтой байх вэ? Төрийн албаны зөвлөлийнхөн бол энэ дутуу байгаа орон тоон дээр ажиллах хүн байхгүй байгаа, төрийн албаны тавигдсан шалгуур нөхцөлийг хангаж чадахгүй байгаа ийм ийм асуудал, бэрхшээлүүд та бүхэн дээр одоо тооцоо судалгаагаар ямар байдаг юм? Манай энэ тухайлбал салбар чиглэлээр нь манай биеийн тамирын салбар чиглэлээр хийсэн тооцоо судалгаа юм байна уу? Манай хувьд бол нэлээн хүндрэлтэй ийм нөхцөл байдалтай.

С.Одонтуяа: Хэн хариулах вэ? Хууль санаачлагч Содномын Чинзориг хариулъя.

С.Чинзориг: Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Ер нь Засгийн газар өөрөө төрийн албан хаагчдынхаа хувьд бол ажил олгогч нь. Тийм учраас төрийн албан хаагчдын цалин хөлс, нийгмийн хамгаалал, нийгмийн баталгаа ажиллаж амьдрах нөхцөл боломжийг нь сайжруулахтай холбоотой асуудал бол Засгийн газрын өөрийнх нь одоо шийдэх ёстой асуудал байдаг. Үе үеийн Засгийн газар л төрийн албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах, цалин хөлсийг нь нэмэгдүүлэх, нийгмийн хамгааллыг нь одоо сайжруулах талын олон арга хэмжээ авч ажиллаж ирсэн.

2023 оны төсөв дээр ч гэсэн бас төрийн албан хаагчдын цалинг бас нэмэгдүүлэх, ялангуяа төрийн захиргааны албан хаагчдын цалингийн шатлалыг цөөлөх, доод цалинг нэмэгдүүлэх, орон нутагт ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчдад, орон нутгийн 20 хувийн нэмэгдэл олгох энэ тэр гээд асуудлууд орж ирсэн байгаа. Энийг бол бид бол бас дэмжиж байгаа. Ер нь төрийн албан хаагчдадаа төр ижил тэгш хандах ёстой гэсэн ийм бас зарчмын

байр суурь бид бол баримталж ажилладаг. Тэр утгаараа бид өмнө нь одоо бас гишүүд санаачилж батлуулсан Төрийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулаад төрийн үйлчилгээний албан хаагчид хэдийгээр төрийн үйлчилгээний албанд ажиллаж байгаа ч гэсэн төрийн албан хаагч. Гэсэн атлаа төрийн захиргааны албан хаагчид нь төрд ажилласны удаан жилийн нэмэгдэл аваад байдаг, төрийн үйлчилгээний албан хаагчид нь төрд ажилласан удаан жилийн нэмэгдэл авдаггүй байсныг бид одоо бас Төрийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулахдаа бас одоо төрийн үйлчилгээний албан хаагчдыг төрдөө ажиллаж байгаа, зүтгэж байгаагийнх нь хувьд адилхан үнэлж, төрд ажилласны удаан жилийн нэмэгдэл олгодог болгосон гэх мэтчилэн ийм төр төрийнхөө албан хаагчдад ялгамжгүй, тэгш хандах ийм бодлого бол баримталж байгаа.

Энэ удаагийн энэ төрийн сумын ЗДТГ-т ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчдад 5 жил тутамд нэг удаа мөнгөн урамшуулал олгодог энэ бодлого ч гэсэн төрийн албан хаагчдаа төр ялгамжгүй, тэгш хандах зарчмын хүрээнд л энэ хуулийн төслийг бол боловсруулж оруулж ирсэн гэж бол үзэж байгаа. Одоо суманд ажиллаж байгаа багш нар, эмч нар 3 жилд нэг удаа, багш нар бол 5 жилд нэг удаа цагдаа, онцгойгийнхон 5 жилд нэг удаа мөн одоо бас мөнгөн урамшуулал авдаг. Тэгсэн атлаа суманд ажиллаж байгаа сумын ЗДТГ ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчид нь 5 жил тутамд нэг удаа, бусад одоо төрийн албан хаагчидтайгаа адилхан нэг удаагийн мөнгөн урамшуулал авч чадахгүй яваа юм аа.

Тийм учраас бол сумын ЗДТГ-т одоо ажиллаж байгаа төрийн захиргааны жинхэнэ албан хаагчдаа, бусад суманд ажиллаж байгаа төрийн албан хаагчидтай адилхан тэгш хандах ялгамжгүй хандах нь зүйтэй гэж үзэж Тамгын газарт ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчдад 5 жил тутам мөнгөн урамшуулал олгодог байх энэ хууль эрх зүйн орчныг бол боловсруулж оруулж ирж байгаа гэдгийг бол хэлье. Энэ бол Засгийн газрын баримталж байгаа бодлого шийдвэр. Ялангуяа төрийн албан хаагчидтайгаа ялгамжгүй, тэгш хандах ёстой гэсэн энэ зарчимтай бүрэн бас нийцэж байгаа гэдгийг бол хэлье.

Би Бат Эрдэнэ гишүүнтэй санал бол нэг байдаг. Ер нь бол төр төрийнхөө албан хаагчтай ижил тэгш, ялгамжгүй хандах ёстой.

Хоёрдугаарт, төрийн албан хаагчдын цалин хөлс, нийгмийн хамгаалал, нийгмийн баталгаатай холбоотой асуудлыг нэг цонхоор хардаг байх, зөвхөн Төрийн албаны тухай хуулиар одоо зохицуулагддаг байх ёстой гэсэн ийм зарчим бас баримталж байгаа гэдгээ хэлье. Бид ч гэсэн одоо энэ зарчмынхаа дагуу төрийн албаны хуулийн шинэчилсэн найруулгад бас тусгаж, төрийн албан хаагчид олгодог нэг удаагийн мөнгөн урамшуулал, цалин хөлс, тэтгэвэрт нь гарахад нь олгодог нэг удаагийн тэтгэмж, эд нарыг бүгдээрэнг нь ижил, ялгамжгүй болгосон гэдгийг бас хэлэхийг хүсэж байна.

С.Одонтуяа: Төрийн албаны зөвлөлөөс нэмэлт мэдээлэл өгнө үү. 93 дугаар микрофон.

Б.Баатарсайхан: Ер нь суманд ажиллаж байгаа албан хаагчдын

цалин хөлс, нийгмийн баталгаатай холбоотой асуудал бол бага байгаа гэдгийг түрүүн хэлсэн. Жишээлээд та бүхэнд саяын одоо өнгөрсөн хугацаанд авсан төрийн албаны ерөнхий шалгалтын мэдээнээс бас товч харуулъя. Тэгэхээр одоо суманд байгаа албан хаагчдад нөхөгдөх нөөц бүрдсэн гэж ойлгож байгаа.

Улаанбаатар хотын хэмжээнд 754 албан хаагч тэнцсэн байх жишээтэй. Ер нь улсын хэмжээнд бол 1541 албан хаагч шалгалтад тэнцсэн. Тэгэхээр энэ чинээгээр бас аймгуудад, сумдуудад төрийн албаны сул орон тоонд тусгай шалгалтаар өрсөлдөх нөхцөл бололцоо нь бол бүрдэж байгаа. Цаашидаа бол улирал бүр шалгалт авах учраас он гарангуут одоо эхний улирлын шалгалт мөн л одоо ойрхон ирсэн гээд. Энэ дээр Төрийн албаны зөвлөлөөс бол энэ шалгалтын сорил даалгаврыг бас уян хатан болгох, байгаль хамгаалагчид тохирсон, арай зөөлрүүлсэн сорил тесттэй байх гэх мэтчилэнгийн ийм бодлогууд бас явж байгаа.

Баярлалаа.

С.Одонтуяа: Нанзадын Наранбаатар гишүүн асуулт асууя.

Н.Наранбаатар: Баярлалаа. Сүүлийн жилүүдэд хөдөө орон нутагт суманд, ялангуяа ЗДТГ ажиллах төрийн албан хаагч, төрийн үйлчилгээний албан хаагчид олдохоо байж маш олон сул орон тоо бий болж байгаа. Энэ нь юутай холбоотой юм гэхээр зэрэг энэ юмны өсөлт, тэгээд тэдний орлого болох цалинтай холбоотой. Тэгэхээр эндээс одоо хамаарч маш олон орон тоо сул байгаа. Улсын Их Хурлаас Засгийн газраас бол энэ хөдөө орон нутагт ажиллах, энэ сэдлийг төрүүлэх, идэвх

урмыг өгөх зорилгоор бид бас тодорхой хуулийг санаачлаад өнгөрсөн хаврын чуулганаар аймгийн төвөөс бусад суманд ажиллаж байгаа онцгой шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албан хаагчид бас 5 жил тутмын урамшуулал олгодог болсон. Одоо бас сумын Тамгын газар ажиллаж байгаа Төрийн захиргааныхан бас одоо урамшуулал олгодог болох зэргээр мөн энэ төсөв дагаж орж ирсэн Төрийн албаны хуулиар бол мөн орон нутгийн нэмэгдэл 80 хүртэлх хувийг олгох, 20 хувийн нэмэгдэл төрийн захиргааныханд олгох гэх мэтчилэн энэ Улсын Их Хуралд Засгийн газраас бас нэлээн арга хэмжээ авч төвлөрлийг сааруулах одоо ийм хөшүүргүүдийг бол хэрэглэж байна аа.

Нөгөө талдаа Төрийн албаны зөвлөлөөс бас төрийн албаны шалгалтыг авч, ялангуяа хөдөө орон нутаг, сумын тамгын газрын ТЗ, байгаль орчны байцаагч нараас төрийн албаны шалгалтыг яг Улаанбаатарт одоо авдаг шалгалттай ижил хэмжээнд авснаас болоод энэ бидний хэрэгжүүлээд байгаа энэ бодлого чинь хэрэгжихгүй байгаад байна. Маш их олон орон тоо сул хэвээрээ байгаад байна аа. Ажиллах хүн олдохгүй байна. Үүнийгээ дагаад одоо төрийн үйлчилгээ иргэдэд хүрч чадахгүй байна гэдэг асуудал бас их яригдаж байна.

Тийм учраас Төрийн албаны зөвлөлөөс бас тодорхой асуулт асууя.

Яг өнөөдрийн байдлаар сумын ЗДТГ-т хэчнээн сул орон тоо байна вэ? Энэ тоог нэг хэлээдхээч. Цаашидаа одоо энэ сул орон тоог нөхөхөд танайхаас одоо ямар арга хэмжээ авах вэ? Тухайлах юм бол суманд төрийн албаны шалгалт авахгүй байх ч юм уу, аль эсвэл одоо Улаанбаатар

аймагт авдаг энэ төстээс арай өөр хэлбэрээр тэдний амьдрал дээр буусан, байдлаар асуулт хариулт даалгаврыг нь зохицуулдаг ч юм уу, иймэрхүү ямар дорвитойхон арга хэмжээ авахаар байна. Заавал хуульд өөрчлөлт оруулах шаардлага байна уу, аль эсвэл та бүхэн тодорхой өөрсдийнхөө дүрэм журамд өөрчлөлт оруулаад ингээд цаашидаа сумын энэ сул орон тоог нөхөх бодлого баримталж байна уу гэдэг дээр товч ойлгомжтой тайлбарыг бас өгөөч ээ гэж хүсэх байна.

Баярлалаа.

С.Одонтуяа: Хэн хариулах уу Баатарзориг дарга 93 дугаар микрофон.

Б.Баатарзориг: Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт 7 сард орох үед Наранбаатар дарга тодорхой санал Их Хурлын гишүүн илэрхийлсэн. Бид нар үе шаттайгаар зөвхөн хуульд өөрчлөлт ороод зогсохгүй дагалдан гарах журам, дүрмүүдээ өөрчлөлт оруулалтын ажлууд бол явагдаж байгаа. Үүнтэй холбоотойгоор сум, тосгон, багт ажиллах төрийн албан хаагчдын шалгалтыг тусгай журмаар зохион байгуулах боломж бол бүрдүүлж байгаа. Өмнө нь сонгон шалгаруулалтыг 5 тус тусдаа төрлөөр 5 журмаар зохицуулдаг байсан бол одоо журмыг хүртэл цөөлж, нэг журамтай, нэг журмыг үзэхэд тавуулаа харилцааг нь зохицуулчихдаг. Тэгээд аль алиныг нь харчихдаг хүн ерөнхийгөө ч харна, тусгайгаа ч харна гээд.

Хоёрдугаарт нь сумдад ажиллахад тусгай шалгалтын тухайд зөвхөн ярилцлага авахаар ийм одоо бас өөрчлөлтүүд бол орж байгаа. Яагаад гэхээр хэд хэдэн цогц үе шаттай алхмуудыг Засгийн газраас Улсын Их

Хурлаас 2023 оны төсөвт суурилуулж байна. Энэ төрийн захиргааны мөн одоо тусгай албадын цалин хөлсийг нэмэгдүүлэхтэй холбоотой орон нутгийн нэмэгдлийг олгохтой холбоотой, мөн Чинзориг гишүүний болон 4 гишүүний санаачилсан орон нутагт ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчдыг 5 жил тутамд 6 сарын энэ цалин хөлсний урамшуулалтай холбоотой зүйл яригдаж байгаа. Энэ хүрээнд иж бүрэн хандах нь зөв гэж үзээд бид нар одоогоор 312 суманд яг үнэндээ боловсон хүчин, хүний нөөц дутагдалтай байна. Энэ дээр 1472 сул орон тоо байгаа. Энэ дээр нөхөх ажлыг нэн тэргүүнд хийх зорилго тавьж байгаа. Тэр хүртэл нүх нөхөхгүй гэхгүй. Ковидын хуулийн үйлчлэх хугацаа нь зайлшгүй шаардлагатай тохиолдолд яг одоо зүйл, заалтаа бариад томилоход ажилласан жилийн босго мэргэжлийн шаардлагыг яг туслах түшмэл дээр, дэс түшмэл дээр уян хатан хандаж байгаа. Яагаад гэвэл 312 суманд одоо боловсон хүчин хүний нөөц дутагдалтай байгааатай холбоотойгоор нөхцөл байдалд тохирсон менежментүүдийг бол зохион байгуулж байгаа.

Шаардлагатай тохиолдолд бүсчилсэн болон бусад хэлбэрээр ерөнхий шалгалтыг авах журамласан зохицуулалт бол бий. Улсын Их Хурлын гишүүдэд талархалтай байгаа. Энэ төрийн албан хаагчдын цалин хөлс, нийгмийн баталгааг хангахтай холбоотой үе шаттай үйл ажиллагаанууд дээр аль ч тойргууд дээр нэгдмэл бодлого бариад ингээд одоо энэ жилээс эхлүүлээд үе шаттайгаар хэрэгжүүлж байгаад талархалтай байгаагаа зориуд хэлье ээ. Энэ бол миний үг биш, одоо төрийн албан хаагчидтай уулзахад зөв ажлын

эхлэлүүд тавигдаж байна даа гэдэг ийм сайн талын хандлага байгаа гэдгийг зориуд хэлье ээ.

Баярлалаа.

С.Одонтуяа: Наранбаатар гишүүн тодруулахын өмнө мэндчилгээ дэвшүүлье.

Улсын Их Хурлын гишүүн Чинбатын Ундрамын урилгаар Орчлон сургуулийн 9-ийн Б ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Нийт Улсын Их Хурлын гишүүдийнхээ өмнөөс та бүхэнд сурлагын өндөр амжилт хүсье. Эрдэм боловсролтой, эрүүл чийрэг бие бялдартай, эх оронч үзэлтэй ирээдүйн иргэд болохын ерөөлийг дэвшүүлье.

Багшид нь мөн сурган хүмүүжүүлэх үйлсэд нь амжилт хүсье ээ.

Наранбаатар гишүүн тодруулъя.

Н.Наранбаатар: Хөдөө суманд бүүр одоо алслагдсан сумаас зайдуу хөдөө газар, байгаль орчны байцаагч, Тусгай хамгаалалттай газар нутгийн байгаль хамгаалагч энэ тэр гэсэн хүмүүс бол дандаа малчид байгаа л даа. Тэнд бол залуучууд очиж ажиллана гэж байхгүй. Тэгээд малчид маань төрийн албаны шалгалтад ороод тэнцэхгүй байгаа. Энэ бол одоо бодитой. Би тойргоороо явж байгаад уулын аманд очиж нэг айлд орж очсон. Тэр айлын өвгөн хөгшин 2 байсан. Өвгөн надад ярьж байсан юм. Үгүй ээ, ах нь одоо энэ хавьд манайх ганцаараа. Эргэн тойрон хорь гаруй километр айл байхгүй. Тэгээд энэ хавийнхаа одоо байгаль хамгаалагч, тусгай хамгаалалттай газрын байцаагч хийх

гэхээр төрийн албаны шалгалт өг гэх юм. Тэрийг нь өгөхөөр одоо 3 удаа ороод тэрэнд нь тэнцэхгүй юм гээд ингээд сууж байсан.

Тийм учраас энэ дээр ямар өөрчлөлт оруулахаар та бүхэн төлөвлөж байна вэ? Байгаль орчны яаманд бас би саналаа хэлж байсан. Төрийн албаны зөвлөлд саналаа явуулсан гэж хэлсэн. Энэ дээр та бүхэн дорвитой шийдэхээр.../минут дуусав/

С.Одонтуяа: Наранбаатар гишүүний тодруулгад хариулъя. 93 дугаар микрофон. Баатарзориг дарга.

Б.Баатарзориг: Наранбаатар гишүүний тодруулга асуултад хариулъя.

Хоёр бэрхиээлтэй асуудал байгаа юм.

Нэгдүгээрт нь одоо салбарынх нь хууль дээр тодорхой мэргэжил заачихдаг нэг ийм зохицуулалтаас болж зарим дээр нь бол яалт ч үгүй мэргэжлийн ийм шаардлагууд яваад байгаа. Засгийн газраас баримталж байгаа бодлогын хүрээнд ангилал зэрэглэлийн шинэчилсэн төсөл явж байгаа. Энэ төсөл дээр одоо ТЗ-ны 1, 2, 3 дугаар шатлал дээр тус бүрд нь 5 шатлалтай байсан бол нэг шатлал руу шилжих гэж байгаа. Түрүүний асуултад холбоотой. Тухайлах юм бол төрийн үйлчилгээний 295 ийм шатлалтай цалин байдгийг 59 болгож цөөрүүлэх гэж байгаа. Төрийн тусгайгийн 165-ыг 10 болгож цөөрүүлэх гэж байгаа. Төрийн захиргааны 165-ыг 10 болгоно гээд ийм зүйлүүд. Яг шалгалтын үйл ажиллагаатай холбоотой зүйл дээр бол шалгалтад бэлтгэх бүхий л бололцоо нь бол хангалттай.

С.Одонтуяа: Нэмээд хариултаа дуусгачих даа.

Б.Баатарзориг: Наранбаатар гишүүний асуугаад байгаа зүйл яг бодит байдал дээр байгаа орон нутгууд дээр.

Ингээд яг байгаль орчны улсын байцаагч, хоёрдугаарт нь одоо хөдөө аж ахуй, мал аж ахуй эд нар дээр бол үнэхээрийн хүний нөөц байгаа. Байж байгаа хэд нь хуулийн шаардлага хангахгүй ийм тохиолдлууд бий. Энэнтэй холбоотойгоор яахын аргагүй хүн нь хүргэгдэхгүй байхад тухайн орон нутагтаа түр томилгоо хийх ийм зүйлүүд дээр бол их эрх шилжүүлэлт хийчхээд байгаа. Мөн одоо энэ цалин хөлсний системд өөрчлөлт орох хууль батлагдчихвал үүнийг дагалдан гарах ангилал, зэрэглэлийн системд өөрчлөлт орох юм. Энэ дээрээ саяын орон нутагт дутагдалтай боловсон хүчнүүдийг аль ангилал зэрэглэлд хамаарах вэ гэдгээр бас хувилбар гаргаад үзэж байна аа.

Ер нь хууль дагасан журам, дүрмүүд бас одоо захиргааны акт давхар гарна.

С.Одонтуяа: Цэвэгдоржийн Туваан гишүүн асуулт асууя.

Ц.Туваан: Хуулийн төслийг дэмжиж байгаа. Юу вэ гэхээр өнгөрсөн хугацаанд би бас энэ асуудлыг нэлээдгүй ярьж ирсэн. Хөдөө орон нутагт иргэдтэй уулзахад бол энэ цалингийн л асуудлыг ер нь маш их ярьж байгаа. Яагаад гэхээр тэр хүмүүс чинь ажил хийгээд ажиллаж байгаа хэрнээ орлогын дутагдалд ороод ядуучуудын эгнээнд ороод байна шүү дээ. Зээлдээ баригдаад, өрөндөө баригдаад ингээд яваад байна.

Тэгэхээр энэ асуудлыг бас шийдэх гэсэн, одоо тодорхой зорилготой хууль орж ирж байгаа бол 2 гараа өргөөд дэмжиж байна. Төрийн захиргааны албан хаагчдын аймгийн төвөөс бусад сумдад ажиллаж байгаа захиргааны алба хаагчдад орон нутгийн нэмэгдэл гэж бид нар ярьдаг. Энэ одоо манай эрүүл мэндийн салбарынхан, боловсролын салбарынхан бол 3 жил, 5 жилд ингээд авдаг ийм урамшуулал л даа. Тэгээд энийг бас авах ийм хуулийн төсөл байгаа юм. Тэгэхээр энэ дээр хууль санаачлагчаас энэ төсөвтэй Сангийн яамтай санал энэ тэр нь одоо яаж орж ирсэн юм бэ? Одоо яг төсөв хэлэлцэж байгаа энэ үетэй уялдаж саналаа авсан уу?

Тэгээд хэзээнээс энэ нэмэгдлийг одоо хууль батлагдчихвал авч эхлэх юм бэ?

Тэгээд дээрээс нь энэ дээр бас бид нарын нэг асуудалд хандахдаа нэг тийм өрөөсгөл, аль нэг ярьсан газруудад нь гал унтраах байдлаар асуудалд хандаж байгаагийн бас нэг илрэл болчих вий дээ гэсэн ийм одоо бодол байна.

Ер нь бол манай Монгол чинь хэрэгцээтэй боловсон хүчнийг бэлдэх бодлого алдагдчихаад удаад байгаа. Тэгээд тэр төрийн ТЗ-ийн албан хаагч дутагдалтай байгаа чинь энэнтэй л холбоотой.

Дээрээс нь шинээр тэнд очиж ажиллах залуучууд дээр цалингийн асуудал, нийгмийн асуудал нь хүрэлцэхгүй учраас сонирхохгүй байна. Амьдралд нь яагаад ч хүрэхээргүй ийм цалин санал болгож байгаа учраас. Тэгэхээр энэ бол манай улсын энэ хөгжил бодлоготой холбоотой л ийм асуудал болчихоод байгаа юм.

Хоёрдугаарт, энэ жилийн төсөв дагаж бас нэлээн олон манай энд байгаа гишүүд энэ тэр нэлээн ярьсны үндсэн дээр энэ төрийн захиргааны албан хаагчдын цалин нэмэгдэхээр орж ирсэн. 20 хувь нь бол төсвөөс гэж ингэж ойлгож байгаа. 80 хувийг нь орон нутгаас гэж байгаа юм. Орон нутгаас бол үндсэндээ улсын төсвөөс татаас авч байгаа аймгууд чинь яаж энийгээ одоо нэмэх вэ дээ. Энэ бол худлаа тоо гэж ингэж харж байгаа юм. Маш цөөхөн аймаг, сумдуудад л энэ одоо илүү орлого төвлөрүүлж, үүгээрээ цалингийн тэр 80 гэж яриад байгаа хувийг нэмэх ийм боломж байгаа. Тэгэхээр энэ дээр бол алагчлалгүй, ер нь яг бодитойгоор авч үзэхгүй бол нөгөө одоо боломжийн гэж бид нарын харж байсан амьдралаа аваад явж байгаа ийм хүмүүс хүртэл өнөөдөр 25 хилийн шуудай гурил 50000 хүрчихлээ шүү гишүүн ээ гээд ингээд яриад эхэлж байна. Энэ бол нэлээн том харангын дохио.

Тэгэхээр энэ дээр бас нэлээн алагчлалгүй ярих ийм үлдэж байгаа хүмүүс байх вий дээ гэсэн ийм болгоомжлол байна.

Хоёрдугаарт, хууль санаачлагч Чинзориг гишүүн бас ярьж байна. Энэ ТҮ-гийнхэн гээд. Хамгийн түрүүнд ирдэг, хамгийн орой явдаг. Тухайн байгууллагын хамаг хар бор ажлыг нуруун дээрээ үүрдэг хэсэг байгаа. ТҮ, ТЗ дээр адилхан бид нар цалингийн шатлал 1-5 байсныг нь 1-4-ийг нь байхгүй болгоод 5-аар нь бүгдийг нь тооцдог болчихсон.

Өнөөдөр ТҮ, ТЗ-ээр шинээр ажилд орж байгаа хүн хүртэл энэ шууд 5 руу нь цалингаа бодох боломжтой болж байгаа юм.

Зэрэглэлүүд нь бол 1-15 хүртэл байгаа. Тэгэхээр энэ дээр нэг хамгийн доод талдаа тавин хэдэн мянгаас эхлээд л нэмэгдлүүд гарч ирж байгаа. Энэ бол бас ингээд нэлээн үлдчихэж байгаа юм.

Хоёрдугаарт энэ Сангийн яамныхан энэ засгийнхны ярьж байгаа энэ боловсрол, эрүүл мэндийн салбарынхны цалин нэмэгдчихсэн гээд байгаа юм. Энэ бол худлаа шүү, яг бодитойгоор бас. Боловсролын сайд дээр бол энэ багш нарын цалингийн үр дүнгийн урамшуулал.

С.Одонтуяа: Туваан гишүүний 1 минутыг нэмж өгье, тодруулга.

Ц.Туваан: Энэ боловсролынхон нь болохоор бид нар мэдэж байгаа шүү дээ. 90 тэрбум төгрөг оруулж ирээд үр дүнгийн урамшуулал гээд. Тэгээд одоо энэ чинь багш нар дээр явсан. Нийгмийн ажилтнууд дээр жишээлбэл байхгүй. Эрүүл мэндийнхэн дээр бол бүр орон нутагт суман дээр бүр худлаа шүү. Бүр бахь байдгаараа байгаа. Энэ одоо нэг гүйцэтгэлийн санхүүжилтийн бодлого гээд бодлого явж байгаа. Салбарын яам нь энийгээ олигтой буулгаж ажиллахгүйгээс болоод Эрүүл мэндийнх нь бахь байдгаараа бүр дордчихсон сууж байгаа. Юун цалин нэмэх, нэмэгдчихсэн тийм юм байхгүй.

Гүйцэтгэлийн санхүүжилтийн программ нь ч ажилд ороогүй, гүйцэтгэлээр нэг ч төгрөгийн санхүүжилт аваагүй сууж байгаа. Ер нь энэ хууль батлагдсан гээд л авч байгаа гээд л аваад байгаа. Ялангуяа Сангийн яамныхны үгнээс энэ үг бол маш их гарч байгаа. Энэ бол худлаа шүү. Тэгэхээр иймэрхүү бодлогын цоорхойнууд нэлээн байна аа. Тэгэхээр энийг цогцоор нь авч үзэж болоогүй юу

гэсэн ийм асуултыг хууль санаачлагчаас асууя.

С.Одонтуяа: Хууль санаачлагч Содномын Чинзориг гишүүн хариулъя.

С.Чинзориг: Туваан гишүүний асуултад хариулъя.

Сумын Тамгын газарт ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчид 5 жил тутам 6 сарынх нь цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал олгоход ирэх оноос олгож эхэлнэ гэвэл сумын Тамгын газарт ажиллаж байгаа төрийн албан хаагчдаас 5 ба түүнээс дээш жил ажиллачихсан 1534 хүн байна гэсэн ийм судалгаа гарсан юм. Тэгээд энэ хууль батлагдаад ингээд 2023 оноос хэрэгжиж эхэлнэ ээ гэвэл 5 тэрбум төгрөгийн хэрэгцээ гарах юм байна төсөв.

Цаашидаа бол жил тутам 1 орчим тэрбум төгрөгийн санхүүжилт шаардлагатай гэсэн ийм тооцоо бол байгаа юм. Тэгэхээр одоо бидэнд бас боломж бол байгаа гэж би бол үзээд байгаа юм. 2023 оны төсвийн тухай хуулийг Улсын Их Хурал хэлэлцэж байна.

Хоёрдугаарт нь Төсвийн тухай хуулийг дагалдан өргөн барьсан олон хууль бий. Тэрэн дотроо Төрийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах, орон нутгийн нэмэгдэлтэй холбоотой асуудал орж ирж байгаа юм. Тийм учраас өнөөдөр энэ бидний өргөн барьсан хуулийн төслийг хэлэлцэх эсэхийг нь дэмжээд анхны хэлэлцүүлэгт шилжүүлчих юм бол Төсвийн тухай хууль болоод Төсвийн тухай хуулийг дагалдан өргөн барьсан Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулиудтайгаа хамтатган хэлэлцээд ингээд явчихъя.

Тэгэх юм бол Төрийн албаны хуульдаа нэг мөсөн бас өөрчлөлт ороод явчихъя.

Хоёрдугаарт нь санхүүжилттэй холбоотой асуудлыг нь бас шийдээд явчих ийм боломж бол гарах байх гэж би бол хараад байгаа юм. Тантай би бол санал нэг байна. Ер нь цаашидаа бид нар нэг дээд боловсролтой мэргэжилтэн бэлтгэхдээ хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд суурилсан элсэлт авдаг байх. Түүндээ тулгуурлаж элсэлтээ авдаг мэргэжилтэн бэлддэг ийм тогтолцоо руу бид бол зайлиггүй шилжих шаардлагатай гэж үзэж байгаа.

Төсвийн тухай хуульд өөрчлөлт ороод орон нутгийн нэмэгдэлтэй холбоотой асуудлууд орж ирсэн.

Яах вэ энийг Төсвийн хууль хэлэлцэх явцдаа бол хэлэлцэх байх. Би бол 2 алдаа байна гэж л хараад байгаа юм.

Нэг дэх асуудал нь таны саяын яриад байгаа 20 хувийн нэмэгдэл бол үндсэн цалин нэмж байгаа юм биш шүү дээ Туваан гишүүн ээ. Үндсэн цалин дээр нь нэмээд 20 хувийн орон нутгийн нэмэгдэл өгөх асуудал байгаа юм. 20 хувийнхаа нэмэгдлийг төсөвт тусгаж өгье. Тэгээд 20 хувиасаа дээш 80 хүртэл хувиар орон нутгийн нэмэгдэл олгодог байхыг нь орон нутагт өгье гэдгийг ийм төсөл орж ирсэн байна лээ Засгийн газраас. Би бол энэ зарчим нь бол буруу гэж үзээд байгаа юм. Яагаад ингэж үзэж байна вэ гэхээр өнөөдөр улсын төсвөөс татаас авдаггүй, өөрөөрөө орлогоо нөхдөг зургаахан аймаг л байна шүү дээ.

Тэгэхээр бусад аймгууд чинь энэ 20-иос дээш 80 хүртэлх хувийн нэмэгдэл, орон нутгийн нэмэгдэл өгөх

ийм боломж бол орон нутгуудад бол гарахгүй ээ. Манай улс чинь нэгдмэл улс учраас ийм одоо ялгамжтай байдлаар асуудал шийдэж болохгүй гэж л бодоод байгаа юм. Харин энэ орон нутгийн нэмэгдлийг харин 20 биш жсоохон ялгамжтай тогтоож болох юм гэж би бол үзээд байгаа юм.

Тухайлбал говийн аймгууд юм уу, эсвэл Улаанбаатар хотоос хэт одоо алслагдсан баруун аймгуудад ажиллаж амьдарч буй төрийн албан хаагчдад олгох орон нутгийн нэмэгдэл нь арай өөр бас байж болох юм гэж.

Хоёр дахь нэг асуудал нь энэ. Орон нутгийн нэмэгдэл чинь зөвхөн төрийн захиргааны албан хаагчид дээр орон нутгийн 20 хувийн нэмэгдэл олгохоор хууль орж ирсэн байна лээ. Тэгэхээр орон нутагт ажиллаж байгаа төрийн үйлчилгээний албан хаагчдадаа 20 хувийн нэмэгдэл өгөхгүй байх уу, үгүй юу. Төр орон нутагтаа ажиллаж байгаа төрийн албан хаагчдадаа ТЗ, ТҮ гэдгээр нь ингээд бас тэгш бус ялгамжтай одоо хандах асуудал байх уу, энэ тэр гээд асуудлууд байгаа гэж би бол харж байгаа. Эдгээр асуудлуудыг төсвийн хуулийг одоо 2 дахь одоо хэлэлцүүлэгт бэлтгэх одоо явцдаа, ялангуяа Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг энэ дээр нэлээн нухацтай хандаж, тэгш ижил ханддаг байх, оновчтой тогтоох. Ялангуяа орон нутгууд орлогоосоо хамааран ялгамжтай орон нутгийн нэмэгдэл олгодоггүй байх ийм зохицуулалтыг нь нэлээн оновчтой болгож өгөх нь зүйтэй байх гэсэн ийм бас байр суурьтай байгаа гэдгээ хэлье.

С.Одонтуяа: Туваан гишүүн тодруулъя.

Ц.Туваан: Энэ төсөв дагаж орж ирж байгаа хуультай ямар нэгэн байдлаар хамтатгаад хэлэлцээд явчихвал энэ их сайн байгаа юм. Шууд үр дүн гарна. Тэгээд зарим хуулиудыг ярихаар тухайлбал Нийгмийн даатгалын хууль, Нийгмийн халамжийн тухай хууль ярихаар энэ бол тусдаа. Төсөв дагаж орж ирсэн хуулиуд чинь бол тусдаа гээд ингээд зааглаад байгаа.

Тэгэхээр энэ дээр манай хууль санаачлагчид бас тодорхой хүмүүсээс нь асуугаад ингээд шийдлийг нь гаргачихна биз. Тэр олон жилийн нэмэгдэл дээр төсөв дагуулаад бас 1 жил, 1 хувь гээд концепц энэ жилээс орж ирж байгаа юм байна лээ. Тэгэхээр энэ зүйлийг бол бас ингээд дэмжиж байгаа. Харин тэр нөгөө үлдэж байгаа хүмүүс хэр байгаа вэ. Судалгаа байгаа юу гээд хууль санаачлагчаас одоо энэ бас ороогүй хүмүүс сая ТҮ-гийнхнийг ярилаа. ТҮ ч гэсэн төсвөөс цалин авч байгаа учраас би бас орчхов уу гээд ингээд горьдоод байгаа юм.

С.Одонтуяа: Хууль санаачлагч Содномын Чинзориг тодорхой хариултаа өгье.

С.Чинзориг: Яах вэ энэ Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийг төсвийн хуулийг дагалдан өргөн барьсан хуультай хамтатган хэлэлцэх боломж бол байгаа гэж бол хараад байгаа юм. Яагаад вэ гэхлээр орон нутгийн нэмэгдэл олгохтой холбоотойгоор Төрийн албаны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төсөл ороод ирчихсэн учраас энэ 2 хуулийг хамтатгаад хэлэлцээд явах ийм боломж нь бол байгаа. Тэр орон нутгийн нэмэгдэл олгохтой холбоотойгоор хэчнээн төрийн албан

хаагч, ялангуяа төрийн үйлчилгээний албан хаагчид орохгүй, одоо үлдчих гээд байгаа вэ гэдэг нь яг нарийн тоо бол одоо надад бол алга. Тэрийг төсвийн хэлэлцүүлгийн явцад нэлээн тодорхой болох болов уу гэж л бодож байна.

С.Одонтуяа: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Одоо үг хэлэх гишүүдийн нэрс авъя. Дэмжиж байгаа 3, дэмжээгүй 3 хүртэлх. Нэрсээ өгье. Туваан гишүүнээр тасаллаа. Амарсайхан гишүүн үг хэлнэ.

С.Амарсайхан: Төрийн албаны хууль хэлэлцэж байгаатай холбоотой нэг зүйлийг эхлээд хэлэх нь зүйтэй байх. Төрийн албаны зөвлөл бол маш сайн ажиллаж байгаа. Ажил хийлгэхгүй байгаа албан тушаалтнууд, ах дүү, амраг садан, найз нөхөд чаддаг, чадахгүй хүмүүсээ томилдог нөхдүүд Төрийн албаны зөвлөлд нэлээн бас төвөг чирэгдэл учруулж байгаа. Тэр асуудал дээрээ анхаарч хаа хаанаа энэ хүмүүсээ мэргэшүүлэх хууль журам, дүрэм журамдаа нийцүүлж ажилладаг, ажиллуулдаг байх боломжийг бүрдүүлж байж энэ төрийн алба өшөө мэргэшинэ нэгдүгээрт.

Хоёрдугаарт, ерөнхийд нь хэлэхэд энэ төрийн ч бай, хувийн ч бай салбарууд бүгд боловсон хүчний хомсдолд орсон. Мэдлэгтэй, чадвартай, туршилагатай хүмүүс ажиллах боломж, улс төрийн албан тушаалаас бусад нь бараг ер нь байхгүй гэж хэлж болно. Цалингийн ялгаатай, чадвартай, чадалтай нь ажиллахаа больсон. Нөгөө талдаа чадахгүй, мэдэхгүй нь хуулиар хамгаалагдаад үлддэг. Энэ завсар төрийн албаны ажил цалгарддаг,

орхигддог. Тэр дундаа шинжлэх ухааны салбараа хаячихсан, аливаа асуудалд шинжлэх ухаан ч судалгаа тооцоотой, мэргэшсэн байна гэдэг төрийн албаны үндсэн зарчим алдагдаад удаж байгаа. Энэ юутай холбоотой вэ гэхээр нэгдүгээрт энэ бүтээмж, хариуцлага, ур чадвар дээр суурилсан цалингийн нэгдсэн систем байхгүй.

Дээрээс нь энэ оновчтой зохицуулалт байхгүй. Цалинг хавтгайруулж тогтоодог, дээрээс нь инфляцтай уялдуулж цалингийн нэмэгдлийг хийдэггүй. Улс төрийн шинж чанартай энэ нэмэгдлүүд хийж ирдэг. Тэгээд нэг хэсэг нь одоо нэмэгдэл цалин авдаг, нөгөө хэсэг нь орхигддог гээд үндсэндээ энэ Төрийн албаны тухай хууль батлагдсанаас хойш 30 удаа өөрчлөлт орсон байгаа цалин тэтгэмжтэй холбоотой.

Өнөөдөр ч гэсэн энэ хэлэлцэж байгаа асуудал бас л яг энэний нэг хэлбэр нь. Гэхдээ энэ хэлэлцэж байгаа асуудлыг би бол бас дэмжиж байгаа. Гэхдээ энийг дэмжээд зогсохгүй цогцоор нь суурь өөрчлөлтийг хийх ёстой. Бүтээмж дээр суурилсан. Ур чадвар дээр суурилсан. Тэгэхгүй бол дахиад хэдэн жилийн дараа энэ төрд ажилладаг ч хүн байхгүй, хувьд ажилладаг ч хүн байхгүй болно. Гадагшаа гарах нь гараад энд байгаа нь цалингаа голоод, эргээд нэгдсэн бодлого, уялдаа холбоогүйгээр хүний нөөцийн асар том хомсдол доголдолд орж байгаа юм.

Хамгийн хүнд ажил хийж байгаа асрагч, үйлчлэгч, төрийн үйлчилгээний албан хаагчид гээд бүгд одоо хамгийн доод цалин авч байгаа. Ялангуяа энэ орон нутгийн нэмэгдэлтэй холбоотой асуудлууд. Нэлээн хэдэн аймаг, сумдууд

хоорондоо хилийн цэсийн маргаантай байдаг. Газар нутгийн ялгаа байдаг.

Алслагдсан дүүргүүд байдаг, алслагдсан сумууд байдаг. Гэтэл яг хилийн цэс буюу нэг зураасаар 2 талд нь тусгаарлагдсан, аймаг орон нутгууд хоорондоо ялгаатай цалин авч байгаа. Би нэг жишээ дурдъя. Төв аймаг, Сэргэлэн сум, Баянжаргалан сум, Налайх дүүрэг, Эрдэнэ сум гээд ингээд Багануур дүүрэг, Бага хангай дүүрэг гээд хоорондоо нэгхэн зураасаар хилийн цэгийг нь тогтоосных нь үр дүнд энэ нутгуудад, энэ газруудад ажиллаж амьдарч байгаа хүмүүс ялгаатай, цалин авч байгаа. Аймгийн статустай нь нэмэгдэл авч байгаа, аймгийн статусгүй алслагдсан дүүрэг 110 километрт байгаа Багануур дүүрэг нэмэгдэл байхгүй. Гэтэл 20 гаруйхан километрт байгаа Төв аймаг нэмэгдэлтэй. Ийм байдлаар бид үзэмжээрээ улс төрийн агуулгаар асуудалд хандаж ирсэн нь өөрөө энэ төрийн албыг сульдуулж байгаа. Төрийн албанд итгэх ажиллах боловсон хүчингүй болсон. Тэрийг дагаад иргэд төрийн албанд үнэлэмжгүй болсон, төрийн алба бүтээмжгүй болсон, бодлого шийдвэр нь хэрэгждэггүй, гүйцэтгэл байхгүй ийм асуудал болсон.

Тэгэхээр энийг бол одоо Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, салбарын яам бол цогцоор нь оруулж ирж цалин тэтгэмж, нийгмийн даатгал, энэ халамжийн бодлого, хүн амын боловсон хүчний бодлого, цалин хөлс, түүнтэй уялдуулж ямар бодлогоор, ямар хугацаанд, ямар нөхцөлд цалинг нэмж явах юм. Амьжиргааг нь хэрхэн дэмжиж явах юм. Нийгмийн асуудлуудыг нь яаж шийдэж явах юм. Хаа хаанаа хариуцлага, бүтээмж яаж бий болгох юм гэдэг дээр онцгой анхаарахгүй бол

энд дахиад үргэлжилж яваад цаашаа дорвитой өөрчлөлт орохгүй. Энэ цалингийн асуудал яригдсаар байна. Тэр хооронд төрийн алба эзгүйрнэ шүү гэдгийг хэлье.

С.Одонтуяа: Сайнбуянгийн Амарсайн гишүүн үг хэллээ.

Одоо Сайнхүүгийн Ганбаатар гишүүн үг хэлнэ ээ.

С.Ганбаатар: Энэ хуулийг дэмжиж байгаа. Тэгээд өнөөдөр төрийн албан хаагчдын нөхцөл байдал, ялангуяа суманд, багт ажиллаж байгаа төрийн албан хаагчдын нөхцөл байдал хүнд байгааг бид бүгдээрээ мэдэж байгаа. Үнэн 500 орчим төгрөгөөр л гол зогоож байна шүү дээ. Тэгээд энийг нэмэгдүүлэхийг бүгд хүсэж байгаа. Тэгээд нэмэгдүүлбэл төрийн үйлчилгээ сайжирна. Төрийн нэр хүнд сайжирна. Төрийн хариуцлага дээшилнэ. Одоо бол суманд багт, төрийн албанд ажиллах хүн олдохгүй байна гэдэг асуудал гарч ирж байна шүү дээ.

Бүр сүүлдээ бол Солонгос руу яваад алга болчихлоо, ирэхгүй байна л гэж байгаа юм. Боловсрол, эрүүл мэнд дээр энэ бүхэлдээ байгаа. Төрийн үйлчилгээн дээр бас байгаа. Энэ хуулийн заалтыг бол ингээд харахад үндсэндээ Засгийн газрын хуралдааны тэмдэглэлээс ингээд анхаарч ажиглах юм бол Засгийн газар ерөнхийдөө татгалзсан хариу өгсөн байгаа шүү. Энийг бол Улсын Их Хурал дээр дэмжигдэх болов уу гэж би найдаж байгаа. Төрийн албан хаагчдыг 5 жил тогтвортой ажиллах юм бол 6 сарын цалинтай тэнцэх хэмжээний урамшуулал гэж байгаа шүү дээ. Энэ чинь үгүй мөн хол юм ярьж байгаа юм шүү. Тэгээд энэ дээр нь бид татганаад яах вэ? Хамгийн гол хэлэх гэж байгаа

зүйл гэвэл цогцоор нь оруулж ирэх нэг чухал зүйл байгаа юм.

Өнгөрсөн жилийн 500000 төгрөгийн цалин, суманд ажиллаж байгаа хүний 500000 төгрөгийн цалин, энэ жилийн 300000 төгрөгийн цалинтай ижилхэн болчихоод байгаа шүү дээ. Үнийн хөөргөдөл 200000 төгрөгийг нь идээд уучихсан. Одоо бид үндсэндээ цалин нэмэх гэж байгаа урамшуулал нэмэх гэж байгаа ч юм биш. Төрийн буруутай үйл ажиллагаанаас болж төгрөгийн худалдан авах чадварыг алдсанаас болж цалин тэтгэврээс нь. Цалингаас, ялангуяа хулгайлагдсан боломжийг нь бага сага хэмжээгээр нөхье өө л гэж байгаа хэлбэр шүү дээ. Энийг би нэгдүгээрт хэлмээр байна.

Хоёрдугаарт, энэ нөгөө хэлэх үгэндээ би оруулж хэлэхэд би одоо 3 дахь удаагаа хэлж байна. Энэ шинэ Хөдөлмөрийн хуулиа одоо ер нь Их Хурлын гишүүд бид сайн уншихгүй бол энэний хэрэгжилт бол зүгээр л хүн хуурсан юм болж байгаа байхгүй юу. Энэ цалин, тэтгэврийг урамшууллыг энд оруулж ирж ярьж байгаа нь сайн. Салбарын хэлэлцээрээр ярих заалттай шүү. Одоо яг салбарын хэлэлцээрүүд ерөөсөө хийгдэхгүй. Цалин хөлсийг чинь зүгээр, дээрээс нь Засгийн газраас яамдаас нь тогтдог.

Дээрээс нь заадаг тэр үе өнгөрчихсөн шүү дээ. Тухайн салбарын хөдөлмөр эрхэлж байгаа хүмүүс, ажил олгогчдын төлөөллүүд хоорондоо зөвлөлдөнө гэсэн Хөдөлмөрийн хуулийн хэрэгжилт хангагдахгүй байгааг энэ дээр онцолж хэлмээр байна.

Ингээд энэ хуулийг бол дэмжиж байгаа.

С.Одонтуяа: Одоо Цэвэгдоржийн Туваан гишүүн үг хэлнэ. Дараа нь санал хураалттай шүү гишүүд ээ.

Ц.Туваан: Энэ дээр түрүүн би бас үнэнээ хэлж байсан. Энэ эрүүл мэндийн салбарынхан Улаанбаатар хотын энэ төвлөрсөн том суурин газар, аймгууд дээр бол гүйцэтгэл явж байна. Дээрээс нь муу хэлээд байдаг ковидын буянаар бас гүйцэтгэл нэлээн сайн бичээд энэ шинэ хуулийн орчин, тэр гүйцэтгэлээ сайн бичээд хэдэн төгрөгтэй болсон, өрөө дарсан. Энэнийхээ үлдэгдлээр одоо сумдын эмнэлгүүд амь зогоож байна. Тэрнээс биш өөрөөр сумдын эмнэлгүүд дээр энэ Сангийн яамныхны яриад байгаа шиг цалин нэмэгдсэн нэг ч асуудал байхгүй. Яг хэвээрээ байгаа. Сумд дээр ярьж байгаа шүү би.

Боловсрол дээр яг ний нуугүй хэлэхэд ноднингийн төсвийн тодотгол дээр сайд нь гүйж байгаад нэг 90 орчим тэрбум төгрөг тавиад энийгээ л үр дүнгийн урамшуулал гэдгээр нэмчихсэн байгаа. Тэгээд багш нар олон жил ажилласан багш сая гаран төгрөгийн л цалин аваад явж байгаа юм. Бид нар энэ тэтгэвэр нэмсэн, энэнтэй холбогдуулаад энэ тэтгэвэр чинь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй уялдаж явдаг юм. Тэгээд тэрнээс болсон уу хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг 550000 болгосон. Одоо бараг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс доош цалинтай хүмүүс яг бодитойгоороо байгаа шүү. Төрийн үйлчилгээн дээр байгаа. Бүх татваруудаа төлөөд гар дээрээ 390000 төгрөгийн цалин авч байгаа ТҮ-ийн ажилчид байгаа. Сая харин тэр цалингийн шатлалыг эхний 4-ийг нь байхгүй болгосноороо нэг 63000 төгрөг нэмэгдээд нэг 400 гаруй мянган төгрөг болсон байх.

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс доошоо цалин авдаг ажилтнуудтай байх юм бол энэ доод хэмжээг бид нар ингэж тогтоож яах юм бэ. Энэ дээр нэлээн одоо асуудлууд байна. Тэгэхээр энийг бас бид нар анхаарахгүй бол түрүүн би бас сургуулийнхан дээр хэлсэн. Сургуулийн багш биш ажилтнууд тухайлах юм бол захиргаанд нь ажиллаж байгаа нийгмийн ажилтан энэ тэр нярав, санхүүгийн ажилтнууд яах юм үлдчихээд байгаа юм. ТУ дотор явж байгаа. Яг ний нуугүй хэлэхэд энэ хөдөө орон нутагт ялангуяа энэ Төв аймагт гэхэд энэ байгалийн баялаг хүртээж байгаа, бүр тодорхой хэлчихвэл энэ самар гарсан жил одоо төрийн захиргааны албан хаагчид чинь хуйгаараа чөлөө аваад л самранд явж байгаа шүү дээ. Сарын цалин нь самраас олдог нэг өдрийн орлоготой тэнцээд байхаар чинь явахгүй яах юм. Ногоо тарьж байгаа, тариа тарьж байгаа тариалан бүхий сумдууд дээр намрын ургац хураалт, хаврын тариалалт дээр чөлөө авч байгаа шүү дээ.

Амьжиргаа нь давхар нэг тийм юм хийхгүй бол энэ цалингаар амьдрал явахгүй болчихсон байгаа юм. Тэгэхээр энийг ер нь бол хэдүүлээ нэг одоо амьдрал төсөв бүрдүүлэлт энэ тэр хүнд байгаа ойлгож байна. Тэгэхдээ энэ чинь ойлгоод ойлгоод бас амьдралтай зөрчилдөөд ажиллангаа ядуураад байх юм бол энэ чинь төрийн бодлого мөн юм уу? Тэгэхээр энэ чухал асуудал хөндөж гаргаж ирсэн. Ямар ч байсан нэмэгдэл ярьж байгаа учраас дэмжиж байгаа. Энийг цогц болгож, яаж одоо бүр өргөн байдлаар авч үзэх вэ? Түрүүн хэлсэн шүү дээ, тэр 25-ын шуудай гурил 50000 хүрчихлээ шүү гээд. 2000 малтай малчин хүн ярьж байна лээ. Тэр хүн хэрвээ хониных нь

мах, хөдөө аж ахуйн түүхий эд, бүтээгдэхүүн нь үнэтэй байсан бол ийм юм ярихгүй л дээ, ярьдаггүй.

Өнөөдөр нэг хонийг одоо зарлаа гэхэд мах нь төгрөгөөрөө 4000, 5000 гээд байдаг. Тэрүүгээр зарчхаад авах юм нь тэр мөнгөнд нь ирдэг юм байхгүй болсон. 2 дахин үнэтэй болчихсон. Мал борлуулаад ордог орлого бол 2 дахин буурсан. Өнөөдөр нэг хязаалангаас дээш адуу зах зээл дээр өгчихөд нэг 700 гаран мянган төгрөг л болж байна. Энүүгээр буцаагаад ахуйн хэрэглээний бараа хүнс авахаар хуучныхаа авч байгаагийн талтай тэнцүү хэмжээний л юм аваад байна.

Тэгэхээр энэ хуулиа хэдүүлээ хэлэлцье. Тэр төсөв дагасан хуулиудтай нь хэрвээ одоо хамтдаа хэлэлцэж болдог бол их л сайн байна. Тэгээд засаг эсрэг санал өгсөн гэж сая одоо нэг гишүүний үгэнд гарчихлаа. Тэгэхээр энэ дээр Монгол Улс парламентын засаглалтай орон. Парламент нь юмаа мэдээд явдаг юм бол бас гишүүд дэмжээд ингээд явцан нь дээр байх аа. Нэг хэсгийгээ ч гэсэн бас нэмэгдэлтэй болгох, төрийн албаа эзэнгүй болгохгүйн төлөө бас энэ ажлыг хэдүүлээ хийсэн нь дээр байх аа. Тэгэхгүй бол нэг хэдэн хүн цалинжуулах асуудал бас биш шүү дээ тэнд байгаа бүх хөдөө амьдарч байгаа иргэдийг чинь төрөөс авч байгаа үйлчилгээний чанарын асуудлыг л давхар яригдаж байгаа гэдгийг ойлгож байгаа байх гэж бодож байна.

С.Одонтуяа: Баярлалаа гишүүд үг хэлж дууслаа. Одоо санал хураалт шүү. Гишүүд орж ирж байна, С.Чинзориг, Д.Тогтохсүрэн Н.Энхболд, Ж.Батжаргал, Ц.Идэрбат нарын 5 гишүүн санаачилсан юм байна.

Байнгын хорооны саналаар Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хурааа. 63.8 хувийн саналаар дэмжигдлээ. Төслийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлээ.

15.25 цаг

Одоо дараагийн асуудалдаа оръё.

“Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын технологид тохирохгүй хүдрийн овоолгыг ашиглах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ ээ.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Норовын Алтанхуяг танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Ажлын хэсэг танилцуулъя. Ажлын хэсэг орж ирээрэй.

Н.Алтанхуяг: Улсын Их Хурлын Улсын дэд дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

2020 оны 5 дугаар сард хүчин төгөлдөр болж мөрдөгдөж эхэлсэн Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт байгаа. Энэ нэмэлт, өөрчлөлтийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заахдаа “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлнэ. Түүний үр өгөөжийн

дийлэнх нь ард түмэнд ноогдож байх эрх зүйн үндсийг хуулиар тогтооно” гэж тодотгож заасан.

Миний бие Улсын Их Хурлын гишүүн, 2020 оны 6 сард болоод Монгол Улсын Ерөнхий сайд Хүрэлсүхэд хууль зөрчиж авсан Эрдэнэтийн баялгийг буцаан авч, Эрдэнэт үйлдвэр нь 34 хувьтай, Эрдэнэт хотын 33 хувьтай, Эрдэнэтийн иргэд 33 хувь эзэмших компани байгуулах ажлыг хуулийн дагуу зохион байгуулах арга хэмжээ авч, иргэдээ дэмжиж ажиллахыг хүссэн санал хүргүүлсэн.

Харамсалтай нь энэ маань Засгийн газрын түвшинд ажил болоогүй. Эрдэнэт үйлдвэр дараа ашиглахаар овоолсон зэсийн хүдрийг хаягдал мэтээр тайлбарлаж, хууль журам байхгүй, сонгон шалгаруулалт байхгүй, зөвхөн албан тушаалтны үзэмжээр олгодог явдал хавтгайрсан учраас энэ асуудлаар эрх зүйн зохицуулалт хийх нэн шаардлага үүссэн юм.

Тиймээс хүдрийн овоолгыг зэсийн хүдрийн овоолгыг ашиглаж, катодын цэвэр зэс үйлдвэрлэх хуулийн этгээдийг Улсын Их Хурлын тогтоолоор хаалттай хувьцаат компани хэлбэрээр байгуулах нь зүйтэй гэж үзэж Улсын Их Хурлын гишүүний хувиар Эрдэнэт үйлдвэрийн технологид нь тохирохгүй хүдрийн овоолгыг ашиглах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсрууллаа.

Энэ төсөлтэй холбоотой би 5 зүйлийг та бүхэнд танилцуулгад хэлье. Бүх материал та бүхэнд танилцуулагдсан. Дээр нь бас перзинтэйшин байдлаар дэлгэрэнгүй

материалыг би бүх гишүүдэд 4 сард тараасан байгаа.

Нэгдүгээрт нь бол энэ хаалттай компани бол Эрдэнэт үйлдвэр хүдрийн овоолгыг боловсруулах үйлдвэр байгуулах хөрөнгө оруулагч, Орхон аймгийн шалгуур хангасан иргэдийн хамтын сан гэсэн ийм хувьцаа эзэмшигчидтэй байх бөгөөд компанийн сайн засаглалын зарчмыг үйл ажиллагаандаа чанд мөрдөн ажиллах шаардлагатай гэж үзсэн учраас энийг хаалттай хувьцаат компанийн хэлбэрийг сонгосон юм. Мэргэжлийн хүмүүстэй яриад нээлттэй хувьцаат компани байгуулах юм бол нээлттэй хувьцаат компани маань хувьцаагаа заавал биржээр дамжуулж олон нийтэд арилжаалах үүрэг хүлээдэг учраас зөвхөн тодорхой шалгуур хангасан этгээдэд хувьцаагаа эзэмшүүлэх компани маань нээлттэй компани байх боломжгүй байгаа юм. Тийм учраас хаалттай компани гэж байгаа юм.

Хоёрдугаарт нь энэ овоолгон дээр зэсийн хүдрийн овоолгон дээр босгох үйлдвэрийг барьж байгуулах, шаардагдах санхүүжилтийг бүрэн шийдвэрлэж чадах хөрөнгө оруулагч маань компанийн хувьцааны 33 хүртэлх хувийг тодорхой хугацаагаар эзэмших бөгөөд үйлдвэр ашиглалтад орсноос хойш 7-оос илүүгүй жилийн дотор өөрийнхөө эзэмшиж байгаа 33 хувийн хувьцааг компанид шилжүүлэн өгөх юм. 7 жилийн хугацаанд хөрөнгө оруулагч нь хөрөнгө оруулалтаа бүрэн нөхөж, бас дээр нь нэмээд ашиг олох боломжтой гэж судалгаа тооцоо хийсэн. Эрдэнэт үйлдвэр маань технологид тохирохгүй, овоолго ашиглах эрхийг хаалттай ХК-д шилжүүлэх учраас энэ овоолгыг барьцаалж санхүүгийн эх үүсвэрийг

олох боломжтой юм. Одоо явж ирж байгаа практик нь ч ийм байгаа юм. Овоолгыг барьцаалж санхүүжилт босгох боломжтой учраас 7-оос илүүгүй жилийн дотор хувьцаагаа үнэ төлбөргүйгээр компанид буцаан өгөх болзлыг тавьсан болно. Мөн хөрөнгө оруулагчийг хэн нэг нь биш нээлттэй сонгон шалгаруулалтаар сонгох учраас аж ахуйн нэгжүүдийн дунд өрсөлдөөн үүсэж магадгүй. 7 жилийн хугацаа ч бас багасах боломжтой юм.

Гуравдугаарт нь хөрөнгө оруулагч маань 7 жилийн дараа компанид эргүүлж өгсөн 33 хувь хувьцааг давуу эрхийн хувьцаагаар сольж Орхон аймгийн орон нутгийн өмчид шилжүүлнэ. Орон нутаг маань 33 хувийн хувьцаа эзэмшсэнээр үүндээ тохирсон ногдол ашгийг авч орон нутаг, санхүүгийн нэмэгдэл эх үүсвэртэй болох бөгөөд энэ мөнгийг аймгийн иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлэх, ажлын байрыг бий болгох, Эрдэнэт хотын дэд бүтцийн асуудлыг шийдэхэд ашиглахаар зохицууллаа. Мөн орон нутгийн өмчлөлд шилжүүлэх хувьцааг давуу эрхийн хэлбэрээр хувьцаа хэлбэрээр гаргах үндсэн шалтгаан нь юу вэ гэхээр компанийн үйл ажиллагаанд улс төрийн компанийн үйл ажиллагааг улс төрийн нөлөөллөөс ангид байлгахыг зорьсон болно.

Дөрөвдүгээрт нь иргэдэд хувьцаа эзэмшүүлэх мөн ногдол ашгийг тогтоолд заасан зарчимд нийцүүлэн иргэдэд өгөөжтэй хэлбэрээр олгох, иргэдийн хамтын саналыг компанийн удирдлагын шийдвэрт тусгах боломжийг хангах зорилгоор иргэн бүр хувьцаа эзэмшигч байх биш харин хамтарсан сангийн хэлбэртэй ТББ-аар дамжуулж хувьцаа эзэмшүүлэх нь зүйтэй гэж үзсэн юм. Энэ нь бол 3 төрлийн давуу талтай юм.

Нэгдүгээрт, иргэд хамтын зохион байгуулалтад орсноор санаа бодлоо нэгтгэж, санал өгөх эрхээрээ дамжуулж компанийн удирдлагууд өөрсдийн төлөөллийг сонгох, бас хяналт тавих боломжийг нээж байгаа юм.

Хоёрдугаарт, эрх ашгаа хамгаалах хүчтэй тогтолцоо бий болгох учраас компанийн сайн засаглалын практикийг хэвшүүлэх нь баталгаажиж байгаа юм.

Гуравдугаарт, ногдол ашиг хуваарилах ажиллагааг хамтын сайн хариуцаж хэрэгжүүлэх учраас бэлэн мөнгө тараахгүй бөгөөд тодорхой зориулалтын дагуу ногдол ашгийг шилжүүлснээр иргэдэд хуримтлал үүсэх, амьжиргааны түвшин дээшлэх зэрэг үр дүнтэй. Энэ нь баялгийн өгөөжийг зөв хүртээх арга механизмыг бий болгож байгаа юм.

Тавдугаарт, Орхон аймгийн ямар иргэд хувьцаа эзэмших вэ гэхээр Орхон аймагт сүүлийн 5 жил тасралтгүй оршин суусан, Орхон аймагт төрөөд 5 нас хүрсэн иргэдийг хувьцаа эзэмшүүлэх зарчим барьсан. Энэ нь бол энэ хувьцааны сургаар бусад газраас зохиомол шилжилт хөдөлгөөн огцом үүсэхээс хамгаалах ийм механизм болох юм. Тухайн иргэн Орхон аймгаас шилжиж, оршин суух бүртгэлээсээ албан ёсоор хасагдсан болон иргэн нас барсан тохиолдолд тухайн иргэний хувьцаа эзэмших эрхийг дуусгавар болгохоор тогтоолын төсөлд тусгалаа.

Зургаадугаарт, иргэд маань ноогдол ашгийг бэлэн мөнгө хэлбэрээр хуваарилахгүй байх зарчмыг баримталж, иргэд зөвхөн дараах

төлбөрүүдэд ноогдол ашгаа шилжүүлэхээр тусгалаа.

Үүнд: Нэгдүгээрт нь бол иргэд орон сууцны зээл болон зээлийнхээ хүүгийн төлбөрийг төлөх,

Хоёрдугаарт нь хүүхдүүдийнхээ сургалтын төлбөрийг төлөх,

Гуравдугаарт нь эмчилгээний зардлыг төлөх,

Дөрөвдүгээрт нь даатгалын хураамжийг төлөх зэрэгт бол ноогдол ашгаа шилжүүлэхээр тусгасан.

Тавдугаарт нь ноогдол ашгийн үлдэгдэл мөнгө гэж үүсэх юм бол энэ мөнгийг өсгөх зорилгоор эрсдэлээс хамгаалагдсан хөрөнгө оруулалтын санд төвлөрүүлж болохоор тусгалаа.

Найм дугаарт нь 5 биш 7 байна.

Наймдугаарт энэ тогтоол хүчин төгөлдөр болохоос өмнө хүдрийн овоолго ашиглаж, үйл ажиллагаа явуулж байгаа бүх компанийг энэ тогтоол батлагдсан өдрөөс эхлээд 1 жилийн хугацаанд энэхүү Улсын Их Хурлын тогтоолд нийцүүлэн өөрчлөн зохион байгуулахаар тусгасан болно.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

С.Одонтуяа: Төслийн талаарх Үйлдвэржилтийн бодлогын Байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Нанзадын Наранбаатар танилцуулна. Индэрт урьж байна.

Н.Наранбаатар: Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Алтанхуягаас 2022 оны 4 сарын 14-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Эрдэнэт үйлдвэр төрийн өмчит үйлдвэрийн газрын технологид тохирохгүй хүдрийн овоолгыг ашиглах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо 2022 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Төсөл санаачлагч Эрдэнэт үйлдвэр, төрийн өмчит үйлдвэрийн газрын технологид тохирохгүй хүдрийн овоолгыг ашиглан зэс үйлдвэрлэх ХК байгуулж, уг компанийн хувьцааны 34 хувийг Эрдэнэт үйлдвэр төрийн өмчит үйлдвэрийн газар, 33 хувийг хөрөнгө оруулагч, 33 хувийг Орхон аймагт оршин суугаа иргэд хамтарсан сан байгуулж эзэмшихээр зохицуулсан Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг өргөн мэдүүлсэн.

Дээрх тогтоолын төслийг Улсын Их Хурлын 2022 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэхээр байсан боловч Байнгын хорооны гишүүдийн олонх тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх, төслийн зохицуулалтын хэрэгжих боломжийн талаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1 дэх хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын Тамгын газраар эрх зүйн дүгнэлт гаргуулах нь зүйтэй гэж үзсэний дагуу эрх зүйн дүгнэлт гаргаж, 2022 оны 6 сарын 27-ны өдөр тус Байнгын хороонд ирүүлсэн.

Уг дүгнэлтэд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 6 дахь хэсэгт заасныг үндэслэн бусад өмчийн этгээдтэй хамтран хуулийн этгээд байгуулах, хөрөнгө оруулах саналаа Эрдэнэт үйлдвэр төрийн өмчит үйлдвэрийн газраас ирүүлсэн бол Засгийн газар өөрийн бүрэн эрхийн хүрээнд уг саналыг хэлэлцэн шийдвэрлэж болох бөгөөд төсөл нь хуульд заасан компанийн удирдлагын эрх хэмжээнд халдсан агуулгатай байгаа нь Монгол Улсын Үндсэн хуулийг өмчлөх эрхтэй холбоотой заалтуудад нийцэхгүй байна.

Тогтоолын төсөлд Орхон аймгийн иргэдэд хамтарсан сангаар дамжуулан хувьцаа эзэмшүүлэхээр тусгасан нь байгалийн баялгийн үр өгөөжийг хуваарилахтай холбоотой Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг хөндөж байх бөгөөд Төсвийн тухай хууль болон бусад хуульд нийцэхгүй байна. Мөн Монгол Улсын Үндсэн хууль, Компанийн тухай, Төсвийн тухай хуулиудад тухайн харилцааг хуулиар зохицуулахаар заасан байхад тогтоолоор зохицуулахаар төсөлд тусгасан нь хууль зүйн хүчин чадал, хэлбэрийн хувьд шаардлага хангахгүй байна гэсэн дүгнэлтийг гаргасан байна.

Хэлэлцүүлгийн явцад Улсын Их Хурлын гишүүн Батжаргал Эрдэнэт үйлдвэр төрийн өмчит үйлдвэрийн газрын технологид тохирохгүй хүдрийн овоолгыг ашиглахаар өөрийн хөрөнгөөр үйлдвэр байгуулан үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгжүүдийг дэмжиж, татварын бааз суурийг өргөжүүлэх, мөн төсөлд тусгагдсан зохицуулалтыг Улсын Их Хурлын тогтоолоор бус холбогдох хуулиудад өөрчлөлт оруулж, хуулиар

зохицуулах нь зүйтэй гэж үзэж, Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар өргөн мэдүүлсэн тогтоолын төслийг дэмжиж, үг хэлсэн болно.

““Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын технологид тохирохгүй хүдрийн овоолгыг ашиглах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжээгүй болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүдээ,

““Эрдэнэт үйлдвэр” Төрийн өмчит үйлдвэрийн газрын технологид тохирохгүй хүдрийн овоолгыг ашиглах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх талаарх Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

С.Одонтуяа: Баярлалаа.

Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Болдын Цэнгэл Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын дарга, Батсүхийн Элбэгзаяа Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Уул уурхайн бодлогын газрын дарга, Цэнддаваагийн Баяр-Эрдэнэ, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга, Дорж-Юндэнгийн Алтанхуяг Эрдэнэт үйлдвэр төрийн өмчит үйлдвэрийн газрын ерөнхий геологич, Гаадамбын Тамир Эрдэнэт үйлдвэр төрийн өмчит үйлдвэрийн газрын Улаанбаатар

хотын төлөөлөгчийн газрын албаны дарга, Мэгддоржийн Баясгалан Эрдэнэт үйлдвэр Төрийн өмчит үйлдвэрийн газрын эдийн засагч.

Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнийн урилгаар Булган аймгийн Дашинчилэн сумын эмнэлгийн эмч, ажилтнууд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Ард иргэдийнхээ эрүүл мэндийн манаанд цаг наргүй зүтгэж ажилладаг эмч, эмнэлгийн ажилтнууд та бүхэнд нийт Улсын Их Хурлын гишүүдийнхээ өмнөөс ажлын амжилт, эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүдийг бүртгэе. Гишүүд нэрсээ өгөөрэй. Бейсен гишүүнээр тасаллаа.

Ширнэнбандийн Адьшаа гишүүн асуулт асууна.

Ш.Адьшаа: Улсын Их Хурлын гишүүн Норовын Алтанхуягаас Эрдэнэт үйлдвэрийн катодын бус ийм зэсийн баяжмалыг ашиглахтай холбоотой зохицуулалт хийхээр оруулж ирсэн Улсын Их Хурлын тогтоолын төслийг бол дэмжиж байгаа юм.

Хоёр асуулт байгаа. Асуулт асуухын өмнө бас нэг байр сууриа илэрхийлчихье.

Монгол Улсын Үндсэн хуулийн 6.2-т бол зааснаар баялгийн эзэн ард түмэн байна аа, Баялгийн сангаар дамжуулж энэ газрын доорх, дээрх бүх баялгийг нийт ард түмэн эзэмшинэ ээ гэсэн Үндсэн хуулийн үзэл

баримтлалын хэрэгжүүлэх эхлэл байсан ийм одоо тогтоолын төсөл байсан байгаа. Энийг бол Үйлдвэржилтийн байнгын хороо бас ингээд дэмжээгүйд их харамсаж байгаа.

Нөгөө талаар энэ Улсын Их Хурлын Тамгын газрын дэргэд эрх зүйн дүгнэлт гаргах гэдэг нэг ийм хууль бус ажиллагаа өнөөдөр энэ ард түмний мэдэлд, энэ байгалийн баялгаа ашиглах энэ үндсэн зарчимд одоо гар дүрж, хууль бус дүгнэлт гаргасанд их туйлын харамсаж байна.

Ийм юмыг өнөөдөр цензурийг оруулж ирсэн Улсын Их Хурлын Дэгийн тухай хуульд ийм асуудал оруулж ирж, өнөөдөр тухайн эрх барьж байгаа намын бүлгийн шийдвэрийг одоо дэмждэг, Улсын Их Хурлын гишүүний хууль санаачлах бүрэн эрхэд хөндлөнгөөс нэг дүгнэлт гардаг. Энэ хууль бус ажиллагаа цаашид битгий гараасай гэж ингэж бодож байна. Тэгээд би 2, 3 зүйлийг асууя. Өнөөдөр энэ Эрдэнэт үйлдвэрийн одоо зэсийн хаягдлын овоолго гэж нэрлээд байгаа энэ овоолго гэдэг энэ овоолгууд чинь одоо хэдэн компани энд үйл ажиллагаа явуулж байна. Энэ үйл ажиллагаа явуулж байгаа компаниудыг яаж сонгон шалгаруулдаг вэ, энэ дээр бол Эрдэнэт үйлдвэр сонгон шалгаруулдаг юм уу? Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар сонгон шалгаруулдаг юм уу? Засгийн газар одоо сонгон шалгаруулдаг юм уу гэдэг талаар яг тодорхой хариултыг бас өгөх шаардлагатай байна.

Нөгөө талаар энэ үйлдвэрийн энэ овоолгыг ашигласны үр дүнд гарч ирэх үр дагавар болох энэ ногдол ашиг хуваарилалт дээр энэ иргэдэд энэ бэлэн мөнгө өгөхгүй тухай энэ асуудал нь яригдсан байгаа. Энэ мөнгө төгрөгийг

нь яаж энд өгөх вэ? Энэ ашгаа яаж хүртэх вэ? Энэ хамгийн гол нь бол Эрдэнэт үйлдвэрийн энэ овоолгоос Орхон аймгийн тэр олон мянган ард иргэд бас баялагтаа эзэн байхын зарчим, Баялгийн санг биелүүлэх эхний үе шат болсон энэ хүүг хүртэх энэ боломжийг энд яагаад өнөөдөр энэ Үйлдвэржилтийн байнгын хороо, Засгийн газар энэ дээр ийм хаасан, боосон ийм бодлого явуулж байна вэ? Энэ талаар Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын байр суурийг сонсьё.

С.Одонтуяа: Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын дарга Цэнгэл хариулах уу? 83 дугаар микрофон.

Б.Цэнгэл: Адьшаа гишүүний асуултад хариулъя.

Өнөөдрийн байдлаар Эрдэнэт үйлдвэртэй гэрээ байгуулаад энэ овоолгыг ашиглаж байгаа компани бол Эрдмин үйлдвэр.

Эрдмин үйлдвэр бол 1994 оноос хойш үйл ажиллагаа явуулж байгаа. Ачит эх гэж бас компани байна. Ачит эх компани бол 2003 оноос эхлэн үйл ажиллагаа явуулж байгаа. 2014 онд үйлдвэр нь ашиглалтад орсон. Зэс эрдэнийн хувь гэж компани бол үйл ажиллагаа нь одоо хараахан эхлээгүй туршилтын үйлдвэрлэлээ ингээд явуулаад байж байна. Бас нэг компани бол хамтран ажиллах санал хүсэлтээ илэрхийлчихсэн байгаа. Эрдэнэт уулын өгөөж гэж нэг компани байгаа. Одоогийн байдлаар бол яг үйл ажиллагаа хамтарч явуулж байгаа нь бол 2 компани. Нэг компани бол туршилтын үйл ажиллагаа явуулж байна. Нэг компани бол зүгээр санал хүсэлтээ өгчихсөн байгаа, ийм байдалтай байж байгаа. Энэ дээрээс

нь нэмээд Эрдэнэт үйлдвэр өөрөө дотоодын зэс жилд 10000 тонн үйлдвэрлэх дотоодын зэс бас байгуулна гэдэг ийм зорилт тавьчихсан ажиллаж байгаа. ТЭЗҮ нь бол батлагдчихсан явж байгаа. Ямар үр өгөөжтэй ажилласан юм бэ гэдэг асуулт бас тавилаа.

Тэгэхээр бол Эрдмин компанид Эрдэнэт үйлдвэр 25 хувийг эзэмшдэг. Тэгээд 25 хувьдаа ногдол ашигийг бол 2005 оноос хойш өгсөн. Өнөөдрийн байдлаар бол Эрдмин компани 25 хувьдаа 30.8 сая америк долларын одоо ногдол ашиг хуваарилсан байдалтай байгаа Ачит эхт компани бол 2015 оноос роялти төлж явсан. Өнөөдрийн байдлаар бол 18.7 тэрбум төгрөгийн роялтиг бол одоо төлөөд байж байна. Ямар шалгуураар одоо энэ компаниудыг шалгаруулдаг юм бэ? Тендер зарладаг юм уу, үгүй юу гэж асуусан. Тэгээд энэ дээр бол тендер зарлаад ингээд сонгон шалгаруулалт явуулсан зүйл бол байхгүй. Эрдэнэт үйлдвэр бол хамтран ажиллах одоо саналаа илэрхийлээд хөрөнгө оруулалт нь одоо ийм байх юм, ингэж хөрөнгө оруулах юм, ингээд одоо үр өгөөжтэй, ингэж байх юм. Эрдэнэт үйлдвэртэй ийм байдлаар хамтран ажиллуулах гэдэг албан ёсны саналаа тавиад, тэр саналыг нь бол Эрдэнэт үйлдвэр судалж үзэж байгаад тэгээд хамтарч ажиллах эсэхээ одоо шийддэг.

Ингээд Эрдэнэт үйлдвэр өөрийнхөө эрх хэмжээний хүрээнд бол одоо хамтын ажиллагааны гэрээ байгуулаад ингээд явж ирсэн, ийм байдалтай байж байгаа. Цаашидаа Үндсэн хуульд орсон нэмэлт, өөрчлөлтийн дагуу 6.2-ыг одоо яаж хэрэгжүүлэх вэ, баялгийн сантайгаа энийг яаж уях вэ гэдэг асуудал бол байж байгаа. Тэгэхээр энэ дээр бол Монгол Улсын Засгийн газар бас

онцгой анхаарч ажиллаж байгаа гэдгийг бол хэлэх нь зүйтэй байх.

Бид ер нь бол Баялгийн сантайгаа уяад Эрдэнэс Монгол компанийг өөрчлөн байгуулаад нэгдлийн зохион байгуулалтад оруулж байгаа. Эрдэнэс Монгол компанийн доор бол зэс металлын групп, нүүрсний групп, эрчим хүч, дэд бүтцийн групп гэдэг одоо группүүдийг бол гаргаж ирэх. Ер нь Засгийн газрын 225 дугаар тогтоол бол гарчихсан байж байгаа. Тэгэхээр энэ групп доор бол Эрдэнэт үйлдвэрийг бол оруулж байгаа. Ирэх 7 хоногийн Засгийн газрын хурлаар Эрдэнэт үйлдвэр болон Монросцветметийн дүрэмд өөрчлөлт оруулаад Эрдэнэс Монголын одоо нэгдэлдээ яаж энийгээ уяж ажиллуулах вэ гэдэг ийм шийдвэрүүд ингээд ер нь гараад бол явж байгаа. Тийм учраас ер нь бол Баялгийн сан Үндсэн хуулийн 6. 2-ыг хэрэгжүүлэх зорилгоор Баялгийн сантайгаа уяж, энэ бүх зүйлийг.

С.Одонтуяа: Үйлдвэржилтийн байнгын хорооны дарга Төмөртоогоогийн Энхтүвшин нэмж хариулъя.

Т.Энхтүвшин: Баярлалаа.

Энэ Монгол Улсын Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хууль гэж бий. Энэ Дэгийн тухай хуулиар бид Дэгийн тухай хуулийн 38 дугаар зүйлд эрх зүйн дүн шинжилгээ хийж, дүгнэлт гаргах гэсэн ийм хэсэг байж байгаа юм.

Энэ заалтын дагуу Үйлдвэржилтийн байнгын хороо анхны хуралдаанаа хийгээд Үндсэн хууль зөрчсөн байж болзошгүй гэж үзээд Улсын Их Хурлын Тамгын газрын одоо Хууль, эрх зүйн хэлтэст хандсан байж

байгаа, дүгнэлт гаргуулахаар. Тэгээд би энэ 38 дугаар заалтыг уншаад өгчихье. Холбогдох Байнгын хороо хэлэлцүүлгийн явцад хууль тогтоолын төслийн талаар эрх зүйн дүн шинжилгээ хийж, дүгнэлт гаргуулахаар шийдвэрлэсэн бол тухайн Байнгын хорооны дарга эрх зүйн дүгнэлт хийлгэх төсөл, төслийн тодорхой зүйл, хэсэг, заалт, гишүүний гаргасан саналын томъёоллын талаар албан бичгээр Тамгын газарт хүргүүлж, дүгнэлт гаргуулна гэж заасны дагуу л бид одоо Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсээс дүгнэлт гаргасан.

Монгол Улсын Үндсэн хууль дээр заачихсан байгаа шүү дээ. Газрын доорх хэвлэлийн баялаг бол бүх ард түмний өмч гээд заачихсан байж байгаа. Тэгвэл юу гэдэг юм. Энэ Улсын Их Хурлын тогтоолоор юу гаргах гээд байна вэ гэхээр Орхон аймгийн иргэдэд хамтарсан сангаар дамжуулан хувьцаа эзэмшүүлэхээр тусгасан нь байгалийн баялгийн үр өгөөжийг нэг аймгийн иргэдэд л өгөх гээд байгаа асуудал байна шүү дээ. Энэ бол Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн байна гэдэг л асуудал тавьсан байдаг юм гаргаж ирсэн энэ дүгнэлтээр.

Хоёр дахь асуудал бол юу гэдэг юм. Энэ Улсын Их Хурлын тогтоол гаргах шаардлагагүй. Компанийн тухай хуулиараа явах ийм бололцоо боломж байна. Энэ нь бол нээлттэй. Монгол Улсын Засгийн газарт энэ асуудлаа тавиад Монгол Улсын Засгийн газраас шийдвэрээ гаргаад ингээд Эрдэнэт төрийн өмчит үйлдвэрийн газартай хамтарсан гэрээ байгуулаад явах нээлттэй байна гэдэг асуудлыг энэ Үйлдвэржилтийн байнгын хорооноос энэ хуралдаанаар бол шийдсэн байж байгаа. Тухайлбал юу гэдэг юм, түрүүний төрийн өмчийн

бодлого зохицуулалтын газрын даргын яриад байгаа Ачит эх байж байна. Зэс эрдэнийн хувь байж байна. Эрдмин компани байж байна. Эрдэнэт уулын өгөөж гээд энэ компаниуд бол Компанийн тухай хуулиар л зохицуулагдаад тухайн Эрдэнэт төрийн өмчит үйлдвэрийн газартай гэрээ байгуулаад энэ овоолгыг ашиглаад л явж байгаа юм байна лээ. Энэ зарчмаараа явахад бол нээлттэй байгаа. Баярлалаа.

С.Одонтуяа: Тогтоолын төсөл санаачлагч Алтанхуяг нэмж хариулт өгье.

Н.Алтанхуяг: Цэнгэл дарга хариулчихлаа даа. Одоогоор бол 3 компани, тэгээд цаашаагаа бас явж байгаа юм байна шүү дээ. Тэгэхээр гол асуудал бол өнөөдөр энэ ямар компани энэ овоолгод зэсийн хүдрийн овоолго дээр хэнийг ажиллуулах вэ, хэний ямар компани орох вэ гэдэг бол хүний үзэмжийн асуудал байгаа. Бүр үзэмж үзэмждээ ГОК-ын захирал, Уулын баяжуулах үйлдвэрийн захирал, нөгөө нэг компанийн захирал 2-ын л хоорондын гарын үсгээр явж байгаа учраас энэ бол эрх зүйн хувьд болохгүй байна. Энэ бол дарга нарын шахааны компани очдог, дарга нарын компани очдог ил тод биш болдог, хээл хахууль, авлигал гээд нөгөө ард түмэнд очих ёстой мөнгийг дундаас нь завшсан ийм байдлыг ядаж энэ компаниа шалгаруулж байгаа байдал нь ийм нууцлагдмал учраас энэ тогтоолын төслийн 2 дугаар зүйл дээр юу гэж хэлсэн юм гэхээр энэ хөрөнгө оруулагчийг нээлттэй шалгаруулья л гэж байгаа юм. Олон нийтэд ил тод болгоё. Хэн гэдэг хүний ямар компани, ямар нөхцөлөөр шалгараад байгаа юм бэ?

Энэ чинь өөрөө маш их мөнгөтэй тэр зэсийн хүдрээ овоолго гэдэг бол. Тийм учраас энийг ил тод болгоё гэж байгаа. Энхтүвшин дарга, Байнгын хорооны дарга хэлчихнэ лээ. Их Хурал дээр нэг ийм ялгавартай байж болмооргүй байна л даа. Нэг гишүүний санаачилсан тогтоолын төсөл дээр нь хууль зүйн дүгнэлт гаргана гээд давхидаг. Улаан цайм Үндсэн хууль зөрччихсөн гэдэг юм уу, тийм байдалтай тогтоолууд дээр нь юм уу, хууль дээр нь болохоор зүгээр яваад оруулчихдаг нэг ийм үзэмжийн шинжтэй зүйл манай Их Хурлын дэгийн тухай хуульд орсон юм байна лээ.

Манай олонх бодож болгоож үзэж, тэрийгээ засаж залруулна биз дээ. Алтанхуягийн санаачилсан юм болохоор нь заавал тэрэн дээр нь хууль зүйн дүгнэлт гаргана, энэ нөхрийн юм нь аягүй бол Үндсэн хууль зөрчсөн байж магадгүй энэ тэр гэж ийм байдлаар хандах бол ялгавартай юмаа, буруу юмаа л гэж байгаа юм. Ер нь Их Хурлын гишүүн болоод хэний санаачилсан, Засгийн газрын санаачилсан хуульд зарчим байдаг бол бүгдээрэнг нь адилхан дүгнэлт гаргах ёстой. Тэгэхдээ хэзээ ч Улсын Их Хурлын Тамгын газар Үндсэн Хуулийн Цэцийн ажлыг хийхгүй ээ. Үндсэн хууль зөрчиж үү, үгүй юу гэдгийг шийддэг ганцхан дээрээ хөх тэнгэртэй гэдэг нөхдүүд сууж байгаа шүү дээ. Цэц тэгэхээр ийм тийм юмаа цаашаагаа бас залруулна биз дээ.

Энэ тендер чинь ил тод зарлагдахгүйгээс болоод яаж байгаа вэ гэхээр жишээ нь Эрдмин бол 25 хувьтай, Ачит эхт компани бол одоо хувь байхгүй. Эрдэнэт 34 хувиа ч аваагүй сууж байгаа. Одоо Зэс эрдэнийн хувь гээд босож байгаа энэ ажилд орох байх. Тэрэн дээр ажиллаж

эхлэхээр нь 34 хувиа авна гэж байгаа. Ингээд ялгавартай байдал байгаа байхгүй юу. Нэг нь 25 хувьтай, нэг нь 34-тэй, нэг нь огт хувьгүй рояалти гэдэг нэртэй юм гаргаад ирчихсэн зогсож байдаг. Тэр рояалти нь хуулиараа бол 5 хувьтай байх ёстой байхад жил жилээс хамаараад 0.5, 1.5 гээд ингээд ийм үзэмжийн юм Монгол Улсад байж болохгүй. Ялангуяа энэ дарга нарын үзэмжээс хамаарч байж болохгүй. Энийг Улсын Их Хурлын тогтоолоор ингэж шийдье ээ л гэсэн ийм оролдлого байгаа юм. Баярлалаа,.

С.Одонтуяа: Баярлалаа.

Мэндчилгээ танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Энхтайваны Бат-Амгалангийн урилгаар БЗД-ийн Сууц өмчлөгчдийн холбооны удирдлагууд, Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Нийт Улсын Их Хурлын гишүүдийнхээ өмнөөс иргэдийнхээ тав тухтай орчныг сайжруулахын төлөө хичээл зүтгэл гарган ажилладаг та бүхний ажилд амжилт хүсье.

Одоо одонгийн Цогтгэрэл гишүүн асуултаа асууна.

С.Одонтуяа: Баярлалаа.

Эрдэнэтийн овоолгыг ашиглах энэ тогтоолын төсөл бас үнэхээр асуудал хөндсөн, нөгөө талаасаа зөв шийдвэл тийм сайн жишиг авчрахуйц ийм л үзэл санаа үүний цаана байна гэж би хувьдаа дүгнэж байгаа юм. Яагаад гэвэл одоо Монгол Улсын одоо уул уурхайн баялгийг хэрхэн яаж, улс орны эрх ашгийн төлөө, хэрхэн яаж, орон нутгийн иргэдийн эрх ашгийн төлөө яг ингэж тал талууд нь улсын төсөв хожсон, тал талууд нь хожсон байдлаар ингэж шинэ жишиг гаргаж цаашид явах юм бэ? Нэг бол улсын

хэмжээний том төслүүд орон нутаг дээр очоод гацаад зогсчихдог, аль эсвэл энэний цаана одоо маш олон ийм үндсэндээ тийм боломж бололцоог алдсан маш их олон жишээнүүд Монголын орон нутагт маш их бий.

Тэгэхээр яг энэн дээр бас зөв гарц гаргалгаа гаргаад ажиллавал үнэхээр энэ бол маш чухал зүйл, энэний цаана орон нутаг бас орлогоо нэмэгдүүлэх, орон нутгийн бие даасан байдал нэмэгдэх гээд олон сайн талууд бий. Гэтэл энийг одоо Улсын Их Хурлын Хууль зүйн хэлтэс гээд байгууллага энэ Үндсэн хууль зөрчсөн байна гээд тодорхойлоод ингээд сууж байдаг. Энэ бол тэр шийддэг газар нь шийддэг л ёстой байлгүй Үндсэн хуулийн цэц нь. Энэнээс наана энэ ямар ч байсан энэ хууль эрхийн хүрээнд Үндсэн хуулийн хүрээнд олон энэ давуу талуудыг авчрах ийм боломж бололцоог бүрдүүлсэн энэ төсөл өө л гэж бодож байгаа. Тэгээд 2 асуулт байгаа юм. Алтанхуяг гишүүнээс хууль санаачлагчаас асууя. Ер нь энэ одоо таны төсөөллөөр одоо энэ тооцооллоор энэ загвар схемээр одоо энэ овоолгыг ашигласнаар Эрдэнэтчүүд нэгдүгээрт нь,

Хоёрдугаарт нь Эрдэнэт үйлдвэр,

Гуравдугаарт нь орон орон нутгийн болоод улсын төсөвт ер нь яг ямар давуу тал, ямар орлого, ямар ашиг өгөөж авчрах юм. Энэ дээр яг хэдэн жилийн хугацаанд ямар юу авчрах юм. Энэ дээр нэг тийм тооцоо судалгаа нь юу байгаа бол?

Хоёрдугаарт нь одоо энэ тогтоолын төслийн үзэл санаанд өмнөх гарсан тэр одоо явагдаж байгаа гэж байгаа, гэрээ хийгдсэн гэж байгаа төсөл хөтөлбөрүүд хамаарах юм уу,

ирээдүйд байгаа овоолгууд нь хамаарах гээд байгаа юм уу, бүгдэд нь хамаатай юм уу тус бүрд нь хамаатай юм уу?

Хоёрдугаарт нь энэ Төрийн өмчийн хорооноос одоо ер нь энэ овоолго гэж яриад байгаа маань хэчнээн хэмжээний, хэчнээн овоолго гэдэг нь тус бүр нэгж яриад байх шиг байна. Хэчнээн овоолго, хэчнээн тонн, энэ нь ямар агууламжтай, энэнд хэчнээн тонн зэс байдаг юм? Энийг яг зах зээлийнхээ үнээр болоод үржүүлбэл ямар байдаг юм? Нөгөө талаасаа энэ одоо энэ жишгийг харвал энэ ямар зардалтай үйл ажиллагаа явуулж, эндээс энэ компаниуд бол ямар ашиг олдог юм? Тэгээд нийтдээ үлдэж байгаа тэр сул байгаа овоолго гэдэг нь өөрөө ямар хэмжээний тийм потенциалыг агуулаад байгаа юм.

Тэгэхээр энэн дээр ер нь ямар тооцоо байна вэ? Би Цэнгэл даргад өөр нэг хувилбар нөхцөл байдал асууж үзэх гээд байгаа. Одоо энэ Алтанхуяг гишүүний санаачилгыг ерөнхийдөө ингээд дэмжихгүй талдаа дуугарцаагаад байх шиг байна лээ.

Тэгэхээр хэрвээ энэ үнэхээр энэ овоолго чинь төчнөөн тонн, төчнөөн мянган тонн зэс энд ингээд байж байдаг гээд тодорхой зүйл юм бол тэгээд гараад одоо үндсэндээ бараг хүдэр болоод баяжигдсан ашиглалтын технологи хялбархан тодорхой ийм зүйл юм бол энийг тэр урьдчилсан гэрээгээр дуудлага худалдаагаар ил тод худалдаагаар энэ бүх овоолгыг чинь олон нийтэд нээлттэй тендер зарлаад зарчихаар яадаг юм?

Шууд одоо тэр оптек гэрээ ч гэнэ үү, аль ч хувилбараар байж болно тэгвэл одоо наад улсын төсөв чинь энэ хүнд хэцүү цагт бид нар шууд бэлэн

мөнгийг нь аваад дуудлага худалдаагаар зарчихвал яадаг юм, энийг хэн чадахад нь. Зүгээр жишээ нь яг Төрийн өмчийн хороон дээр энэ талаас бодож үзсэн тийм төсөв тооцоо олон зүйл байна уу?

Эдгээр асуултуудад хариулт өгөөч ээ?

С.Одонтуяа: Хэн хариулах вэ? Цэнгэл дарга хариулъя тодорхой асуулт асуусан.

Б.Цэнгэл: Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя.

Ер нь бол Эрдэнэт үйлдвэрт 10 овоолго байгаа. Овоолго бол дотроо бол 2 янзаар ангилж үзэж байгаа. Исэлдсэн хүдрийн овоолго бол 4 байна. Ядуу агуулгатай буюу тодорхой нөхцөлд үр ашиг өгөх гэдэг ийм овоолго бол 6 байгаа. Исэлдсэн хүдрийн овоолго бол нэг 52.4 сая тонн ийм одоо нөөцтэй. Ядуу агуулгатай буюу тодорхой нөхцөлд үр ашигтай байх овоолго нь бол 222.2 сая тонн ийм одоо нөөцтэй гэж бол үзэж байгаа. Бид бол Эрдэнэт үйлдвэртэй Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, хамтарсан ажлын хэсэг бас нэлээдгүй хугацаанд бол хамтарсан ажлын хэсэг байгуулаад ингээд ажилласан. Тэгээд бид бол яах вэ, ер нь бол энэ өнөөдрийн өнөөгийн одоо үнэ цэнийн асуудлыг бас ингээд тодорхойлж үзсэн л дээ. Тэгэхээр бол ерөнхийдөө бол 480 гаруй сая ам.долларын өнөөдрийн одоо үнэ цэнээр үнэлж үзэх юм бол ийм бас зүйл байна гэж ингэж тооцооллоор бол ингэж гарсан. Манай Алтанхуяг гишүүн бол энэ дээр арай өөр байр суурьтай байдаг юм байна лээ, тэгээд.

Ер нь Цогтгэрэл гишүүний яриад байгаа саналтай бол Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

бол санал нэг байгаад байгаа юм. Ажлын хэсэг дээр бол бид нар 2, 3 хувилбар гаргасан. Гаргаад Засгийн газраар хэлэлцүүлэх шатанд яваад, ингээд яг Уул уурхайн сайд нь хариуцсан салбарын сайд нь бол энэ асуудлыг оруулах нь зүйтэй гээд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар оруулах гэж байсан энийг Уул уурхайн сайд руу шилжүүлчихсэн байж байгаа. Яг одоогийн байдлаар. Бид энэ дээр бол 2, 3 хувилбар гаргачихсан явж байгаа.

Нэгдүгээрт, Цогтгэрэл гишүүний хэлж байгаачлан би чинь ер нь овоолгоо ер нь үнэлье. Яагаад гэвэл энэ чинь бол тодорхой хэмжээний өртөг зардал шингэчихсэн. Эрдэнэт үйлдвэрийн өөрийнх нь буюу төрийн өмч байгаа байхгүй юу. Тэгэхээр нэгэнт өртөг зардал шингэчихсэн энэ зүйл тэгээд дотор нь байгаа зүйлийг бид нар үнэлээд ингээд нэг үнэлгээ гаргаад мэдээж сонирхож байгаа этгээдүүдэд бол мэдээж бас ашигтай хувилбар, тодорхой хэмжээнд ашигтай хувилбар санал болгох маягаар ерөөсөө энэ овоолгоо худалдчих нь зүйтэй юм байна гэдэг нэг хувилбар явж байгаа.

Хоёр дахь хувилбар бид нар судлаад үзэхэд бол өнөөдөр тухайлбал Ашигт малтмалын тухай хуулиар бол рояалти бол 2.5 байгаа. Бид нар судалгаа хийж үзэхэд бол ер нь Ачит эх дээр бид нар тооцоо хийж үзсэн юм. Ачит эхийнхэн бол 34 хувийг өгнө, өгөхгүй гэж ярьдаг. Тэгээд рояалтигоо бид нар судлаад үзэхэд 10-15 хувийг рояалти авах юм бол 34 хувийнхаа юун дээр түүх юм байна гэдэг асуудал гарахад Ачит эх бол хамгийн сүүлд ирүүлсэн санал дээрээ тухайлбал энийг зөвшөөрөхгүй байгаа байхгүй юу. Тэгээд хамгийн сүүлд Ачит эх бол ингэсэн байгаа юм. Рояалтиг Ашигт

малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдсан тохиолдолд 5 хувь, Эрдэнэт үйлдвэр төлөх рояалтиг 4.5 хувь нийт 9.5 хувь байх саналыг хүргүүлж байна.

Ер нь бол энэ олон улсын жишигийг судалж үзэхэд уул уурхайн рояалти дунджийн 5 хувь, зэсийн рояалти 2.7-3.8 хувь байдаг байна гээд бидэнд бас хичээл заагаад байгаа юм л даа. Ийм л юмыг өгнө. Энэнээс илүү юмыг өгч чадахгүй. Энэ тохиолдолд бол зүгээр Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын даргын даргын хувьд хэлчихэд ер нь бол Ачит эх компани бол яг өөрийнх нь тэр зүгээрээ бол 2023 оны сүүлээр бол үндсэндээ энэ овоолгоо ашиглаад бол дуусна.

Энэнээс цаашаа хэрвээ асуудалд ингээж хандаж байвал Ачит эхтэй гэрээг бол цаашид сунгах тухай асуудал бол байж болохгүй л гэж үзэж байгаа би бол. Эрдмин компанийн хувьд бол Эрдмин компанийг бол 34 хувьд л хүргэх ийм шаардлага тавьж байгаа. Эрдмин компани бол өөрөө компани.

С.Одонтуяа: Хууль санаачлагч хариулъя гэсэн үү тэ? Норовын Алтанхуяг гишүүн нэмж хариулъя.

Н.Алтанхуяг: Ер нь товчхондоо хэлэхэд Цогтгэрэл гишүүн ийм л юм байгаа юм. Яг одоо өнөөдрийн амьдрал дээр байгаа нь бол түрүүн үзэмжээр шалгаруулдаг гээд ярьчихсан. Энийг нь болиод нээлттэй шалгаруулдаг болчихъё.

Хоёрдугаарт нь энэ баялаг дээр ингээд шүлсээ гоожуулаад байгаа нэг цөөхөн хүмүүс байгаа. Тэрэнд өгөхийг нь больчихъё. Тэгээд яах вэ гэхээр нэгдүгээрт бол Эрдэнэт үйлдвэр ерөөсөө үүнээс хойш 34 хувиа түүнээс

цааш 34 шууд ав л даа. Өөрийнхөө баялгийг ард түмний баялгийг хүнд өгчхөөд одоо чи 34 хувийг нь өг гэж гуйдаг ийм эргүү тэнэг юм ер нь хорвоо дэлхий дээр байхгүй. Тэгэхээр үүнээс хойш түүнээс цааш Эрдэнэт нээлттэй тендер зарлалаа, нөгөө компанид би 34 хувийг Эрдэнэт үйлдвэртээ өгнө гэдэг нь ойлгомжтой байна, нэгдүгээрт.

Хоёрдугаарт 33 хувь дээр нь бол хөрөнгө оруулагч 7 жил ажиллаад би ашгаа аваад гарна гэдгийг зөвшөөрсөн хөрөнгө оруулагч орж ирнэ. 7 жилд бол тэр хөрөнгө оруулагч 60, 70, 80, 90 сая долларын хөрөнгө оруулаад хангалттай хэмжээний ашгаа аваад гарна. Анхныхаа хөрөнгө оруулалтыг нөхчихнө.

Гуравдугаарт, 7 жилийн дараа хөрөнгө оруулагч гарангуут нь тэр 33 хувийн хувьцаа бол Эрдэнэт хот юм уу, Орхон аймаг руу шилжинэ. Ингээд 34 хувьтай, Эрдэнэт хот аймаг 33 хувьтай үлдэж байгаа. 33 хувийг бол иргэд анхнаасаа эзэмшинэ. Энийг тоогоор би та нарт илэрхийлэх гэж оролдоё. Энэ юу гэсэн үг вэ гэхээр хөрөнгө оруулагч 70 сая доллар оруулаа. Одоо 1 жилд 100 сая долларын борлуулалт хийж байгаа нөхдөө 10000 тонн цэвэр зэс жилдээ гаргаж байгаа үйлдвэр бол одоо 10000 төгрөг 10000 доллар болчихсон шүү дээ. Нэг тонн зэс.

Тэгэхээр 100 сая долларын борлуулалт хийж байгаа. Талыг зардал гэж хасахад 50 сая долларын ашигтай ажиллаж байгаа юм. Тэгэхдээ хөрөнгө оруулагчаа бид нар хүндэлье. Мөнгөө оруулсан юм чинь чи 7 жил энэнээсээ юмаа ав гэхээр бараг дурын хөрөнгө оруулагч гар өргөөд орж ирнэ. Заавал гадаад гэх юм байхгүй. Яагаад гэвэл бид нар аж ахуй эрхлэгчдийг дэмжих

ёстой хөрөнгөө оруул, мөнгөө өсгөж аваад тэгээд орхи. Ингээд өнөөдрийн ханшаар бодох юм бол байна шүү дээ. ГОК бол 100 тэрбум төгрөг, жил бүхэн, Орхон аймаг бол жил бүр 100 орчим тэрбум төгрөг, Орхоны иргэд бол 100 тэрбум төгрөгийг авна. Орхон 100000 орчим иргэн байдаг гэвэл нэг иргэн жилдээ 1 сая төгрөгийн хувьцааг хүртэх ийм боломж ийм л нөхцөл бүрдүүлж байгаа.

Өнөөдөр яаж байгаа юм. Эрдэнэт үйлдвэр одоо энэ Цэнгэл дарга хэлээд өөрөө гайхчихсан сууж байна юу ч гэсэн үг юм. Тэр компани 34 хувь 34 хувь авч чадахгүй сууж байна шүү дээ. Тэгээд хэн хохирч байна? Эрдэнэт ГОК уулын баяжуулах үйлдвэр хохирч байгаа. Монгол Улсын төсөв хохирч байна. Тэгээд тэр бараг 100 хувь шахуу юмыг хэн авч байна. 2, 3 хүн л хувааж авч байгаа. 50, 60, 70, 80 сая долларыг жилдээ шүү дээ 1 жилийн. Тэгэхээр ийм шударга бус байж болохгүй ээ.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтөөр аль болохоор газрынхаа доорх баялгийг олон хүнд л хүртээе гэсэн учраас одоо энэ схемээр явбал ингээд хонь ямар юм билээ бүтэн, чоно цатгалан. Өөрөөр хэлбэл ГОК Уулын баяжуулах үйлдвэр цатгалан. Эрдэнэт хот мөнгөтэй, ард иргэд мөнгөтэй, хөрөнгө оруулагч хожилтой. Ингээд 4 юм хождог ийм схем ер нь хэцүү л дээ. Ингээд хийх ёстой. Саяын Цогтгэрэл гишүүний хэлж байгаа шиг оптек гэрээ гэдэг юм уу, дуудлага худалдаагаар зарчхаж болно л доо. Монгол Улсад чинь Үндсэн хуульд яах гэж өөрчлөлт оруулсан юм. Тэнд байгаа ард иргэд, тэнд байгаа баялгаасаа жоохон ч гэсэн юм хүртдэг байвал яасан юм бэ гэсэн ийм концепцтой Үндсэн хуулийн өөрчлөлт орсон шүү дээ.

Тэгэхээр хэдүүлээ энийг хийе. Энэ зөвхөн Эрдэнэт дээр зогсохгүй. Одоо Баянхонгор аймагт исэлдсэн, зэс илэрчихсэн. Баян-Өлгий аймагт исэлдсэн зэс гарчихсан. Сүхбаатар аймагт аль хэдийн нөгөө цайрт минерал ажиллаж байгаа. Бүх аймгуудад бараг ийм юм байгаа. Энэнээс нь бүх баялгийнх нь тухай яриагүй. Өнөөдөр Эрдэнэт байна шүү дээ.../минут дуусав/

С.Одонтуяа: *Хууль санаачлагч гүйцээгээд хариулъя.*

Н.Алтанхуяг: *Ер нь зүгээр манай Их Хурлын гишүүд ингээд нэг их улс төржихгүйгээр энийг ингээд зөв хэдүүлээ ойлгоцчихвол энэнээс хэн хожих вэ гэхээр хөдөө орон нутагт байна шүү дээ, ашигт малтмал ашиглахад төвөг бэрхшээлгүй болно. Өнөөдөр яагаад ашиглах дургүй байгаа юм. Яагаад бүгдээрээ очоод л зодолдоод л зодоон цохион хийгээд байгаа юм. Тэр тэнд байгаа иргэдэд юу ч очихгүй шүү дээ, хоосон ухсан нүх үлдэж байна шүү дээ хөдөө.*

Тийм учраас энэ иргэд. Тэгэхээр иргэддээ ингээд хувьцаа эзэмшүүлчихсэн, аймаг нь хожчихсон. Тэгээд үндсэн үйлдвэр нь бас хожчихож байгаа байхгүй юу. Тэр цайрт минерал өөрөө хожно л биз дээ хамаагүй шүү дээ. Ийм схем шүү дээ. Энийг нэг л Алтанхуяг гэдэг хүн л санаачилсан болохоор нь жаахан гутаан доромжлоод байгаа. Би бол тэгэхдээ нийгэмд итгэлтэй байгаа. Энийг бол хэний нэрээр нэрлэх нь надад их сонин биш. Ерөөсөө бид нар ийм загварыг бол заавал нэвтрүүлэх хэрэгтэй байна. Бүх аймагт энэ загвар бол ажилламаар байна. Би нэг тоо хэлье эрхэм гишүүд анхаарч байгаарай.

Өнөөдөр Уулын баяжуулах үйлдвэр 500 гаруй мянган тонн зэсийн хүдрийн зэсийн баяжмалыг гаргаж худалддаг юм. Тэрийг нь гадаадынхан аваад л одоо цэвэр зэс ялгахар 120000 орчим тонн зэс гаргадаг юм. 120000 тонн зэс л гаргадаг айл байхгүй юу. Одоо өнөөдөр тэр овоолго гээд энэ Цэнгэл даргын хэлээд байгаа тэр овоолго дотор 400 орчим мянган тонн цэвэр зэс байж байгаа, ялгаж авбал. Тэр бол өөрөө гурав, дөрвөн тэрбум Америк доллар хэвтэж байгаа. Үгүй ээ, тэгээд гурав, дөрвөн тэрбум америк доллар хажууд чинь хэвтэж байна шүү дээ. Үгүй ээ тэгээд Эрдэнэтийн иргэд гадаа жорлонд бие засаад, өнөөдөр юмны үнэ нэмэгдээд амьдрал ахуй нь барзайгаад ингээд сууж байж болох юм уу? Ядаж нэг аймгаас эхлээд хэрэгжүүлчхэж болохгүй юу? Тэгээд хэдүүлээ ярьж байгаад Сүхбаатарыг хийчихье. Баянхонгорыг хийчихье. Баян-Өлгийг хийчихье. Хөвсгөлд тэр Могойн голын уурхай.

Тэр нь тэдний бүх баялгийг аймгийнханд хувааж өгнө гээд байгаа биш. Тэр том баялгаас нь нэг жоохон хэсгийг нь тэр аймагт нь үлддэг болгоё. Би өөрөө Сангийн сайд хийж байсан хүний хувьд нэг зовлон хэлэхэд Баттөмөр ингэдэг байхгүй юу. АМНАТ-ын төдий хувийг үлдээлээ. ААН-ийн орлогын албан татварын төдөн хувийг үлдээлээ. Энэ чинь ажилладаггүй юм. Яагаад гэхлээр би Сангийн сайд байсан. Тэрийг үлдээчихээр өгч байсан мөнгөө татаад авчихдаг байхгүй юу, Улсын төсвөөс.

Тэгэхээр энэ бол механизм биш ээ. Тийм учраас одоо Өмнөговь аймаг бол жилдээ 40-50 тэрбум төгрөг авдаг. Хаанаас орон нутгийн өмчтэй 5 толгойгоосоо орон нутгийн ногдол ашиг гэж явдаг байхгүй юу. Тийм

учраас баталгаатай орон нутагт нь ноогдол ашиг л өгөх ёстой. Ноогдол ашиг, өөр юм байхгүй. Двидентээс өөр юмаар бид нар татварыг зохицуулахгүй ээ. Энэ бол бас энэ жил өнөөдөр надаас гарсан санаа биш. Энэ олон жил бид нар манай Их Хурлынхан дунд яригдаад хэрэгжихгүй байсан. Ингэчихвэл иргэд хожоод, аймаг хожоод улс хөгжөөд явчих гээд байна шүү дээ.

С.Одонтуяа: Мэндчилгээ дэвшүүлье.

Улсын Их Хурлын гишүүн Чинбатын Ундрам, Дамдинсүрэнгийн Өнөрболор, Жаргалтулгын Эрдэнэбат нарын урилгаар Сэлэнгэ аймгийн Шаамар сумын мод үржүүлгийн Шаамар бетоник компанийн ажилчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа Төрийн ордонтой танилцаж байна.

Мод тарих нь эх дэлхийдээ зориулж буй хамгийн том буян юм. Тэгээд Их Хурлынхаа нийт гишүүдийн өмнөөс та бүгдийн энэ буянтай сайхан үйлсэд нь амжилт хүсье ээ.

Одонгийн Цогтгэрэл гишүүн тодруулъя.

О.Цогтгэрэл: Энэ тогтоолыг дэмжиж байгаа. Хамгийн гол нь энэ чинь асуудлыг ил тод болгоё, иргэдийн оролцоотой болгоё, олон тал оролцогч талууд нь бүгдээрээ хождог болёо оо л гэдэг ийм үзэл санаан дээр л явж байгаа нь одоо хамгийн зөв зүйтэй л санагдаж байгаа юм. Одоо яг ямар байна уу. Эрдэнэт үйлдвэрийн дарга нар асуудлыг шийдэх юм байна. Тухайн үед бай байгаа эрх баригч намын албан тушаалтнууд асуудлыг шийдэх юм байна. Одоо энэ нь яг энэ чигээрээ цаашаа үргэлжлэх ийм л нөхцөл байдалд. Энэнд л өөрчлөлт оруулъя

гэж байгаа нь үнэхээр бас ингээд чухал. Тэгээд гишүүдийг бас энэ тогтоолын төслийг дэмжиж өгөхийг хүсье. Энэ бол бас орон нутагт бас их зөв зүйтэй жишиг болсон хөгжлийн шинэ гарц гаргалгаа болсон ийм ажлын эхлэл болно оо л гэж бодож байна.

Асуулт бол алга.

С.Одонтуяа: Баярлалаа. Одоо Наянтайн Ганибал гишүүн асуултаа асууна.

Н.Ганибал: Эрдэнэт үйлдвэрийн үнэ цэнтэй гэж нэрлэхийе даа. Зэсийн баяжмалын овоолгыг хэрхэн зөв зохистой зарцуулах вэ гээд Алтанхуяг гишүүний оруулж ирсэн Их Хурлын тогтоолын төслийг дэмжиж байна. Ер нь бид бүхэнд энэ тогтоолын төсөл шиг ийм судалгаатай, үр дүн нь бодитой ийм арга замууд зайлшгүй хэрэгтэй болчихоод байна, Монгол Улсын хэмжээнд. Бид нар одоо зүгээр энгийн жишээ ярьж л даа. Өчигдөрхөн Эрдэнэс Тавантолгой томилж байна. Энэ чинь уг нь одоо бас л ард түмний өмч шүү дээ. 1072 хувьцаатай боллоо гээд Монголын иргэн бүр баярлаж л байлаа.

Цаашилаад төмөр замтай болчихлоо гээд л бас баярлууллаа.

Харамсалтай нь өнөөдөр эргээд харсан б томилгоо гэдэг чинь одоо банкны хэллэгээр бол дамнуурах гэж байгаа банкныг нэг бүрэн эрхт төлөөлөгч томилоод дамнуурлыг нь эвтэйхэн авч гарна гэдэг ийм л хэллэг, ойлголт байдаг Монголчуудын хувьд. Энэ удаа бид бүхэн хамгийн том баялаг дээрээ б томилоод явчхаж байна. Энэ өөрөө юу хэлээд байна вэ гэхээрээ түүрүүний яриад байгаа тэр оптек гэрээнүүд, тэр нууц хаалттай

даргад үйлчилдэг энэ төрийн систем өнөөдөр Монголыг дамнуурал руу авч яваад байгаа юм аа.

Харин өнөөдөр Алтанхуяг гишүүн Эрдэнэтийн энэ үнэ цэнтэй овоолгон дээр хамгийн үнэ цэнтэйгээр яаж зарцуулах вэ, ард түмэн яаж хожих вэ, яаж тэр санг бий болгох вэ гээд бүхий л асуудлуудыг хөндөөд гаргаж ирж байна. Энэ дээр бас манай Төрийн өмчийн хорооныхон өнөөдөр Засгийн газрынхан баярлах хэрэгтэй. Өнөөдөр Засгийн газрынхныг энэ ажлуудыг хийгээсэй гээд олон жил хүлээлээ.

Харамсалтай нь МАН-ын Засгийн газрууд бол энийг хэзээ ч оруулж ирэхгүй юм байна? Нөгөө л даргад авлига шингэсэн үйлдлүүд нь өнөөдөр явсаар байгаад Монгол Улсыг дамнууруулж байгааг Монголын ард түмэн бүгд мэдэж байгаа. Баялгийн сан, Ирээдүйн өв сан маш олон сангууд байгуулсан нэг төгрөг ч байхгүй.

Өнөөдөр төсөв хэлэлцэхэд орон нутгийн эрх мэдлийг хаасан тогтоолын төсөл бас дагуулаад ороод ирсэн. Өнөөдрийн энэ тогтоолын төсөл бол орон нутаг хэрхэн хөгжих вэ, яаж баялагтаа эзэн болох вэ, цаашилаад тэр уул уурхайн нэр хүнд тухайн аймаг орон нутаг, уул уурхайтай бол түүнээсээ хэрхэн баялаг хүртэх вэ гэсэн энэ бүх асуудалд хариу өгсөн, маш нарийн тооцоололтой ийм л асуудлыг оруулж ирж байгаад нь Алтанхуяг гишүүндээ бас баярлалаа гээд хэлчихье.

Энэ ер нь цаашид бүх аймгууд, уул уурхайтай аймгууд бол одоо энэ загварыг аваад явах юм бол бүгдээрээ бас хөгжих ийм боломжоор хангагдана гэсэн ийм ойлголттой

байна. Ингээд энэ тооцоолол дотор бас харлаа.

Хэрвээ тогтоолын төсөл батлагдах юм бол одоо хөрөнгө оруулагч нарыг нээлттэй зарлана гэсэн байна. Тэгэхдээ энэ одоо шалгарсан хөрөнгө оруулагч нь одоо компани нь 7 жилийн дараа ашгаа хийгээд одоо хувьцаагаа шилжүүлнэ гэсэн байна. 7 жилийн дотор энэ тооцоо ашгаа олох ийм тооцоо судалгаан дээр жоохон нэмэлт тайлбар хийж өгөөч ээ гэж танаас хүсэж байна.

Хоёр дахь асуудал нь энд одоо Эрдэнэт үйлдвэр, Эрдэнэт хот, Эрдэнэтийн иргэд, тэгээд бас хөрөнгө оруулагч компани гэсэн ингээд 4 одоо хамтрагч субъектүүд гарч ирээд байгаа байхгүй юу. Тэгээд энэ хөрөнгө оруулагч нь одоо 7 жилийн дараа болоод гарахдаа хувьцаагаа яаж хэнд шилжүүлэх вэ гэсэн ийм асуулт байна.

С.Одонтуяа: Хэн хариулах вэ? Тогтоолын төсөл санаачлагч Алтанхуяг гишүүн хариулъя.

Н.Алтанхуяг: Энэ хөрөнгө оруулж байгаа компани маань ер нь хэдэн жил ажиллаад гарвал гомдолгүй гарах уу, хөрөнгө оруулалтаа нөхөөд ашгаа нөхөөд гарах вэ гэдэг тооцоо судалгааг их олон янзаар хийсэн юм. Би өнөөдөр амьдрал дээр байгаа жишээг нь хэлье л дээ. Өнөөдөр амьдрал дээр бол ингэсэн Эрдмин гэдэг компани бол одоо жилдээ 3000 орчим тонн цэвэр зэс гаргаж байгаа юм. Анхны хөрөнгө оруулалт нь бол 16 сая. Одоо бол 3000 тоннын борлуулалт хийж байна гэдэг бол жилдээ 30 сая долларын борлуулалт хийж байгаа юм. Ачит эх компанийг ярья. Одоо бол жилдээ 10000 тонн зэс гаргаж байгаа. Эднийх 90 сая долларын хөрөнгө оруулалт

хийсэн гэж ярьдаг. Нэрээр нь тооцоод явъя. Одоо зэс эрдэнийн хувь босож байгаа. Эднийх бас жилдээ 10000 тонн зэс гаргана. Эднийх 88.3 сая буюу ойролцоогоор дахиад адилхан 90 сая долларын хөрөнгө оруулалт хийж байгаа юм. Одоо ингээд би Эрдэнэт дээр очиж манай инженер техникийн ажилтнуудын дунд энэ хэлэлцүүлгийг хийсэн юм. Миний анхны төсөл дээр бол би 10 жилийн дараа гаръя гэж явсан юм. Гэтэл манай Эрдэнэтэд байгаа тэр инженер бол одоо тэнд сууж байгаа хүмүүс ч байж байна. Тэд нар юу гэсэн юм гэхлээр наана чинь 7 жил хангалттай юм байна л гэж хэлсэн. Би одоо та нарт цээж бодлого бодож өгье дөө.

Ерөөсөө хэдүүлээ хамтраад бодъё. 90 сая долларын хөрөнгө оруулалт хийсэн. Эхний жил ажиллалаа. Хөрөнгө оруулагч бол бүх зардлаа хасаад 100 саяас 50 сая доллартой үлдэнэ. Татвар бүх төрлийн юмаа 50 сая. 50 сая доллароосоо 40 саяын хөрөнгө оруулалтдаа авна. Ингэхэд ерөөсөө бүр дээд тал нь 3 жил болоод хөрөнгө оруулалтыг нь өгч байна. Бүр хамгийн муугаар бодоход 3 жилийн дараа 90 сая доллар олоод авчихъя. Тэгвэл цаана нь 4 жил энэ хүн бол ашиг авах боломжтой. Жилдээ 40 сая гэдэг чинь $4 \times 4 = 16$. 160 сая долларын ашигийг хийх ийм боломж харагдаж байгаа.

Тийм учраас энэ Ганибал гишүүн 7 жилд хөрөнгөө нөхөөд нэмээд 100 гаруй сая 150, 160 сая долларын ашиг ойролцоогоор авах ийм нөхцөлтэй юм.

Тийм учраас энэ дээр бол ямар ч хөрөнгө оруулагч орж ирээд хөрөнгөө оруулна гэж. 7 жилийн дараа болохоор зэрэг ингээд давуу эрхийн хувьцаа гэж гаргаж өгье гэдэг. Нэг ийм зовлон үүсээд байгаа юм. Одоо энэ хэн байна

уу, алга байна. Наранбаатар гишүүн байх ёстой, тийм. Энэ Өмнөговь аймаг ийм схемээр яваад байгаа. Энэ их цоо шинэ ч биш л дээ. Өмнөговь дээр ийм схем байгаа шүү дээ. Том Тавантолгой дотор жижиг Тавантолгой гээд нүүрсний уурхай байгаа. Орон нутгийн 51 хувьтай, 49 нь бол хувьчлагдсан. Тэгэхээр манай Өмнөговь яагаад мөнгөтэй болоод тэнд иргэд нь бас сэтгэл хангалуун амьдраад байна вэ гэхээр орон нутгийн Тавантолгойд 51 хувьд оногдох ноогдол ашигаа авчихдаг юм. Тэр ноогдол ашиг бол бид дунджаар ирж байна шүү, нүүрсний үнээс хамаараад гүйнэ. Дунджаар жилдээ 40-50 тэрбум төгрөг бол цэвэр аймаг тэндээсээ авчихдаг юм.

Энэ бол аймаг орон нутгаа хөгжүүлэх, иргэдийнхээ авах амьжиргааг дээшлүүлэхэд асар одоо том дэмжлэг болсон ийм мөнгө юм байгаа юм. Эндээс бас санааг нь авсан. Энэ их олон хүн ажилласан шүү дээ. 2, 3 жил ажилласан. Тэгээд энэ загварыг нэг иймэрхүү 34, 33, 33 гэдгээр явбал яасан юм бэ гэж ингэж гаргаж байсан. 7 жилийн дараа Эрдэнэт хот гэдэг юм уу, Орхон аймаг тэр хөрөнгө оруулагчийн 33 хувийг авчихна. Ингээд Орхон аймаг бол жил болгон 100 тэрбум төгрөг олох боломжтой болж байна. Ноогдол ашиг л яриад байна шүү дээ, би. Ноогдол ашиг байна. 100 сая доллар гэдэг чинь 300 тэрбум төгрөг байхгүй юу даа. 300 тэрбум төгрөг. Энэ ганцхан үйлдвэрийн тухай яриагүй, одоо 3 үйлдвэр босчихоод байна шүү дээ. Тэгээд тэр бүгдээсээ ноогдол ашигаа цуглуулахаар жилдээ бол ГОК бол зуун тэрбумыг авна. Аймаг бол 100 тэрбумыг авна. Иргэд бол 100 тэрбумыг л авна. Тэгээд та нар маань ингээд ойлгоод янз бүр болоод минийхийг одоо дэмжихгүй энэ Алтанхуяг гэдэг нөхөр санаачилсан юм чинь гээд ойлгоод байгаа бол.

С.Одонтуяа: Цэвэгдоржийн Туваан гишүүн асуулт асууна.

Ц.Туваан: Тэгээд энэ тогтоолын төслийн дотор нь бас нэг ганцхан Эрдэнэттэй ч холбоотой биш, энэ бусад бүх одоо аймгуудтай холбоотой, ер нь л Монголын одоо ард түмэн энэ уул уурхайтай холбоотой асуудал яваад байна л даа. Бид нар ингээд нэг тийм гаднынханд шоолуулж байгаа шүү дээ. Алтан дээр суусан гуйлгачин ч гэж яриад байгаа. Энэ зарим хүмүүс бол ерөөсөө үнэхээр гайхаад учрыг нь олохгүй байх шиг байна. Ийм том газар нутагтай, ийм баялагтай ийм цөөхөн хүн одоо 50 хувь нь ядуу амьдарч байна гэдгийг ерөөсөө ойлгохгүй байгаа шүү дээ. Учир нь ерөөсөө л энэ шүү дээ. Хэдхэн нэг олигархууд мэдээлэлд ойрхон дарга нарт ойрхон улсууд л ингээд л одоо баялагт эзэн суучаад дангаараа баяжаад л байгаа асуудал шүү дээ.

Тэгэхээр энийг ер нь бол одоо ярих цаг нь болчихсон, одоо нийтээрээ жоохон ахихгүй бол нээрээ Монголчуудын энэ ядуурал бол арай хэрээс хэтэрлээ. Болж байгаа, бүтэж байгаа юм үнэхээр бараг байхгүй байна. Эрдэнэтийнхэн дээр энэ нэлээн сайн яригдчихсан, сая бас Өмнөговь аймагт энэ тогтоол санаачлагчаар Өмнөговь аймагт, тэр жижиг 5 толгой гээд л ингээд л иргэддээ ногдол ашиг өгөөд болоод байдаг. Яагаад зарим нь болоод бусад нь болдоггүй юм. Яагаад энэ юм, яагаад ийм алаг цог байгаад байгаа юм. Одоо энэ дээр бол энэ Ашигт малтмалын тухай хууль дээр өөрчлөлт оруулах, одоо зүйлийг энэ улсын төсөв хэлэлцсэний дараагаар ярих цаг нь болчихсон. Үндсэн хуулийн 6.1 гэж заалтыг үнэхээр мөрдөх ёстой юм бол энэ газар доор байгаа, дээр байгаа энэ баялаг

чинь энэ ард түмний өмч мөн л юм бол одоо жинхэнэ эзэн болсон хүмүүст нь өгөөжтэй байдлаар шийдье л дээ.

Тэгээд ингээд сөрөг хүчин нэг зүйл ярихаар, ингээд ямар нэгэн байдлаар Байнгын хороон дээр эсэргүүцээд л унагаагаад л ямар хэрэг байна аа? Энэ байтугай л хачин хачин юмнууд оруулж ирээд л, батлуулаад л, тэгээд л дэмжигдээд явдаг шүү дээ. Тэгээд энэ яагаад энэ Эрдэнэтийнхэн дээрээс нь энийг дагаад Өмнөговь, манай Төв аймагт ч гэсэн бусад бүх энэ уул уурхайгаа талаа там болтол ашиглуулаад байгаа энэ газруудын эхлээд иргэд нь. Том байвал аймгаараа. Бүр цаашилаад улсаараа ашиг хүртэх энэ зөв жишиг рүү явчих нэг гаргалгаа юм биш үү гэж ингэж харж байгаа юм.

Тэгэхээр одоо ийм байдлаар хандахгүй бол нээрээ арай байна. Нээрээ ер нь бол маш хэцүү болж ирж байна.

Асуулт нь бол энэ 33, 33, 34 гээд ингээд нэг хуваарилалт хийсэн байгаа. Тэгэхдээ энэнээс гадна нэг хэсэг хугацаанд хөрөнгө оруулагч хөрөнгө оруулалтаа хийгээд 7 жилийн дараа гараад явахаар тухайн орон нутаг нь, тэр хувийг нь одоо цааш нь ашигийг нь хүртээд явах ингээд дөрөвлөсөн ашигтай гэнэ. Энэний одоо яг ингэж хуваарилсан энэ хувь хуваарилсан явдлууд тооцоо нь ямар тооцоололтой юм бэ? Энийг нэг сонирхож үзье.

Хоёрдугаарт нь энэ ногдол ашгаа бас хэн хариуцаж, ямар байдлаар иргэддээ хуваарилах юм бэ гэдэг нэг асуудал. Одоо энэ зэс эрдэнийн хувь тэгээд л одоо бусад нөгөө ашиглаж байгаа, одоо овоолгоос ашиг олж байгаа зүйлд нь ногдол ашиг энэ тэр гэж ер нь яаж хуваарилдаг юм

уу? Энэ талаар мэдээлэлгүй байна. Мэдээлэл байна уу? Тэгэхээр энийг жишээлбэл Төв аймаг дээр гэхэд одоо тэр Заамар гээд ёстой жинхэнэ алтыг нь аваад авдрыг нь хаядгийн жишээ тэр шүү дээ. Та хэд очиж үзсэн нь бол үнэхээр зүрх шимширмээр, нулимс гармаар байгаа л байгаа шүү дээ. Там болгоод хаячихсан. Тэгээд л улсын төсвийг нэг хэсэг тодорхой бүрдүүлж, төсвийг бүрдүүлж, улс эх орноо хүртэл тэжээж байсан ийм газар одоо нутгийнх нь иргэд рүү нэг жоохон.

С.Одонтуяа: Хариултын өмнө мэндчилгээ дэвшүүлье.

Улсын Их Хурлын гишүүн Дамбын Батлутын урилгаар Орхон аймгийн Хот тохижуулах газрын ажилчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна аа.

Халуунд халж, хүйтэнд хөрж, өглөө үдэшгүй ажилладаг та бүхэндээ сайхан бүхний дээдийг нийт Улсын Их Хурлын гишүүдийнхээ өмнөөс хүсэн ерөөе.

Яг бас Эрдэнэтийн асуудал ярьж байхад төлөөлөл орж ирж байна. Хэн хариулах вэ? Үйлдвэржилтийн байнгын хорооны дарга Энхтүвшин хариулъя гэж байна.

Т.Энхтүвшин: Баярлалаа. Өмнөговийн асуудлыг бас нэлээн яриад байх шиг байна. Өмнөговь аймгийн одоо жижиг Тавантолгой бол 51, 49 хувь л даа. 51 хувь нь одоо аймгийн өмч, 49 хүн нь бол хувийн өмч байдаг. Тэгээд аймгийн ИТХ-аар шийдээд явдаг л асуудал шүү дээ. Энэ ганц Өмнөговь дээр ч байгаа асуудал биш. энэ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Компанийн тухай хуулийг

үндэслээд аймгийн ИТХ нь шийдвэрээ гаргаад хувь хувьцааг нь тохироод явдаг л асуудал байж байгаа шүү дээ.

Тухайлбал, энэ зэс эрдэнийн хувь байж байна. Мөн л ялгаа байхгүй одоо Эрдэнэт хотын ИТХ нь шийдээд Эрдэнэтдээ газрыг нь олгоод, Эрдэнэт тэр одоо хувийн компанитай гуравласан гэрээ байгуулаад л явж байгаа асуудал байж байгаа шүү дээ. Би Алтанхуяг гишүүний ярьж байгааг ойлгож байгаа. Баялгийнхаа тодорхой хэсгийг тухайн сум, орон нутгийн иргэд од хүртдэг байя гэдгийг би ойлгож байгаа. Сонгон шалгаруулалтыг ил тод нээлттэй хийдэг байя гэдгийг би ойлгож байгаа. Бид нар Компанийн тухай хуульд өөрчлөлт оруулаад ингээд явах бүрэн бололцоо, боломж байж байгаа шүү дээ. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль дээрээ ч гэсэн бүрэн одоо өөрчлөлт оруулаад ингээд сумын аймгийн ИТХ буюу нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага ингээд явах одоо бүрэн бололцоо, боломж байж байгаа. Олгоод явах бололцоо боломж байж байгаа юм.

Тэгээд Үйлдвэржилтийн байнгын хороо нэг хууль зөрчсөн юм бол байхгүй. Бид нар хуулийнхаа дагуу л одоо юу гэдэг юм Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсээс дүгнэлтээ авсан. Дэгийн тухай хуулиар. Энэ дүгнэлтийнхээ үндсэн дээр Үйлдвэржилтийн байнгын хороо шийдвэр гаргасан. Энэ бол Улсын Их Хурлын тогтоол гаргах шаардлагагүй юм байна. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Компанийн тухай хуулиараа бүрэн зохицуулаад явах одоо бололцоо, боломж байна гэдэг л ийм шийдвэр гаргасан шүү дээ.

Тийм учраас энэ асуудлаа бол Засгийн газар дээр асуудлаа тавиад шийдээд явбал илүү их, одоо дөхөмтэй юм байна аа. Та бүхэн нэг юмыг л одоо ойлгох хэрэгтэй шүү дээ, том Тавантолгойн одоо юу гэдэг юм, 51 хувийг 40, 34 хувийг аймаг нь авна гээд Улсын Их Хурлын тогтоол гаргах гээд байвал яах юм. Энэ Дорноговь аймагт ажиллаж байгаа хувийн хэвшлийн баахан компаниуд байж байна. Энэний 34 хувийг аймаг нь эзэмшинэ ээ, иргэд нь эзэмшинэ ээ гээд тогтоол гаргах гээд Улсын Их Хурлын тогтоол гаргах гээд явбал яах юм. Энэ бүгд л одоо хууль зөрчинө шүү дээ.

Тийм учраас энэ Компанийн тухай хуулиар энэ зохицуулчихсан юмыг заавал одоо Улсын Их Хурлын тогтоол гаргах шаардлагагүй ээ л гэж үзсэн юм.

С.Одонтуяа: Баярлалаа.

Нэмж хариулъя. Тогтоол санаачлагч Норовын Алтанхуяг хариулъя.

Н.Алтанхуяг: Цэнгэл дарга аа, та бид хоёрын нэг тоо зөрчихсөн шүү. Та ер нь нэг нягталж байгаад нэг хэлчхээрэй. Одоо тэр манай Эрдэнэтэд ингээд 2 төрлийн хүдрээ овоолго байгаа. Исэлдсэн хүдэр балансын бус буюу ядуу агуулгатай гээд. Тэгэхээр тэр маань ингээд нэг 600-аад мянган тонн болж байгаа юм. Тэрийг нь тавиас, 70 хувийг нь металлын авалттай гээд бодохоор нэг 400 гаруй мянган тонн цэвэр зэс байгаа юм. Тэрийг доллар руу шилжүүлэхээр 3-4 тэрбум америк долларын хөрөнгө хэвтэж байгаа юм гэж би хэлж байгаа юм.

Та 480 сая гэдэг чинь ингээж гарч байгаа юм байна лээ. Өчигдөр бас одоо

энэ мэргэжлийнхэн сууж байгаа асуусан. Одоо тэр баахан овоолгыг гаргаж хаяхад чинь гаргаж овоолоход чинь их зардал гарна даа. Тэр чинь 480 сая доллар аль хэдийн гарчхаад байгаа гэдэг ийм агуулгаар хэлсэн шүү та бид 2. Би буруу хэлж байгаа бол та засаарай.

Хоёулаа тоогоо нэгтгэхгүй бол бас хүмүүс толгой нь эргэчих вий. Түүрүүн бас асуусан юм. Ганибал гишүүний өмнөх энэ байгаа 3 компани руу буцаж үйлчлэх юм уу гэж. Энэ үйлчлэх биш энэ өмнөх нөхдүүд чинь хууль дүрэм зөрччихсөн гээд энэ Цэнгэл дарга бас хэлж байна. Тэгэхээр тэр хууль дүрмээ дагуулах нь зөв байх. Одоо жишээ нь Эрдмин бол анх байгуулагдсан. Тэрийг анх байгуулагдах үед нь 34 хувийн ойлголт байгаагүй учраас 25-аар хийсэн л юм байна лээ л дээ. Тэгэхдээ тэр компани өнөөдөр бол 34 болгочихъё гэж хэлж байгаа юм гэсэн.

Зэс Эрдэнэ гэдэг компани бол 34-ийг чинь 0 болгочоод сууж байгаа компани байхгүй юу. Би энэ дээр та нарт зүгээр л үндэсний юу билээ, тэр чинь Аудитын газар, Аудитын газрын гаргасан ганцхан тоо хэлж өгье. Энэ зэс эрдэнийг юу Ачит эх гэдэг компани 34 хувиа 0 болгосноос болоод Эрдэнэт үйлдвэр бол өнөөдрийг хүртэл 200 гаруй тэрбум төгрөг авах, авлага, 200 гаруй тэрбум төгрөгөө авч чадаагүй. Уг нь 34 хувиа эзэмшээд, тэгээд Ачит эхээс мөнгөө аваад явсан бол өнөөдөр Уулын баяжуулах үйлдвэр 200 гаруй 4 төгрөг нэмэгдчихсэн байх ёстой байхгүй юу. Энэ бодитой тоо шүү. Та нарт би сүүлд нь нэмээд тарааж болно. Энэ бол аудитын дүгнэлт дээр байгаа тоо. Тийм учраас тэр 0 гээд байгаа хувиа Ачит эхэд бол 34 болгох байх. Зэс эрдэнийн хувь бол одоо үйлдвэр нь удахгүй ашиглалтад орох

юм гэсэн. Тэр бол 34 болох байх. Ингээд юм ерөөсөө ялгаваргүй шударга л байх хэрэгтэй шүү дээ. Нээлттэй тэгээд ГОК-д эзэмшдэг хувь нь ойлгомжтой. Ийм л энгийн нь ойлгомжтой л болгоё гээд байгаа юм. Түүнээс биш нэг даргын үзэмжээс хамаараад л хулгай зэлгий хийгээд л хээл хахууль авлигал өгөөд л. Жилийн 50 сая долларын ашигтай хүнтэй өнөөдөр үзчих амьтан байна уу? Манай Их Хурал дотор. Байхгүй дээ энэ бол тийм тоглоом биш шүү. Би бас хүнд хэцүү, одоо гүтгэлэг доромжлол, ална, хядна гэсэн заналхийлэл олон юман дундуур л олон жил явж байгаа. Энэнээс би нэг цент ч авахгүй.

Тэгэхдээ ард түмэн баялагтаа эзэн болог. Эрдэнэтийн овоолгын хажууд Эрдэнэтийн баялгийн хажууд одоо 40 жил ядуу амьдарлаа шүү дээ, одоо болоо шүү дээ. Тэгээд энэ аймгаас эхэлчихье. Эрдэнэтээс л эхэлчихье, тэгээд явна. Бүх аймаг болно, Баттөмөр гишүүн Увс аймаг болно. Зөндөө олон уурхайтай шүү дээ, хувьчилчихсан. Хувийн хөрөнгө авах гээгүй одоо намайг ингээд хувийн хөрөнгө хурааж авах гээд үгүй ээ. Эрдэнэтийн тэр овоолго чинь бол Эрдэнэтийн өмч байхгүй юу. Тэр нь ард түмний өмч байхгүй юу. Үгүй ээ, тэрэн дээр очоод нэг үйлдвэр босгосон нөхрийн өмч болчихдог гэж ер нь тийм юм юу байх вэ. Энэ Улсын Их Хурал дээр тэр нэг дүгнэлт гаргадаг ажлын хэсэг гээд нэг Тамгын газрын. Тэд нар бас намайг тэгж буруутгасан байна лээ. Алтанхуяг Үндсэн хууль зөрчиж байна. Юу ярьж байгаа юм. Харин Үндсэн хуулийн 6.2-ын чинь заалтыг хэрэгжүүлэх гэж үзэж байхад чинь. Ер нь тэгээд та нар бодчихоорой, Тогтохсүрэн дарга энэ Их Хурал дээр нэг ийм дүгнэлт гаргаад гишүүдийн эрхэнд халдаад тэр нь тэгээд үзэмжийн шүү. Алтанхуягийнхыг бол

дүгнэлт гарга, Баттөмөрийнхийг бол битгий дүгнэлт гарга тэгээд ийм ялгаатай.

С.Одонтуяа: Багаагийн Баттөмөр гишүүн асууя.

Энэ өнөөдрийн яригдаж байгаа асуудал, энэ баялгийн менежментийн асуудал яригдаж байна л даа. Зөв зүйтэй асуудал. Энийг одоо бид ярихгүй бол болохгүй шүү дээ. Монгол Улс ер нь цаашидаа яаж хөгжих юм бэ гээд ингээд үзэхээр зэрэг их сонин сонин судалгаанууд гарсан байдаг юм л даа. Ардчилал, зах зээлийн нийгэмд шилжээд бид нар энэ шилжилтийнхээ суурийг одоо буруу тавьчихсан. Бүх юмыг бүгдийг нь устгаад, тэгээд шинээр эхэлнэ гээд л ингээд л эхэлсэн. Тэгээд одоо дэлхийд энэ хөгжил их онц их их олон загвар байна л даа.

Тухайлбал, одоо би энэ хамгийн ойрхон энэ БНХАУ-ын загварыг ярья. Төрийн өмч одоо баялаг дээрээ төрийн өмчтэй компани байгуулаад татвараа аваад үлдсэн ашгаасаа тэр баялгийн сангуудаа байгуулчхаж байна шүү дээ. Өнөөдөр 8 их наяд долларын одоо валютын нөөцтэй. Дэлхийн 70 оронд хөгжлийн зээл олгож байна шүү дээ. Бид тив алгасаад л, одоо яваад л одоо туршилага судлаад байдаг 30 жил судаллаа. 30 жил макро, микро эдийн засаг ярилаа ерөөсөө байхгүй. Тэрийг энэ хажуунаасаа судалъя л даа бид нар. Энэ ярьж байгаа асуудал бол зүйтэй. Би бол энийг одоо ингэж дэмжиж байна. Тэгэхдээ ямар хэлбэрээр хийх вэ, яах вэ, ийх вэ гэдгээ их олон талаас нь сайн ярьж ингэж хийх нь зүйтэй. Энэ чинь одоо зүгээр өнгөцхөн тооцоход л одоо Эрдэнэтийн 3 жилийн одоо орлоготой тэнцэх хэмжээний баялаг, тэнд одоо овоолготой байж байна шүү дээ.

Нөгөө муу нэртэй, луу данстай социализмын үед бий болгосон нэг хэсэг овоолго нь байж байгаа шүү дээ. Тэрийг нэг хэсэг хүмүүс одоо сая тэр Туваан гишүүний хэлж байгаа зөв шүү дээ. Одоо нэг их мэдээлэлд ойрхон, тэгээд одоо нэг дарга нарт ойрхон улсууд очоод л тэнд үйлдвэр байгуулаад л асар их хэмжээний мөнгө, хэдэн 10 саяар нь одоо жилд олоод байдаг. Монголын ард түмний нийт ард түмний 35, 36 хувь одоо ядуу байгаад байдаг. Баялгийн менежментээ зөв хийе л дээ. Тэр баялгаас бусад юмандаа тэр хувийн хэвшилийг нь бүгдийг нь өгөх хэрэгтэй. Баялаг дээрээ бол Монгол Улс өөрийн одоо тэр монополийг тогтоож, өөрийн бодлогоо хэрэгжүүлж, ингэж мөнгөтэй, төр мөнгөтэй болж байж Монгол Улс хөгжинө. Төр даржин өнөөдөр хоосон байж байж одоо бид яагаад хөгжихгүй байна гэхэд яг л энэ шүү дээ.

Тийм учраас одоо энэ баялгийн менежментийг зөв хийе гээд оруулаад ирээд байгаа энэ санал бол зүйтэй. Эрдэнэтийн иргэд одоо тодорхой хэмжээний ногдол ашиг авснаар Үндсэн хууль зөрчинө гэж одоо юу байдаг юм бэ? Одоо энэ Өмнөговь бусад газрууд уул уурхайгаас л одоо зөндөө мөнгө авч байгаа шүү дээ. Үгүй ээ, тэр чинь Үндсэн хууль зөрчөөд байгаа юм уу? Үндсэн хууль зөрчих гээд байгаа юм бол тэр овоолгын нэг хэсгийг нь тэр Эрдэнэтийн ард түмэнд өгчихье л дээ.

Эсвэл сая тэр Цогтгэрэлийн яриад байгаа тэр худалдчихъя л даа. Яагаад хоёр, гуравхан компани ингэж давуу эрх эдлээд бусад нь хоосон ядуу ингэж байх ёстой юм бэ? Энэ тоглоомын дүрмээ зөв болгоё оо нөхдүүд ээ. Монгол хөгжихгүй байгаа чинь энэнтэй холбоотой. Тоглоомын

дүрэм тодорхойгүй. Хэсэг улсууд одоо илүү эрх эдэлдэг. Энэ 30 жил хөгжихгүй ирсэн алдаа энэ байна шүү дээ. Тэгээд одоо нэг хог гэж яриад байдаг тэр чинь одоо мэдээж хөдөлмөр шингэчихсэн, өртөг шингэчихсэн овоолго шүү дээ тэр чинь.

Хоёр, гурван асуулт байна. Энэ Ачит эх одоо анх байгуулагдахдаа 34 хувь нь төрийн өмч байсан юм. Яагаад одоо төрийн өмч өнөөдөр байхгүй болчихсон байгаа юм? Хэн ямар шийдвэр гаргаж энийг төрийн өмчийг байхгүй болгосон юм бэ? Нэг дэх асуулт.

Хоёр дахь асуулт бол энэ Эрдэнэт концерн гэдэг байгууллага байхдаа Эрдманий 54 хувийг, 51 хувийг эзэмшиж байгаад одоо 25 хувь болчхож. RCM гэдэг компани 49 байснаа 58 хувь болчхож Мико гэдэг компани нэмэгдэж орж ирээд 10 хувь болчхож. Дамдинжав гэдэг иргэн 6.5 хувь болчхож, Энэ шийдвэрийг хэн гаргасан юм бэ? Энэ төрийн өмчийг төрийн одоо эзэмших хувийг багасгасан шийдвэрийг хэн гаргасан юм бэ? Ийм 2 асуултад хариулт авъя.

С.Одонтуяа: Цэнгэл дарга хариулъя 83 дугаар микрофон.

Б.Цэнгэл: Баттөмөр гишүүний асуултад хариулъя.

Ачит эх компанидаа анх гэрээ хийж ажиллаж байхад 34 хувийг Эрдэнэт үйлдвэр авах ийм асуудал байсан уу гэвэл байсан. Тэр үед Эрдэнэт үйлдвэрийнхэн дотроо ярьж байгаад энэ технологи Монголд анх удаа нэвтэрч орж ирэх гэж байгаа. Нуруулдан уусгах технологи энд бас яг ашигтай байх, ашиггүй байх нь бол тодорхойгүй байна. Эрсдэлтэй байна гэж дотроо ажлын хэсэг гаргаад

дүгнэлт гаргаад 34 хувь авах нь Эрдэнэт үйлдвэрт бол эрсдэлтэй юм байна аа. Ийм учраас Эрдэнэт 34 хувиа авахаас татгалзаж. Ингээд тухайн үед бол бас тодорхой хэмжээний одоо роялти авъя гэдэг асуудлыг Эрдэнэт үйлдвэр өөрсдөө ийм ажлын хэсэг гаргаж ингээд дүгнэлт гаргаад ингээд явчихсан юм байна лээ. Ингээд ер нь бол би түрүүн хэллээ. Ер нь бол хамтарсан ажлын хэсгийг бол 2021 оны одоо сүүлээр гаргасан. Бараг л жил орчим хугацаандаа бол Эрдэнэт үйлдвэрийг бид бол их шахааж ажилласан. Ер нь яагаад 34 хувь дээрээ зогсоогүй юм бэ?

Одоо та нар яагаад роялтигоо ингээд нэмээгүй юм бэ? Энэ дээр бид нар бүр холбогдох тооцоо судалгаа гаргаад, ер нь бол авах ёстой байсан ямар ногдол ашгийг алдсан бэ гэдэг хүртэл тооцоо гаргасан. Түрүүн Алтанхуяг гишүүн бас тодорхой тоо хэлж байна лээ. Тэгээд яах вэ ийм асуудлууд бол өрнөж байгаа. Яг энэ асуудлаар бол Ачит эхтэй бол бид нар ажлын хэсгийн хүрээнд хэд хэдэн удаа хэлцэл хийсэн. Хэлцэл хийх гэж оролдсон боловч Ачит эх компани бол янз янзын тайлбар бол тавьдаг. Ингээд ерөнхийдөө бол нөгөө нэг шүүхийн маргаан руу яваад орчих гээд байгаа учраас бид нар бол 2 санал дээр ингээд тогтоод ингээд бол явж байгаа.

Ер нь бол Эрдэнэт үйлдвэрийнхний зүгээс бол хариуцлагагүй хандсан зүйлүүд бол байдаг. Ер нь одоо шулуухан хэлчихэд бол энэ овоолготой холбоотой асуудлыг цааш нь хөдөлгөхгүй явуулахгүй, энэ янз хэвээр нь явуулаад байх сонирхолтой бүлэг улсууд ч ер нь Эрдэнэт үйлдвэрт бол байдаг. Зүгээр энэ бүгдийг одоо даван туулж, Засгийн газар бол ер нь энийг нэг мөр цэгцэлж,

одоо нээлттэй сонгон шалгаруулалтаар явуулдаг болъё гээд манай Алтанхуяг гишүүний хэлээд байгаа санал, санаачилгыг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар бол зөв гэж үзэж байгаа. Тэгэхээр ер нь бол Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9.6 дээр бол өөрөөр хэлбэл Эрдэнэт үйлдвэртэй хамтарсан хэлбэрээр хөрөнгө оруулалт буюу энэ хувь хувьцааны асуудал яригдаж байгаа учраас яг энэ саяын миний өмчийн тухай хуулийн 9.6-аараа бол Засгийн газрын бүрэн эрх болчхоод байгаа юм л даа. Тэгэхээр хамаагүй зүгээр эрхэм гишүүн бол энэ асуудлаа холбогдох шугамаар бол Засгийн газарт тавиад журмынхаа дагуу ингээд явахад бол нээлттэй л гэж үзээд байгаа юм.

Тийм учраас бид нар бол юу гэж бодож байна гэхээр бол яах вэ ер нь тэр Байнгын хорооны санал, дүгнэлт тодорхой хуулийнх нь хүрээнд нь хууль санаачилсан ч болно, хуульд өөрчлөлт оруулсан ч болно гэдэг агуулгаар явж байна гэж бид ойлгож байгаа.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хувьд бол бид одоо гишүүдийн асуултад л одоо хариулах ийм л хэмжээнд байгаа.

Эрдманий хувьд бол ер нь дотроо бол их асуудалтай байгаа, Эрдмин.

Ахнаасаа бол яах вэ ер нь Эрдмин компани бол угаасаа 100 хувь хувийн компани шүү дээ. Хувийн компани гаднын хөрөнгө оруулагчтай гэж би ойлгодог. Ер нь бол дотроо бол хувь хувьцаагаа зарсан, одоо яг саяын хэлснээр бол үндсэндээ бол 4 орчим хувьцаа эзэмшигчтэй болчихсон явж байгаа.

Хамгийн сүүлд удирдлагын хооронд маргаан үүссэн. Удирдлагын хооронд маргаангүй гээд тэр иргэн Даваа хэн билээ. Дамдинжав гэдэг хүн бол гүйцэтгэх захирал хийж байсан. Дамдинжав.../минут дуусав/

С.Одонтуяа: Цэнгэл дарга нэмж хариулъя.

Б.Цэнгэл: Иргэн Дамдинжав гэдэг хүн бол зургаа аравны хэдэн хувьтай тийм хувьцаатай. Иргэн Дамдинжав бол тус компанийн гүйцэтгэх удирдлагаар ажиллаж байсан боловч тухайн үед бас Одхүү гэж нөхөр одоо үймүүлж хүчээр шахуу тэр компанийн удирдлагыг сольсон явдал болсон. Тэгээд тэнд үйлдвэрт ажиллаж байсан олон ажилчид бол Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт бол гомдол тавьсан. Бид юу гэж үзсэн бэ гэхээр бол Эрдэнэт үйлдвэрт чиглэл өгсөн.

25 хувийн хувьцаа эзэмшигчийн хувьд энэ асуудлыг анхааралдаа ав, нэгдүгээрт.

Хоёрдугаарт дийлэнх хувь нь одоо хувийн хэвшилд байгаа учраас хувийн хэвшлийн дотоод асуудалд хэт оролцох нь зохимжгүй гэж үзсэн. Ийм учраас энэ асуудал бол ерөнхийдөө хувийн компанийн дотоод одоо маргааны шинжтэй асуудал болоод хувираад байгаа юм. Ер нь бид 25 хувийг 34 хувь болгох асуудал тавьж байгаа энийг бол зарчмын хувьд зөвшөөрсөн. Гэхдээ гол хөрөнгө оруулагч нь бол гадаад хүмүүс байгаа учраас тэр нь.../минут дуусав/

С.Одонтуяа: Баттөмөр гишүүн нэмж тодруулъя.

Б.Баттөмөр: Эрдмин компани Эрдэнэт 51 хувь RCM гэдэг компани 49

хувь байж байгаад л одоо ингээд 25 хувь болчихсон байж байгаа юм л даа. Энэ Эрдэнэтийн тэр Ачит эхэд бол 34 хувь байснаа өнөөдөр ингээд л байхгүй болчихсон. Яг энийг үзэхээр зэрэг энэ цаад талд нэг албан тушаалын асуудал, авлигалын асуудал энд байж л байгаа байхгүй юу. Тэгээд энийг чинь эрх мэдэлтэй хүмүүс л ингэж хэлж байгаа шүү дээ. Түүнээс биш нэг Эрдэнэтийн захирал бол энийг шийдчихэж байгаа юм биш шүү дээ. Үгүй ээ, ингэх юм бол Монгол улс хөгжихгүй ээ, энэ заваан юмыг энэ Монголын ард түмэн бүгд мэдэж байгаа. Энэ бүх шатанд ийм байна шүү дээ. Тэр шатыг бол дээрээс нь цэвэрлэдэг ёстой. Энэ заваан юмныхаа төлөө бид нар ажиллахгүй бол болохгүй. Тэгээд энэ Их Хурал болдоггүй юм бол тэр Засгийн газрын шийдвэрээ гаргаад энэ 6 жил болж байна шүү дээ. Юу хийж байгаа юм бэ? Шийдэлдээ энийгээ.

С.Одонтуяа: Алтанхуяг гишүүн нэмж хариулъя.

Н.Алтанхуяг: Би их нарийн судалсан юм. Их олон жил. Би Баттөмөр гишүүнд хариулаад хэлээд өгье. Энэ 34 хувь яаж яваад алга болчихсоныг нь би хэлж өгье. Ганзориг захирлын үед 34 хувьтай гэрээ хийсэн байдаг юм. Дараагаар нь би он сартай нь хэлье 2013 оны 7 сард Даваацэрэн гэдэг захирал 2 сард байна уу? томилогдоод байж байгаад 2013 оны 7 сард дахиад гэрээ хийхдээ Эрдэнэт 34 хувиа эзэмшинэ гэж хийсэн байдаг юм. Зөв хийсэн байдаг юм. Тэгснээ 2015 оны 6 сарын 26-ны өдөр Даваацэрэн, Эрдэнэцэцэг гэдэг хүнтэй гэрээ байгуулахдаа 34 хувь нь алга болоод ингэж бичсэн байдаг юм. Эрдэнэт үйлдвэр төлөх ашиглалт катодын зэсийг борлуулсан борлуулалтын орлогоос одоо роялти

гэж хэлээд байгаа нь энэ 34 хувь чинь алга бол роялти болж орж ирж байгаа юм. Тэндээ...

С.Одонтуяа: Гүйцээгээд хариулъя. Алтанхуяг гишүүн.

Н.Алтанхуяг: Энэ сонин юм хийчихсэн юм 34 хувь нь алга болоод роялти төлнө. Нийт борлуулалтынхаа орлогоос 2015 онд 0.5, 2016 онд 1 хувь, 2017 онд 1.5 хувь. 2034 оныг дуустал 2 хувийг өгнө гэсэн. Үгүй ээ тэгээд энэнээс чинь болоод жишээлэх юм бол ГОК-ын авах ёстой 200 гаруй тэрбум төгрөг алга болчхож байгаа байхгүй юу?

Үгүй ээ тэгээд тийм улаан цайм ийм юм хэлэхээр намайг энэ Алтанхуяг Цагаан гэдэг хүнтэй өстэй юм байна лээ. Ийм юм оруулаад гэнэ. Тийм юм байхгүй шүү дээ. Цагаан бид хоёрын хооронд юу байх вэ дээ. Энэ ард түмэн чинь ядраад зүдрээд энэ байгалийн баялаг гэдэг юмыг чинь бүр хараал нь хүрээд сууж байхад чинь. Бид нар чинь нэг совет гаргаад яришиг даа. Зөндөө идлээ хавааск үлдсэнийгээ өгчихье гээд яагаад хэлчхэж болохгүй байгаа юм бэ?

Би ингээд гайхаад байдаг юм. Үгүй ээ, тэгээд бүх юм нь цаастай, бүртгэлтэй тооцоотой. Энэ Цэнгэл дарга бол үнэн юм хэлж байна. Ийм л болчихсон улс. Тэгээд захаас нь цэгцэлье. Тэгээд манай ард түмэн жаахан юм хувь хүртээ, аймаг орон нутгууд бүгдээрээ ийм ногдол ашиг аваг ээ. Ноогдол ашиг шүү. Тэгээд үйлдвэр нь авдаг юмаа ав. Одоо Цэнгэл дарга би таныг ойлгохгүй байгаа шүү дээ. Үгүй ээ, манай Ачит эхтэй ярьсан чинь 34 өгөхгүй гэсэн гэдэг юм. Энэ одоо юу гэсэн үг вэ? Энэ хэний өмч юм? Тэр хувийн компанийн өмч юм уу? Миний асуугаад байгаа энэ

Эрдэнэтийн баялаг Эрдэнэтийн өмч юм уу, ард түмний өмч хэвээрээ байгаа юм уу, үгүй юм уу? Ингээд л толгой нь хөл болоод, хөл нь толгой болчихсон л нэг ийм байдлыг л цэгцлэх гээд байгаа юм. Тэгэхдээ би Цэнгэл даргыг бол энийг цэгцлэх гэсэн санаа байна гэж бодож байгаа юм.

Тэгэхдээ Цэнгэл дарга аа, та нар яах вэ гээд тэр нам намынхаа бүлэг дээр ярьж байгаад энийг унагаасан ч гэсэн би нэхэл хатуудаа үзнэ. Бүх аймаг дээр энэ схемийг хэрэгжүүлэх ёстой хувь процент нь янз бүр байж болно. Тэгэхдээ эцсийн эцэст ард иргэд тодорхой хувьтай, аймаг орон нутагт тодорхой хувьтай ийм болно. Энхтүвшин дарга бид 2 нэг зөрөө үүсэж байна. Энэ бол Эрдэнэтийн баялаг дээр яриагүй, тэр 500 мянган тонн нь явдгаараа яваад улсын төсөвт ордог нь орно. Энэ бол зөвхөн овоолгон дээр яригдаж байгаа. Эрдэнэтийн баялгийн нэг жоохон хэсэг. Эрдэнэт 46 жил нэмж ажиллана гээд энэ Цэнгэл дарга өчигдөр ярьж байна лээ. Тэгээд 46 жил ажиллахад чинь 50, 60 тэрбум доллар болно. Энэ чинь бол өөрөө 3, 4 тэрбум доллар дээрх юмны тухай ярьж байгаа шүү.

С.Одонтуяа: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Одоо дэмжсэн, дэмжээгүй 3 хүртэлх гишүүн үг хэлнэ. Дамдинням гишүүнээр тасаллаа. Дамдинням гишүүн үг хэлнэ.

Г.Дамдинням: Энэ одоо миний судалдаг мэргэжлийн юмыг л яриад байгаа юм. Баялгийн хуваарилалтыг хэрхэн зохион байгуулах вэ гээд. Яах вэ ард түмэнд энэ газрын баялгийг тэгш хүртээх бол манай төрийн бодлого дэлхийн аль ч улс үндэстнүүдийн л боддог бодлого. Гэхдээ хүргэх аргын

тухай л асуудал нь яригдаад байгаа байхгүй юу. Тэгэхээр манай Алтанхуяг гишүүний оруулж ирж байгаа тогтоол дээр юу нь болохгүй байгаад байгаа вэ гэхээр жижиг хэлбэрийн Оюутолгой шиг л модель орж ирээд байгаа юм. Ямар нэг хөрөнгө оруулалт хийхээр бол тэр Эрдэнэтийн ард түмэн 34 хувийн өрөнд орно. Эрдэнэт хотын захиргаа 34 хувийн өрөнд орно. Тэгээд Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэр 34 хувиар нь хөрөнгө оруулалт хийх ийм л юм болно.

Өнөөдөр бид нар Оюутолгой дээр ямар бэрхшээлтэй байдал руу орчхоод байгаа вэ гэдгээ бүгдээрээ сана даа. Ногдол ашиг гэдэг юманд найдаад 34 хувийн ноогдол ашиг гэдэг юм нь найдаад хавханд тавиад орчихсон. 10 гаруй жил бид нар зууралдаж байж бараг 20 жил зууралдаж байж одоо нэг юм сая тэр тавьсан өрөө цэглэж авч байгаа байхгүй юу. Энэ анхнаасаа буруу модель гэдэг нь Монголд харагдаж байгаа шүү дээ. Дэлхий дээр энийг яаж зохицуулсан байдаг вэ гэхээр хэн ч хөрөнгө оруулж болно, хэн ч ашиглаж болно. АМНАТ татвараараа аваад тухайн газар орны ард иргэдэд арай илүү боломжийг олгож, хуваарилалтыг нь хийдэг юм, төр засаг нь. Энийг яг одоо Өмнөговь аймагт Оюутолгой төсөл дээр хийж байгаа. Орон нутгийг хөгжүүлэхийг дэмжих санд жил болгон 3-6 сая америк долларыг Оюутолгой төслөөс хийж байгаа. Энэ нь Оюутолгой төслөөс орж ирж байгаа АМНАТ-аас хуваарилагдаж байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ модель бол хуулийн дагуу бид нар шийдэгдчихсэн л байгаа л даа. Хэрэгжүүлээд явах тухай л асуудал юм.

Тэгэхээр энэ дээр бол бид нар улс даяараа орчихсон байгаа. Энэ нэг бүтэлгүй моделиосоо арай салж байж аймаг болгон дээр ийм модель хийчих юм бол улсаар өрөнд дахиад л орно доо. Энэ дээр бол яг л тийм юм болно. Тэгэхээр зүгээр хувилбар нь бол хэн нэгэн хүн энэ дээр ажиглаж болно. Татвар хураамж, роялти дээрээс нь тухайн аймаг орон нутгийн ард иргэдэд арай түлхүү олгоё гэдэг хувилбараар явбал дэлхий дээр бодлого нь зөв явдаг. Канад улсын Брич Колумбын муж гэж байна. Тэнд Нью Афтон гэж уурхай байна. Нью Голд гэдэг компанийн. Тэнд ямар загвараар хийдэг вэ гэхээр яг энэ загвараар хийдэг. Алтанхуяг гишүүн ээ. Энэ бол дэлхийн хамгийн зөв модель гэж дэлхийд үнэлэгддэг загвар шүү дээ. Хэн ч хөрөнгө оруулаад хийгээд тэнд баялаг бүтээж болно. Хувийнхан ороод өөрийнхөө эрсдэлийг үүрээд баялаг бүтээж болно, тэндээс нь давах ногдол ашиг, татварын хэмжээ, тэрийг төр засаг нь аваад хэрхэн хуваарилах тухай асуудлаа л бид нар зохицуулбал хэн хэндээ эрсдэлгүй зөв модель болж байгаа юм. Ноогдол ашигт суурилсан энэ баялгийн хуваарилалтын модель бол дэлхий дээр явахаа байгаад их удаж байна. Тийм болохтой зэрэг би эн хэлбэрээр нь бол дэмжихгүй байна.

Би Алтанхуяг гишүүндээ санал болгоход тэр Брич Колумб мужийн хийсэн тэр хуваарилалтын зохицуулалтыг хараарай. Манай Ашигт малтмалын хуулийн АМНАТ-ын хуваарилалт уг нь бол хэрэгжээд явбал бас нэг иймэрхүү юм байгаа шүү дээ. Оюутолгой дээр бид нар яг энэ моделиор хийгээд явж байгаа. Энийгээ л хийх ёстой байхгүй юу. Тэгэхгүй ингээд хавханд орчихсон загварыг аймаг болгон дээр хийнэ гэвэл наадах чинь жоохон буруу л болно. Маш

товчхондоо жоохон онцгүй хэлэхэд жоохон мэдлэггүй сайхан сэтгэл тэнэгийн төрсөн дүү шиг л юм сонсогдоно доо наадах чинь. Тэгээд бүгдээрээ тал талаас нь дахиад ярилцах ёстой шүү.

Дэмжих боломжгүй байна.

С.Одонтуяа: Гишүүд уг хэлж дууслаа.

Санал хураалт. Тогтохоо дарга аа унших уу? Саналыг нь томъёоллоо гайгүй овоо байгаа юм биш үү? Гайгүй болчих байх. Би саналын томъёоллыг уншъя.

Байнгын хорооны саналаар ““Эрдэнэт үйлдвэр” Төрийн өмчит үйлдвэрийн газрын технологид тохирохгүй хүдрийн овоолгыг ашиглах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх шаардлагагүй гэсэн саналын томъёоллоор санал хураана.

Санал хураалт.

Их Хурлын гишүүн. Хэлэлцэх эсэх нь юм чинь дээ, гишүүд юу, яахгүй дээ, хэлэлцэх хэсэг дээрээ яриад явахгүй юу даа. байн Нийт 55 хувиар уг асуудлыг хэлэлцэх шаардлагатай гэж гишүүдийн олонх үзлээ.

Байнгын хорооны тэгээр тогтоол тэгэхээр ““Эрдэнэт үйлдвэр” Төрийн өмчит үйлдвэрийн газрын технологид тохирохгүй хүдрийн овоолгыг ашиглах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх шаардлагатай гэж гишүүдийн олонх үзсэн тул Үйлдвэржилтийн байнгын хороонд шилжүүлээ. Анхны хэлэлцүүлэгт шилжүүлээ.

Дараагийн асуудалдаа оръё.
Дараагийн асуудал одоо ганцхан
асуудал байгаа шүү, гишүүд ээ.

16.53 цаг

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг шийднэ ээ.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Ширнэнбандийн Адьяа танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Ш.Адьяа: Улсын Их Хурлын дэд дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 5 сарын 13-ны өдөр баталсан Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 4.4 дэх зорилт болох чадварлаг, ёс зүйтэй төрийн алба гэсэн хэсгийн 1 дүгээр шатны 3-т төрийн албанд ёс зүй, сахилга, хариуцлагын оновчтой тогтолцоо бүрдэж, ёс зүйтэй төрийг төрийн алба төлөвшинө гэж,

2 дугаар шатны 3-төрийн албан хаагчид нийгэмд ёс зүй, сахилга хариуцлагаараа үлгэрлэх тогтолцоо бэхэжсэн байна гэж.

6.5 дахь зорилт, Авлигагүй засаглал гэсэн хэсгийн 1 дүгээр үе шатанд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх хууль, эрх зүйн болон бодлогын орчин, шударга ёсыг эрхэмлэсэн бүх нийтийн хандлагыг төлөвшүүлэх үе гэж тус тус зорилтыг дэвшүүлсэн байна.

Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг дэмжих эдийн засгаа сэргээх, эрчимжүүлэх хүрээнд жижиг, дунд аж ахуйн нэгжүүдийг төрөөс баталгаа гаргасан хөрөнгө оруулалтаар дэмжин хөгжүүлэх чиглэлээр жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэн сан Монгол Улсын хөгжлийн мега төслүүдэд хөрөнгө оруулах чиглэлээр Монгол Улсын хөгжлийн банкныг байгуулсан билээ. Гэвч энэхүү хөрөнгө оруулалтууд зорилтот салбартаа, зорилтот бүлэгтээ тэр бүр хүртэхгүйгээр улс нөлөө бүхий албан тушаалтнууд хувийн ашиг сонирхлоо завшсан зээл олгоход баримтлах хууль тогтоомжийг зөрчин нөлөөлж өөрийн хамаарал бүхий хуулийн этгээдэд олгуулсан. Улмаар энэ хэрэгт улс төрийн болон эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн явдал удаа дараа гараад байна.

Энэ нь улс төрд нөлөө бүхий этгээдүүд, шийдвэр гаргах түвшний албан тушаалтнууд төрөөс баталгаа гаргасан хөнгөлөлттэй нөхцөлөөр их хэмжээний зээл, хөрөнгө оруулалт бий болгож, тэдгээрийг эргээд өөрсдөө хувийн хамаарал бүхий хуулийн этгээдүүдээрээ дамжуулан хувааж авч байгаа маш ноцтой ашиг сонирхлын зөрчил юм.

Үүний улмаас Хөгжлийн банкны чанаргүй зээлийн хэмжээ өсөж, банкны эрсдэл даах чадваргүй болох, Хөгжлийн банкныг санхүүжүүлсэн

олон улсын бондын эргэн төлөлтөд эрсдэл учрах, Монгол Улсын олон улс дахь зээлжих зэрэглэл буурах зэрэг ар араасаа шаталсан олон сөрөг үр дагаврууд бий боллоо. Эдгээр зүй бус асуудлууд, авлига, албан тушаалын хэрэгтэй холбоотой гэх олон нийтийн хардлага эрс нэмэгдэж, төрд итгэх иргэдийн итгэл буураад байна.

Иймд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн зорилтыг хангах, төрд итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлэх, нийтийн албаны үйл ажиллагааг хувийн ашиг сонирхлын зөрчлөөс хамгаалах зорилгоор Авлигатай тэмцэх газарт хөрөнгө, орлогын мэдүүлгээ гаргадаг төрийн албан хаагчдын хувьд орлогоосоо давсан хэт их хэмжээний зээл, бусад этгээдээс авах, хуулиар хүлээсэн үүргээ хөсөрдүүлж, давхар бизнес эрхлэх, төрөөс баталгаа гаргасан аливаа төрлийн зээл, хөрөнгө оруулалтыг хувийн хэвшлийн урдуур орж завших. Өөрийн хамаарал бүхий этгээдэд олгуулахаар нөлөөлөх асуудлыг хориглох талаар зохицуулалт хийх зайлиггүй шаардлага тулгараад байна.

Дээр дурдсан хууль зүйн болон практик шаардлагуудыг үндэслэн Авлигын эсрэг хуульд заасны дагуу хөрөнгө орлогын мэдүүлэг гаргадаг албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэх үедээ ипотекийн зээл болон эрүүл мэндийн үйлчилгээ авахаас бусад зориулалтаар хувийн ашиг сонирхлын мэдүүлэгтээ мэдүүлсэн жилийн орлогынхоо 80 хувиас дээш хэмжээний зээлийг бусад этгээдээс авах эсхүл төрөөс баталгаа гаргасан хөрөнгө оруулалтын аливаа этгээдэд хууль зөрчин олгуулахаар нөлөөлөх, улс төрд нөлөө бүхий албан тушаалтан,

тэдгээрийн хамаарал бүхий этгээдийн хувь эзэмшдэг хуулийн этгээд төрөөс баталгаа гаргасан хөрөнгө оруулалтад хамрагдах зэрэг асуудлыг хориглож, үүнийг нийтийн албан тушаалаас чөлөөлөгдсөнөөс хойш 2 жилийн хугацаанд мөн дагаж мөрдөх асуудлыг тодорхой зохицуулсан Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Уг хориглосон зохицуулалтыг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан нийтийн албан тушаалтан хөрөнгө орлогын мэдүүлэгтээ зээлийн зориулалт, өөрийн хамаарал бүхий хуулийн этгээдээ үнэн зөв, тодорхой мэдүүлэх үүрэгтэй байх, хууль зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлага зэрэгтэй нийцүүлэн боловсруулсан болно.

Түүнчлэн нийтийн албан тушаалтны хувийн ахуй нөхцөлөө сайжруулах, хуулиар тогтоосон хэмжээнд хувийн аж ахуй эрхлэн орлого олох, эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах эрхийг хөндөхгүй байх асуудлыг хориглохгүй байхаар зохицуулсан.

Хуулийн төсөлтэй холбогдуулан дагаж мөрдөх журмын тухай хуулийг боловсрууллаа.

Эрхэм Улсын Их Хурлын гишүүд ээ,

Энэ хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

С.Одонтуяа: Баярлалаа.

Одоо төслийн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Энхтайваны Бат-Амгалан танилцуулна.

Таныг индэрт урьж байна.

С.Одонтуяа: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Адьшаагаас 2022 оны 6 дугаар сарын 03-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Хууль зүйн байнгын хороо 2022 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ. Хууль санаачлагч төрийн албан тушаалтан ипотекийн зээл болон эрүүл мэндийн үйлчилгээ авахаас бусад зориулалтаар хувийн ашиг сонирхлын мэдүүлэгтээ мэдүүлсэн, жилийн орлогын 80 хувиас дээших хэмжээний зээл авах, албан тушаалтан өөрийн болон өөртэй нь хамааралтай бүхий этгээдийн хувийн ашиг сонирхолд нийцүүлсэн, төрөөс баталгаа гаргасан зээл авах, гаргуулахаар гуравдагч этгээдэд нөлөөлөх нэр бүхий албан тушаалтан, тэдгээрийн хамаарал бүхий этгээдийн хувь эзэмшдэг хуулийн этгээд эдийн засгийн хөгжлийг дэмжих зорилгоор төрөөс баталгаа гаргасан зээлд хамрагдахыг хориглох. Зөрчсөн тохиолдолд хариуцлага хүлээлгэх зохицуулалтыг тусгасан хуулийн төслийг боловсруулсан байна аа.

Хуулийн төсөл батлагдсанаар улсын төсвөөс нэмэлт санхүүжилт шаардагдахгүй гэж хууль санаачлагч үзсэн бөгөөд хуулийн төслийг parliament.mn цахим сайтад байршуулж ирээд, олон нийтийн саналыг авч байгаа болно оо. Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Сэргэлэн, Төрийн албаны тухай хуульд төрийн албан хаагчийн ажил, албан тушаал давхар эрхлэхийг хориглосон зохицуулалт тодорхой байдаг бөгөөд хуулийн төслийн зохицуулалт давхардал үүсгэх эсэх, төрийн албан хаагч орон сууцтай болохын тулд ипотекийн зээлээс бусад зээлийн эх үүсвэрийг ашиглан зээл авах асуудлыг хаах нь зөв эсэх талаар. Орон нутагт ажиллаж байгаа төрийн албан хаагчдын цалин хөлс бага байгаатай холбоотой ажлаас гарах явдал нэмэгдэж байгаа бөгөөд зээл авах зохицуулалтыг хааснаар энэ асуудал улам бүр өсөж, хүний нөөцийн хомсдолд орж болзошгүй тул үүнийг шийдвэрлэх тооцоо, судалгааны талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан орон нутагт ажиллаж байгаа төрийн албан хаагчдын цалин хөлс бага бөгөөд жилийн орлогын 80 хувиас дээш хэмжээний зээл авахыг хориглох асуудал оновчтой эсэх, түүнчлэн Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд албан тушаалтан албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж бусдад нөлөөлж зээл авахыг хориглосон зохицуулалт байгаа бөгөөд хуулийн байгууллага шалгаж тогтоох нь нээлттэй байгаа талаар, мөн хуулийн төсөлд мэдээлэгчид олгогдсон зээлийн 10 хүртэлх хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал олгох зохицуулалт ойлгомжгүй байгаа талаар Улсын Их Хурлын гишүүн Дэлгэрсайхан Улсын

Их Хурлаас Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхол зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг анх батлахдаа хуулийн үйлчлэлийг тухайн этгээд болон хамаарал бүхий этгээд гэж хэт ерөнхий томъёолсонтой холбоотой тусдаа амьдарч байгаа хүүхэд, ах дүү, хамаатан саданг хамаарч энэ Монгол Улсын Үндсэн хуульд гэм буруутны ял зэмийг түүний гэр бүлийн гишүүд, төрөл саданд нь халдаан хэрэглэхийг хориглох зарчимтай зөрчилдөж байгаа асуудлаар нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай байгаа талаар асуулт асууж, хариулт авсан болно оо.

Улсын Их Хурлын гишүүн Сэргэлэн хуулийн төслийн зохицуулалтыг нарийвчлан тодорхойлох, хуулийн үйлчлэлд хөрөнгө орлогын мэдүүлэг гаргадаг бүх албан тушаалтныг хамруулах бус авлига, албан тушаалын эрсдэлийн үнэлгээнд үндэслэн хамаарах этгээдийг шийдвэрлэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Цогтбаатар авлига, ашиг сонирхлын зөрчилтэй тэмцэх гэсэн үзэл баримтлалыг дэмжиж байгаа хэдий ч цөөн тооны өндөр албан тушаалтны хязгаарлалтын асуудлыг нийт төрийн албан хаагчдад хамруулж байгаа нь Монгол Улсын Үндсэн хууль, гэм буруугүйн зарчимтай зөрчилдөж байгаа талаар, түүнчлэн өөрийн орлогын 80 хувиас доош ямар ч зээлийг авч болохоор байгаа нь төрийн албан хаагчид авлига, ашиг сонирхлын зөрчилд өртөх нөхцөл үүсгэж болзошгүй талаар, мөн Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалан хуулийн төсөлд мэдээлэгчид олгогдсон зээлийн 10 хүртэлх хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал олгохоор зохицуулсан байх бөгөөд урамшууллыг олгох зохицуулалт

тодорхойгүй байгаа нь хуулийг нэг мөр хэрэгжүүлэхэд хүндрэл үүсэж болзошгүй тул хэлэлцүүлгийн явцад анхаарах талаар, Улсын Их Хурлын гишүүн Дэлгэрсайхан аливаа этгээд, төрийн өндөр албан тушаалтан болохоос өмнө хувийн хэвшилд амжилттай ажиллаж бий болгосон өмч хөрөнгийг төрийн албан тушаал эрхлээд олсон мэтээр олон нийтэд буруу ойлголт төрүүлэх болсон асуудлыг цэгцлэх, зааг ялгааг гаргах, төрийн өмчийн компанийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох асуудлыг яаралтай хэлэлцэх, Улсын Их Хурлын гишүүн Энх-Амгалан төрийн өндөр албан тушаалтан албан тушаалын давуу байдлаа ашиглан төрийн оролцоотой хуулийн этгээд, банк тусгай сангаас зээл авах асуудлыг таслан зогсоох болон авлига, ашиг сонирхлын зөрчилтэй тэмцэх гэж байгаа үзэл баримтлалыг дэмжиж байгаа хэдий ч хуулийн төсөлд төрийн албанд ажиллаж байгаа нийт албан хаагчдын зээл авах эрхийг хаасан зохицуулалт тусгасан нь төрийн байгууллагын хүний нөөцийн бодлогод нөлөөлөөд зогсохгүй төрийн албанд эрдэм мэдлэг, ур чадвартай хүнийг ажиллах боломжийг хааж, Монгол төрийн дархлаанд нөлөөлж болзошгүй талаар, Улсын Их Хурлын гишүүн Мөнхбаатар төсөл санаачлагч, хуулийн төслийн үзэл баримтлалд улс төрд нөлөө бүхий этгээд зээл авах асуудлыг хязгаарлахаар тусгасан боловч хуулийн төслийн зохицуулалтыг ерөнхий томъёолсон нь энэ Монгол Улсын Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлд заасан хүнийг эрхэлсэн ажил, албан тушаалаар нь ялгаварлан гадуурхахыг хориглох заалтыг зөрчиж болзошгүй талаар, түүнчлэн орон нутагт ажиллаж байгаа төрийн албан хаагчийн жилийн орлогыг тооцоход маш бага хэмжээний зээлд хамрагдах нөхцөл үүсэх бөгөөд

ипотекийн зээлээс гадна өөр эх үүсвэрээс зээл авах боломжийг хааж байгаа зохицуулалтыг хэлэлцүүлгийн явцад анхаарах талаар тус тус саналаа хэлсэн болно оо.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 63.6 хувь нь дэмжих боломжгүй гэж үзсэн болно оо.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.6 дахь хэсэгт Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжих боломжгүй гэж үзсэн бол хуулийн төслийг хууль санаачлагчид буцаах тогтоолын төсөл боловсруулж, нэгдсэн хуралдаанд оруулна гэж заасныг баримтлан хуулийн төслийг буцаах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулсан болно оо.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаар Хууль зүйн байнгын хорооны

санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээсээ хүсье ээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

С.Одонтуяа: Хууль санаачлагчдын илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүдийг бүртгэе. Нэрээ өгнө үү?

Наранбаатар гишүүнээр тасаллаа, Бат-Эрдэнэ гишүүнээр тасаллаа, Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн. Одоо Наранбаатар гишүүн асуулт асууя.

Н.Наранбаатар: Хуулийн төслийн үзэл баримтлалтай танилцлаа.

Тэгээд энэ Авлигатай хөрөнгө орлогын мэдүүлгээ гаргаж өгдөг, төрийн албан хаагчид зээл авахыг хориглосон ийм л зүйл байна. Амьдралд энэ хэр нийцэх бол оо. Ялангуяа энэ хөдөө орон нутагт төрийн албанд ажиллах хүн байхгүй боллоо гэж би түрүүн энэний түрүүний хэлэлцэх асуудал дээр хүртэл ярьж байсан. Энэ хөдөө орон нутагт юмны үнийн өсөлт төрийн албан хаагчдын цалинтай харьцуулахад бол одоо хэд дахин илүү болоод явчихлаа.

Тийм учраас төрийн албан хаагчид маань бас зээлээс зээлийн хооронд л одоо өнөөдөр амьдарч байна аа, тийм өрх гэр бүл бол маш олон байна. Төрийн албан хаагчид маань төрийн цалингаас гадна хувийн жижиг аж ахуй эрхлэх ийм асуудал бол хөдөө орон нутагт зөндөө. Өөртөө жижиг одоо ногоо тарих ч юм уу, малтай байх юм уу, жижиг сажиг гар урлалын зүйл хийх ч гэдэг

юм уу, төрийн албан хаагчдын хамаарал бүхий этгээдүүд, гэр бүл, үр хүүхдүүд нь жижиг дунд одоо бизнес эрхэлдэг зөндөө айл өрхүүд бол байна. Тэгээд энэ улсууд маань энэ үйл ажиллагаагаа явуулах өрхийн орлогоо нэмэгдүүлэхэд зайлшгүй л одоо ипотекийн зээлээс бусад зээлүүдийг авч л таарна. Тэгээд цалингийн зээл гээд. Хөдөө орон нутагт ажиллаж байгаа төрийн албан хаагчид чинь 1 сарын 600 жилийн 6, 7 сая тэгээд тэрний 80 хувиас хэтрэхгүй гэхээр нэг дөрөв, тавхан саяас хэтрэхгүй ийм хэмжээний зээлийг нь ингээд хориглочихоор энэ улсууд маань цаашаа яаж амьдрах бол оо? Энэ хууль маань орон нутагт яаж одоо амьдрал дээр хөрсөн дээр бууж очих бол оо. Хүмүүсийн амь амьжиргаанд нөлөөлчих болов уу, үгүй болов уу гэдгийг та хэрхэн одоо судалсан бэ?

Дээрээс нь бас нэг асуудал, тэр сая Байнгын хорооны санал, дүгнэлтэд сонсогдож байх юм. Үндсэн хуульд энэ хүмүүсийг ажил мэргэжлээр нь ялгаварлахгүй гээд заасан мөртөө төрд байгаа бол зээл авч болохгүй, төрд байхгүй бол авч болно гэдэг нэг бол чиний хамаарал бүхий этгээд чинь төрд байгаа бол чи зээл авч болохгүй гэж, энэ төрд ажиллаж байгаа улсуудын ар гэрийг нь одоо яллах маягтай, хавчих маягтай, ялгаварлах маягтай л ийм л санаа орчихсон юм болов уу? Тэгэхээр зэрэг Үндсэн хуулийн одоо энэ заалтыг зөрчиж байгаа юм биш биз ээ гэсэн бас нэг 2 дахь ийм тодруулга байна. Тэгээд энэний дараа бас нэмж тодруулж асууя.

С.Одонтуяа: Хууль санаачлагч Адьшаа гишүүн хариулъя.

Ш.Адьшаа: Наранбаатар гишүүний асуултад хариулъя аа.

Энэ асуудал бас Хууль зүйн байнгын хороон дээр хөндөгдөж байсан. Энэ Наранбаатар гишүүний асуултад хүндэтгэлтэй хандаж байна. Энэ дээр бол, ер нь төрийн бүх албан хаагчдыг тэр цалингийн зээл, бусад юмыг нь хязгаарласан юм байхгүй ээ.

Яагаад гэхээр жилийн хөрөнгө орлогынхоо мэдүүлгийн 80 хувиас дээш гарсан ийм л хөрөнгө орлогын мэдүүлгээсээ 80 хувиас дээш гарсан энэ л цалинтай тэнцэх хэмжээний л асуудалд зээл олгоё гэж байгаа юм. Олгохыг хориглоно гэж байгаа юм. Тэрнээс биш одоо нэг ипотекийн зээл, сургалтын зээл, орон сууцны зээл гээд, эрүүл мэндийн зээл гээд энэ бол нээлттэй. Дээр нь бол өнөөдөр Авлигатай тэмцэх газраас авсан мэдээлэл, судалгаагаар төрийн албан хаагч өөрийнхөө Авлигатай тэмцэх газарт мэдүүлсэн бүх орлогоосоо хэд давсан тэрбум гаруй, 500 сая төгрөгийн зээл авдаг. Тэгээд өнөөдөр төрийн алба хаашдаг ийм судалгаа байгаа.

Зээлээр дамжуулж өнөөдөр авлигал авдаг, авлигын ашиг сонирхол бий болдог, энэ авлигынхаа асуудлыг зээлээр хаацайлдаг ийм одоо асуудлууд байгаа тухай Авлигатай тэмцэх газар бусад одоо энэ иргэний нийгмийн байгууллагууд, судалгааны байгууллагад гарсан судалгаан дээр бол тулгуурласан. Энэ асуудлыг бол яах вэ, хэлэлцүүлгийн явцад ярилцаад, засаад бас дахин судлах ийм боломжтой гэж үзэж байгаа.

Хоёр дахь асуудлын тухайд Үндсэн хуульд заасан хүн бүр тэгш эрхтэй, хөрөнгө мөнгө, албан тушаал, арьс өнгөөр ялгаварлахгүй байна гэсэн энэ зарчим байгаа нь үнэн. Энэ дээр бол

санал нэг байна Наранбаатар гишүүнтэй. Гэхдээ нийт улсын ашиг сонирхлын эрх ашгийн үүднээс өөрийнх нь болон бусад хүний эрх ашиг хөндөгдөх ийм асуудал өнөөдөр байх ёстой. Энэ бол дэлхий дахинд хаана ч гэсэн байдаг л асуудал. Энэ дээр бол одоо тийм хүний эрх зөрчсөн тэр Үндсэн хуулийн заалтыг зөрчсөн ийм ойлголт байхгүй байх гэж ойлгож байгаа. Яагаад гэвэл нийт улсын ашиг сонирхлын өмнөөс хууль зөрчихгүй байя л гэдэг юмыг чинь бид нар Улсын Их Хурлын гишүүд энэ тангараг өргөхдөө ч Үндсэн хуулийнхаа тангараг өргөсөн, тэгэхдээ нийт улсын ашиг сонирхол, нийт хүний эрх ашгийн төлөө тухайн хувь хүний эрх ашиг зөрчигдөх ийм асуудал байвал энэ бол Үндсэн хууль зөрчсөн асуудал болохгүй ээ л гэсэн ийм зарчмыг баримталж энэ хуулийг боловсруулсан.

С.Одонтуяа: Нанзадын Наранбаатар гишүүн тодруулъя.

Н.Наранбаатар: Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулиуд дотор бол төрийн албан хаагчтай холбоотой зөндөө олон асуудлуудыг бол бас хориглож хязгаарлачихсан байдаг.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах тухай хуульд чинь бол одоо хориглосон зүйлүүд зөндөө байгаа шүү дээ. Төрийн албан хаагчид одоо элдэв зээл тусламж, янз бүрийн юмнуудад нөлөөлж болохгүй энэ тэр гээд маш олон одоо зүйлүүд. Тэгээд хөрөнгө орлогынхоо мэдүүлгийг гаргаж өгөөд тэрийгээ тайлбарлаад жил бүхэн тодотгоод ингээд явдаг юм аа. Тэгэхээр дахиад заавал одоо энд хуульд нэмэлт өөрчлөлт оруулах замаар

ингээж дахиж оруулах ямар шаардлага байгаа юм бол оо?

Нөгөө талаасаа энэ томоохон асуудалд ороод байгаа тэр ЖДҮ санг тоноод байгаа нөхдүүдтэйгээ харин хатуухан шиг хуулиа чангаруулж тэмцэх нь илүү үр дүнтэй байх юм болов уу? Энэ авлигыг бууруулахад гэсэн одоо миний бодол санаа байна.

Баярлалаа.

С.Одонтуяа: Одоо Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн асуултаа асууна.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Улсын Их Хурлын гишүүн Адьшаагаас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах энэ хуулийн төслийн үзэл баримтлалыг бол зарчмын хувьд дэмжээд байгаа юм. Энэ өнөөдөр би бол одоо хүндрэлтэй нөхцөл байдал, улс орны хөгжил дэвшил урагшлахгүй байгаа, ард иргэдийн амьдрал өнөөдрийн энэ дүр төрх байгаа байдал бол ялангуяа энэ төрийн өндөр эрх мэдэлд байгаа хүмүүс өөрийн эрх мэдлийн давуу байдлаа ашиглаж нөлөөлж, тусгай зөвшөөрөл, лиценз, тендер, концесс, төр, ард түмний нэр барьж авсан зээл, бонд. Цаашилах юм бол элдэв сангууд, бүр цаашилах юм бол одоо ингээд Боловсролын сангийн зээл гээд тэгээд ийм асуудлуудтай холбогдоод байгаа юм. Яах вэ, хүмүүс бол ярьж байгаа.

Дээр дурдсан Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх тухай хууль, төрийн албаны хууль, бусад хуулийн хэмжээнд

одоо зохицуулалт бол хангалттай байгаа гээд байгаа юм. Тэгээд манайд хууль хэрэгжихгүй байгаагийн нэг тодорхой жишээ бол энэ л дээ. Тэгээд ийм нөхцөл байдлуудаас үндэслээд Адьшаа гишүүнээс ийм хуулийн төсөл өргөн барьж байна гэж ойлгож байгаа. Тэгээд энэ хуулийн төсөлд бол анхаарахаар зүйл байна. Ялангуяа одоо энэ хөрөнгө орлогын мэдүүлгээ гаргадаг бүх албан тушаалтныг одоо хамруулж байгаа. Энийг их өргөн хүрээнд хамруулж байгаа нь хүмүүсийн тайлбарлаад байгаагаар маш олон хүмүүс хамрагдаж байгаа. Энэний цаад талд нөгөө одоо гол өндөр эрх мэдэлтэй нөлөө үзүүлдэг бодитойгоор энэ Хөгжлийн банк, төр ард түмний нэр барьж авсан зээл, бондуудаас зувчуулсан хүмүүс цаана нь сугараад үлдэх нэг нүхээр одоо цуваад гарцгаах ийм нэг бололцоог нь гаргаж өгсөн байна уу гэж би ингэж үзээд байгаа юм.

Үнэхээр энэ авлига, ашиг сонирхлын ийм эрсдэлтэй, тэр хэсэгтээ бол сайн хааж өгөх ийм шаардлага байгаа байх. Энэ талаас нь одоо юу гэж үзэж байна гэж нөгөө талынх нь юм бол хамгийн түрүүнд олон нийтийг бариад хэлээд байна шүү дээ. Энэ нийт төрийн албан тушаалтнуудад хамааралтай мэтээр ингээд энэ рүү чинь нөгөө тал руу гарах гээд байгаа юм. Нөгөө талынх нь юм бол Үндсэн хуулийн одоо 14 дүгээр зүйлийг тавиад байдаг. Гэтэл чинь бол хуулиар нийтийн албанд ажиллаж байгаа, энэ ажил хариуцаж байгаа хүмүүст бол тодорхой хэмжээнд эрхээ хязгаарлуулсан хязгаарлалттай заалтууд бий л дээ. Тэгээд тийм учраас энүүгээрээ одоо зохицуулахгүй бол өнөөдөр яг бодит байдал дээр чинь бол одоо Хөгжлийн банк гээд аваад үзье л дээ. Хөгжлийн банканд бид нар ажлын хэсэг байгуулахыг Их Хурал дээр

шаардаж байгаад ажлын хэсэг нэг 56 хоног ажиллаад тодорхой санал, дүгнэлтээ боловсруулаад ингээд одоо Их Хуралд тайлагнаад Их Хурал Түр хороо байгуулаад ингээд үргэлжлээд ажиллаж байгаа юм. Тэгээд энийг аваад үзэх юм бол найдваргүй зээлийн ангилалд оруулчихсан компаниуд дотор ч нөлөөтэй хүмүүс.

С.Одонтуяа: Ширнэнбандийн Адьшаа гишүүн хариулъя.

Ш.Адьшаа: Баярлалаа. Бат-Эрдэнэ гишүүндээ бас өнөөдөр Монгол оронд үүсээд байгаа ч гэж хэлэх юм уу, энэ төрд одоо нөлөө бүхий улс төрийн албан тушаалтнууд энэ төрөөс баталгаа гаргадаг энэ зээл тусламжийг ард түмний өмнүүр орж, тэд нарын одоо шударга бусаар энэ зээл тусламж авдаг энэ асуудлыг бид өнөөдөр цэг тавих ёстой. Энэ дээр бол тэр Монгол Улсын Үндсэн хуульд заасан энэ төрийн андр өндөр албан тушаалтнуудын зээл авах эрхэд халдаж байна гэдэг ийм асуудалыг одоо цэгцэлж, энэ төрд итгэх ард түмний итгэлийг бий болгох жинхэнэ одоо эзэд нь тэр төрөөс баталгаа гаргасан зээл тусламж очих энэ боломжийг л одоо хангахын тулд энэ хуулийн төсөл санаачилсан. Энэ дээр бол яах вэ нийт одоо Авлигатай тэмцэх газарт хөрөнгө орлогын мэдүүлгээ мэдүүлдэг бүх хүнийг хамруулах, энэ зээл авах асуудлыг хязгаарлах нь бол бас учир дутагдалтай байна гэсэн энэ Бат-Эрдэнэ гишүүн болон бусад гишүүдийн саналыг одоо би бас хүндлэлтэй хандаж байна. Энэ дээр бол хэлэлцүүлгийн явцад, хэрвээ энэ хуулийн төслийг хэлэлцэхийг дэмжвэл энэ асуудал дээр та бүгд бас хамтраад, энийг дэмжээд асуудлыг бас өөрчилж, энэ зүйл заалтыг нь заримд нь өөрчлөлт оруулах нь бол

өнөөдөр бүрэн нээлттэй байгаа гэдгийг хэлье.

С.Одонтуяа: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Одоо үг хэлэх гишүүдийн нэрс авъя. Дэмжсэн 3, дэмжээгүй 3 гишүүн. Алга байна. Одоо санал хураана. Тогтохоо даргаа яах юм? Хүмүүсээ дуудах юм уу? санал хураана. Саналаа хураах уу? МАН-ын бүлгийн дарга зөвшөөрсөн шүү.

Байнгын хорооны саналаар Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх шаардлагагүй гэсэн саналын томъёоллоор санал хураая.

Ирц хүрэхгүй байна. Санал хураахад ирц хүрэхгүй байна гишүүд. 50 хувийн ирцтэй байна шүү. Гишүүд санал хураалтдаа оролцмоор байна. Тэгвэл одоо юу хүрэхгүй байгаа юм чинь хойшлуулах уу? Бүр 48 болчихлоо.

44.7 хувийн ирцтэй байгаа учраас санал хураалтыг хойшлууллаа.

Маргаашийн сонсгол байсан. Энийг хойшлуулах талаар энэ Тэмүүлэн гишүүний хүсэлтийг уншиж танилцуулъя.

Асуулгын хариу сонсохыг хойшлуулах тухай.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн наймын нэг. 13 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэд хандан 2022 оны 6 дугаар сарын 3-ны өдрийн 27 тоот албан бичгээр Монгол Улсын экспортын уул уурхайн бүтээгдэхүүний хяналтыг сайжруулах талаар асуулга тавьсан болно оо.

Дээрх асуулгын хариуг хэлэлцэхээр тов дараалалд оруулсан боловч холбогдох Засгийн газрын гишүүн нь гадаад албан томилолтоор ажиллахаар байгаа тул уг асуудлын хариуг хэлэлцэх тов дарааллаас хойшлуулж өгөхийг хүсье. Улсын Их Хурлын гишүүн Тэмүүлэн гэсэн байна. Энэ асуудлыг хойшлууллаа.

Одоо даргын дэргэдэх зөвлөлийн гишүүд манай өрөөнд хуралтай. Өнөөдрийн чуулганаар хэлэлцэх асуудал үүгээр дууслаа.

Чуулганы ажиллагаа хаасныг мэдэгдье ээ.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ П.МЯДАГМАА

